

АГУУЛГА

I. ӨГҮҮЛЭЛ ИЛТГЭЛ

- А. Саруул
ХДХВ/ДОХ ба хүний эрхийн асуудлууд 3
- Г. Нарантуяа
Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцийг хэрэгжүүлэх зарим асуудал 11
- Д. Баянбилэг
Хууль тогтоомж ба хүний эрх 19
- Ч. Алтангэрэл
Хүний эрхэд суурилсан хөгжлийн хандлага 24
- С. Цэрэндорж
Цөөнхийн эрх ба цаатан иргэдийн эрхийн тухай зарим асуудал 33
- Б. Хишигсайхан
Цөөнх болох цаатан иргэдийн соёлын эрхийн хэрэгжилт 37
- Ж. Дашдорж
Цагдаагийн хэрэг бүртгэлт ба хүний эрх 43
- Л. Сүхээ
Хэрэг бүртгэх ажлын өнөөгийн байдал, цаашдын зорилт 49

II. ХЭҮК-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС

- “Цаатан XI” төслийн тайлан 55
- Зөвлөмж 66
- Уриалга 69

III. АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧУУЛГАНЫ Х ХУРАЛДААНЫ ЗАРИМ БАРИМТ БИЧИГ, МЭДЭЭЛЭЛ

- Ази, Номхон Далайн Бүс Нутгийн Хүний Эрхийн Үндэсний Байгууллагуудын Чуулган
Товч мэдээлэл 71
- Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын Ази Номхон Далайн Бүс Нутгийн Хүний Эрхийн Үндэсний Байгууллагуудын Чуулганы Х Хуралдаан дээр хэлсэн үг 73
- Монгол улсын ХЭҮК-ын дарга С.Цэрэндоржийн Ази Номхон Далайн Бүс Нутгийн Хүний Эрхийн Үндэсний Байгууллагуудын Чуулганы Х Хуралдаан дээр хэлсэн үг 76
- АНДБНХЭҮБЧ-ны хуралдааны төгсгөлийн баримт бичиг 78
- Ж. Дашдорж
Хүний эрхийн үндэсний байгууллага ба эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь 83
- Б. Хишигсайхан
Хүний эрхийн боловсрол албан боловсролын хөтөлбөрт 89
- АНДБНХЭҮБЧ-ны Хуульчдын зөвлөлийн эрүү шүүлтийн талаарх судалгааны тайлан 96

IV. ОРОН НУТГИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ НАРЫН МЭДЭЭЛЭЛ

- Дорнод аймаг 129
- Дорноговь аймаг 131
- Завхан аймаг 133

CONTENT

I. ARTICLES AND REPORTS

- A. Saruul
HIV/ AIDS and human rights 3
- G. Narantuya
International human rights documents 11
- D. Bayanbileg
Jurisdiction and human rights 16
- Ch. Altangerel
Rights based approach 24
- S. Tserendorj
Minority rights and some issues of the tsaatan 33
- B. Khishigsaikhan
Cultural rights of the tsaatan 37
- J. Dashdorj
Police investigation and human rights 43
- L. Sukhee
Present situation of the investigation and future objectives 49

II. ACTIVITIES OF NHRCM

- Report of the “Tsaatan XI” project 55
- Recommendation 66
- Appeal 69

III. TENTH ANNUAL MEETING OF THE ASIA PACIFIC FORUM OF NATIONAL HUMAN RIGHTS INSTITUTION

- Brief information about the Tenth Annual Meeting 71
- Opening speech of the Tenth Annual meeting of the Asia Pacific Forum of National Human Rights Institution by the Mr N. Enkhbayar, President of Mongolia 73
- Opening speech of the Tenth Annual meeting of the Asia Pacific Forum of National Human Rights Institution by the Chairperson of the Tenth Annual Meeting Mr S. Tserendorj, Chief Commissioner of the NHRCM 79
- Concluding statement of the Tenth Annual Meeting 78
- J. Dashdorj
National human rights institution and prevention from torture 83
- B. Khishigsaikhan
Human rights education 89
- Torture report by the Advisory Council of Jurists 96

IV. BRIEF REPORTS BY LOCAL HUMAN RIGHTS EXPERTS

- Dornod Aimag 129
- Dornogobi Aimag 131
- Zavkhan Aimag 133

ХДХВ/ДОХ БА ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДЛУУД

А. Саруул,
ХЭҮК-ын референт

“Нэр хоч, шошго, хаяг зүүлтээс айх ичих асуудал нь анир чимээгүйд хүргэдэг. ДОХ-ын хувьд анир чимээгүй байна гэдэг нь үхэлрүү түлхэж буй нэг хэлбэр юм. Нэр хоч, хаяг, шошго нь ХДХВ/ДОХ-ын талаарх бодит мэдээллийг хүлээн авч, өөрийгөө илэрхийлэх болон хувь хүнийхээ эрхийг эдлэхэд саад тотгор болдог. Иймд бид ХДХВ/ДОХ-той хүн болгон өөрийгөө ойлгон, хүндлүүлж, эрхээ бүрэн эдэлж чадах орчин бүрдүүлж нэр хоч, хаяг, шошгын оронд - туслалцаа дэмжлэг; айдас, түгшүүрийн оронд - итгэл найдвар; анир чимээгүйн оронд - хүмүүнлэг, энэрэнгүй орчинг бүрдүүлж өгөх хэрэгтэй”

НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Анан

ХДХВ/ДОХ-ын асуудлыг цэвэр анагаах ухааны асуудал гэж та бодож байгаа бол энэ нь том эндүүрэл юм.

Учир нь ХДХВ/ДОХ-той холбоотой аливаа асуудал нь хүний эрхийн салбарт ч мөн адил хамаарагдаж байдаг.

“Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах”, “Аюулт ДОХ өвчнөөс үндэсний аюулгүй байдлыг сэргийлэх” зэрэг сүржин уриа, **“Замбраагүй, завхай явдалтай хүмүүст тусгаг өвчин”** гэх зэрэг хандлага нь ХДХВ/ДОХ-той холбоотой хүний эрхийн зөрчлүүд их гарахад шууд нөлөөлдөг. Бодит амьдрал дээр ХДХВ/ДОХ-той бүлэг хүмүүсийн эрхийг зөрчиж буй явдлууд тухайн өвчнөөс сэргийлэх биш улам даамжруулж, далд байдалд оруулсаар ирснийг дэлхий нийтийн сүүлийн 20-иод жил ХДХВ/ДОХ өвчинтэй тэмцэж ирсэн түүх харуулсан бөгөөд хүний эрхийг хамгаалан, хүндэтгэн дээдлэхгүйгээр ХДХВ/ДОХ өвчинтэй бид үр дүнтэй тэмцэж чадахгүй гэдэг нь ч “цагаан толгойн А үсэг” шиг тод болсон билээ.

Иймд ХДХВ халдвар авсан, ДОХ өвчнөөр өвчилсөн хүний эрхийг хүндэтгэн үзэх нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох ёстой юм.

“Хүний эрх” гэдэг нь элдэв баримт бичигт чимэг болгон оруулдаг хий хоосон үг огт биш юм. Хүний эрхийг үнэхээр чандлан хамгаалж чадсан нөхцөлд ХДХВ халдвар багасч, ХДХВ халдвар авсан, ДОХ өвчнөөр өвчилсөн хүмүүсийн болон тэдний гэр бүлд тулгарч буй бэрхшээлийг харьцангуй амжилттай даван туулах боломжтой болдог гэдэг нь ч судалгаагаар нотлогдсон байдаг.

1993 оны Венийн Тунхаглалд хүний бүхий л эрх нь түгээмэл, хуваагдашгүй, харилцан хамааралтай хэмээн заасан байна.

ХДХВ/ДОХ-ын асуудалд үр дүнтэй нөлөөлөхийн тулд хүний эрхийн салбар дахь олон улсын стандартын дагуу хүний бүхий л эрхийг, нэн ялангуяа иргэний, улс төрийн, эдийн засаг нийгэм соёлын эрхүүдийг хэрэгжүүлэхийг шаарддаг. Эдгээр шаардлагуудыг биелүүлэх зарчмууд нь хүний эрхийн салбарын бүхий л олон улсын баримт бичгүүдэд байр сууриа эзэлсэн байдаг.

Олон улсын хүний эрхийн зарим баримт бичиг тулгуурлан ХДХВ/ДОХ-той нягт холбоотой зарим эрхүүдийг авч үзье.

- **Аливаа хэлбэрийн алагчилалаас ангид байх, тэгш байх эрх**

Олон улсын ихэнх баримт бичигт хүн бүр яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан эрх, эрх чөлөөг ямар ч гадуурхалтгүйгээр эдлэх ёстой гэж заасан байдаг. Аливаа төрлийн алагчилал, гадуурхалт нь хууль бус бөгөөд ялангуяа ХДХВ халдвартай хүмүүсийг нийгмээс гадуурхах үндэс болж, тэдний эмчлүүлэх таатай нөхцөл бүрдэх, цаашилбал амьд явах эрхэд ноцтой нөлөөлөхүйц орчинг бий болгох хор уршигтай юм. Иймд төрийн зүгээс эдгээр нөхцлүүдийг бий болохоос урьдчлан сэргийлж алагчлан гадуурхахаас ангид байх баталгааг хууль тогтоомжоороо баталгаажуулж өгөх, аливаа хэлбэрийн алагчилал, гадуурахалт үүсгэж болох нөхцлийг бүрдүүлэхгүй байх тал дээр анхааран ажиллах хэрэгтэй.

- **Бие бялдарын болон сэтгэцийн эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрх**

ЭЗНСЭОУП-ын 12-р зүйлийн: “Хүн бүр бие бялдарын болон сэтгэцийн эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрхийг хүлээн зөвшөөрнө” мөн “... халдварт өвчнөөс...урьдчлан сэргийлэх, эмчлэх, тийм өвчинтэй тэмцэх, өвчилсөн тохиодолд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, сувилах нөхцлийг бий болгох” үүргийг төр хүлээсэн байдаг. Иймд төр боловсрол, сурталчилгааны үйл ажиллагааг өргөнөөр өрнүүлэн, хөхиүлэн дэмжих, эмнэлэг, сувилал зэрэг үйлчилгээний газрын хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр анхаарлаа хандуулан ажиллахаас гадна сайн дурын, нууцаар шинжилгээ хийлгэх нөхцлийг бүрдүүлэх ёстой.

Түүнчлэн тухайн өвчний тархалт, урьдчилан сэргийлэх арга зам, эмчилгээний талаарх үнэн зөв бодит мэдээллийг байнга түгээж, аливаа хэлбэрийн алагчилал, гадуурхахлтаас ангид байх арга хэмжээг хуульчилан баталгаажуулах үүрэгтэй.

- **Эрх чөлөөтэй, халдашгүй, дархан байх эрх**

ИУТЭОУП-ын 9-р зүйлд “хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй” гэж заасан байдаг.

Иймд ХДХВ/ДОХ-той хүмүүсийг зөвхөн энэ өвчнийх нь улмаас **“нийгмийн сайн сайхан, аюулгүй байдлын төлөө”** нэрийдлээр аливаа хэлбэрээр нийгмээс тусгаарлан, халдашгүй дархан, эрх чөлөөнд нь халдаж болохгүй. Мөн түүнчлэн **“эрсдэл бүхий бүлэг хүмүүс”** нэрийдлээр бие үнэлэгчид,

мансууруулах бодис хэрэглэгчид, бэлгийн ижил чиг баримжаатай хүмүүс, хоригдол, цэргийн алба хаагч нарыг албадан шинжилгээнд оруулах нь хүний халдашгүй дархан, эрх чөлөөтэй байх эрхэнд халдаж буй зөрчлийн нэг хэлбэр юм.

ХДХВ/ДОХ-ын шинжилгээ нь:

- ◆ Сайн дурын үндсэн дээр
- ◆ Нууц
- ◆ Мэдээллээр бүрэн хангагдсан байх (шинжилгээний өмнөх болон, дараах зөвлөгөө, мэдээлэл)
- ◆ Хүртэмжтэй байх шаардлагуудыг хангагдсан нөхцөлд хийгдэх ёстой юм.

Түүнчлэн олон улсын жишиг, стандартаар албадан шинжилгээнд дараах мэргэжлийн хүмүүс заавал хамрагдсан байх шаардлагатай байдаг:

- ◆ ХДХВ/ДОХ-той хүмүүстэй шууд холбогдон ажилладаг эмч, эмнэлгийн ажилтнууд
- ◆ Мөн ХДХВ/ДОХ-ын шинжигээний лабораторид ажилладаг шинжилгээний ажилтанууд болон эмч, эмнэлгийн ажилтнууд
- ◆ Цус болон бусад шингэн эдийн ба бие эрхтэний донорууд.

• Чөлөөтэй зорчих эрх

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 13-р зүйлд: “Хэн боловч улсынхаа дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй. Хэн боловч аливаа улс орныг, түүний дотор эх орноо орхин явах, эх орондоо эргэж очих эрхтэй” гэж заасан байдаг. Иймд хэнийг ч, түүний дотор ХДХВ/ДОХ-оор өвчилсөн шалтгаанаар тухайн улс орныг орхихыг шаардаж болохгүй.

Түүнчлэн гадаад, дотоодын жуулчдаас орж гарахад нь ХДХВ/ДОХ-ын шинжилгээ шаардах нь хүний эрхийг зөрчиж буй асуудал бөгөөд үүнийг “**үндэсний аюулгүй байдал**”, “**нийгмийн эрүүл мэндийн аюулгүй байдлыг хамгаалах үйл ажиллагаа**” зэргээр тайлбарлаж үл болно.

Дэлхийн хэмжээнд Эрүүл мэнд, ариун цэврийн Дүрмийн дагуу албадан шинжилгээ авч болох ганц л өвчин байдаг нь “шар чичиргэн” юм.

• Орогнох боломж эрэлхийлэх болон орогнох эрх

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 14-р зүйлд: “Хэн боловч мөрдөлт мөшгөлтөөс зугтаж, өөр улсад орогнох боломжийг эрэлхийлэх эрхтэй” мөн түүнчлэн 1951 онд батлагдсан Дүрвэгсдийн тухай олон улсын Конвенцийн дагуу аливаа улс орон дүрвэгсдийг хүлээн авахаас татгалзах, буцаан гаргаж болохгүй байдаг. Иймд ХДХВ халдвар болон ДОХ өвчний улмаас өөрийн улсад мөрдүүлж мөшгүүлэн, гадуурхагдсан этгээд орогнол эрэлхийлэх тохиолдолд тухайн этгээдийг буцааж үл болно.

1988 оны 3-р сард НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Эгэд Комиссар орогнол эрэлхийлсэн дүрвэгсдээс ХДХВ/ДОХ-ын шинжилгээ авахыг хориглосон. Энэ нь аливаа улс оронд дүрвэгсдийг ХДХВ/ДОХ-той гэсэн шалгаанаар хүлээн авахгүй байхаас урьдчлан сэргийлсэн юм.

Түүнчлэн НҮБ-ын Хүний эрхийн Хороо шилжин суурьшигчид, цагаач иргэд, дүрвэгсэд болон ямарваа нэгэн ажил төрлийн шугамаар өөр орон руу нэвтрэхэд ХДХВ/ДОХ-ын шинжилгээ шаардахыг хориглосоноо дахин тэмдэглэсэн билээ. Харамсалтай нь энэхүү зөрчил нь одоо болтол устаж үгүй болоогүй байна.

- **Хувийн амьдралын эрх**

ИУТЭОУП-ын 17-р зүйл: “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно. Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй”.

Энэ нь хүний биеийн байдал, тэр тусмаа шинжилгээ, үзлэгт хамруулахдаа зайлшгүй өөрийн зөвшөөрөл авсан байх болон тухайн хүний өвчин, биеийн байдлын талаар бусдад зөвшөөрөлгүйгээр мэдээлэхийг хориглож буйг илэрхийлж байгаа юм.

Хүний хувийн амьдралын эрх нь ХДХВ/ДОХ-ын хүрээнд:

Нэгдүгээрт: албадан шинжилгээнд хамруулахаас хамгаалуулах,

Хоёрдугаарт: нууцлалыг чандлан хадгалснаар аливаа хэлбэрийн алагчлалаас ангид байх,

Гуравдугаарт: хүмүүс эрүүл мэндтэйгээ холбоотой хувийн нууцаа задруулах, хувийн амьдралд нь хөндлөнгөөс хутгалдах, хувь хүний эрх нь зөрчигдөх зэрэг айдас түгшүүргүйгээр амьдрах эрхүүдтэй холбоотой байдаг.

Иймд төр энэхүү эрхийн хүрээнд шинжилгээ, үзлэг, эмчилгээний нууцлалыг чандлан хадгалах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн зүгээс мөрдөж мөшгүүлэхгүй байх арга хэмжээ авах талаар хууль тогтоомжид баталгаажуулах үүрэгтэй.

НҮБ-ын Хүний эрхийн Хороо нь зарим нэгэн улс орны эрүүгийн хуульд орсон зүйл заалтууд нь ИУТЭОУП-ын 17-р зүйлийг зөрчиж байгааг цохон тэмдэглэж, хоёр талын зөвшөөрөлтэйгээр бэлгийн ижил чиг баримжаатай насанд хүрсэн хүмүүс бэлгийн харьцаанд орж, гэр бүл болох зэргийг хоирглож, гэмт хэрэгт тооцон шалгадагийг буруушаасан юм. “Хүйс” гэдэг үгийг болон “бэлгий чиг баримжаа”-г тухайн Пактын 26-р зүйлд тодорхой тайлбарласан хэмээн Хороо үзэж байгаагаа илэрхийлсэн бөгөөд хэрэв “бэлгийн ижил чиг баримжаатай” эрчүүлийг ХДХВ/ДОХ түгээгч нар хэмээн алагчлан үзэж, гадуурхаж байгаа бол ИУТЭОУП-ын 26-р зүйлийг зөрчсөнд ойлгоно хэмээн тусгажээ.¹

- **Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хүлээн авч, түгээх эрх**

ИУТЭОУП-ын 19-р зүйлд: “Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй ...хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг...үл хамааран...эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана” хэмээн заажээ. Энэ утгаараа тус эрх нь ХДХВ/ДОХ-ын талаар мэдээ мэдээллийг түгээх, эрж хайх, хүлээн

¹ Международные обязательства в области прав человека и ВИЧ/СПИД, 2003

авах тухай тусгасан гэж ойлгож болох юм.

Төр нь ХДХВ/ДОХ хэрхэн яаж тусдаг, хэрхэн хамгаалж, урьдчилан сэргийлж, ямар журмаар эмчлүүлэх талаарх үнэн брдит, шинэ соргог мэдээллийг байнга түгээж байх үүрэгтэй.

Түүнчлэн хэвлэл мэдээллийхэн хүний эрх, нэр төр, хувийн халдашгүй амьдрал, нууцад хүндэтгэлтэй хандаж аливаа хэлбэрээр санаатай болон болгоомжгүйгээр гутаан доромжлохоос зайлсхийж, тухайн асуудалд маш уян хатан хандаж байх хэрэгтэй юм.

- **Хөдөлмөрлөх эрх**

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 23-р зүйлд: “Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шудрага, аятай нөхцлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй” гэж заасан.

Энэхүү эрх нь ажилд ороход ХДХВ/ДОХ-ын шинжилгээ шаардаж эхэлснээр шууд бусаар зөрчигддөг эхэлдэг ба ХДХВ халдвар эерэг гарсан тохиолдолд ажил олгохоос татгалзсанаар буюу тухайн шалтгаанаар халснаар шууд зөрчдөг байна. Иймд төрийн зүгээс энэхүү нөхцлийг бүрдүүлэхгүй байх бүх төрлийн арга хэмжээг авч, баталгаажуулах үүрэгтэй байдаг.

Түүнчлэн ОУХБ-ын “ХДХВ-ДОХ ба хөдөлмөрийн орчин” Дүрэмд ч ХДХВ халдвартай болон ДОХ-оор өвчилсөн хүмүүсийн хөдөлмөрийн харилцааны талаар нарийвчлан тусгасан байдаг.

- **Гэр бүл болох эрх**

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 16-р зүйлд гэр бүлийн тухай, гэр бүл болох эрхийн тухай тодорхой тусган өгсөн байдаг: “насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэгтэй холбоотой аливаа хязгаалалтгүйгээр гэрлэх, өрх тусгаарлах эрхтэй. Тэд гэрлэхдээ, гэрэлсний дараа болон гэрлэлтээ цуцлуулах үед тэгш эрх эдлэнэ”, “нөхөр, эхнэр болох хоёр хүн чөлөөтэй, харилцан бүрэн зөвшөөрсөн нөхцөлд гэрлэж болно”, “гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй” гэж. Үүний адил бусад хүний эрхийн гол баримт бичих болох ИУТЭОУП ба ЭЗНСЭОУП-д ч энэ тухай заасан байдаг. Иймд гэр бүл болоход ХДХВ/ДОХ-ын шинжилгээ шаардах нь хүний эрхийг зөрчиж буй нэг хэлбэр юм.

Түүнчлэн ХДХВ халдвартай жирэмсэн эмэгтэйд хүчээр үр хөндүүлэх нь **гэр бүл болох эрх, эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрх** зэрэгт халдаж буй хэрэг юм.

Мөн цөөнгүй улсын эрүүгийн хууль тогтоомжид “өөрийгөө ХДХВ халдвар авсан болон ДОХ-оор өвчилснөө мэдсээр байж бэлгийн харьцаанд орох болон тухайн өвчнийг түгээхэд эрүү үүсгэнэ” гэж заасан байдаг. Энэ нь тухайн өвчнөөс урьдчилан сэргийлэх гэснээсээ илүүтэй хүний халдашгүй дархан байх, эрх чөлөөтэй байх эрхэд халдсан асуудал болно. ²

- **Сурч боловсрох тэгш боломжоор хангагдах эрх**

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 26-р зүйлд: “Хүн бүр сурч боловсрох эрхтэй...Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн

эрх чөлөөг улам хүндэтгэдэг болоход чиглэх ёстой...Боловсрол нь бие бие харилцан ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах ...үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстой” гэсэн байдаг.

Энэ эрхээс ХДХВ/ДОХ-той холбоотой дараах гурван хүчин зүйлийг тэмдэглэх нь зүйтэй.

1. Хүүхэд, томчууд ХДХВ-ДОХ-ын талаар мэдээлэл хүртэж, боловсрол эзэмших эрхтэй. Иймд энэхүү боловсролыг албан болон албан бус замаар олгох үүргийг төр хүлээж байдаг.
2. ХДХВ халдвартай болон ДОХ-оор өвчилсөн хүмүүс сурч боловсрох эрхээ бүрэн эдлэх нөхцлийг төр бүрдүүлж өгөх ёстой.
3. Боловсролын системээр дамжуулан бие биеэ хүндлэн ойлгох, хүнлэг энэрэнгүй хандах, алагчилан гадуурхахгүй байх ухамсрыг төр төлөвшүүлэх ёстой.

- **Хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх болон нийгмийн халамж хүртэх эрх**

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 25-р зүйлд: “Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийн эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй. Ажилгүйдэл, өвчлөх, хөгжлийн бэрхшээлтэй болох, бэдэвсрэх, өтлөх, эсхүл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхтэй” хэмээн заасан. Энэхүү заалт нь ХДХВ/ДОХ-ын улмаас ахуй байдал нь ямарваа нэгэн байдлаар хүнд нөхцөлд орсон, түүнчлэн тухайн өвчний халдвараас болоод гадуурхалтад өртөн ажилгүй болсон, орон байргүй болсон, ядуурсан зэргээр хохирсон хүмүүст шууд хамааралтай юм. Иймд төрийн зүгээс ХДХВ/ДОХ-той хүмүүс энэхүү эрхээ эдлэн амьжиргааны хүрэлцэхүйц төвшинд аж төрөх, нийгмийн халамж үйлчилгээнээс хүртэх эрхээ бүрэн эдлэхэд нь онцгой анхаарлыг хандуулж байх ёстой.

- **Шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг хүртэх эрх**

Орчин үеийн шинжлэх ухаан хурдацтай хөгжиж байгаа өнөө үед ХДХВ/ДОХ-той хүмүүсийн хувьд шинжлэх ухааны дэвшлийн үр шимээс хүртэх эрх нь бас нэгэн чухал эрхийн нэг болоод байна. Шинжлэх ухаанд шинээр гарч ирж буй эм тариа, амин дэм, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар амьдрах хугацааг уртасгах зэрэг чухал ач холбогдолтой билээ.

- **Улс төр, соёлын амьдрал чөлөөтэй оролцох эрх**

Улс төр, нийгэм, соёлын амьдрал оролцох эрх нь ХДХВ/ДОХ-той хүмүүсийн хувьд гол эрхийн нэг байдаг. Учир нь чухамхүү энэ эрхээ эдэлж байж өөрсдийн эрх, эрх чөлөөгөө бүрэн эдлэх нөхцлийг бүрдүүлж чадах юм. ХДХВ/ДОХ-ын талаарх хөтөлбөр, бодлого боловсруулах түвшинд өөрсдийн дуу хоолой, оролцоог бүрэн хангасны үндсэн дээр цаашид оршин тогтонох, тухайн өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах нөхцөл нь бүрдэнэ.

² Поддержка людей живущих с ВИЧ – “ИНФО-ПЛЮС” Москва, 2003

Эдгээрээс гадна эмэгтэйчүүд, хүүхдийн хувьд онцгой анхаарлыг хандуулахыг шаарддаг байна.

- **Эмэгтэйчүүд**

Эмэгтэйчүүд жендерийн тэгш бус байдал, соёлын заншил болон бусад нөхцлийн үр дүнд хүсээгүй болон хамгаалалтгүй бэлгийн харьцаанд орохоос татгалзаж, өөрийгөө хамгаалах чадваргүй байдаг нь тэднийг тухайн өвчинд өртөмтгий, эмзэг байдлыг нэмэгдүүлдэг. Жишээ нь: эмэгтэйчүүд нь санхүүгийн хараат бус байдлаас болж гэр бүлийн хүчирхийлэлд өртөх, биеэ үнэлэх зэрэг асуудлууд нь ХДХВ/ДОХ-ын хувьд өртөмтгий байдлыг бий болгодог.

Үүнээс гадна эмэгтэйчүүдийг хэнээс, яаж, хэрхэн уг өвчнийг авсаныг нь үл харгалзан **“завхай эмэгтэй”**, **“янхан”** зэрэг нэр хоч өгч нүд үзүүлэх, алагчилах явдал их байдаг.

Түүнчлэн мэдээллийн хомс байдлаас болж халдвар авсан эмэгтэйчүүдийн нөхөн үржих эрх нь ноцтойгоор хөндөгдөх асуудлууд их тохиолддог байна.

- **Хүүхэд**

Хүүхдийг наймаалах, хүүхдийг хүчээр бэлгийн харьцаанд оруулах, биеийг нь үнэлүүлэх, бэлгийн хүчирхийлэл зэрэг нь хүүхдийг тухайн өвчинд өртөмтгий, эмзэг болгодог байна.

Үүнд уламжлал, зан заншлын хүчин зүйлс ч хүчтэй нөлөөлдөг хэмээн шинжээчид үздэг. Хүүхдүүдэд бага балчир наснаас нь эрүүл мэнд, бэлгийн харьцаа, нөхөн үржихүй болон ХДХВ/ДОХ-ын талаар үнэн зөв, бодит мэдээлэл өгөх, боловсролын хөтөлбөрт тус сэдвүүдийг тусган сурталчилах нь хүүхдүүдийг ХДХВ халдвар болон ДОХ өвчинд өртөмтгийн, эмзэг байх эрсдлээс урьчдиглан сэргийлэх нэгэн арга зам юм.

Үүнээс гадна төр хүний эрхийг хамгаалах талаар нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенциор хүлээсэн үүргээ чандлан биелүүлж, баталгаажуулж байх ёстой.

ХДХВ-тэй холбоотой хүний эрхийг төрийн зүгээс хамгаалах, нийгмийн эрүүлийг хамгаалах салбарт тавигдсан зорилтуудад хүрэх олон арга зам бий. Хүний эрхийг хамгаалах ба эдгээр асуудлыг шийдвэрлэхэд төрийн үүрэг, оролцоог тодорхойлсон НҮБ-ын **“ХДХВ/ДОХ болон холбоо бүхий асуудлыг хууль зүйн үүднээс зохицуулах зөвлөмж”**-ийн удирдах зарчмуудын заримыг дурдавэл:

- Засгийн Газрын байгууллагын үйл ажиллагааны бүх үе шатанд ХДХВ/ДОХ-д хандах бодлого ба хөтөлбөрийг нэгтгэсэн үр ашиг бүхий үндсэн баазыг бий болгох.
- Нийтийн эрүүл мэндийн салбар дахь хууль тогтоомжийг өөрчлөх, шинэчлэхдээ ХДХВ/ДОХ-той холбоотой хүн амын эрүүл мэндийг хамгаалах асуудлыг цогцоор авч үзэх ба хүний эрхийн олон улсын стандартуудад нийцсэн хууль тогтоомжийг боловсруулах.

- Эрүүгийн хууль тогтоомж ба засан хүмүүжүүлэх байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулсан хуулийг олон улсын стандартуудад нийцүүлэх ба хүн амын эмзэг бүлгүүдийн эрх ашгийг дээд зэргээр харгалзан үзэх.
- Ялгаварлан гадуурхалтыг хориглосон хуулиудыг батлаж, үйлчилгээг нь хүчтэй болгох. Тэдгээр нь ХДХВ/ДОХ-аар халдварлсан ба өвчилсөн хүмүүсийг ялгаварлан гадуурхахаас хамгаалж, халдашгүй байх ба хувийн нууцыг хамгаалж ёс зүйн хэм хэмжээнүүдийг баримтласан байх.
- ХДХВ/ДОХ-аар өвчилсөн хүмүүст тэдгээрийн эрхийн талаар мэдээлэл өгч, эдгээр эрхийг хангахтай холбогдсон хууль зүйн үнэ төлбөргүй тусалцаа үзүүлэх нөхцлийг төрөөс хангах.

Түүнчлэн ХДХВ/ДОХ бүхий хүмүүсийг хувь хүний эрхийг нь хамгаалах, хангахад дараах арга замуудыг олон улсын практикт өргөн хэрэглэдэг байна. Үүнд:

1. Хариу нөлөө үзүүлэх.

ХДХВ/ДОХ-той хүмүүс нь уг өвчнийхөө муу үр дагаврын талаар байнга зовниж улмаар сэтгэлийн гутралд орж, ичиж зовж улмаар айдаст автагдаж, олон нийтийн дунд ялгаварлан гадуурхагдахын хэрээр эрх чөлөө нь ямагт хязгаарлагддаг байна. Үүнээс үүдэн эдгээр хүмүүс ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох, эмнэлгийн тусламж авах, улмаар гэр бүлийн амьдралаасаа ч татгалзах байдалд хүрдэг. Ойр орчинд нь ДОХ-той хүнээс халдвар авахаас болгоомжилсон хүрээлэл бий болдог учир ХДХВ/ДОХ-той хүн эрх ашгаа хамгаалуулах гэсэн бодол аажмаар үгүй болдог ажээ.

Ийм учраас ХДХВ/ДОХ-той хүмүүсийн эрхийг хамгаалах, ХДХВ/ДОХ-ын халдваргүй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудал аль нь нэгэн зэрэг тавигдах учиртай. Нэг үгээр хэлбэл, эрүүл хүмүүс нь өвчтэй хүмүүсээ тийнхүү өвчтэй гэдгээр нь адлахгүй байвал өвчний халдвар ахихгүйн зэрэгцээ өвчтэй, эмзэг байгаа хүн маань байнгын сэтгэл гутралд ороод байхгүй хариу нөлөө болж чадна.

2. Өртөмтгий нөхцөлийг сааруулах.

Хүмүүсийн материаллаг болон нийгэм, соёлын хувьд доогуур, хүнд нөхцөл нь ХДХВ/ДОХ-ыг үүсгэх сөрөг үр дагавартай гэдгийг тооцож, хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явагдах учиртай. Энэ өвчний халдвар ихээхэн тархалттай улс орнуудын байдлаас үзэхэд амьдралын түвшин доогуур, ядуу зүдүү эмэгтэйчүүд, хүүхдүүд, хар тамхи хэрэглэгчид, ижил хүйстэнтэйгээ явалдагчид, цагаач, дүрвэгсэд, шоронгийн хоригдлууд энэ өвчинд өртөх нь илүү байдаг.

Тиймээс эдгээр хүмүүст чиглэсэн сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх ажиллагааг идэвхжүүлэх нь чухал байна.

3. Чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх

Үндэсний хэмжээнд ДОХ-оос урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулж, үр дүнтэйгээр хэрэгжүүлэх шаардлагатай.

ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

**Г.Нарантуяа,
ХЭҮК-ын референт**

Олон улсын харилцааг зохицуулахад улс гүрнүүдийн хооронд байгуулсан гэрээний хэм хэмжээ чухал ач холбогдолтой бөгөөд олон улсын гэрээний давамгайлах байдал өнөө үед улам бүр өсөн нэмэгдэж байна. Олон улсын гэрээ, конвенц нь өөр хоорондоо харилцан адилгүй улс төр, нийгмийн бүтэц, соёл, түүхэн уламжлал, эдийн засгийн хөгжилтэй улс орнуудын харилцан зөвшилцөл, хэлэлцээ, буултын үр дүнд бий болдог учраас ийм гэрээний хэм хэмжээ бий болоход хэлэлцээнд оролцогч улс орнуудын бодлого, үндэсний эрх зүйн хэм хэмжээ чухал нөлөө үзүүлдэг.

Олон улсын гэрээг ном зохиол, эх сурвалжид маш олон янзаар тодорхойлжээ. Эдгээр олон төрлийн тодорхойлолтуудаас нэгтгэн дүгнэвэл олон улсын гэрээг *“тодорхой асуудлын талаар хоёр болон түүнээс дээш улс төрийн эрх бүхий этгээдийн хооронд хэлэлцэн тохиролцож, бичгээр үйлдсэн тохиролцоо”* хэмээн томъёолж болно. Зохицуулж буй харилцааныхаа шинж чанараас хамаараад олон улсын гэрээнүүдийн үндсэн нөхцөл, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих механизм, хүчин төгөлдөр болох болзол нөхцөл харилцан адилгүй байдаг. Харин ямар ч гэрээний хувьд оролцогч талуудын хүлээх нэг л үүрэг нийтлэг шинжтэй байдаг нь *“Pacta sunt servanda”* буюу гэрээ заавал биелэгдэх ёстой гэсэн зарчим билээ. Өөрөөр хэлбэл, аливаа гэрээг байгуулах, нэгдэн орох, үүрэг хүлээх эсэх нь гэрээнд оролцогч талуудын сонголт, хүсэл зоригийн хэрэг боловч нэгэнт л тухайн гэрээний нэг тал болсон бол гэрээгээр тогтоосон хэм хэмжээг биелүүлэх нь хууль зүйн үүрэг мөн. Гэрээний үүргээ биелүүлэхгүй байх нь оролцогч талын нэр хүндэд туйлын сөрөг нөлөөтэй. Ялангуяа олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, хойрго хандах нь аливаа улсын хувьд олон улсын тавцанд нэр хүндээ алдах, улмаар хөгжиж буй улс орнуудад олон улсын хамтын нийгэмлэгээс тусламж дэмжлэг үзүүлэхдээ олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг харгалзан үзэх шалгуур тавих болсон өнөө үед улс орон хөгжлийн чухал боломжоо алдах хүртэл үр дагавартай. Дээрх шалгуурт хүний эрхийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээний хэрэгжилт нь бусад төрлийн гэрээнийхээс илүүтэйгээр нөлөөлдөг байна. Ер нь аливаа улсын зөв хийгээд тулхтай хөгжихийн үндэс нь хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцид заасан жишиг хэм хэмжээг өөрийн орны практикт хэрэгжүүлэх, хөгжлийн аливаа бодлогод хүний эрхийн үүднээс хандаж, улс орноо хүний эрхийн мэдрэмжтэйгээр удирдаж байх явдал юм. Соёрхон батлаж, нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх нь аливаа улс орны хувьд хөгжлийн чиг хандлага хийгээд олон улсын нэр хүндийг тодорхойлоход чухал ач холбогдолтой учраас хүний эрхийн олон улсын гэрээг хэрэгжүүлэхэд анхаарах зарим зүйлийн талаар товч өгүүлье.

Хүний эрхийн салбарт олон улсын гэрээ байгуулах оролдлогыг 19-р зууны дунд үеэс эхлэн Европын улс орнууд хийж эхэлжээ. Эдгээр гэрээнүүд нь ихэвчлэн дайн, зэвсэгт мөргөлдөөний үед ард иргэд, олзлогсод, шархдагсадтай харьцах асуудлуудыг зохицуулж байлаа. Олон улсын Хөдөлмөрийн Байгууллага байгуулагдаж, 1919 онд Ажлын цагийн тухай конвенц, Ажилгүйдлийн эсрэг конвенц, Эхчүүдийг хамгаалах тухай конвенцийг батлан мөрдөж эхэлсэн нь хөдөлмөрлөх эрхийн салбарт олон улсын хамтын ажиллагааг бий болгох, хүний эрхийн энэ мэт асуудлыг тухайн улсын дотоодын л хэрэг гэж үзэх хандлага, сэтгэлгээг өөрчлөхөд ихээхэн хувь нэмэр оруулсан юм. Олон улсын түвшинд хүний эрхийн асуудлыг цогцоор нь гарган тавьж, салшгүй, жам ёсны шинжтэй хүний эрх, эрх чөлөөг хамгаалан баталгаажуулах зорилго бүхий олон улсын гэрээнүүдийг батлан гаргах явдал Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) байгуулагдсанаас хойш эрч хүчээ авсан билээ. Түүнчлэн хүний эрхийг хамгаалах бүс нутгийн механизм бий болж, тодорхой бүс нутагт хүний эрхийг хамгаалах талаар гэрээ, конвенцийг байгуулах болсон нь хүний эрхийн олон улсын гэрээний хөгжилд чухал нөлөө үзүүлсэн юм.

Хүний эрхийн салбарт байгуулагдсан олон улсын гэрээнүүд нь бусад төрлийн гэрээнүүдээс ялгагдах өвөрмөц онцлогтой байдаг. Юуны өмнө хүний эрхийн олон улсын гэрээнүүдийн эрхийн хэм хэмжээ тогтоосон заалтууд ихэвчлэн олон улсын олон талт гэрээ байгуулах замаар бий болдог нь бусад төрлийн гэрээнээс ялгагдах нэг онцлог юм. Өөрөөр хэлбэл, *“хүн бүр ... амьд явах эрхтэй”* гэсэн эрхийн хэм хэмжээг хоёр талт олон улсын гэрээгээр тогтоохгүй бөгөөд ийнхүү тогтоох нь ч ач холбогдолгүй юм. Хүний аливаа эрх түгээмэл шинж чанартай бөгөөд ийм түгээмэл шинжтэй хэм хэмжээг олон талт гэрээгээр баталгаажуулах нь зохистой билээ. Харин хүний эрхийн асуудлаар хоёр улсын хооронд байгуулсан гэрээ нь тодорхой эрхийг хангах, хамгаалах асуудлаар оролцогч улсуудын хамтран ажиллах арга, механизмийг тогтоож байдаг юм. Хүний эрхийн олон улсын гэрээний эрхийг тогтоосон хэм хэмжээ өөрөө биелэгдэх шинжгүй байдаг нь ийм төрлийн гэрээний өөр нэг онцлог мөн. Тухайлбал, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактын 1-р зүйлд заасан *“Бүх ард түмэн өөрөө засан тохинох эрхтэй”* гэсэн заалт нь тунхаглалын шинж чанартай бөгөөд аливаа улс орны практикт шууд өөрөө биелэгдэх боломжгүй билээ. Харин тус Пактын 28-р зүйлийн *“...Хүний эрхийн Хороог байгуулна. Хороо 18 гишүүнээс бүрдэх бөгөөд хойно заасан чиг үүргийг гүйцэтгэнэ.”* гэсэн заалт нь өөрөө биелэгдэх шинжтэй хэм хэмжээ юм. Тэгвэл өөрөө биелэгдэх боломжгүй заалтуудыг хэрхэн биелүүлвэл зохилтой вэ? Энд асуултнаас хүний эрхийн олон улсын гэрээг хэрэгжүүлэх бас нэг онцлог урган гарч ирж байгаа нь хүний эрхийн гэрээ, конвенцийг хэрэгжүүлэх улс орон бүрд таарсан *“нийтлэг жор”* байдаггүй явдал юм. Өөрөөр хэлбэл, хүний эрхийн олон улсын гэрээний тунхаглалын шинжтэй заалтуудыг улс орнууд аль болох уян хатан байдлаар нэг талаас өөрийн өвөрмөц онцлог, уламжлал, зан заншилдаа нийцүүлэн, нөгөө талаас хүний эрхийн үндсэн зарчмыг баримтлан хэрэгжүүлэх учиртай, тэгэх ч зайлшгүй шаардлагатай юм. Тухайлбал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын Пактын 11-р зүйлийн *“Хүн бүрийн болон түүний өрх гэрийн хүрэлцээтэй хоол хүнс, хувцас, орон сууцыг оролцуулан, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, амьдралынхаа нөхцлөө байнга сайжруулах эрхийг хүлээн зөвшөөрч, ...энэ эрхийн хэрэгжилтийг хангах зохистой арга хэмжээ авна”* гэсэн заалтыг хэрэгжүүлэхийн тулд улс орнууд тухайн улсын

хувьд амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх гэдгийг хэрхэн ойлгох стандартыг тогтоон, ард түмнийхээ хүрэлцээтэй түвшинд аж төрөх, амьдралын нөхцлөө байнга сайжруулах чиглэсэн бодлого, стратегийг боловсруулж, дэс дараатай арга хэмжээ авах учиртай. Ингэхдээ өөрийн улсын эдийн засгийн чадавхи, уламжлал зан заншил, түүнчлэн хүний эрхийн үндсэн зарчимд тулгуурласан байх шаардлагатай юм.

Улс орнууд хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцийн эрх тогтоосон хэм хэмжээг хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө тухайн гэрээ, конвенцийн дагуу шууд хүлээсэн үүргээ биелүүлэх шаардлагатай. Нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийнхоо заалттай үндэсний хууль тогтоомжоо нийцүүлэх, хэрэгжилтийг хангах бусад арга хэмжээ авах болон гэрээний хэрэгжилтийн тухай тайлан илтгэл бичих нийтлэг үүргүүдийг НҮБ-ын хүрээнд байгуулагдсан гол чухал гэрээ, конвенциудаар оролцогч улс орнууд хүлээсэн юм. Тэгвэл Монгол улсын хувьд олон улсын гэрээгээр хүлээсэн эдгээр тодорхой үүргүүдийг хэрхэн биелүүлж байгаа талаар авч үзэхэд:

- **Үндэсний хууль тогтоомжоо олон улсын гэрээнд нийцүүлж буй талаар:** Олон улсын гэрээг дотоодын хууль тогтоомжийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хууль тогтоомжийн заалттай зөрчилдсөн тохиолдол давамгайлах хүчин чадалтай байх тухай Үндсэн хууль болон бусад хуульд заасан төдийгөөр хэрэгжилтийг нь хангаж чадахгүй юм. Ялангуяа ихэнх тохиолдолд өөрөө биелэгдэх шинжгүй байдаг хүний эрхийн гэрээ, конвенцийн хувьд ийнхүү тунхагласнаар хэрэгжүүлнэ гэвэл боломжгүй. Харин Үндсэн хууль болон салбар хууль тогтоомжид гэрээ, конвенцид заасан эрхийн хэм хэмжээг бүрэн агуулгаар нь тусгаж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх эрх бүхий этгээдэд шууд үүрэг хүлээлгэх хууль зүйн арга хэмжээ авах нь зүйтэй. Манай улсын хувьд хүний эрхийн олон улсын гэрээ, конвенциудын заалтыг салбар хууль тогтоомждоо тусгах талаар тодорхой арга хэмжээ авч байгаа боловч бүрэн утга агуулгаар нь тусгасан, хэрэгжүүлэх бусад нөхцөл бололцоог бий болгож байгаа байдал хангалтгүй байна. Мөн хүний зарим эрхийн талаар хууль зүйн зохицуулалт хийхдээ хүний эрхийн үндсэн зарчимд нийцүүлээгүйгээс болж практик дээр хууль эс хэрэгжиж, эсвэл хүний эрх зөрчигдөхөд хүрч байна. Монгол улс 2000 онд нэгдэн орсон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид заасан эрүүдэн шүүсэн гэж тооцогдох үйлдлүүдийг, мөн 2002 онд нэгдэн орсон Ромын дүрэмд заасан 4 төрлийн гэмт хэргүүдийг бүрэн агуулгаар нь Эрүүгийн хуулинд тусгаагүй байгааг энд жишээ болгож болох юм. Энэ мэт олон заалт, хууль тогтоомжийг дурдаж болно. Олон улсын гэрээг хэрэгжүүлэх хууль зүйн арга хэмжээг бүрэн хэмжээгээр авахгүй байх нь тухайн гэрээ, конвенцийг хэрэгжүүлэх бололцоогүй болгодог төдийгүй олон улсын гэрээ конвенцийн ач холбогдлын талаарх олон нийтийн хандлагад сөргөөр нөлөөлдөг юм.
- **Хэрэгжилтийг хангах бусад арга хэмжээг авч байгаа талаар:** Хүний эрхийн олон улсын гэрээг хэрэгжүүлэх бусад арга хэмжээний хүрээнд эдийн засаг, нийгмийн шинжтэй олон төрлийн арга хэмжээний тухай ярьж болох боловч энд олон улсын гэрээг нийтэд мэдээлэх, гэрээний зүйл заалтыг тайлбарлах

зэрэг гарцаагүй авбал зохих нийтлэг шинжтэй арга хэмжээний талаар авч үзье. МУ-ын нэгдэн орсон олон улсын гэрээг тусгай эмхтгэл болгон хэвлүүлж байх талаар Олон улсын гэрээний тухай МУ-ын хуулийн 25-р зүйлд заасан байна. Төрийн албан ёсны хэвлэлд олон улсын гэрээг нийтлэх нь нэг талаас төрийн эрх бүхий байгууллагаас тухайн гэрээг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэн, нөгөө талаас агуулгыг нь нийтэд мэдээлэх зорилготой учир хууль зүйн хувьд чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн, олон улсын гэрээний орчуулга нь “Төрийн мэдээлэл” сэтгүүлд нийтлэгдэж байж албан ёсны болдог журамтай. 2004 онд УИХ-ын Тамгын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Гадаад хэргийн Яам, Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам хамтран МУ-ын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийг “Төрийн мэдээлэл” сэтгүүлд нийтлэх ажлыг эхлүүлсэн нь эдгээр, гэрээ конвенцийг практикт хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон юм. Одоогийн байдлаар “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2 эмхтгэл МУ-ын нэгдэн орсон 60 орчим гэрээ, конвенцийг түүвэрлэн нийтлээд байгаа бөгөөд цаашдаа өнөө хүртлэх хугацаанд МУ-ын байгуулсан 3000 шахам хоёр талт гэрээ, 180 орчим олон талт гэрээг уг сэтгүүлд нийтлэх нь чухал ач холбогдолтой болох юм. Тунхаглалын, түгээмэл шинжтэй хүний эрхийн олон улсын гэрээний заалтыг монгол хөрснөө буулгаж, тэдгээр гэрээг хэрэглэх нөхцөл бололцоог бий болгохын тулд Улсын Дээд Шүүхээс тухайн гэрээний зүйл заалтын талаарх албан ёсны тайлбарыг гаргах ажлыг эхлүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, халдашгүй дархан байх эрхтэй, тайван жагсаал цуглаан хийх эрхтэй, зохистой орон байраар хангагдах эрхтэй гэх мэт заалтуудыг шүүхэд хэрэглэхийн тулд халдашгүй дархан байх гэдэгт юуг хамруулан ойлгох, жагсаал цуглаан тайван байна гэдгийг ямар шалгуураар хэмжих хийгээд цаатны урц, монгол гэр, орчин үеийн хаус эсвэл нийтийн орон сууцын аль нь зохистой орон байр гэж үзэх талаар албан ёсны тайлбар гаргахгүйгээр эдгээр заалтуудыг шүүхэд хэрэглэхэд хүндрэлтэй юм. Нөгөө талаас олон улсын гэрээг шүүх, захиргааны практикт хэрэглэхийн тулд төрийн албан хаагчдыг сургах, давтан сургах явдал туйлын чухал байна.

- **Тайлан илтгэлтэй холбоотой үүргээ биелүүлж байгаа талаар:** НҮБ-ын хүрээнд байгуулагдсан хүний эрхийн гол зургаан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үүргийг тухайн гэрээний дагуу байгуулагдсан Хороонууд хүлээдэг. Түүнчлэн оролцогч улс орнууд тэдгээр гэрээнд тусгагдсан эрхүүдийг хэрэгжүүлэх талаар ямар арга хэмжээ авч байгаа тухай тайлан илтгэл боловсруулж Хороонуудад илгээх үүрэгтэй. Манай улсын хувьд тайлан илтгэл бичих үүргээ биелүүлж байгаа байдал туйлын хангалтгүй байна гэж хэлж болно. 2004 оны 4-р сарын байдлаар Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн ээлжит 16 дахь илтгэл 4 жил 4 сараар, 17 дахь илтгэл 2 жил 4 сараар, 18 дахь илтгэл 4 сараар, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын ээлжит 5 дахь илтгэл 1 жил 10 сараар, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын ээлжит 4 дэх илтгэл 1 жил 7 сараар Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн ээлжит 5 дахь илтгэл 6 жил 4

сараар, 6 дахь илтгэл 2 жил 4 сараар, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн ээлжит 3 дахь илтгэл 2 жил 4 сараар, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн анхдугаар илтгэл 11 сараар тус тус хоцорч, Хороонуудад хүргэгдээгүй байна. Гэрээний хэрэгжилтийн талаарх тайлан илтгэлээ тогтоосон хугацааны дотор хүргүүлэхгүй байх нь олон улсын хэмжээнд МУ-ын нэр хүнд унахад нөлөөлөөд зогсохгүй Хорооноос ирүүлж буй санал зөвлөмж учир утгаа алдах, хий дэмий хөрөнгө хүч тарамдахад хүрдэг. Учир нь конвенцийн Хороонууд тайлан илтгэлүүдийг улс орнуудаас ирүүлсэн дарааллын дагуу хянан хэлэлцдэг журамтай бөгөөд хугацаа хожимдож ирүүлсэн илтгэл мөн нь нэлээд хугацааны дараа Хороогоор хянан хэлэлцэгдэх юм. Ийнхүү хожим хэлэлцэгдэн, Хорооны санал, зөвлөмж тухайн улсад хүргэгдэх үеэд тайлан илтгэлд дурдагдсан нөхцөл байдал өөрчлөгдсөн, зөвлөмжид заасан арга хэмжээ ямар ч утга холбогдолгүй болсон байх явдал тохиолдож болно. Энэ нь тухайн улсын хувьд асуудлаа шийдвэрлүүлэхэд гадаад тусламж дэмжлэг авах боломжийг хааж, Хорооны хувьд хий дэмий цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулсан, үр дүнгүй ажил болох уршигтай билээ. Нөгөө талаас Засгийн газар Хороонуудад илгээх тайлан илтгэлийг бичихдээ анхааралтай, аль болох бодитойгоор хандах шаардлагатай байна. Өнгөрсөн хугацаанд конвенцийн Хороонуудад манай улсаас илгээж байсан илтгэлүүдэд ихэвчлэн тухайн гэрээг хэрэгжүүлэх хүрээнд авсан хууль зүйн арга хэмжээнийхээ талаар дурдсан боловч эдгээр заалтууд практикт хэрхэн хэрэгжиж байгаа талаар төдийлөн хөндөөгүй байсан нь ажиглагдаж байна¹.

Манай улс нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээ, конвенциудынхаа дагуу хүлээсэн үүргээ биелүүлж байгаа байдал хангалтгүй байгаа бөгөөд цаашид энэ талаар нэлээд зүйлийг хийх шаардлагатай байгаа юм. Өөр нэг зүйлийг нэмж хэлэхэд 1993 онд батлагдсан МУ-ын Олон улсын гэрээний тухай хуулийн 20-р зүйлд олон улсын гэрээний хэрэгжилтэд УИХ болон Засгийн газар хяналт тавихаар заасан бөгөөд зохицуулж буй асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу агенлагийн дарга олон улсын гэрээний биелэлтийг гаргаж жил бүрийн 6, 12-р сарын 20-ны дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон улсын гэрээний биелэлтийг явцыг нэгтгэн дүгнэж шаардлагатай тохиолдолд саналаа Засгийн газарт оруулахаар заасан байдаг. Хуулийн энэ заалт хэдийгээр олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих дотоодын механизмийг бий болгож байгаагаараа чухал боловч хэрхэн хэрэгжиж байгаа нь тодорхой бус байдаг юм. Иймээс холбогдох байгууллага, албан тушаалтнууд Олон улсын гэрээний тухай хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх талаар анхаарал тавьж, авсан арга хэмжээнийхээ талаар олон нийтэд мэдээлж занших нь МУ-ын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийг хангахад нэн ач холбогдолтой билээ.

¹ 2004 онд ХЭҮК-оос эмхтгэн гаргасан “Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх МУ-ын ээлжит илтгэлүүд, НУБ-ын холбогдох хороодын хуралааны тэмдэглэл, зөвлөмжүүдийн эмхтгэл” товхимолоос үзнэ үү.

ХУУЛЬ ТОГТООМЖ БА ХҮНИЙ ЭРХ

Д.Баянбилэг,
Монголын хүний эрхийн төв

*“...Хүмүүс үгээ хэлэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөтэй,
түүнчлэн айх аюулгүй, гачигдах зовлонгүй дэлхий ертөнцийг
бий болгох нь хүн ардын эрхэм дээд эрмэлзэл мөн...”*

*“...Хүмүүс эзэрхэг засаглал, дарлалын эсрэг өөрийн эрхгүй
эссийн арга болгон зэвсэглэн босоход хүргэхгүйн тулд
хүний эрхийг хуулиар хамгаалах нь зайлшгүй чухал...”*

/Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948 он, Удиртгал хэсгээс/

1941 оны 1 дүгээр сард АНУ-ын Ерөнхийлөгч асан Франклин Делано Рузвельт “...Дэлхий дахинд энх тайван тогтоохын тулд “Дөрвөн гол эрх чөлөө” буюу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, гачигдах зовлонгүй, айх аюулгүй байх эрх чөлөө хангагдсан байх ёстой...” гэж хэлсэн нь дайнаас сэрэмжлэх, НҮБ-ыг бий болгох, хүний эрхийг дэмжин дэлгэрүүлэх үйлсэд онцгой түлхэц өгсөн төдийгүй тэдгээр эрх чөлөө нь чөлөөт бие хүний эрхэм зорилго, туйлын хүслэн болж Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын удиртгал хэсэгт тодорхойлогдсон байна.

Дэлхийн улс орнуудын дотоод бодлогын нийтлэг чиг хандлага нь 1990-ээд он хүртэл нэгдүгээрт- улс орны эрх ашиг, хоёрдугаарт- байгууллагын сонирхол, гуравдугаарт- хувь хүний хэрэгцээний асуудал байсан бол одоо хүний эрх, эрх чөлөө /зөвхөн хүний хэрэгцээ гэдгээр явцуу тодорхойлж болохгүй/-ний асуудал эхэнд нь тавигдах боллоо. Энэ нь ч Монгол Улсын 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулийн “иргэний” эрхийн, 1992 оны шинэ Үндсэн хуульд тодорхойлсон хүний эрх, эрх чөлөөний талаархи заалтыг харьцуулан үзэхэд тодорхой ажиглагдана.

Монгол Улсын арван дөрөвдүгээр он буюу 1924 онд Улсын Их Хурал анх удаа хуралдаж, Монгол Улсын анхны Үндсэн хуулийг баталсан билээ. Энэ Үндсэн хуулиар өөрөө хүчнийг үнэлэх буюу хувийн аж хийж амьдрагчид, ардын хувьсгалт цэрэг болох “жинхэнэ ард”-ын шүтэх, итгэх явдал; элдэв хэргийг шүүмжлэн хэлэлцэх; хэвлэн нийтлэх; нийтээр хуралдах; цэнгэлдэх, баяр ёслол үйлдэх; эвлэл, хоршоо байгуулах; элдэв ухааны эрдэмд бүрнээ үнэ төлбөргүйгээр боловсрох; сонгох, сонгогдох; эрэгтэй, эмэгтэй ялгаваргүй эрх, эрх чөлөөтэйг илтгэн тунхагласан.

“Жинхэнэ ард”-ын эрх, эрх чөлөөгөө эдлэхийг дээр дурдсанчлан зөвхөн 1924 оноос эрх зүйн баримт бичгээр баталгаажуулж эхэлсэн гэж ойлгож болохгүй юм. 1921 онд Ардын хувьсгал ялсны дараахнаас буюу Засгийн газраас мөн оны

8 дугаар сард бага сургууль, Европ эмнэлэг байгуулах, 9 дүгээр сард хүнд харгис эрүү шүүлт хэрэглэхийг зогсоох шийдвэр гаргаж байжээ.

Монголын анхдугаар Үндсэн хуульд хүний эрхийн асуудлыг хүний болон иргэний эрхийн талаар 1789 онд баталсан Францын тунхаглалыг үндэслэн тухайн үеийн Европт тогтсон Үндсэн хуульд ёсны соёл иргэншлийн түвшинд Монгол оронд эрт дээр үеэс уламжлан ирсэн хүний эрхийн үүрэгт тулгуурласан соёлд нийцүүлэн хуульчилсанд түүний соён гэгээрүүлэх ач холбогдол оршино. /Г.Совд, Монгол Улсын Үндсэн хууль-Хүний эрх, 1999 он, х-10/

1940 онд батлагдсан Үндсэн хуулиар “малчид, ажилчид, сэхээтэн” хөдөлмөрчдийн амин хувьдаа өмчтэй байх, өмч өвлөх; амрах; үнэ төлбөргүй боловсрох; эдийн тусламж авах; эмнэлэгт үнэ төлбөргүй үзүүлэх; угсаа үндэстэн ялгаварлалгүйгээр тэгш эрх эдлэх; эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй байх; шашин шүтэх, эс шүтэх; эвлэлдэн нэгдэх; өргөдөл гомдол гаргах; биеэр чөлөөтэй шилжин явах ба оршин суух газраа шилэн сонгох; чөлөөтэйгээр саналаа хэлэх, хэвлэн нийтлэх; хурал цуглаан, гудамжны жагсаал ёслол хийх; иргэний бие, орон байр, захидал харилцааны нууцын халдашгүй эрх, эрх чөлөөг тунхаглажээ. Улсын 9 дүгээр Их Хурал/1949 он/-аас Үндсэн хуульд олон шаттай ил сонгуулийн системээс нууцаар санал хураах, шууд сонгуульд шилжих тухай нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Социализмыг төгөлдөр байгуулж, цаашид коммунист нийгэм байгуулах зорилго тавьсан ажилчид, хоршоолсон ард /малчид, тариаланчид/ хөдөлмөрийн сэхээтний Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 1960 оны Үндсэн хуульд өмнөх Үндсэн хуульд зааснаас гадна өмгөөлүүлэх; төрийн аль ч байгууллагад сонгох, сонгогдох; арьс үндсээр ялгаварлагдахгүй байх зэрэг иргэний эрх, эрх чөлөөтэйг тодорхойлон заасан байдаг.

1940, 1960 оны Үндсэн хуулиудаар иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөг тунхагласан боловч тэдгээрээс ялангуяа хүний хувийн болон улс төрийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх зохион байгуулалт, улс төр, хууль зүйн бодит баталгаа байгаагүй юм. /С.Төмөр, “Монгол Улсын Үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөөний талаархи үзэл баримтлал, агуулга” илтгэл, “Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал” семинар, 1997 он/

Түүхэн баримт нь хэдийгээр эдгээр Үндсэн хуульд зөвхөн “анги”-ийн ба иргэний харьяалаар нь хүний эрх, эрх чөлөөг ялгавартай эдлүүлэхээр тогтоож байсан ч нөгөө талаар түүнийг хамгаалах асуудлын хөгжил, дэвшлийн замналыг, урагшилсан алхмыг илэрхийлж байгаа юм.

1992 онд Монголын ард түмэн эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлон хөгжүүлэхийг эрхэм зорилго болгон зарлан тунхагласан Үндсэн хуулиар анх удаагаа хүний эрх, эрх чөлөөг зохих ёсоор баталгаажуулсан билээ.

Монгол Улсын Үндсэн хууль бүтцийн хувьд 6 бүлэг, 70 зүйлтэй.

Үндсэн хуулийн бүлэг бүрт, нийтдээ 35 зүйлд хүний эрх, эрх чөлөөний талаар өөрөөр хэлбэл иргэний эрх, үүрэг, төрийн засаглалын эрх мэдлийн байгууллагаас хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах талаархи зарчим, эрх хэмжээ, үүрэг, хязгаарлалт хийх эрх зүйн эх үндсийг :

Нэгдүгээр бүлэг /Монгол Улсын бүрэн эрхт байдал/-т: Нэгдүгээр зүйлийн 2; Гуравдугаар зүйлийн 1; Тавдугаар зүйлийн 2, 3, 4; Зургадугаар зүйл; Долдугаар зүйл; Наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг;

Хоёрдугаар бүлэг /Хүний эрх, эрх чөлөө/-т: Арван таваас Арван есдүгээр зүйл;

Гуравдугаар бүлэг /Монгол Улсын төрийн байгуулал/-т: Нэг /Монгол Улсын Их Хурал/-т. Хорин нэгдүгээр зүйлийн 2, 3; Хорин гуравдугаар зүйлийн 1; Хорин тавдугаар зүйлийн 1.14, 1.16, 1.17, 1.18; Хорин тавдугаар зүйлийн 2, 3; Хорин зургадугаар зүйлийн 2; Хоёр /Монгол Улсын Ерөнхийлөгч/-т. Гучаас Гучин гуравдугаар зүйлийн 1.8, 1.9, 1.11, 1.12; Гурав /Монгол Улсын Засгийн газар/-т. Гучин наймдугаар зүйлийн 2.4, 2.7; Дөчин зургадугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг; Дөрөв /Шүүх эрх мэдэл/-т. Дөчин есдүгээр зүйлийн 2; Тавьдугаар зүйлийн 1.3; Тавин нэгдүгээр зүйлийн 3; Тавин хоёрдугаар зүйлийн 2; Тавин гуравдугаар зүйлийн 2; Тавин тавдугаар зүйл; Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг;

Дөрөвдүгээр бүлэг /Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага/-т: Тавин долдугаар зүйлийн 3; жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг;

Тавдугаар бүлэг / Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц/-т: Жаран тавдугаар зүйлийн 2; Жаран зургадугаар зүйлийн 1; Жаран зургадугаар зүйлийн 2.2;

Зургадугаар бүлэг /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлт/-т: Жаран наймдугаар зүйлийн 2; Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсон байна.

Олон улсын болон дотоодын эрх зүйн баримт бичигт хүн ямар эрх, эрх чөлөөтэйг утга санаа, томъёоллоор нь нарийвчлан үзвэл Хүний эрхийн түгээмэл Тунхаглалд 25 хэсэгт, мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэгт 21 хэсэгт тус бүр хүний 80-аад эрх, эрх чөлөөг тодорхойлсон байна. Жишээ нь: Хүний эрхийн түгээмэл Тунхаглалын арван гуравдугаар зүйлд чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох, эх орноо орхин явах, эх орондоо эргэж очих гэсэн 4 эрхийг, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 8-д соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх, эрхээ хуулиар хамгаалуулах гэсэн хүний 4 эрхийг тодорхойлжээ.

Үндсэн хуульд тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хамрах хүрээ, салбараар нь 1/улс төрийн, 2/хувийн, 3/эдийн засгийн, 4/нийгэм-соёлын, 5/эрүүл, аюулгүй орчинд амьдрах буюу экологийн гэж ангилж болох юм.

Гэхдээ хүний тухайн эрх, эрх чөлөөг шууд л дээр дурдсан салбарын аль нэгд нь орно гэж ойлгож болохгүй, зарим нь давхардан орж болно.

Жишээ нь: Амьд явах эрх нь хувийн эрхийн салбарт орох боловч, нөгөө талаар аюулгүй орчинд амьдрах талаасаа экологийн, эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй холбогдвол нийгмийн салбарт дам хамрагдаж болно.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Монгол Улсын Үндсэн хууль болон дотоодын бусад холбогдох хууль тогтоомжоор баталгаажсан хүний ба иргэний улс төрийн эрх, эрх чөлөөг хүн дангаараа эдлэхээс гадна хэсэг бүлгээрээ хамтарч /нам, олон нийтийн байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал, цуглаан хийх/, мөн заримыг нь зөвхөн Монгол Улсын иргэн дангаараа эдэлдэг /төрийн байгууллагад сонгох, сонгогдох, төрийн зарим албан тушаал эрхлэх тухайлбал, захиргааны албан тушаал/ нь түүний бусад эрх, эрх чөлөөнөөс ялгагдах онцлог юм.

Мөн эдийн засаг, нийгэм-соёлын, экологийн эрх нь төрийн бодлого, улс орны эдийн засгийн чадавхиас ихээр, шууд хамааралтай бол улс төрийн болон иргэний хувийн эрх нь тийм биш, түүнчлэн тэдний зарим нь салшгүй, төрөлхийн, хязгаарлаж болохооргүй /амьд явах, халдашгүй чөлөөтэй байх, итгэл үнэмшилтэй байх/ байдаг.

Өнөөгийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа 290-ээд хуулийн 140 гаруйд хүний эрх, эрх чөлөө, иргэний эрх, үүрэг болон түүнийг хамгаалах, хангах төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг тогтоосон хууль байна.

Монгол Улсын Үндсэн хууль /1992/-ийн ололтууд нь алс хэтийн бий болох нөхцөл байдлыг урьдчлан харж, тодорхойлсон явдал юм.

Тухайлбал, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх /Зургадугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг/, захиргааны шүүн таслах ажлын төрлөөр дагнасан шүүх байгуулах /Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг/ зэргийг дурдаж болно.

Өөрөөр хэлбэл, өнөөдөр биеллээ олж байгаа шинэ зүйл, шинэ үзэгдлийг 10 гаруй жилийн тэртээгээс урьдчилан харж чаджээ.

2002 онд Захиргааны шүүх байгуулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг Улсын Их Хурлаас баталсан нь нийгмийн нэгэн шинэ, “хүсүүштэй” үзэгдлийн эрх зүйн үндэсийг бэхжүүлсэн, хүний эрх, эрх чөлөөний хамгаалалтын нэгэн шинэ механизмын “хөдөлгүүр”-ийг ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж өгсөн юм.

Шүүх эрх мэдлийн байгууллага нь хэрэг хянан шийдвэрлэх, шүүхийн хяналт тавих үндсэн үүрэгтэй байдаг. Тэгвэл эдгээр нь 1/Үндсэн хуульт ёсны хэм хэмжээ, түүнд нийцсэн эрх зүйн актыг мөрдлөг болгох, 2/хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагын тэнцвэртэй байдлыг хадгалах, 3/төрийн албадлагын арга хэмжээг хэрэглэх, 4/хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, шаардлагыг хангахад чиглэгддэг.

Захиргааны хэргийн шүүх нь захиргааны хууль бус шийдвэр, үйл ажиллагааг хүчингүй болгож, эрхээ хангуулахаар иргэд, хуулийн этгээдийн гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр “захиргааны хэрэг”-ийг хянан шийдвэрлэх замаар төрийн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд хүний субъектив эрхийг хамгаалж, шүүхийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх юм.¹

Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд тавих захиргааны хэргийн шүүхийн хяналтын зорилго нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээгээр баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг /зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээх/ хамгаалах; захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, хуульд нийцүүлэн засч залруулахад оршиж байдаг.

Явцуу утгаар хэлбэл энэ хяналт нь захиргааны байгууллагын үйл ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих зорилготой юм.

Захиргааны хэргийн шүүхээс захиргааны байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтын ажиллагаа нь иргэн, хуулийн этгээдийн нэхэмжлэлийг хүлээн авсан үеэс эхэлнэ.

Шүүх аливаа /захиргааны тодорхой/ хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих ёстой.

Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, хэрэг гарах үед хүчин төгөлдөр болсон, албан ёсоор нийтлэгдсэн бусад хуулийг хэрэглэдэг.

Тодотгол

Улсын Их Хурлын тухайн шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхтгэлд албан ёсоор нийтэлнэ. /“Монгол улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол, 2001 он, дугаар 61, заалт 26.6, 26.7/

2005 оны 7 дугаар сарын байдлаар Монгол Улсад 290-ээд хууль, 180-аад Монгол Улсын олон улсын гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байна.

Монгол Улсын олон улсын гэрээг 2005 оноос “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн тусгай дугаар болгон албан ёсоор цувралаар нийтэлж эхэлж байгаа бөгөөд хүний эрх, эрх чөлөөний холбогдолтой 43 гэрээг эхний тусгай дугаарт нийтэлсэн билээ. Энэ нь шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхэд хуулиас гадна Монгол Улсын олон улсын гэрээг анх удаагаа хэрэглэх өргөн бололцоог олгож байгаа юм.

Захиргааны хэргийн шүүх нь хэрэгт холбогдох хуулийн заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэхдээ Үндсэн хуулиас бусад хуулийг тайлбарласан Улсын дээд шүүхээс гаргасан албан ёсны тайлбарыг дагаж мөрдөх ёстой. Харин Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж мөрдөхийг Шүүхийн тухай хуульд тодорхой заасан байдаг.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1-д захиргааны тодорхой байгууллага, албан тушаалтны гаргасан захиргааны хууль бус актад холбогдох маргааныг захиргааны хэргийн шүүхээс хянан шийдвэрлэхээр хуульчилсан. Энэ жагсаалтад Монгол Улсын Засгийн газар орсон байсан.

Гэвч Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс захиргааны хэргийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хэргийн оролцогч /хариуцагч/-ийн жагсаалтаас Засгийн газрыг хассан шийдвэр гаргасан.

Засгийн газар нь Улсын Их Хурлаас хуулиар тусгайлан эрх олгосон нөхцөлд хуульд нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрхийн зүйн акт гаргаж болохыг Засгийн газрын тухай хуульд заасан. Үүний дагуу Монгол Улсын Засгийн газар 1992 оноос 2005 оны 7 дугаар сарын байдлаар нийт 3291 тогтоол гаргасан байна. /Хүснэгт №1/

¹ Б.Чимид “Шүүх эрх мэдлийн талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд” илтгэл, “Шүүх эрх мэдэл-Шинэ зуун” олон улсын онол практикийн бага хурлын эмхтгэл, 2001 он, 49 дэх тал

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС БАТАЛСАН ТОГТООЛЫН ТОО

/Хүснэгт №1/

Д/д	Он	Баталсан ЗГТ-ын
1.	1992	121
2.	1993	198
3.	1994	231
4.	1995	243
5.	1996	329
6.	1997	259
7.	1998	239
8.	1999	239
9.	2000	203
10.	2001	288
11.	2002	274
12.	2003	277
13.	2004	250
14.	2005 оны 7 дугаар сар	140
	Нийт	3291

Нөгөө талаар Засгийн газар нь Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэж заасныг үндэслэн хуулийн биеэлтийг зохион байгуулж, хангах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх бүрэн эрхийнхээ хүрээнд 1992 оны 1 дүгээр сараас 2005 оны 5 дугаар сар хүртэл Засгийн газрын 800 тогтоолоор Монгол Улсын Засгийн газар /БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл/-ын зарим тогтоол (тогтоолын зүйл, заалт)-ыг хүчингүй болсонд тооцжээ.

Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 1997, 2002, 2003 онд батлагдсан 5 тогтоолоор 1943-1999 оны хооронд батлагдсан Сайд нарын Зөвлөл /хуучин нэрээр/, Засгийн газрын ач холбогдлоо алдсан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн 803 тогтоолыг хүчингүй болсонд тооцсон байна. /Хүснэгт №2/

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР /БНМАУ-ЫН САЙД НАРЫН ЗӨВЛӨЛ/-ЫН
ЗАРИМ ТОГТООЛ (ТОГТООЛЫН ЗҮЙЛ, ЗААЛТ)-ЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦСОН ТОО**

/Хүснэгт №2/

Д/д	Засгийн газрын тогтоол баталсан огноо, дугаар	Хүчингүй болсонд тооцсон ЗГТ-ын тоо	Хамаарах он
1.	1997 оны 12 дугаар сарын 3-ны өдөр, Дугаар 66	9	1963-1993
2.	2002 оны 2 дугаар сарын 27-ны өдөр, Дугаар 30	34	1968-1997
3.	2002 оны 12 дугаар сарын 25-ны өдөр, Дугаар 266	136	1943-1990
4.	2003 оны 12 дугаар сарын 17-ны өдөр, Дугаар 256	118	1991-1999
5.	2003 оны 12 дугаар сарын 31-ний өдөр, Дугаар 274	506	1962-1995
	НИЙТ	803	1943-1999

Улсын Их Хурлаас Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн болон тодорхой хүрээний ажил эрхлэх яам болон төрийн захиргааны бусад байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг баталдаг /Хүснэгт №3/.

МОНГОЛ УЛСЫН ЯАМ, ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ТОО
/Хүснэгт №3/

Д/д	Он	Яам	Засгийн газрын агентлагийн тоо
1.	1990-1992	11 + Улсын хороо 1	-
2.	1992-1996	16	-
3.	1996-2000	9	56
4.	2000-2004	11	47-оос 42
5.	2004 оноос	13	36

Захиргааны хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хэргийн оролцогч /хариуцагч/ болж болох тэдгээр яам /сайд/, агентлаг /хуучнаар тусгай газар/ нь эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн нийтээр дагаж мөрдүүлэхээр хэм хэмжээ тогтоосон актыг батлан гаргаж, биелэлтийг хангадаг.

Түүнчлэн шүүх нь захиргааны акт нь хүчин төгөлдөр мөн үү, улсын бүртгэлд бүртгэгдсэн байна уу гэдэгт хяналт тавих нь хүний эрх, эрх чөлөөг төрийн байгууллага, албан тушаалтнаас зөрчсөн тохиолдолд учирсан хохирлыг арилгах, нөхөн төлүүлэх нэг хэрэгсэл болох ёстой юм. /Хүснэгт №4/

Учир нь захиргааны байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан акт нь Засгийн газрын 2003 оны 8 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн даргын нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг хянаж, бүртгэх журам”-ын дагуу хянагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэн байх ёстой бөгөөд хэрвээ акт нь улсын бүртгэлд бүртгэгдээгүй, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэгдээгүй л бол хүчин төгөлдөр биш гэж тооцогдоно.

МОНГОЛ УЛСЫН САЙД, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ДАРГЫН НИЙТЭЭР ДАГАЖ МӨРДҮҮЛЭХЭЭР ГАРГАСАН ШИЙДВЭРИЙГ ХЯНАЖ, УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭСЭН ЖАГСААЛТ

/Хүснэгт №4/

№	Он	Улсын бүртгэлийн дугаар	Улсын бүртгэлд бүртгэгдсэн актын тоо
1.	1991	1-228	228
2.	1992	229-447	219
3.	1993	448-604	157
4.	1994	605-746	142
5.	1995	747-841	95
6.	1996	842-928	87

7.	1997	929-1123	195
8.	1998	1124-1339	216
9.	1999	1340-1502	163
10.	2000	1503-1681	179
11.	2001	1682-1799	118
12.	2002	1800-1944	145
13.	2003	1945-2351	407
14.	2004	2352-2497	146
15.	2005 (1.1-8.20)	2498-2548	51
Нийт			2548

Нөгөө талаар эрх зүйн акт нь дурдсан журмын дагуу хянагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэн боловч хууль бус нь шүүхээс тогтоогдвол түүнийг улсын бүртгэлд бүртгэсэн шийдвэрийг хүчингүй болгох, улсын бүртгэлээс хасах арга хэмжээ авахыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгахаар шүүхээс шийдвэрлэж болно.

Харин гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл аль ч захиргааны байгууллагыг, албан тушаалтан хэнийг ч хууль бус үйл ажиллагаа явуулсан гэж гэм буруутайд тооцож үл болно.

Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажлын нэгдсэн дүнгийн статистик мэдээгээр 2004 онд захиргааны хэргийн шүүхүүд 516 нэхэмжлэл, өргөдөл хүлээн авч, 337-г нь харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх буюу захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг хангуулахаар нэхэмжлэгчид нь буцааж, нийт нэхэмжлэлийн 28.1 хувь буюу 145 хэргийг шийдвэрлэсэн байна. Харин 2005 оны эхний хагас жилд 411 нэхэмжлэл, өргөдөл хүлээн авч, 37.2 хувь буюу 153 нэхэмжлэлийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх буюу захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг хангуулахаах нэхэмжлэгчид нь буцааж, нийт нэхэмжлэлийн 49.4 хувь буюу 203 хэргийг шийдвэрлэсэн байна.

Захиргааны хэргийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр/акт/-ийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа уг хэрэгт холбогдох иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага заавал биелүүлүүлэх үүрэгтэй юм.

ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА

Ч.Алтангэрэл

Боловсролын Их сургуулийн багш, Магистр

Өмнөх үг:

Аливаа хөгжлийн бодлогыг хүний эрхийн үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн тодорхойлох, хэрэгжүүлэх ба үнэлэх хандлага НҮБ болоод түүний системийн байгууллагууд, олон улсын төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, хөгжлийн хөтөлбөрүүдийн нэгэн зайлшгүй элемент болсон билээ. Орчин үеийн хөгжлийн тухай ярихад харьцангуй шинэ энэ үзэл баримтлалыг “эрхэд суурилан хөгжих хандлага” хэмээх томъёоллыг түлхүү ярих болов. Шинээр бүрэлдэн тогтож буй энэхүү дэвшилтэт үзэл санааны үндсэн зарчим, хандлагыг танилцуулж, улмаар Монгол улсын төрийн бодлого, хөгжлийн тухай үзэл баримтлалд хэрхэн туслаж, өөриймшиж буй байдлыг тодорхойлох зорилгоор энэхүү өгүүллийг бичсэн болно.

Эрхэд суурилсан хөгжлийн хандлага гэж юу вэ?:

Шинэ мянганы эхлэлийг зарлан тунхаглаж, цаашдын хөгжлийн хэтийн төлөвөө тодорхойлж байсан тэр үеэс хойш даруй 5 жил өнгөрч дуулиан шуугиан багасаж эхлэв. Гэсэн хэдий боловч энэ XXI зууны хөгжлийн хандлага ямар байх, бид ямар ертөнцөд амьдарч хэрхэн хөгжиж дэвших хийгээд өөрчлөгдөн шинэчлэгдэхийн тухай асуултууд хамгийн их сонирхлыг татаж байна. Дэлхий нийт, ялангуяа судалгаа шинжилгээний хүрээнийхэн энэхүү асуултуудад хариулт өгч өнөө ба ирээдүйн хөгжлийн дүр төрхийг урьдчилан зураглахыг оролдсоор байна. Эдгээр нь эдийн засгийн, улс төрийн, олон улсын харилцааны, соёлын зэрэг бүхий л давхарга, бүрэлдэхүүн хэсгүүдэд задран асар өргөн цар хүрээг хамрах тул тэр бүхэн нэгтгэн дүгнэх нь нэн бэрх болох нь маргаангүй.

Ерөөс аливаа хөгжлийн асуудлууд нь олон талтай, зорилго чиглэл хийгээд хүлээж буй үр дүн, үзүүлж буй үр нөлөө гээд харгалзан үзэх олон өнцөгтэй байдаг. Түүний нэгэн салаа мөчир нь хүний эрхийн өнцгөөс хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх ба үнэлэх тухай асуудал юм. Өөрөөр хэлбэл, хүний эрхийн шалгуураар нийгмийн үйл явц хэрхэн өөрчлөгдөж, ямар хөтөлбөрөөр хөгжиж байгааг тодорхойлохын тулд “Эрхэд суурилсан хөгжлийн хандлага” хэмээх үзэл баримтлалыг дэлхий нийт боловсруулжээ.

“Эрхэд суурилсан хөгжлийн хандлага” нь өнөө цагийн дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа боловч уг үзэл санаа нь цоо шинэ зүйл биш гэж үздэг. Өөрөөр хэлбэл энэхүү “эрхэд тулгуурлан хөгжих хандлага”-ыг цогц ойлголт, бодлогын түвшинд хэрэгжүүлж байгаагүй боловч түүний агуулга, зарим хэсэг элементүүд нь тодорхой үйл ажиллагаа, хөтөлбөрүүдээр дамжин боловсрогдож

мөн шалгагдаж иржээ. Тухайлбал, НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо, Хүүхдийн Сан, Хөгжлийн Хөтөлбөр, Хүний Эрхийн Дээд Комиссиарын газар болон бусад олон улсын байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг хүний эрхийн зарчим, стандартад нийцүүлэх чиглэлээр тодорхой санаачлагууд гарган ажиллаж иржээ. Эдгээр санаачлагууд нь эрхэд суурилсан хөгжлийн үзэл баримтлал төлөвшин хөгжихөд зохих үүргийг гүйцэтгэсэн байна.

Эрхэд суурилсан хөгжлийн хандлага нь хүний эрхийг хангах, хамгаалах зорилго бүхий олон улсын хүний эрхийн стандартад нийцсэн хүний хөгжлийн үйл явцын тухай үзэл баримтлал юм. өөрөөр хэлбэл, олон улсын хүний эрхийн зарчим, хэм хэмжээ, стандартуудыг аливаа хөгжлийн үйл ажиллагааны бодлого, төлөвлөлт, үйл явцад нэгтгэн оруулах байдлыг “Эрхэд суурилсан хөгжих хандлага” хэмээн ойлгодог байна.

НҮБ-аас баталсан “Хөгжих эрхийн тухай тунхаглал”-д зааснаар “хөгжил гэдэг нь нийт иргэд, хувь хүмүүсийн идэвхтэй, чөлөөт оролцоонд үндэслэн гарч буй үр ашгийг шударгаар хуваарилах, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм соёлын цогц үйл явц мөн¹” хэмээн тодорхойлсон байна. Хүний эрх болон хөгжлийн үйл явц хоёр нь маш олон талт харилцаагаар холбогддог. Ялангуяа хөгжил нь хүний эрхийн үзэл санаа, эрх чөлөөт байдал дээр үндэслэх ба эргээд түүнийг түгээн дэлгэрүүлэх, хангах хамгаалах үндэс суурь болж өгдөг. Хүний эрх болон хөгжлийн үйл явцын хоорондын хамаарлын тухай НҮБ-ын Хөгжих Эрхийн тухай Тунхаглал, НҮБХХ-ийн “Хүний эрх ба түлхтэй хөгжил” бодлогын баримт бичиг болон Хүний хөгжлийн илтгэлүүдээс сайтар харж болно. Хүний эрхийн хэм хэмжээ, стандарт нь олон улсын гэрээ, конвенциуд болон тэдгээрийн хэрэгжилтэнд хяналт тавих байгууллага, хороо зэргээс гаргасан тайлбар, баримт бичгүүдэд агуулагддаг.

Эрхэд суурилсан хөгжих хандлагын Зарчмууд.

Дээрхи хандлагад холбогдуулан баримтлах зарчмуудыг байгууллага бүр дээр өөр өөрийн онцлогоос үүдэн ялгаатай байдлаар тодорхойлж иржээ. Тухайлбал, Олон Улсын Хүний Эрхийн Сүлжээ (International Human Rights Network) хэмээх байгууллагын тодорхойлсноор аливаа байгууллагууд нь үйл ажиллагааны бүхий л түвшиндээ дараахи үндсэн зарчмуудыг баримталж байх нь зүйтэй ажээ. Үүнд²:

1. Хууль журам: Аливаа шийдвэрүүд нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг өөрийн хууль зүйн үндэс болгон авч үздэг. Тэдгээр хэм хэмжээ нь олон улсын гэрээний эрх зүйн зарчмын дагуу оролцогч талуудын заавал хэрэгжүүлэх үйл ажиллагааны наад захын түвшин байна. Энэ зарчмын үүднээс хөгжлийг авч үзэх явдал нь хүний эрхийн харилцан хамааралтай, салшгүй, хуваагдашгүй зэрэг зарчмуудад тулгуурлана гэсэн үг юм. Хууль эрх зүйн баримт бичгүүд нь хүний эрх, эрх чөлөөг цогц байдлаар хангах, хамгаалах, нөхцлийг бүрдүүлэх шаардлагыг хангахуйц байдлаар боловсруулагдах ёстой.

2. Гэрээ: Эрхэд суурилсан хөгжлийн хандлага нь хувь хүн болон бүлгүүдэд тэдний эрх, үүргийн талаар мэдүүлэх, ойлгуулах, хамгаалах талаар гэгээрлийн

¹ UN Declaration on the Right to Development; www.unhchr.ch/html/menu3/b/74.htm

² Basic Principles; International Human Rights Network, <http://www.ihrnetwork.org/hr-based-approaches.htm>

ажил зохион байгуулах ёстой. Өөрөөр хэлбэл хөгжил нь ядуу дорой хүмүүст хэрэгцээ байгаа, тиймээс өглөг тараах шаардлагатай хэмээх тактикаас хүмүүс мөн эрх, эрх чөлөөтэй, түүнийгээ мэддэг ашиглах чадвартай байх гэсэн тактикийг сонгож байна. Энэ нь хүний эрхийг хамгаалах, хүндэтгэх, хэрэгжүүлэх эрх зүйн болон ёс суртахууны хэм хэмжээ, үүрэг хариуцлага байгааг ойлгуулахад чиглэнэ.

3. Нээлтэй, ил тод байдал: Асуудлыг хүний эрхэд тулгуурлан шийдвэрлэх нь засгийн газар, түүний байгууллагуудын зорилт болж байдаг. Харин энэхүү үүргээ хэрэгжүүлэхийн тулд төр, засгийн газрын үйл ажиллагаа нь иргэд, олон нийтэд чөлөөтэй, ил тод байх зарчимд үндэслэх ёстой. Тиймээс хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг хүлээгч талууд нь хүний эрхийг хамгаалах, хүндэтгэх, хэрэгжүүлэхийн тулд олон нийтэд тайлагнах, хариуцлагатай байх зарчмыг мөрдлөгө болгон ажиллана.

4. Оролцоо: Аливаа хүн өөрийн амьдралын асуудлуудыг шийдвэрлэхэд оролцох нь өөрөө хүний эрхийн үндсэн шаардлагын нэг юм. Тиймээс хүний хөгжлийн асуудлуудад тухайн бүлгийн оролцоо их байх тусам хөгжлийн үр нөлөөг ихэсгэж, түүний тогтвортой байдлыг хангадаг.

5. Олон түвшинт: Хүний эрхийн асуудлуудыг шийдвэрлэх арга зам нь Эрхэд тулгуурласан шийдэл байх бөгөөд энэ нь тухайн асуудалд тогтолцоот чанарын болон стратегийн шинжилгээний үүднээс хандахыг илэрхийлнэ. Ялангуяа орон нутгийн, үндэсний болон олон улсын түвшинд хувь хүмүүс болон бүлгүүдийг оролцуулах боломж бүхий механизмыг бүрдүүлнэ. Байгууллагын үйл ажиллагааны бүх хэлбэрүүд нь хүний эрхийн хэрэгжилтийг дээшлүүлэх, тус нэмэр үзүүлэхэд чиглэсэн байна. Өөрөөр хэлбэл байгууллагын урт болоод дунд хугацааны төлөвлөгөө, бодлого хөтөлбөр, түншлэл болоод байгууллагын ажилтнуудын ажлын нөхцөл, сонгон шалгаруулалт, сургалтын болоод идэвхижүүлэлтийн менежмент зэрэг нь хүний эрхэд суурилсан байх шаардлагатай.

Мөн НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Хүүхдийн Сан (ЮНИСЕФ) зэрэг байгууллагуудын зорилго, үйл ажиллагааны хөтөлбөрүүд нь дээрхи эрхэд суурилан хөгжих хандлагыг цогц байдлаар тусгасан байдаг. Тухайлбал, НҮБ-ын Хүүхдийн Сан “Эрхийг хэрэгжүүлэх нь, үр дүнд хүрэх нь” уриан доор тус байгууллагын зүгээс хүний эрхэд суурилан хөгжих хандлагыг үндэсний засгийн газруудтай хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд оруулах замаар эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийг хамгаалах үйлсэд өөрийн хувь нэмрээ оруулах зорилго дэвшүүлжээ. Хүүхдийн Сангийн хувьд эрхэд суурилсан хөгжлийн хандлага гэдэг нь³:

- Байгууллагаас дэмжин хэрэгжүүлж буй бүх үйл ажиллагаа нь Хүүхдийн эрхийн конвенци, Эмэгтэйчүүдийг алагчлан үзэх бүх хэлбэрийг устгах тухай конвенцид тусгагдсан эмэгтэйчүүд ба хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд чиглэнэ.
- Хүний болон хүүхдийн эрхийн зарчмууд нь бидний үйл ажиллагааганы бүх салбарт, үйл явцын түвшин бүрд чиг баримжаа болно. Үүнд дараахи зарчмууд багтана. Хүний эрхийн түгээмэл байх, үл ялгаварлан гадуурхах, салшгүй болон харилцан хамааралтай, үүрэг хариуцлагатай байх, хүүхдийн эрх ашгийг тэргүүнд тавих, амьдрах ба хөгжих, хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэн үзэх зэрэг болно.

³ <http://www.unicef.org/rightsresults/index.html>

- Хүүхдийн Сангийн хамтын ажиллагааны хөтөлбөрүүд нь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах үүрэг бүхий этгээдүүдийг дэмжих, чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Ийнхүү хөгжлийн хөтөлбөрүүд тодорхой үр дүнд хүрсэн тохиолдолд эмэгтэйчүүд ба хүүхдийн эрх хангагдана. Тиймээс НҮБ-ын Хүүхдийн Сан болон түүний хамтын ажиллагааны түншүүд нь үр дүнд тулгуурласан төлөвлөлт ба менежментийг шаардах бөгөөд хөтөлбөрийн үр дүнд тодорхой байх, дэвшлийг үнэлэх, шаардлагатай өөрчлөлтийг хэрэгжүүлэх зэрэгт нөөц хуваарилах бодлогыг баримталж байгаа ажээ.

Үүний хамт Монгол улсын хувьд Их Британийн Хүүхдийг Ивээх Сан манай улсын Боловсролын хуулийн үзэл санаа, заалтууд нь Хүүхдийн эрхийн конвенцийн зүйл заалтуудад хэрхэн нийцэж байгааг тодорхойлох судалгааны ажлыг хэрэгжүүлж байгаа нь уг ажлын эхлэл гэлтэй байна.

Ийнхүү хүн төрөлхтөн өөрсдийн оршин амьдарч буй дэлхийг энх амгалан байлгаж, амьдралын чанарыг сайжруулах зорилгод хүрэх гол хандлага нь эрхэд суурилсан хөгжлийн хандлага болоод байна. Аливаа засаглал зөвхөн цөөн хэсэг хүмүүсийн төлөө бус, нийтийн төлөө, түүний дотор эмзэг, амьдрал дорой бүлгийнхэн, үндэсний цөөнхи зэрэг эрсдэлд учраад буй хүмүүсийн төлөө үйл ажиллагаагаа чиглүүлдэг байх нь энэхүү хандлагын нэгэн үнэт чанар юм. Мэдээллийн нийгэм дэх хөгжлийн гол шалгуур нь хүний эрх, түүний бодлого, соёл, боловсрол зэрэг асуудлууд байх болно. Иймээс хүний эрхийг хэмжин тодорхойлох оролдлогуудыг ямагт хийсээр ирсэн байна. Өөрөөр хэлбэл хүний эрхийн төлөв байдал одоо ямар байна? Түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн ямар бодлогууд байгаа, тэдгээр нь хувийн болон төрийн салбаруудад хэрхэн үр дүнд хүрч буй эсэх, энэ хүрэн дэх бодлогууд нь үндэсний болон олон улсын түвшинд хэр найдвартайд тооцогдож байгаа, гол оролцогчид, тэдгээрийн үүрэг хариуцлага, зорилгоо ухамсарласан байдал, олон нийтийн санаа бодол, тэдгээрийн хүлээлт оролцоо зэрэг маш олон хүчин зүйлүүд, нөхцөл байдал, үйл явцыг агуулсан цогц үйл ажиллагаа болно. Тиймээс хүний эрхийн бодлого, түүний хэрэгжилт, мониторинг, чадавхийг бүрдүүлэх боломж зэргийг тодорхойлох бодит үнэн зөв статистик баримтууд байх шаардлагатай.

Монгол улс ба эрхэд суурилсан хөгжлийн бодлого:

Эрхэд суурилсан хөгжлийн хандлагыг Монгол улсын хувьд хэрхэн ойлгож, бодлого үйл ажиллагаандаа нэвтрүүлж байна вэ? Энэхүү асуултын мөрөөр Монгол улсын төрөөс батлан гаргаж хэрэгжүүлж байгаа үзэл баримтлал, хөтөлбөр төлөвлөгөө зэрэгт анализ хийх шаардлагатай болох нь тодорхой. Монгол улсын УИХ-аар 1994 онд “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, 1996 онд “Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал”, 1998 онд “Монгол улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөр”, 2001 онд “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр”, “Бүсийн хөгжлийн үзэл баримтлал” болон хамгийн сүүлд “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” (2004-2008) зэрэг үндэсний хэмжээний бичиг баримтуудыг тус тус батлан гаргаж, тэдгээрт хөгжлийн талаархи төрөөс баримтлах чиг хандлагыг тусгасан билээ. Дээрхи баримт бичгүүдэд Монгол улсын төрөөс баримтлах гадаад ба дотоод бодлого, эдийн засгийн өсөлт, нийгмийн

тэгш байдал, байгаль орчны зүй зохистой ашиглалт, хүний хөгжил зэргийг олон талт байдлаар тодорхойлсон Монгол улсын хөгжлийн стратеги тусгагдсан байна. Гэхдээ дээрхи баримт бичгүүдэд хүний эрхэд суурилан хөгжих тухай үзэл санаа, баримтлах нэгдсэн бодлого, байр суурь ажиглагдсангүй. Мөн төрөөс энэ чиглэлд баримтлах гол баримт бичиг болох Улсын Их Хурлаас 2003 онд батлан гаргасан “Монгол улсад хүний эрхийг хангах хөтөлбөр”-г баталсан.

Дээрхи хөтөлбөрийн 1.1.2.10-т “Хүний эрхийн орчны стандартыг боловсруулж, Монгол улс дахь бүх төрлийн аж ахуйн нэгж байгууллагуудад дагаж мөрдүүлэх, ажлын байрны стандартад хүний эрхийн орчныг тусгана” хэмээн заасан нь нэн чухал зорилт юм. үүний адилаар дээрхи хөтөлбөрүүдэд олон чухал санал санаачлагууд тусгагдсан боловч энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах, биелэлтэд нь хяналт шинжилгээ хийх үндэсний хөтөлбөрийн хороог байгуулахгүй хоёр жил болсноос хэрэгжилт нь тодорхойгүй хэвээр байна.

“Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн оршилд зааснаар манай улс нь НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудаас гаргасан олон улсын 30 гаруй гэрээнд нэгдэн орсон байна. Монгол Улсад Мянганы Хөгжлийн Зорилтуудын хэрэгжиж буй явц, байдлын тухай 2003 онд гаргасан илтгэлд “Монгол Улс хүний эрхийн холбогдолтой олон улсын зургаан гол гэрээ, конвенцийг соёрхон баталсан хэдий ч эдгээр эрхийг бүрэн хэмжээгээр нь хэрэгжүүлэх засгийн газрын чадавхийг хөрөнгө хомс, чадавхи муутай хуулийн болон шүүхийн тогтолцооны сул талууд хязгаарлаж байна. Зохистой сайн засаглалыг хэрэгжүүлэхэд саад тотгор учруулж байгаа бусад хүчин зүйлд хууль тогтоох болон гүйцэтгэх засаглал, иргэний нийгмийн хоорондын мэдээлэл солилцоо хязгаарлагдмал, төрийн албаны чиг үүргийн давхардал болон тодорхой бус байдал, засаглалын доод төвшинд олон нийтийн төлөөлөл болон тайлагнал дутмаг байгаа зэрэг орж байна⁴” хэмээн тодорхойлжээ. Нөгөө талаас төр, засгийн газрын зүгээс тийнхүү олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагаа хэрхэн биелүүлж байгаа, мөн тухайн салбар чиглэлүүдээр ямар амжилтанд хүрээд байгааг тодорхойлон өөрийн ард иргэдэд танилцуулах байдал хангалтгүй мэт санагдана. Хүний Эрхийн үндэсний Комиссоос Монгол улсын нэгдэн орсон гэрээ конвенцийн дагуу НҮБ-д өргөн барьсан тайлан илтгэлүүд, холбогдох санал зөвлөмжийг эмхтгэн гаргасан нь энэ ажилд чухал алхам болсон юм.

Монгол улсын Ерөнхийлөгч Н.Багабанди 2002 онд өөрийн зарлигийг гаргаж, “үндэсний хөгжлийн хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгон даалгасан байна. Хөгжлийг авч үзэх болон нийгмийн дэвшлийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд өөрчлөгдөж, хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг иш үндэс болгож буй дэлхий нийтийн хандлага тогтож байгаа нь энэхүү хөтөлбөрийн үндэслэл болж өгчээ. Харамсалтай нь энэхүү хөтөлбөр өнөөг хүртэл батлагдаагүй, төсөл хэвээр байгаа нь Монгол улсын хөгжлийн тухай үзэл баримтлалыг шүүн хэлэлцэх бололцоог олгохгүй байна. Тиймээс хөгжлийн хандлагыг түүнийг тодорхойлж буй шалгууруудтай харьцуулан авч үзье.

⁴ Монгол улсад ардчиллыг бэхжүүлэх үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн төсөл УБ. 2005

Хүний хөгжлийн индекс:

Учир нь эрхэд суурилан хөгжих хандлага нь өөрийгөө тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахыг шаардаж байдаг. Энэхүү зорилгын хүрээнд олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс “Хүний хөгжлийн индекс”-ийг боловсруулан гаргаж, түүний ачаар хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилт, улмаар түүний хэрэгжих орчин нөхцлийн талаар иж бүрэн мэдээлэл бүрдүүлж авдаг. Улмаар дэлхийн улс орон бүр хүний амьдралын орчин нөхцлийг хэрхэн биелүүлж, эрх эрх чөлөөг хангаж байгааг тодорхойлох зорилгоор “хүний хөгжлийн илтгэлүүд”-ийг жил тутам боловсруулан гаргадаг болжээ. 2005 оны дэлхийн хүний хөгжлийн илтгэлээр Монгол улс нь дундаж хүний хөгжлийн индекс буюу HDI 0.500-0.799 зэрэглэлд багтаж, нэг хүнд ноогдох ҮНО-ний хэмжээ нь 765 ам.доллараас бага буюу “бага орлого”-той 61 орны нэг болсон зэрэг үзүүлэлтээр дэлхийн 177 орноос 114-р байрт орсон байна. Энэхүү байр нь хүн амын доторхи хүүхэд, залуучуудын эзлэх хувийн жин, сургуульд хамрагдах байдал, бичиг үсэг тайлагдалтын түвшин ба хүн амд ноогдох эмч, эмнэлгийн ор зэрэг бидний бахархан иш татдаг тоон мэдээллүүдтэй харьцуулахад тийм ч хүсмээр зүйл биш болох нь тодорхой. Монгол улс ардчилал, зах зээлийн нийгэмд шилжсэнээс хойш даруй 15 жил өнгөрч, нийгэм, улс төр, эдийн засгийн салбарт олон амжилтанд хүрсэн хэдий ч ард иргэдийн амьжиргааны байдал төдийлэн сайнгүй байна. өсөн нэмэгдэж байгаа ядууралтай тэмшэж, уг хандлагыг өөрчлөхийн тулд НҮБ, олон улсын тусламж дэмжлэг, хамтын ажиллагаанд түшиглэн засгийн газраас Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг санаачлан 1996-2000 онд хэрэгжүүлсэн хийгээд улмаар энэхүү хөтөлбөрийг үргэлжлүүлэн Өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр болгон хэрэгжүүлж байна. Ийнхүү энэ асуудлаар олон хөтөлбөр, арга хэмжээ авч байгаа боловч ядуурал үндэсний тулгамдсан асуудал хэвээр байна. Үүнд эдийн засгийн өсөлт удаан, ажил эрхлэлт нэмэгдээгүй, ядуучуудын сэтгэлгээг өөрчлөх, тэдний боловсролд анхаарлаа түлхүү хандуулаагүйтэй холбоотой гэж үзэж болох юм⁵. Монгол улсын Хүний хөгжлийн илтгэл 2003-д бичсэнчлэн “Хүн амын ядуу хэсэг хөгжлөөс гадуур орхигдох нь олонтаа. Тэд өөрсдийн амьжиргаанд нь шууд нөлөөлөх асуудлаар шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаагаас хөгжлийн үр шимийг хүртэж чадахгүй байна. Эдийн засгийн өсөлт нэн чухал боловч ядуу иргэд түүний үр шимээс нь хүртэхүйц, далайцтай хүний хөгжилд чиглүүлэхүйц төрийн бодлого шаардлагатай байна. Энэ байдлаас шалтгаалаад хүний эрхийн зөрчил, доголдол гарсаар байгаа нь нэгэнт илэрхий зүйл юм.

Өнөөгийн хүний эрхийн хөгжлийн чиг хандлага нь иргэний болон улс төрийн эрхийн хүрээнээс хальж, эдийн засаг, нийгэм соёлын эрхийн үзэл санааг ихээхэн “анхаарах” болсон. өөрөөр хэлбэл, ядуурал, амьжиргааны хангалтгүй байдал нь хүний эрхийн зөрчлийн үндэс шалтгаан хийгээд үр дагавар мөн хэмээн үздэг хандлага нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн билээ. Мөн эдгээр эрхүүд нь өөрийн дотоодод “хөгжих эрх”-ийг агуулж байдаг бөгөөд хэрэгжүүлэхийн тулд тодорхой үйл ажиллагаа, бодит хэрэгжилт шаарддаг байна. Хүний эрхийн олон улсын болон үндэсний эрхзүйн хувьд тодорхой үнэт зүйлс, хэм хэмжээ болон зарчмуудыг

⁵ Д. Дагвадорж *Тулхтай хөгжил ба Монголын ирээдүй* УБ, 2002 х.8

тодорхойлох замаар эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд тухайн төр, засгийн газарт хүний эрхэд холбогдох доорхи үүргүүдийг хүлээн зөвшөөрдөг. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;
- Хүний эрх, түүнд холбогдох үүрэг, хамгаалах арга хэрэгслүүдийн талаархи мэдлэг, ойлголтыг дэмжих;
- Эмзэг буюу эрсдэлд учраад буй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах;
- Хүний тогтвортой хөгжлийг хангах замаар иргэдийн одоогоор эдэлж чадахгүй байгаа эрхийг нь хангаж өгөх зэрэг үүргүүд болно.

Дээрх үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхэд төр болон төрийн биш оролцогчдын үүрэг хариуцлага ижил түвшинд тавигддаг. Мөн цөөнхийн эрхийг хамгаалах, үндэстэн ястнууд зэрэгцэн оршихыг дэмжих, нийгэм, соёлын болон улс төрийн олон эшт байдлыг хадгалах, энх тайван, хүний аюулгүй байдлыг сахин хамгаалах зорилгоор дараахи үйл ажиллагааны чиглэлүүдийг санал болгодог байна. Эдгээр нь:

1. Хэм хэмжээний хүрээг тогтоох;
2. Байгууллага тогтолцооны суурийг тавих;
3. Бодлогын хүрээг хангаж өгөх;
4. Улс оронд тулгарч буй бэрхшээл, саадыг арилгах зэрэг юм.

Ийнхүү хүний эрхийн хэрэгжилттэй холбоотойгоор хоёр зөрчилт хандлагууд тодрон гарч байна. Хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр олон улсын түвшинд эрхэм чухал амлалт бүхий идеал байдал бүрэлдэн тогтож байна. Нөгөө талаас тэрхүү амлалт, санаачлагуудыг өөрийн эх орны бодит хөрс шороон дээр буулгах үйл ажиллагаа нь олон түмнийг итгэл алдарсан байдалд хүргээд байна. Иргэдийн хувьд төрийн байгууллага, улстөрийн нам, улс төрчдөөс амлалт, баталгаа, уран илтгэх чадвар зэргээс илүүтэйгээр идэвхитэй үйл ажиллагаа, тодорхой үр дүн, баримтуудыг шаардаж, хүлээж байгаа нь илэрхий болоод байна. Үнэхээр хүний эрхийг хангах, хамгаалах нь дан ганц сайхан амлалт, хүсэл зоригоор биелэгддэг зүйл биш билээ. Энэ нь тодорхой хөгжлийн бодлого, хүний ба санхүүгийн нөөц, оролцогч талуудын хамтын ажиллагаа зэргээс шалтгаална.

Хөгжлийг тодорхойлохын тулд түүнийг тодорхойлох үзүүлэлтүүд оновчтой, зөв байх нь гарцаагүй. Харин одоогоор хөгжлийг тодорхойлж буй уламжлал болсон шалгууруудад дараахи 4 үндсэн хүрээ орхигдож иржээ. Эдгээр нь:

- ◆ Зүй ёсны тогтолцоо
- ◆ Хувийн аюулгүй байдал
- ◆ Улс төрийн оролцоо ба ардчилал
- ◆ Хөгжлийн үзэл баримтлалын асуудлууд

Мөн үүнээс гадна одоогоор хүний хөгжлийг тодорхойлоход нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүд ихээхэн чухал байр суурьтай байсан ба байсаар байна. Гэтэл эрхэд суурилсан хөгжлийн үйл явцыг үнэлэхийн тулд түүнд нөлөөлж байгаа субъектив хүчин зүйлсийн нөлөөллийг тооцож чадахуйц шалгуурыг боловсруулах асуудал нэн чухлаар тавигдаж байна. Ялангуяа төрийн байгууллагуудад ард түмний итгэх итгэл ямар байгаа, төрийн албан хаагчдын хууль зүйн болон хүний эрхийн боловсрол мэдлэг, ёс зүйн хэм хэмжээ, хариуцлагын мэдрэмж, олон түмний зүгээс хууль хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнуудаас айж эмээх зэрэг нь хөгжлийн асуудлыг үнэлэх дүгнэхэд чухал ач холбогдолтой.

Дэвшилтэт талууд:

Ийнхүү манай улсын хувьд эрхэд суурилан хөгжих талаар төрийн шэгцтэй бодлого үгүйлэгдэж байгаа хэдий ч нийгмийн хөгжлийн үйл явцад зохих зэрэг хандлагууд ажиглагдаж байна. Эдгээр хандлагуудыг нэгтгэн авч үзвэл, иргэдийн зохистой оролцооны түвшин нэмэгдсэн, эмэгтэйчүүдийн байр суурийн дээшлэлт зэрэг болно.

Ерөөс аливаа шийдвэр гаргах үйл явцад идэвхитэй, чөлөөтэй, утга учиртайгаар оролцох нь иргэдэд өөрсдийн эрхэд суурилан хөгжих зохих шаардлагыг хангаж буй байдал мөн. Орчин үеийн нийгэмд улс төрийн засаглал монополь байдлаа алдаж, иргэний нийгмийн институтууд түрэн гарч ирж байгаа нь засаглалын мөн чанарын талаархи ойлголт үзэл санааг ихээхэн өөрчлөлтөнд оруулж байна. Иргэдийн зүгээс олж авах мэдээллийн хэрэгцээ хийгээд хүрэлцээ ихэссэн, засаглалын харилцаанд ардчилал, хүний эрхийн агуулга ихээхэн тусгагдаж буй учраас тэдний оролцоо идэвхи нэн өндөр түвшинд байх болсон байна. Үүнд иргэдийн үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнөөс эхлээд олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Эмнести Интернэйшнл зэрэг хүний эрхийн олон улсын болон дотоодын төрийн бус байгууллагууд хамтран нийгмийн томоохон зорилтуудыг шийдвэрлэхэд өөрсдийн хувь нэмрээ оруулж байна. Иргэд төрөл бүрийн үүсгэл санаачлагаар олон талын байгууллага, бүлгийг идэвхийлэн байгуулж жагсаал цуглаан хийх, шаардах хуудас, өргөх бичиг барих, мэдээ баримт нийтлүүлэх, шинэ хууль санаачлах лоббидох, буруу шийдвэрийн талаар шүүхэд хандах зэрэг олон талт үйл ажиллагаа явуулж байна.

Дараагийн нэн чухал ахиц дэвшил бол эмэгтэйчүүдийн нийгэм дэх байр суурийн дээшлэлт юм. Одоогоос хэдхэн арван жилийн өмнөхтэй харьцуулбал эмэгтэйчүүдийн боловсролын түвшин ихэд дээшилсэн нь олон баримтуудаас харагдаж байна. Тухайлбал олон эмэгтэйчүүд өөрсдийн бизнесийг эрхэлж, менежмент хийх болсноор эдийн засагт буюу ажлын байранд эзлэх хувийн жин ихсэж, эрүүл мэндийн үйлчилгээ, гэр бүл төлөвлөх зэрэг олон арга хэмжээнд эрчүүдийн хамт эн тэгш байх боломж бүрдэж байна. Эмэгтэйчүүдийн байр суурийн дээшлэлтийн талаар НҮБ, түүний салбар байгууллагуудаас гаргасан хүний хөгжлийн илтгэлүүдэд дурьдсанаар хөгжиж буй орнуудад сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд хөгжингүй орнуудын 100 жилээс ч илүү чанарын ахиц дэвшил гарсан⁶ хэмээн тооцоолжээ. Жендерийн холбогдолтой судалгааны дүнгүүдээс үзвэл бичиг үсэгт тайлагдахын хэрээр эмэгтэйчүүдийн төрөлтийн тоо буурч, хөдөлмөр эрхлэх болсноор нөхрөөс хараат бус орлогын эх үүсвэртэй болж өөрийн гэр бүлийн эрүүл мэнд, боловсролд зарцуулах мөнгөний дүн хэмжээ өсдөг байна. Ийнхүү эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нь хүн амын өсөлтийг зохистой түвшинд барьж, ядуурлыг бууруулах үйл явцыг түргэсгэх зэргээр нийгмийн дэвшилд хүргэдэг байна.

Нийгэм дэх дээрхи өөрчлөлтүүд нь нэгэн талаас боловсролын үр дүн, нөгөө талаас мөн боловсролын хөгжлийн чиг баримжаа болохуйц хүчин зүйлүүд билээ. Учир нь нийгэм дэх аливаа хөгжил дэвшлийн уг үндэс суурь нь тухайн үеийн

⁶ Allen Hammond, *Which World? Scenarios for the 21st Century* Island Press; 1998 p. 119

боловсролын тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлттэй шууд уялдан холбогдох нь тодорхой. Тиймээс боловсролын байгууллагууд нь дээрхи өөрчлөлт шинэчлэлтийн үйл явцыг өөрсдийн сургалт, судалгааны чиглэлүүдэд сайтар нийцүүлэн тохируулах замаар үр дүнтэй, чанартай боловсролын үйлчилгээг суралцагсад хийгээд нийгэмд үзүүлэх нь зүйтэй. Ингэснээр дээр дурьдсан эерэг өөрчлөлтийн үйл явцыг улам бүр эрчимжүүлэх дэмжлэг болно.

Дүгнэлт:

Энэ бүгдээс дүгнэн үзэхэд Монгол улсын төр, түүний бодлогын цар хүрээнүүд нь эдийн засаг, нийгмийн шинэчлэлтээс илүүтэй илүү гүн утга агуулгатай, холч мэргэн байх ёстой. Өөрөөр хэлбэл “эрхэд суурилан хөгжих хандлага”-ыг баримтлах нь хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг бүх талаар хангасан, хүний эрх, эрх чөлөөг хөгжлийн бодлогын гол цөм болгон тавина гэсэн үг юм. Төр нь хамгийн үр ашигтай, бүтээлч байхын тулд зөв зохист бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх бөгөөд мөн хэрэв тэдгээр нь зүй бус байвал өөрчлөгдөж байх ёстой. Хэрвээ иргэдэд нийгмийн харилцаанаас авч буй үр ашиг хийгээд оногдож буй ачаа нь харилцан тэнцүү хуваарилагдсан, үндсэн эрх ба үүргүүд нь тэнцвэрийн зарчимд үндэслэсэн, энэ бүгдийг иргэд нь ухамсарласан, мөн харилцан зөвшилцөл хийхэд бэлэн байж чадвал “эрхэд суурилан хөгжих” хандлага тогтож байна гэсэн үг.

НОМ ЗҮЙ:

1. “Монгол улсад хүний эрхийг хангах хөтөлбөр” УБ. 2003
2. “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал УБ. 1994
3. “Монгол улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөр” УБ. 1998
4. “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр” УБ. 2001
5. “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” (2004-2008) УБ.2004
6. Монгол улсад ардчиллыг бэхжүүлэх үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн төсөл УБ. 2005
7. “Монгол Улсын Хүний Хөгжлийн Илтгэл” (2003) УБ. 2003
8. UNDP Human Development Report 2005 Hoechstetter Printing. Co; NY 2005
9. Allen Hammond, Which World? Scenarios for the 21st Century Island Press; 1998
10. Measuring human rights: The challenges for the information society. 2002 Statistical Journal of the UN Economic Commission for Europe by Garonna, Paolo; Balta, Evren
11. Д. Дагвадорж Тулхтай хөгжил ба Монголын ирээдүй УБ, 2002
12. “Олон Улсын Хүний Эрхийн Сүлжээ” байгууллагын веб хуудас
International Human Rights Network
<http://www.ihrnetwork.org/hr-based-approaches.htm>
13. НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссиарын Газрын веб хуудас
www.unhchr.ch/development/approaches.html
14. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн веб хуудас
www.undp.org/governance/humanrights.htm
15. НҮБ-ын Хүүхдийн Сангийн веб хуудас
<http://www.unicef.org/rightsresults/index.html>

ЦӨӨНХИЙН ЭРХ БА ЦААТАН ИРГЭДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ЗАРИМ АСУУДАЛ*

**С.Цэрэндорж,
ХЭҮК-ын дарга**

Улс орнуудад арьсны өнгө, хэл, шашин шүтлэг, үндэс угсаа, яс үндэс, бэлгийн чиг баримжаагаараа ялгаран нийгэмдээ дийлэнх болдоггүй бүлэг хүмүүсийг цөөнх хэмээн ерөнхийд нь тодорхойлдог. НҮБ-ын ивээл доор олон улсын хамтын нийгэмлэг цөөнхийг хамгаалах зорилгоор цөөнхийн эрхийн стандартыг томъёолж эхлээд байна.

Аль ч улсын хувьд олонх цөөнхүүд хоорондоо зохицон амьдрах явдлыг чухалчлан үздэг. Ийнхүү зохицон амьдрах үндэс нь хүн бүр эрх, эрх чөлөөгөө аливаа төрлийн ялгаварлал, тэгш бус байдалгүйгээр эдлэх нөхцөлд бүрдэх нь ойлгомжтой. Энэ үзэл санаа нь Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын оршилд “Хүн төрөлхтөний гэр бүлийн бүх гишүүнд угаас заяасан нэр төр болон тэдний тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөнгийг иш болгоно,” хэмээн томъёологдсон байдаг билээ. Тиймээс цөөнхийн тухай асуудлыг онцгойлон авч үзэж байгаа нь ардчиллын нэг чухал хэмжүүр болох нь дамжиггүй.

Үндэстний цөөнхийн эрхийн тухай асуудлыг тусгасан олонх гэрээ конвенцийг Монгол улс соёрхон баталсан.

Түүнчлэн зарим гэрээ, конвенцийн хэрэгжилтийг хянах Хороонд үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдлын талаар тайлагнах үүргийг манай Засгийн газар хүлээсэн байдаг.

Олон улсын гэрээ, конвенциудад үндэстний цөөнхийн эрхийг хангаж, хамгаалах, хөхиүлэн дэмжихэд ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш байх зарчмыг мөрдлөг болгохыг чухалчлан заасан байдаг. Ихэнх улс орнууд хууль тогтоомждоо ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг тусгасан байдаг ч хуулийг хэрэгжүүлэх шатанд үндэстний цөөнхүүд ялгаварлагдах байдал элбэг байдаг. Аливаа улс үндэстний цөөнхийн эрхийг хэрхэн хангаж, хамгаалж байгаа нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын хүрээнд үндэстний цөөнхийн эрхийн асуудлыг ямар түвшинд авч үзэж, асуудлыг нь хэрхэн шийдвэрлэж буй байдлаар тодорхойлогддог. Тиймээс үндэстний цөөнхийн эрхийг хангаж, баталгаажуулах нь зөвхөн хууль тогтоомжид зааж өгөх төдийгөөр хязгаарлагдах зүйл биш. Үүний тулд үндэстний цөөнхөө зөв тодорхойлж, томъёолох ёстой бөгөөд бид нэг тодорхойлолтыг онцлон авч үзсэн болно. Үндэстний цөөнх гэдэг нь тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөнх болох хэл, арьсны өнгө, соёл иргэншлийнхээ хувьд ялгарах, өөрсдийн өвөрмөц байдлыг хадгалах хүсэл эрмэлзлэл бүхий тодорхой бүлэг хүмүүсийг хэлнэ. Үүнээс улбаалаад зарим цөөнхийг үндэстний цөөнх, угсаатны цөөнх хэмээн маргах тал ажиглагддаг бөгөөд

* “Үндэстний цөөнх ба хүний эрх” бага хурал дээр тавьсан илтгэл /16.09.2005/

энэ нь зарчмын хувьд төдийлөн ач холбогдолтой биш юм. Гол нь тухайн цөөнхийн хүн амын дунд цөөнх болж байгаа онцлог шинж болох зан заншил, хэл, соёл, шашин шүтлэг зэрэгтэй холбоотой бий болсон эрхийг хангаж, хамгаалах үүргийг улс орны төр, засаг хүлээх ёстой тухай олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд тусгаж өгсөн байдаг. Тиймээс угсаатны цөөнхийн хувьд ч мөн ялгаагүй цөөнх болж байгаа онцлогоо хадгалан үлдэх гэсэн хүсэл эрмэлзлэлийг төр хангаж, хамгаалах учиртай.

Тэгвэл манай улсын хувьд үндэстний цөөнхүүд байдаг уу, байдаг бол ямар бүлгийг үндэстний цөөнхөд тооцдог вэ гэсэн асуулт гарч ирнэ. Монгол улс 1969 онд нэгдэн орсон Арьс үндсээр алагчилах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн хэрэгжилтийн талаар НҮБ-ын Арьс Үндсээр Алагчилах Үзлийг Устгах Хороонд нийт 11 удаа тайлан тавьсан байх бөгөөд энэ бүх хугацаанд Монгол улсын үндэстний цөөнх бол ганцхан казак үндэстэн хэмээн үзэж иржээ. Дээрх илтгэлүүдэд Монгол улсад 25 хүртэлх үндэстний цөөнх, угсаатны цөөнх амьдарч байгаа хэмээсэн ч зөвхөн казак иргэдийг үндэстний цөөнх хэмээн тодорхойлсон бөгөөд үндэслэл нь өөрийн хэлтэй, бусад цөөнхүүд монгол хэлээр өөрсдийн нутгийн аялгуугаар ярьдаг хэмээн үзсэн тэй холбоотой ажээ. Харин 2004 онд хэвлэгдсэн Монгол Улсын түүх, соёл иргэншлийн атласт Монгол Улсын нутаг дэвсгэр дээр түрэг угсааны казак, тува, хотон, чантуу хэмээх үндэстний цөөнх болох бүлэг хүмүүс оршдог хэмээн үзжээ. Гэсэн хэдий ч одоог хүртэл Монгол улс хичнээн үндэстний цөөнхтэй вэ гэдэг асуулт тодорхой хариултгүй явж ирсэн. Энэ асуудлыг тодорхой болгох нь төрөөс үндэстний цөөнхийн эрхийг хангах, хамгаалах чиг үүргээ бүрэн төгс хэрэгжүүлж эхлэх анхны алхам билээ. Дээрх тодорхойгүй байдал нь зарим үндэстний цөөнхийн асуудлыг орхигдуулах, эрхийг нь зөрчигдөх байдалд хүргэж байна.

Тийм ч учраас Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2003 онд НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газрын санхүүжилтээр Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын нутаг дэвсгэрт амьдарч байгаа урианхай буюу цаатан хэмээх цөөнх иргэдийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг судлав.

Цаатан хэмээн нэрийдсэн эдгээр бүлэг хүмүүс нь өөрийн хэл, соёл, шашин шүтлэгээрээ монголчуудаас ялгарч буй бөгөөд үндэсний цөөнх болох нь тодорхой юм. Комиссоос үндэсний цөөнх болох цаатангуудын эрхийн асуудлыг судлахдаа өөрийн соёл иргэншлээ хадгалж үлдэх, өөрийн шашныг шүтэх, төрөлх хэлээрээ ярих эрхээр хэрхэн хангагдаж байгааг онцлон авч үзсэн болно. Эдгээр цөөнх нь “тува”, “урианхай”, “духа” гэх мэтээр ялгагддаг боловч судалгааны тайланд “цаатан” хэмээн нийтэд түгсэн нэрээр нь авсан болно.

Манай улсын умар зүгийн ой тайгад цаа буга маллаж амьдардаг хэсэг ардыг, ардын хувьсгалаас хойш манай утга зохиол, ярианы хэлэнд Цаатан гэж нэрлэх болжээ. Хувьсгалаас өмнө нийтэд нь Тагна урианхай гэж нэрлэдэг байсан боловч тайгын иргэд, Соёд урианхай гэж ялгах явдал ч байжээ. Ийнхүү цаатан хэмээн нэрийдсэн нь тэдгээр бүлэг хүмүүсийг онцлож, ахуйн шинжээр нь тодотгосон байна. “Цаатан” гэдэг үг нь цаа бугатай хүн гэсэн утгыг илэрхийлнэ. 1955 онд анх 53 өрхийн иргэд хүсэлт гаргаснаар Монгол улсын иргэн болжээ. 1960 оны байдлаар нийт 574 цаа бугатай 30 цаатан өрх бүртгэгджээ.

Социалист системийн жилүүдэд Монголын цаатан ардууд нийгэмд хөдөлмөр эрхлэх, ан авыг төлөвлөгөөтэй авлах, цаагаа эрүүлжүүлэх, үүлдэр угсааг

сайжруулах нь тодорхой бодлогоор зохицуулагдаж байв.

Цаатан хүмүүс анх Хөвсгөл аймгийн Улаан-уул, Рэнчинлхүмбэ сумын нутагт харьяалагдаж амьдарч байжээ. 1950-аад оны үед Улаан-Уул сумын намын хорооноос цаатан ардуудыг суурин амьдралтай болгох, тайгаас буулгаж ирэх зорилт тавьж тэдэнд зориулан байшин барьж, цаа бугынх нь хоол болох хөвд ургамлыг нь ой тайгаас машинаар зөөж, цаатангуудыг тайгад нь буцааж явуулахгүй барьж байхын тулд харуул манаа хүртэл гаргаж жил орчим байлгаж байжээ. Гэтэл цаатангууд, цаа буга аль аль нь гундаж, өвчин эмгэг тусах, хөвд ургамлыг нь олж ирэхэд маш их зардал гаргах зэргээс үүдээд Намын Төв Хороонд уламжилж тэдгээр цаатан ардуудыг тайгад нь буцааж байжээ.

Үүнээс хойш 1956 онд Цагаан нуурт загасны үйлдвэр барих үеэр дахин цаатан ардуудыг суурьшуулах ажил хийгдэж эхэлсэн. Энэхүү загасны үйлдвэрийн гол ажилчдыг цаатангуудаас бүрдүүлэх бодлого барьж байжээ.

Мөн цаатангуудад өвлийн дулаан хувцас олгох, өндөр настнуудыг үнэгүй хооллох, тайгад амьдарч байгаа өндөр настнуудад тэтгэвэр олгох зэрэг ажил хийгдэж байжээ. Түүнээс гадна цаатан боловсон хүчнийг бэлтгэх бодлого барьж, ОХУ-ын Автономит Тувад явуулж сургаж байжээ.

Тэр үеийн Парламент болох Ардын Их Хурлын дэргэдэх Залуучууд, Үндэсний Асуудлын Комисст үндэсний цөөнхийн асуудлаар тусгайлан судалгаа хийдэг ажилтныг ажиллуулж, цаатангууд дээр жилд тодорхой хугацаагаар очих томиолтыг төсвөөс гаргаж, тэдний амьдралын түвшин, боловсрол, эрүүл мэндийн байдал, хөдөлмөр эрхлэлт, соёл урлаг гэх мэт зүйлсийн талаар Комисст мэдээлэл, тайлан бичиж өгдөг байжээ. Энэ нь үнэн бодит мэдээллийг төрийн удирдлагад өгөх, энэ дагуу ажил зохион байгуулахад тус дөхөм болж байв.

1990-ээд оны үеэр цаатангуудад цааг нь хувьчлан өгч, урьд өмнөх тодорхой бодлого, үйлчилгээ үгүй болсноор тайгынхны амьдрал эрс хүндэрч, цаагаа олноор нядлах, цааны эврээ худалдах, ангын олзоор амьдрах зэрэг өнөө маргаашаа өнгөрөөн аргацаах байдалд шилжжээ. Цааны эврээ жил бүр хөрөөдөн авч амьдралаа залгуулсаар байгаа нь цааны өвчин ихэсэхэд хүргэж буй бөгөөд цаа бугын үржил багасан, ерөнхийдөө жижгэрч, давжаарч ирсэн юм. Мөн загас агнуурын аж ахуй татан буугдаж тэнд ажиллаж байсан цаатан иргэд эргэн тайгадаа гарснаар тайгын хүн ам ихэсч, цаа цөөрөх хандлага руу оржээ. Түүнчлэн цааг хувьчлахдаа цаа бугын аж ахуйд үржлийн цааг авч үлдээгүй, цаа бугыг нэгэнт хувьчилсан гэдэг шалтгаанаар эрүүлжүүлэх болон бусад үржил селекцийн асуудалд анхаарал тавихаа больсон зэрэг хүчин зүйл цаа бугыг хорогдоход их нөлөөлсөн.

2003 оны 6-р сард цаатны төлөөлөгчид Улаанбаатарт ирж төрийн түшээдэд өөрсдийн санал хүсэлтээ уламжилсны дагуу шат шатандаа үүрэг өгч Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг Цагааннуур суманд 2 өдөр ажиллаж, тэдний хэрэгцээг судалж, амьдрал байдалтай нь танилцжээ. Үүний дагуу Хөвсгөл аймгийн Засаг даргаас Монгол улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газарт нийт 7 зүйлийг багтаасан цаатан ардуудын хэрэгцээт зүйлийг хүсэлт болгон тавьжээ.

УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооноос 2003 оны 8-р сард Монгол улсын Ерөнхий сайдад хандан цаатан иргэдийн амьдрал ахуйн өнөөгийн байдал, тугамдаж буй асуудлууд болон тохиолдож байгаа бэрхшээл, цаа бугын сүргийг өсгөн үржүүлэх, хамгаалах талаар цаатан иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг

судлан үзэж, дээрх асуудлаар Монгол улсын Засгийн газар ямар бодлого баримталж байгаа тухай мэдээлэхийг хүссэн албан тоот илгээжээ. Засгийн газар одоо энэ асуудлыг судалж байгаа юм байна.

Монгол улсын Үндсэн хуулинд “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”¹ хэмээн заасан. Бусад хуульд ч үндэсний цөөнхийг ялгаварлан гадуурхахгүй байх талаар тусгагдсан. УИХ-аас 2003 онд батлан гаргасан Монгол Улсын Хүний Эрхийг Хангах Үндэсний Хөтөлбөрт үндэстний цөөнхийн эх хэлээрээ сурч боловсрох, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн хөгжүүлэх боломжийг сайжруулах, эх хэлээрээ мэдээлэл авах, түгээх боломжийг хангах талаар тусгайлсан заалтууд байдаг.

Дээрх хууль тогтоомж, хүний эрхийн олон улсын гэрээг хэрэгжүүлэхэд энэ чиглэлээр боловсруулан гаргасан эрх зүйн актууд чухал ач холбогдолтой юм. Цаатан ардуудын талаар болон тэдний аж амьдралыг дээшлүүлэх чиглэлээр дорвитой бодлого, шийдвэр байхгүй байна.

Өнөөдрийн байдлаар тайгад нийт 44 өрхийн 210 хүн амьдарч байна. Нийт өрхийн 70 орчим хувь нь ядуу, нэн ядуу амьдралтай. Хүүхдүүдийн 39% сургууль завсардсан. Ихэвчлэн хөвгүүд завсарддаг. Ан агнах, ургамал түүх, цаа бугын цусан эврийг зарах зэрэг цөөн бөгөөд тогтвортой биш орлоготой. ЭМД-д хамрагдалт хангалтгүй. Эмнэлгийн үйлчилгээнээс хол. Түргэн тусламж дуудах тохиолдолд зарим газарт 4 хонож хүрдэг. Гурил, будаа, цай, давс авахад л зардал гаргадаг. Мэдээлэл авах боломж хязгаарлагдмал байна.

Үндэстний цөөнх болохын хувьд цаатан иргэдийн өөрсдийн өвөрмөц байдлыг хадгалан үлдэх, түгээн дэлгэрүүлэх гэсэн хүсэл эрмэлзлэл, тэдний онцлог болох хэл, соёл, зан заншил, шашин шүтлэгийн талаар тус бага хурлын үеэр тусгайлан ярих тул энд дурьдсангүй.

¹ Монгол улсын Үндсэн хууль, 1992 он, 2-р бүлэг, 14-р зүйл

ЦӨӨНХ БОЛОХ ЦААТАН ИРГЭДИЙН СОЁЛЫН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ*

Б. Хишигсайхан
ХЭҮК-ын Ажлын албаны дарга

Цөөнх болох цаатан иргэдийн соёлын эрхийн хэрэгжилт ямар байгаа талаар товчхон авч үзье. Соёлын эрхийн тухай асуудал нь Хүний эрхийн биллд тусгагдсан байдаг. Тухайлбал Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 27 дугаар зүйл, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын 15 дугаар зүйлд тус тус тусгагдсан. Мөн түүнчлэн Хүүхдийн эрхийн Конвенц (31), Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (13с), Арьс үндсээр ялгаварлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (5е, vi) зэрэгт тусгагдсан байдаг. Монгол улс 1969 онд Арьс, үндсээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц, 1974 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт, 1991 онд нэгдсэн Хүүхдийн эрхийн тухай Конвенц, 1981 онд Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцид нэгдэн орсон ба бусад хүний эрхийн олон улсын гэрээ хэлэлцээрт үндэсний цөөнхийн эрхийн асуудал тусгагдсан тул Монгол улсын Засгийн газар үндэсний цөөнхийн эрхийг хангах, хамгаалах талаар томоохон үүрэг, хариуцлага хүлээж байгаа юм. Мөн түүнчлэн Монгол улсын Үндсэн хуулинд “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”¹ хэмээн заасан. Бусад хуульд ч үндэсний цөөнхийг ялгаварлан гадуурхахгүй байх талаар тусгагдсан. 2003 онд УИХ-аас батлагдсан Хүний эрхийг хангах Үндэсний Хөтөлбөрт соёлын эрх, үндэсний цөөнхийн эрхийг хангаж, баталгаажуулах талаар зохих заалтууд орсон нь дэвшилттэй зүйл мөн билээ.

Соёлын эрх нь хүний эрхийн мэргэжилтнүүдийн дүгнэснээр 20 дугаар зууны сүүл үеэс илүүтэйгээр хөгжиж, энэхүү эрхийг хангах, хамгаалах талаарх улс орнуудын хүлээж буй үүргийг сануулах болсон. Өмнө нь энэхүү бүлэг эрх нь эдийн засаг, нийгмийн эрхүүдийн сүүдэрт үлдэж байсан хэмээн хэлж болно. 21 дүгээр зуунд соёлын эрхийг хангаж, хамгаалах талаар илүүтэй хөндөгдөн тавьж байна. Энэ нь ч глобалчлалын энэхүү эринд чухал яригдах ёстой сэдвийн нэг билээ. Соёлын эрх нь хэрэгжихдээ бусад эрхүүдтэй мөн харилцан хамааралтай, уялдаатай болохыг хүлээн зөвшөөрөх нь зүй ёсны асуудал билээ. Тухайлбал сурч боловсрох, эвлэлдэн нэгдэх, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх зэрэг нь соёлын эрхээ эдлэх арга зам болж байдаг. Соёлын эрхээ хэрхэн эдэлж байгаа тухай асуудлыг хөндөн тавихад үндэсний цөөнхийн асуудлыг тусгайлан авч үзэх хэрэгцээ шаардлага урган гардаг.

* “Үндэсний цөөнх ба хүний эрх” бага хурал дээр тавьсан илтгэл /16.09.2005/

¹ Монгол улсын Үндсэн хууль, 1992 он, 2-р бүлэг, 14-р зүйл

Олон улсын гэрээ конвенцид тусгагдсанаар соёлын эрхийн асуудалд соёлын амьдралд оролцох, шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг аж амьдралдаа ашиглах, өөрийнхөө туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны аливаа бүтээлтэй холбогдон үүссэн ёс суртахууны болон эд материалын сонирхлыг хамгаалуулах явдлыг хамааруулан ойлгохоор заасан байна. Соёлын эрхийн хэрэгжилт цаатан иргэдийн хувьд ямар түвшинд байгаа тухай асуудлыг хөндсөн энэхүү хавсралт илтгэлийг Комиссын 2003 онд явуулсан судалгаанд түшиглэн хийж байгаа тул бүхий л хүрээг өргөн цар хүрээтэйгээр сонгон аваагүй, дутуу, нэмж, баяжуулах зүйл байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч байгаагаа хэлэхийг хүсч байна.

Цаатан иргэдийн соёлын эрхийн хэрэгжилтийн тухай ярихаас өмнө Комисс цаатан иргэдийг яагаад үндэсний цөөнх гэж үзэж болсон болон цаатан иргэдийн тухай товч танилцуулгыг хийе.

Үндэсний цөөнх гэдэг нь тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөнх болох хэл, арьсны өнгө, соёл иргэншлийнхээ хувьд ялгарах, өөрсдийн өвөрмөц байдлыг хадгалах хүсэл эрмэлзлэл бүхий тодорхой бүлэг хүмүүсийг хэлнэ.

*Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага,
Х.Виктор Кондэ, 102 дахь талд*

Хүний Эрхийн Үндэсний Комисс 2003 онд Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын нутаг дэвсгэрт амьдарч байгаа урианхай² буюу цаатан хэмээх цөөнх иргэдийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг судалсан болно. Өнөөдөр цаатан иргэдийн тухай олон нийтийн мэдлэг хангалттай биш, мэдлэгтэй гэж үзэж байгаа хэсгийн хувьд тэднийг үл тоох хандлага илүүтэй давамгайлах болсон байна. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулах төслийн хүрээнд 2001 онд хийгдсэн “Хүний эрхийн төлөв байдлын судалгаа³”-д цаатан иргэдийн эрхийн талаар хураангуй мэдээ оруулсныг эс тоошвол сүүлийн жилүүдэд цаатан иргэдийн хүний эрхийн хэрэгжилтийн талаар анхаарч судалсан судалгааны ажил байхгүй байна.

Цаатан хэмээн нэрийдсэн эдгээр бүлэг хүмүүс нь өөрийн хэл, соёл, шашин шүтлэгээрээ онцгойрч ялгарч буй бүлэг болохын хувьд үндэсний цөөнх болох юм хэмээн үзсэн болно. Комиссоос үндэсний цөөнх болох цаатангуудын эрхийн асуудлыг судлахдаа өөрийн соёл иргэншлээ хадгалж үлдэх, өөрийн шашныг шүтэх, төрөлх хэлээрээ ярих эрхээр хэрхэн хангагдаж байгааг онцлон авч үзсэн болно. Эдгээр цөөнх нь “тува”, “урианхай”, “духа” гэх мэтээр ялгагддаг боловч энэхүү хавсралт илтгэлд “цаатан” хэмээн нийтэд түгсэн нэрээр нь авсан. Хөвсгөл аймгийн Цагаан нуур сумын хоёрдугаар багийг бүрдүүлж байгаа цаа маллан тайгад амьдардаг уйгар угсааны тува /Духа/ хүмүүс нь Монгол Улсын үндэстний хамгийн цөөнх болно. Эдгээр хүмүүс нь ОХУ-ын Тувагийн нутаг хуучин Тожийн хүшуу, Тоду, Соён Кыргыз, Ханачи, Маат, Балыкчи, Хуулар овгийн Тува яс угшлын хүмүүс юм. Монголд ойн иргэд цаа буга өсгөн маллаж, хонь малладаг малчидтай зөрчилдөж байдаг тухай Ираны түүхчид 1310 оны үед бичсэн байдаг.

Цаатан иргэд нь Улаанбаатар хотоос 1000 гаруй, Хөвсгөл аймгийн төвөөс 300 гаруй, Цагааннуур сумын төвөөс 50-70 км алслагдсан, Монгол улсын нутаг

² С.Бадамхатан, Хөвсгөлийн цаатан угсаатан, 1960 он, 27дахь талд

³ Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал, 2001 он, 128 дахь талд

дэвсгэрийн хөвдөн бэлчээртэй, ян сарьдаг ууланд амьдардаг. Энд өвлийн улиралд цельсийн хасах 29-53 хэм хүртэл хүйтэрч, зуны улиралд цельсийн нэмэх 12-23 хэм хүртэл дулаарна. Уул нуруунууд нь далайн түвшнээс 2500-3500 метр өндөрт өргөгддөг, эрс тэс уур амьсгалтай.

2002 онд Цагааннуур суманд амьдарч байгаа цаатан иргэдийн судалгааг гаргажээ. Тус сумын 2 багт нийт 114 өрхийн 493 цаатан хүмүүс амьдарч байна. Хүйсийн хувьд 240 эрэгтэй, 255 эмэгтэй байна. Тэдгээрийн 39,9%-ийг 0-16 насны хүүхдүүд, 19,8%-ийг 17-25 насны залуучууд, 20,2%-ийг 26-35 насны хүмүүс, 15,2%-ийг 36-60 насны хүмүүс, 4,6%-ийг 60-аас дээш насны ахмадууд эзэлж байна. Цаатан иргэдийн соёлын эрхийн хэрэгжилтийг үндэсний цөөнх болох онцлогийг харгалзан дүгнэлтийг хийсэн юм. Тайгад нийт 45 өрхийн 210 цаатан цаагаа маллан амьдарч байна.⁴

Цаатан иргэдийн соёлын эрхийн хэрэгжилтийг соёлын амьдралд оролцох, шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг аж амьдралдаа ашиглах, өөрийнхөө туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны аливаа бүтээлтэй холбогдон үүссэн ёс суртахууны болон эд материалын сонирхлыг хамгаалуулах гэсэн хүрээнд гаргалаа.

Нэг. Соёлын амьдралд оролцох эрх

Соёлын амьдралд оролцох эрхийн тухайд нутгийн уугуул, цөөнхийн хувьд төрөлх хэл, шашин шүтэх, уламжлал, зан заншлаа хадгалах зэргийг багтаасан өөрийн соёлыг түгээх, хөгжүүлэх явдал хэмээн үздэг.

Өнөөдөр баруун зүүн хоёр тайгад амьдарч байгаа цаатан ардуудын дунд хуучин уламжлал, зан заншил, соёлоо нарийн мэдэх хүн бараг үлдсэнгүй. Шашин, зан заншлынх нь уламжлал, өвөрмөц хэв хэвшил ч дархадын⁵ соёлоос ялгарахаа больжээ. Манай хүн амын цөөнх болсон цаатан хүмүүсийн хэл, соёл, зан заншил, шашныг хуучин хэвээр нь хадгалан үлдээх бодит боломж нөхцөл ихээхэн хязгаарлагдмал байгаа бөгөөд орчин үед энэ нь улам ч хумигдаж байгаа билээ.

Сумын ИТХ-аас Цагааннуур сумыг 2002-2020 он хүртэл тогтвортой хөгжүүлэх зорилт, төлөвлөгөөгөө 2002 онд баталжээ. Тус төлөвлөгөөнд үндэсний цөөнхийн талаарх бодлогыг эрчимтэй хэрэгжүүлж, улс, аймгийн хүн ам зүйн бодлогод онцлон тусгуулах зүйлийг тусгажээ. Хөвсгөл аймгийн хэмжээнд болон Цагааннуур суманд үндэсний цөөнхийн онцлогийг тусгасан хөтөлбөр, арга хэмжээ байхгүй байна.

Өөрийн соёл иргэншлээ хадгалан үлдэх, өвлүүлэх эрх

Цаатан ардууд нь 3-4метрийн урттай, том урц бол 28-32, жижиг урц бол 17-23 мод орсон, брезентээр бүрсэн уламжлалт сууцандаа амьдарч байна. Өмнө нь ангийн болон цаа бугын арьс, модны холтсоор урцаа бүрдэг байсан бол 1970-аад оноос судалгаа явуулж байж, бүх урцыг брезентээр бүрэх болжээ. Социализмын үед цаатан иргэдэд байшин барьж өгч суурьшуулахыг оролдсон боловч тэд модон урцнаасаа салахыг түвдсэнгүй өдийг хүрсэн байна. Энэ нь тэдний цаа бугаа даган жилдээ 5-6 удаа нүүдэллэхэд хамгийн тохиромжтой сууц

⁴ Комиссын 2003 онд судалгаа хийх үед авсан тоо

⁵ Монгол үндэстэн нь ястангуудаас бүрддэг бөгөөд дархад нь ястнууд юм.

болдогтой холбоотой юм. Социализмын үед цаатангуудыг төвлөрүүлж суурьшуулах гэсэн оролдлого нь цаатангуудын амьдралын хэв маяг, уламжлалтай зөрчилдөж, улмаар тайгыг эзгүйрүүлэхэд хүргэж байсан бол өнөөдөр тэдэнд чиглэсэн ямар ч бодлого, зорилтгүй байгаа нь арга хэмжээгүй явж ирсэн нь энэ өвөрмөц амьдралын хэв шинжийг аяндаа мөхөж алга болох аюулд хүргэжээр байна.

Цаатан ардуудын бусдаас онцгойрон харагддаг зан заншлийн гол зүйлс гэвэл:

- гэр бүл болох /хуримлах, бэр буулгах/
- нас барагсдаа оршуулах /хүүхэд оршуулах/
- цаа сэтэрлэх
- ан авд мордох /онцолбол баавгай агнах/
- урц гэрээ барих

нүүж суух зэрэг төрөхөөс эхлээд жам ёсоор хорвоог орхих үе хүртэл амьдралын хугацаанд давтах үйлүүд болно. Цаатан ардуудын амьдралын хэв хэвшил дотор эртний овгийн байгууллын үеийн улбаа өнөө хэр хадгалагдсаар ирснийг тэдний зан үйлийг судалдаг гадаад дотоодын эрдэмтэд ажиглан мэдээлж байна. Тухайлбал, 2002 онд зүүн тайгын 10 өрхөд хийсэн судалгаагаар тэд хүнсээ /махаа/ ав адилхан хуваан авч, яг нэг өдөр хүнсээ дуусгаж байгаа жишээ болно. Мөн нас барагсдаа оршуулах зан үйлэнд ч их эртний хэв шинж хадгалагдаж байгаа юм. Цаатан ардуудын эд өлөг, хувцас хэрэглэл, гоёл чимэглэл, эдийн соёлын бүхий л өв уламжлал нь өнөөдөр бараг бүрэн устан үгүй болж байна. Тэд орчин үеийн шаардлагаар арьсан ауге гутал, богцноосоо аажим салж байгаа шигээ хэл соёл, зан заншлаа мөн бөхөөн орхиж байна. Өнөөдөр цаатан иргэдийн хувцас хэрэглэл бусад үндэстэн, ястнаас ялгарах юмгүй болсон нь судалгааны явцад ажиглагдсан.

Мөн түүнчлэн цаатан иргэд тайгад ургадаг олон сайхан ургамлыг өөрсдийн эрүүл мэндэд хэрэглэж ирсэн уламжлал байдаг хэдий ч европ эм, тариа хүчтэй орж ирсэн үеэс эхлэн энэ чиглэлийн уламжлал алдагдаж, одоо цөөхөн ахмадууд л энэ тухай мэддэг хэмээн ярьж байсан. Судалгаа хийж явах үед ажиглагдаж байсан зүйл бол зан заншил, уламжлалтай холбоотой олон асуудлыг ахмад үеийнхэн нь мэдэж байгаа хэдий ч түүнийгээ хойч үедээ өвлөн үлдээх асуудал аман яриагаар илүүтэй дамжиж байгаа бөгөөд тэдний талаар бичмэл түүх, соёлын материал бараг байхгүй байна. Үүнд Бадамхатан эрдэмтний 1960 онд бичиж хэвлүүлсэн цаатан ардуудын түүх, соёлын судалгааны ажлыг энэ чиглэлийн хамгийн дорвитой бүтээл хэмээн нэрлэж болох юм. Цаатан иргэдийн талаар ном, хэвлэл байхгүйн адил баримтат кино, болон эд өлгийн зүйлс байхгүй байгаа нь туйлын харамсалтай юм.

Өөрийн шашин шүтэх эрх

Цаатан ардууд нь бөөгийн шашин шүтсээр ирсэн. Социализмын үед бөө буух, удган зайран тодруулах нь хязгаарлагдмал байсан ч тэд шашин соёлоо хадгалсаар ирсэн юм. “Цаатан бөө нь дархад бөөгийн мөргөлтэй агуулга хэлбэрээрээ бараг адил. Гэхдээ эртний шинж, агуулга ёс дэглэмийг нэлээд хадгалсан, буддын шашны нөлөөнд ороогүй өвөрмөц шинжтэй байна”⁶ гэж С.Бадамхатан тэмдэглэжээ.

⁶ С.Бадамхатан, Хөвсгөлийн цаатан угсаатан, 1960 он, 37 дахь тал

Өнөөдөр баруун тайгад үе дамжсан онгодын эзэн ер гаруй настай Сууян удган энх тунх амьдарч байна. Судалгааны явцад цаатан ардуудын өрх бүр урц гэрийн хойморт эцэг дээдсийн нь сүнс сүлд шингэсэн онгод шүтээнээ залсан байсан. Харин нэг овог удмын цаатангууд өөр өөрийн тахиж шүтдэг онгон газар байдаг бөгөөд жилд 1-2 удаа очиж тахиж шүтэх ёс байдаг ажээ. Бидэнтэй уулзаж байсан улсын аварга цаачин Дагжий “Эцэг дээдсийн маань онгон Улаан-Уул сумын нутаг дахь хилийн зурваст ойрхон байдаг. Энэ онгон шүтээндээ очиход хилийн зөвшөөрөл авах гэж Улаан-Уул сум орох...Зөвшөөрөл өгөх хүмүүс нь байхгүй байх...Зөвшөөрөлгүй очоод тахиж шүтэх гэхээр хил зөрчигч хэмээн сэрдэгдэх гэх мэт бэрхшээл учирдаг тухайгаа ярьж байсан...” Өөр бусдаар бол өнөөдөр цаатан ардуудад итгэл үнэмшилтэй байх, өөрийн шашин шүтэх эрх нь зөрчигдөх, үүнээсээ үүдэж ялгаварлагдах явдал байдаггүй.

Төрөлх хэлээрээ ярих, суралцах, бичиж туурвих эрх

Цаатангууд тува, монгол хэлээр ярьдаг. Сумын дунд сургуульд тува хэлтэй боловсон хүчинг бодлоготойгоор бэлтгэж байсан. Одоогийн байдлаар цэцэрлэгийн багш 2, бага ангийн багш 2, дунд ангид хичээл заах тува хэл-уран зохиолын багш 1 бэлтгэгдсэн бөгөөд тэдгээрээс 3 нь сумынхаа сургуульд бага ангийн багшаар ажиллаж байна. Социализмын үед тус сургуульд Тувагаас мэргэжилтэн багш нар урьж тува хэлний хичээл орж байсан. Тухайн үед цаатан хүүхдүүдэд тува хэл бичиг зааж байсан энэ сайхан уламжлал одоо алдагджээ. Өнөөдөр цаатан хүүхдүүдэд төрөлх хэл, бичгийг заах цөөн ч гэсэн мэргэжлийн багш байгаа ч орон нутгийнхны хайхрамжгүй байдал сургуулийн захиргааны хөөцөлдлөг дутагдсанаас болоод хичээлийн хөтөлбөрөөс хасагдсан байна.

Цаатан ардууд өнөөгийн байдлаар тува хэлээ зөвхөн хоорондын харилцааны түвшинд л эзэмшсэн, ялангуяа хүүхдүүд тува хэлээр энгийн хэдэн үгээс цааш мэддэггүй байна. Дунд сургуульд тува хэлийг үзэхгүй байгаа нь төрөлх хэлээ мартахад хүргэж буйд ахмад хүмүүс сэтгэл нь ихэд эмзэглэж явдаг ажээ. Хэсэг цаатан ардын төлөөлөгчид төр засгийн удирдлагууддаа эх хэлийг нь дунд сургуулийн сурагчдад оруулдаг болгохоор хүсэлт уламжлаад байгаа бөгөөд УИХ-ын гишүүн Т.Ганди 2005 оноос тува хэлийг Цагааннуур сумын сургуульд заалгах боломжтой тухай хариу өгчээ. Комиссоос энэ чиглэлээр энэ онд ажил зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Хоёр. Шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг аж амьдралдаа ашиглах

Цагааннуур сум нь нийслэлээс 1000 гаруй км алслагдсан, цаатан иргэд сумын төвөөсөө 100 гаруй км-ийн алсад тайгад амьдарч байгаа өнөөгийн нөхцөлд шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг хүртэх эрх хангалттай хэрэгжиж байна хэмээн дүгнэх боломжгүй юм. Шинжлэх ухааны дэвшил нь зам тээвэр, харилцаа холбоо, анагаах ухаан, боловсролын бүхий л салбарт үсрэнгүй хөгжөөд байгаа өнөөгийн эрин зуунд цаатан иргэдийн амьдрал туйлын хүнд нөхцөлд байна. Тухайлбал Цагааннуур сумын эмнэлэгт хүндрэлтэй төрөх эмэгтэйчүүдийг эх барьж чадахгүй, аймгийн төв рүү шилжүүлдэг тухай судалгааны явцад яригдаж байсан. Тайгад амьдарч байгаа иргэд бие биетэйгээ болон нутгийн захиргааны байгууллага, эмнэлэг зэрэгтэй холбоо барихад хоёр тайгад 1,1 холбооны хэрэгсэл байдаг. Гэтэл тайгад амьдарч байгаа 40 гаруй өрхийн хувьд энэ нь хангалттай

холбоо барих хэрэгсэл болж чаддаггүй. Шинжлэх ухааны хөгжил дэвшил битгий хэл нутаг орныхоо сонинг ч цуу яриагаар дамжуулж авдаг нөхцөлд өнөөдөр цаатан иргэд амьдарч байна. Сонин, хэвлэл захиална гэдэг тогтсон орлогогүй ихэнх иргэдийн хувьд боломжгүй зүйл юм. Ийнхүү шинжлэх ухаан, техник, технологийн үрсэнгүй хөгжлийн энэ эринд цаатан иргэд мэдээлэлгүй, харанхуй нөхцөлд амьдарч байгаа нь шинжлэх ухааны хөгжлийн үр шимээс хүртэж чадахгүй байгаагийн илрэл хэмээн үзэж байна.

Гурав. Өөрийнхөө туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны аливаа бүтээлтэй холбогдон үүссэн ёс суртахууны болон эд материалын сонирхлыг хамгаалуулах

Социализмын үед орон нутгийг судлах музей байгуулсан бөгөөд цаатан ардуудын соёл зан заншилтай холбоотой олон сайхан үзмэрийг тухайн үед цуглуулж тус музейг байгуулсан байсан бол одоо энэхүү музей хаалгаа барьж, тэр ч байтугай ховор сайхан үзмэр нь алдагдсан хэмээн энэхүү музейг байгуулалцаж байсан иргэн Батаа гуай хэлж байсан. Анх энэ музейг байгуулж байх үед цаатан иргэд санаачлагатай оролцож, өөрсдийн аж амьдрал, соёл, уламжлалын өвөөс музейд хандивласан байна. Үндэсний цөөнх амьдардаг нутаг орны захиргаа, хурлын байгууллагууд энэ асуудалд ийнхүү хайнга хандсан нь дэндүү харамсалтай юм.

Цаа буга сан болон Тотем төслийн хүрээнд цаатан иргэдэд гар урлалын зүйлс хийх боломжийг олгож, багаж, хэрэгслээр хангаж байгаа нь чухал ач холбогдолтой зүйл мөн билээ. Цаатан иргэдийн соёл, зан заншил, уламжлалын талаар Үндэсний түүхийн Музейд ч мөн эд өлгийн зүйлс хомс байгаа нь цаатан иргэдийн соёлын эрхийг хангах үүргээ манай улс хангалтгүй биелүүлж байгаагийн тод жишээ юм. Үндэсний хөтөлбөрт үндэсний цөөнхийн соёл, зан заншлыг хадгалан үлдээх, төрөлх хэлээрээ суралцах боломжийг олгох гэх мэт зүйлийг тусгаж өгсөн нь чухал ач холбогдолтой арга хэмжээ юм хэмээн үзэж байна.

Судалгаа хийж явахад зарим цаатан иргэд төрийн бус байгууллага байгуулж, өөрсдийн соёл, уламжлалыг хойч үедээ өвлүүлэх арга хэмжээ авах тухай ярьж байсан ч байгууллагаа бүртгүүлэх, санхүүжилт олох зэрэгт ихээхэн бэрхшээл байдаг тухай ярьж байсан.

ЦАГДААГИЙН ХЭРЭГ БҮРТГЭЛТ БА ХҮНИЙ ЭРХ*

**Ж.Дашдорж,
ХЭҮК-ын гишүүн**

Монгол улс 1992 онд шинэ ардчилсан Үндсэн хуулиа баталж, хүний эрх, эрх чөлөө шударга ёсыг эрхэмлэн дээдэлж, хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах зорилго дэвшүүлсэн билээ. Иймд төрийн үйл ажиллагааны бүхий л салбарт ялангуяа хуулийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, хууль ёсыг чандлан биелүүлэх нь хуулийн байгууллага, тэнд ажиллаж буй хуульчдын үйл ажиллагааны гол зарчим байх ёстой.

Хуулийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох ялангуяа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг дэлхий нийтийн хүлээн зөвшөөрсөн хүний эрхийн суурь зарчмуудад тулгуурлан өөрчлөх нь шилжилтийн үеийн гол зорилт байсан.

Монгол улс хуулийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой олон чухал хууль тогтоомжийг шинчлэн өөрчилж, хуулийн байгууллагын тогтолцоо бүтцэд багагүй өөрчлөлт хийж, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийг шинчлэн баталж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хүний эрхийг хангах суурь зарчим баталгааг тусгасан нь онцгой ач холбогдолтой болсон. Шинэ хууль тогтоомжийг амьдралд хэрэгжүүлэх, байцаан шийтгэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь хуульчдын мэдлэг чадвар, сахилга хариуцлага, хүний эрхийн чиг хандлагаас шууд хамаарна. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хүний эрхийн тухай асуудлыг онцгойлон анхаарч хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажлын арга барилд нааштай ахиц өөрчлөлт гарч байгаа ч энэ ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөх, хууль ёсыг гажуудуулах явдал бүрэн арилахгүй байна.

Аль ч улс орны эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нөхцөл байдал нь тухайн улс орны хүний эрхийн нөхцөл байдлын нүүр царайг харуулж байдаг. Монгол улс НҮБаас батлан гаргасан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой 50 орчим гэрээ конвенцид нэгдэн орж эдгээр гэрээ конвенцид заасан хүний эрхийг хангах баталгааг биелүүлэх үүргийг дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн. Иймээс хульчид та бид дотоодын хууль тогтоомжоо мэддэг, мөрддөг байгаад зогсохгүй Монгол улсынхаа нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцийг мэддэг түүнийг хэрэглэдэг байх шаардлага тавигдаж байна. Монгол улсын Үндсэн хууль, манай улсын нэгдэн орсон гэрээ конвенц /Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэргийг, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц/-д тодорхойлон заасан хуулийн байгууллагын үйл ажиллагаанд ялангуяа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд мөрдлөг болговол зохих хүний эрхийг хангах суурь зарчмууд нь

* “Хүний эрх-Хэрэг бүртгэх ажиллагаа” сэдэвт Хэрэг бүртгэх албаны удирдах ажилтны нэгдсэн зөвөлгөөн дээр тавьсан илтгэл

хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчдын өдөр тутмын ажлын чиглэл, баримталбал зохих жишиг хэмжээ байх ёстой.

Олон улсын гэрээ конвенц болон дотоодын хууль тогтоомжид иргэн хүн халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур хэнийг ч нэгжих баривчлах, хорих мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно гэж заасан. Энэ нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хүний эрхийг сахиx гол баталгаа мөн. Гэвч гэм буруугүй этгээдэд үндэслэлгүйгээр хэрэг үүсгэх, яллагдагчаар татах, улмаар баривчлах, саатуулах, их бага хугацаагаар хорих зөрчил байсаар байна. Тухайлбал, 2003 онд 567, 2004 онд 713 хүнд холбогдох хэрэг шүүхийн шатанд хэрэгсэхгүй болгогдож байсан байна. Үүний нилээд хэсэг нь гэм буруугүй иргэдийг үндэслэлгүйгээр мөрдөн шалгаж, халдашгүй чөлөөтэй байх эрхийг нь зөрчсөн нь тодорхой. Хэрэг бүртгэх албаны мэдээгээр 2002-2004 онд жил тутам 4-9 мянган хэргийг хэрэг бүртгэлтийн шатанд хэрэгсэхгүй болгож байсан байна. Эмч хүн алдах эрхгүй гэдэгтэй адил хэрэг бүртгэгчид мөрдөн байцаагчид өөрсдийн үндэслэл муутай сэжиг таамаглалд хэт итгэж, гэм зэмгүй хүний халдашгүй эрхэнд халдаж, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах нэр төрд нь халдах эрхгүй. Энэ бол хүний эрхийн хамгийн ноштой зөрчил мөн. Бид хэнийг ч шалгах мөрдөх эрхтэй, эцэстээ хэрэг нь хэрэгсэхгүй болгогдох гэм буруугүй нь тогтоогдох нь байж болох ердийн зүйл мэтээр ханддаг, ойлгодог үзэл хандлагыг өөрчлөх шаардлагатай байна. Гэм зэмгүй хүнийг мөрдөн мөшигсөн нэр төрд нь халдсан, баривчилж саатуулсан, хорьсон хэрэг нь хэрэгсэхгүй болгогдсон тохиолдол бүрийг нарийн судалж, учир шалтгааныг тогтоож, гэм буруутай албан тушаалтанд ямар нэгэн хариуцлага сахилга тооцдог тогтолцоо зайлшгүй хэрэгтэй байна.

Шинэ хуулиар баривчлах болон цагдан хорих зөвшөөрлийг шүүгч өгдөг болсон нь зарчмын томоохон өөрчлөлт болсон. Олон улсын гэрээ конвенцид баривчлах цагдан хорих арга хэмжээг аль болох нийтлэг хэрэглэхгүй байх, хэрэглэхдээ аль болох богино хугацаагаар хэрэглэхийг чухалчлан заасан байдаг. 2000 онд шүүхээр 28000 хүн шийтгүүлсэн байхад 40 гаруй мянган хүнийг баривчилж цагдан хорьж байсан тухай мэдээ баримт байдаг нь энэ арга хэмжээг ямар өргөн хэмжээнд хэрэглэж байсныг харуулна. Шинэ хууль хэрэгжиж эхэлсэн 2 дахь жил 2003 онд 9000 хүн шүүхээр шийтгүүлж, 7000 орчим хүн баривчлагдаж цагдан хоригдсон тухай мэдээ гарч, шинэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш энэ арга хэмжээг нийтлэг хэрэглэх нь багасаж нааштай өөрчлөлт гарч байна гэж дүгнэж байсан. Гэвч энэ чиг хандлага тогтвортой байж чадаагүй болохыг энэ онд ганц худагт хийсэн шалгалтын дүн харуулж байна. ХЭҮК-оос 2001 оны 4-р сард Ганц худагт шалгалт хийхэд 793 хүн сэжигтэн болон яллагдагчаар цагдан хоригдож байсан бол 2005 оны 6-р сард шалгалт хийхэд 1009 хүн цагдан хоригдож, хоригдож буй хүний тоо бараг 30 шахам хувиар өссөн байна. Эргээд Ганц худгийн ачаалал байвал зохих хэмжээнээсээ хэтэрч, тэнд хоригдогсод эрүүл мэндээр муудах, сүрьеэ тусах, жингээ алдах зэрэг сөрөг үр дагавар ажиглагдах болсныг манай хэрэг бүртгэгчид, мөрдөн байцаагчид, прокурор, шүүгчид анхаарахгүй байж боломгүй. Энэ арга хэмжээг гарцаагүй тохиолдолд болж өгвөл богино хугацаагаар хэрэглэж байх нь хүний эрхийн үүднээс тавигдах гол шаардлага юм. Манай өнөөгийн цагдан хорих байрны нөхцөл байдал ч энэ шаардлагыг тавихад хүргэж байна. Манай улс 1999 онд хууль гаргаж цагдан хорих байрны ахуй нөхцлийн стандартыг тогтоосон ч энэ нөхцлийг хангасан хорих байр нэг ч алга байна. Цагдан хорих байрууд нар,

салхи, агаар, цэвэр усны байнгын дутагдалтай, харин нянгийн бохирдол чийгшэл ихтэй хүнд хатуу нөхцөлд байгаагаас урт удаан хугацаагаар хоригдогсоод эрүүл мэнд нь муудаж, өвчин эмгэг тусч, зарим тохиолдолд амь насаараа хохирох ноштой зөрчил ч гарсаар байна. Баривчлах цагдан хорих арга хэмжээг хүүхэд эмэгтэйчүүдийн тухайд онцлон анхаарч гарцаагүй тохиолдолд бага хугацаагаар хэрэглэхэд анхаарах ёстой. Гэсэнч хүүхэд эмэгтэйчүүд олон тоогоор удаан хугацаагаар хоригдож байна.

Шинэ эрүүгийн байцаан шийтгэх хуулиар сэжигтнийг баривчлах асуудлыг шүүгчид танилцуулж батлах журамтай ч хэрэгжилт нь анхаарал татаж байна. Энэ талаархи хуулийн заалтыг гуйвуулах хандлага ажиглагдаж байна.

2005 оны 6 сард ХЭҮК-оос Ганц худгийн цагдан хорих төвд хийсэн шалгалтаар 2005 оны эхний 6 сарын байдлаар нийт 978 хүнийг баривчилсны 919 хүн буюу 93.9 хувийг нь хойшлуулшгүй тохиолдол гэсэн үндэслэлээр баривчилж, үүнээсээ 59 хүний буюу дөнгөж 6 хувийнх нь тогтоолыг шүүхэд хүргүүлж батлуулсан байна. Үүнээс үзэхэд баривчлах явдал нь шүүхийн зөвшөөрөл, прокурорын хяналтаас үндсэндээ гадуур явж хэрэг бүртгэгч мөрдөн байцаагчийн дур зоргын асуудал мэт болсон гэхэд хилсдэхгүй. Нөгөө талаар бас нэг анхаарал татаж байгаа асуудал бол эдгээр 978 хүнийг бүгдийг нь хойшлуулшгүй ажиллагаа гэдэг нэрээр ажлын бус цагаар аваачиж хорьсон нь тухайн цагдан хорих төвийн улирлын мэдээнээс харагдаж байна.

Эрүүгийн хэрэг бүртгэлтийн ажиллагааны явцад нотлох баримтыг цуглуулахдаа эрүүдэн шүүх, хүнлэг бус хэрцгий хандах, нэр төрийг гутаан доромжлох, айлган сүрдүүлэх, тулган шаардах, хуурч мэхлэх, хүч хэрэглэх зэрэг хууль бус арга хэрэглэхийг хатуу хориглодог.

Манай улс “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенцид 2000 онд нэгдэн орж ЭБШ хуульд ч конвенцийн заалтууд тусгалаа олсон. Гэсэн хэдий ч хэрэгт холбогдогчтой хатуу ширүүн харьцах, хүч хэрэглэх, зодож цохих, өөр бусдаар дарамтлуулах, хэргээ хүлээхийг тулгах, өөр бусад хэрэг үүрүүлхийг оролдох зэрэг зохисгүй үзэгдэл ажиглагдсаар байна.

Хүний Эрхийн Үндэсний Комиссоос эдгээр хууль бус үйлдлийг таслан зогсоох, шалтгаан нөхцлийг илрүүлж арилгах зорилготой нэг жилийн хугацаатай, “Эрүүдэн шүүхийг хориглох нь” сэдэвт нээлттэй хяналт шалгалтын ажлыг хийж байна. Энэ арга хэмжээг Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг, Ганц худгийн цагдан хорих төвд зохион байгуулаад байна. Хоригдон шалгагдаж байгаа сэжигтэн, яллагдагч нараас хэргээ хүлээхийг тулган шаарддаг эсэх талаар авсан санал асуулгын дүнгээс харахад Дархан-уул аймагт хоригдож байгаа 87 хүний 26 нь буюу 29.8% нь, Сэлэнгэ аймагт хоригдож байгаа 19 хүний 31.5% нь, Төв аймагт хоригдож байгаа 93 хүний 35.4% нь, Ганц худгийн цагдан хорих төвд хоригдож байгаа 1009 хүний 44.5% нь тус тус тухайн сэжиглэж байгаа хэргийг хүлээлгэхийг тулган шаардсан буюу өөр ямар нэгэн төрлийн эрүүгийн хэргийг нэмж хүлээхийг тулган албадаж мэдүүлэг авдаг гэсэн хариулыг өгсөн байна. Зарим газар хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч хэргээ хүлээхийг тулгаж хүч хэрэглэж зодож гэмтэл учруулсан гэсэн ч асуудал тавьж байсан ба эмчид үзүүлэхэд бие эрхтэнд нь гэмтэл учруулсан нь ч батлагдаж байсан.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад эрүүдэн шүүж айлган сүрдүүлж, зодох, дарамтлах зэргээр харьцаж байсан эсэх талаар асуулга авахад Дархан-Уул аймагт 26.4% нь, Сэлэнгэ аймагт 26.3 % нь, Төв аймагт 20.4% нь, Ганц худгийн цагдан хорих төвд 36.7% нь тус тус хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын зүгээс дарамталж байсан, зодсон, айлган сүрдүүлдэг гэсэн хариулыг тус тус өгсөн байна. Энэ бүгдийг зуун хувь үнэн гэж үзэхгүй ч ямар нэгэн хэмжээгээр ийм зөрчил байгаа гэдгийг үгүйсгэхгүй байна. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид, эрүүгийн төлөөлөгчдийн зүгээс хүч хэрэглэсэн, зодсон, айлган сүрдүүлсэн, өөр бусдаар дарамтлуулсан тухай прокурор болон УЕП-ын дэрэгдэх мөрдөн байцаах албанд хэрэгт холбогдогч болон тэдний өмгөөлөгч, төрөл садангаас бага бус өрөгдөл гомдол гарч мөрдөн байцаалтын ажиллагаа явагддагч ихэвчлэн хэрэгсэхгүй болгогдон дуусдаг байна. Түүнчлэн хэргээ хүлээгээгүй, өөрийнхөө үйлдлийг гэмт хэрэг гэж үзэхгүй байгаа хүн ихэвчлэн цагдан хоригдож байгаа нь судалгааны явцад харагдаж байна. Хэргээ хүлээгээгүй хүнийг шоронгийн хүнд хатуу нөхцөлд удаан хоорино гэдэг бол мөн чанартаа эрүү шүүлт залхаан цээрлүүлэлт мөн гэж үзэхээс өөр аргагүй. Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагааг зөвхөн хэрэгт холбогдогчийг байцааж өөрөөр нь хүлээлгэж явуулахыг эрмэлздэг хуучирсан арга барилаасаа шийдвэртэй ангижрах шаардлагатай байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд сэжигтэн яллагдагчийн эрхийг хангах чухал баталгаа бол тэдний өмгөөлөгч авах эрхийг нь хангах асуудал мөн. Гэтэл өмгөөлөгчийг байцаан шийтгэх ажиллагаанд оруулхаас болж өгвөл зайлсхийх хандлага ажиглагдаж, өмгөөлөгч авахаараа л болохоо байчихдаг хэргээ хүлээж байсан хүлээхээ байчихдаг гэж зарим хэрэг бүртгэгчид ярьж байгаа нь өмгөөлөгчид яаж хандаж байгааг илтгэнэ. Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын явцад өмгөөлөгч авах эрхийн хэрэгжилт хангалттай биш байгааг дорхи судалгаа харуулж байна.

Дархан-Уул аймагт нийт хоригдогсдын 56.4% нь, Сэлэнгэ аймагт 47.3% нь, Төв аймагт 69.8% нь, Ганц худгийн цагдан хорих төвд хоригдогсдын 40% нь өмгөөлөгчөө сонгох эрх зүйн тусалцаа авах эрхийнхээ талаар мэддэггүй, өмгөөлөгч аваагүй байсан байна. Сүүлийн жилүүдэд гэмт хэрэгт холбогдогчдын дийлэнхи нь эрхэлсэн тодорхой ажилгүй, ар гэрээс нь анхаарал халамж тавих боломжгүй, төлбөрийн чадваргүй иргэд байгаа нь энэ үзүүлэлтэнд нөлөөлж байна. Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлж буй өмгөөллийн үйл ажиллагааны хөлсийг төрөөс санхүүжүүлж байгаа ч хэмжээний хувьд төдийлэн сайн биш байна. Энэ нөхцөлд өмгөөлөгчдийн холбоо ч дүгнэлт хийж, өмгөөлөгчдийнхөө дунд төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлэх хөдөлгөөн санаачлагыг өрнүүлэх дэмжих, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагатай хамтарч ажиллах шаардлагатай байна.

Зарим хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид байцаан шийтгэх ажиллагааны явцад өмгөөлөгчийн тавьсан санал хүсэлтийг хайхарч үздэггүй хүн гэж тоодоггүй, гомдол санал нилээд гаргадаг үйлчлүүлэгчдийнхээ төлөө уйгагүй явдаг өмгөөлөгчийг ад үзэх, ил далд хэлбэрээр шахалт дарамт үзүүлэх, тухайн хэргээс хөндийрүүлхийг оролдох зэрэг зохисгүй байдал гаргадаг тухай санал гомдол нилээд гардаг. Энэ бүхэн нь хэрэг бүртгэгчдийн зүгээс өмгөөлөгчид хандах хандлага, тэднийг үнэлэх үнэлгээ ямар байгааг харуулах дүр төрх мөн. Байцаан шийтгэх үйл ажиллагаанд өмгөөлөгч оролцох нь хэрэг бүртгэх ажиллагаанд хууль ёсыг хэрэгжүүлэх нэг

хөшүүрэг, хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч өөрийгөө хамгаалах нэг баталгаа гэж үзэж өмгөөлөгчид хандах хандлага үнэлгээгээ өөрчлөх шаардлага тулгарч байна.

Баривчлагдсан болон цагдан хоригдсон этгээдийн талаар ар гэрт нь мэдэгдэх, тэдэнтэйгээ хүссэн цагтаа уулзах боломжоор хангах асуудал аливаа хууль бус үйл ажиллагаа явагдахаас сэргийлэх, тийм үйл ажиллагаа хийгдсэн тохиолдолд цаг тухайд нь илрүүлж арилгах гол нөхцөл болдог. Цагдан хорих байруудад шалгалт хийх явцад хэргээ хүлээгээгүй гэдэг шалтгаанаар эргэлт уулзалт оруулахгүй байна гэсэн гомдол цөөнгүй гардаг. Хэргээ хүлээсэн хүлээгээгүй хэн боловч ар гэрийнхэнтэйгээ уулзах эргэлт авах эрхтэй байх ёстой. Одоогийн мөрдөж буй журмаар 7 хоногт зөвхөн 2 өдрийг эргэлт уулзалт авах өдөр болгон журамласан нь Ганц худаг мэт 1000 гаруй хүнтэй том газарт очер дараалал, ар өврийн хаалга үүсэх, зардал чирэгдэл гарах нөхцлийг бүрдүүлж байгааг холбогдох байгууллага эргэж харах шаардлагатай байна.

Байцаан шийтгэх ажиллагааны хүний эрхтэй холбоотой өөр нэг асуудал бол хохирогчийн эрхийг хамгаалах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал мөн. Хэрэг бүртгэх ажлын мэдээ тайлангаас харахад учирсан хохирлыг төлүүлсэн үзүүлэлт ихээхэн өндөр байгаа нь сайшаалтай боловч зарим талаар шүүмжлэлтэй хандахаас өөр аргагүй. Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд гэмт хэрэгт холбогдогчийн хөрөнгийг битүүмжлэх, хөрөнгө орлогыг олж тогтоох талаар төдийлөн хангалттай ажилладаггүй гэхэд хилсдэхгүй болов уу. ХЭҮК-оос 2003 онд нийслэлийн зарим дүүргийн шүүхүүдийн хянан шийдвэрлэсэн хулгай дээрэм, залилан, хүн амь, бусдын биед гэмтэл учруулсан 519 хэргийг хамруулан судалгаа хийж үзэхэд зөвхөн 33 хэрэгт хэрэгт хөрөнгө хамгаалах ажиллагаа хийсэн байсан нь энэ үйл ажиллагааг ихээхэн ховор хийдэг болохыг харуулсан баримт мөн. Эдгээр 33 тохиолдлын 28 тохиолдолд нь битүүмжилсэн хөрөнгийг хэрэгт холбогдогчид өөрт нь хадгалуулсан байсан ба өөрт нь хадгалуулсан хөрөнгө шийдвэр гүйцэтгэлийн шатанд очиход ихэвчлэн байхгүй болсон байдаг байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын мэдээ тайлангаас харахад эрүүгийн хэргийн тогтоолоор гаргуулсан төлбөрийн бодит биелэлт ихээхэн доогуур байгаа нь харагддаг. Энэ мэдээнээс үзвэл эрүүгийн хэргийн гурван хохирогч тутмын хоёр нь хохирол төлбөрөө үндсэндээ авч чаддаггүй байна. Тэгээд ч нэгэнт ял шийтгэл аваад явсан хүн хохирлоо төлөх магадлал маш бага байдаг. Иймээс хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд хохирлын хэмжээг зөв тодорхойлж, хөрөнгө хамгаалах, нуугдмал хөрөнгийг илрүүлэх ажиллагааг сайтар хийх шаардлага тавигдаж байна.

Шүүх, прокурор, хэрэг бүртгэгч мөрдөн байцаагчийн хууль бус үйл ажиллагааны улмаас хилс хэрэгт шийтгүүлсэн, үндэслэлгүйгээр баривчлагдсан, цагдан хоригдсон, ажлаасаа халагдсан, хөрөнгө санхүүгээрээ хохирсон этгээдийн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлөх асуудал иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх чухал арга хэмжээ билээ. Иймд хилс хэрэгт үндэслэлгүйгээр баривчлагдсан, хоригдсон, шийтгүүлсэн, мөрдөн мөшгөгдсөн этгээдийн хохирлыг барагдуулах нь хэрэг бүртгэгчдийн айж зайлсхийх биш харин санаа тавих ажил байх ёстой. Нэгэнт ажлын алдаа гаргаж хүн хохироосон бол адаглаад уучлал гуйдаг, цаашлаад хохирол төлбөрөө гаргуулах журам дүрмийг тайлбарлан ойлгуулдаг, хилс хоригдсон баривчлагдсан тухай лавлагаа өгдөг, холбогдох бичиг баримтыг олгодог ухамсартай байх ёстой. Гэтэл өрөгдөл гомдол гаргаж хохирол

төлбөрөө нэхэмжлэхээс болгоомжилдог, харин ч хохирол төлбөрөө нэхэх өрөгдөл гомдол гаргавал хэрэг материалыг дахин сөхөх, сэргээх сөрөг ажиллагаа хийдэг хандлага тохиолдолд гарч байсан нь харамсалтай. Жил дутам олон арван хүн урт богино ямар нэгэн хугацаагаар үндэслэлгүйгээр цагдан хоригдож эшст нь хэрэг нь хэрэгсэхгүй болгогддог боловч шүүхээр орж эд хөрөнгийн болон сэтгэл санаа, нэр төрийн хохирлоо гаргуулсан тохиолдол бараг байхгүй байгаа нь ийм байдалтай ч холбоотой байхыг үгүйсгэхгүй.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэргийн оролцогчдоод адил тэгш хандах, соёлтой харьцах, хүний нэр төрийг нь хүндэтгэх асуудал хэрэг бүртгэгчдийн ажлын нэг гол үзүүлэлт байх ёстой. Гэтэл зарим ажилтнууд хүмүүстэй зүй бус харьцах хулгайч зэлгийчээр нь дуудах, аль нэг талд нь ялгавартай хандсан тухай гомдол шүүмжлэл гарсаар байна. Саяхан манай комисст ирсэн авто аваарын хэрэгт холбогдсон нэгэн иргэний өрөгдөлд “хэрэг бүртгэгч намайг аль аймаг вэ гэж асууж би Хөвгөл аймаг гэж хариулхад Хөвсгөлийнхөн чинь их хараал хийдэг гэл үү ёо ёо гарын шөрмөс татчихлаа чи хараачихав уу” гэж инээж даапаалж байв гэж бичжээ. Гэхдээ түүний гомдол зөвхөн энэ үгэнд биш өөр зүйлд хандсан байсан.

Энэ мэтээр хэрэгт холбогдогчдыг дорд үзэх, дээрэнгүй хандах, хулгайч зэлгийчээр нь дуудах, тохуурхан даажигнах, гэм буруу нь нотлогдоогүй, шүүхийн тогтоол гараагүй байхад хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээ өгөх нь хүний нэр төрийг үл хүндэтгэсэн хууль бус үйлдэл мөн. Хэргийн холбогдогч хэн ч байсан түүнийг дарга, цэрэг, хөрөнгө чинээ, аливаа хэлбэрээр ялгаварладаггүй зөвхөн эрхэм хүн гэдэг үүднээс адил тэгш, шударга, хүнлэг, соёлтой харьцах нь хэрэг бүртгэгчдийн ёс үндсэн зарчим байх ёстой.

Энэ мэтээр хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажил гарч байгаа хүний эрхтэй холбоотой гол гол зөрчлийг тодорхойлоход ийм байна. Монголын хэрэг бүртгэх байгууллага улсын хэмжээнд гарч буй бүх хэргийн 70-80 орчим хувийн шалгаж шийдвэрлэдэг гээд бодоход мөрдөн шалгах ажлын ихэнх хүндийг манай хэрэг бүртгэгчид үүрч явдаг нь ойлгомжтой. Энэ хүнд бэрх ажлыг хийж гүйцэтгэхэд хэрэг бүртгэгч та бүхнээс илүү их мэдлэг чадвар, хүнлэг нинжин сэтгэл, ур ухаан, ажлын арга туршлага шаардагдана. Ялангуяа дотоодын хууль тогтоомжоо судлаад зогсохгүй олон улсын хүний эрхийн түгээмэл зарчим, гэрээ конвенцийг мэддэг түүнийг үйл ажиллагаандаа мөрддөг байх шаардлагатай.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд гарч буй хүний эрхийн зөрчил нь хуулийн байгууллагад дотооддоо мөрддөг дүрэм заавартай бас холбоотой байдаг. Хэрэг бүртгэх мөрдөн байцаах албанд мөрдөж буй ажил дүгнэх, цалин хөлс олгох, шагнал урамшилд тодорхойлох, цол хэргэм нэмэх зэрэгт хууль дүрмийг хэрхэн биелүүлсэн, хүний эрхийн зөрчил гаргасан эсэхийг нь гол үзүүлэлт болгон үздэг байх ёстой. Мөрдсөн, илрүүлсэн, торгосон, шийтгэсэн, ялласан, баривчисан зэрэг тоон үзүүлэлтийг хэт үнэлэх нь эцэстээ хүний эрх зөрчигдөхөд түлхэц болдог. Иймээс цагдаагийн систем энэ асуудлаараа хэлэлцдэг, доод дунд албан тушаалтнуудынхаа санал хүсэлтийг сонсдог дотоод ардчиллын тухай ч бодолцох зүйл байх ёстой. Энэхүү семинар зөвлөлгөөн нь хэрэг бүртгэх үйл ажиллагаанд хүний эрхийг зөрчихгүй байх, хууль ёсыг чанд мөрдөх ажлыг сайжруулахад чиглэгдэж байгаа тул зөвлөлгөөнд оролцогчдоод санал бодлоо чөлөөтэй ярьж үнэтэй санал шүүмжлэл өрнүүлж, зөвлөлгөөнөөс гарах уриалгыг хэрэгжүүлэхэд идэвх зүтгэл гарган ажиллана гэдэгт та бүхэнд найдаж байна.

ХЭРЭГ БҮРТГЭХ АЖЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЗОРИЛТ*

Л.Сүхээ,
Цагдаагийн ерөнхий газрын Хэрэг бүртгэх
Газрын дарга, цагдаагийн хурандаа

Хэрэг бүртгэх албаны удирдах ажилтнууд, зөвлөлгөөнд урилгаар оролцож байгаа зочид та бүхний энэ өдрийн амрыг эрж, мэндчилгээ дэвшүүлье.

Нийгмийн өөрчлөлт, эрх зүйн шинэчлэлийг гүнзгий мэдэрч, Монгол Улсын Үндсэн хууль, Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан шаардлагын дагуу хэрэг бүртгэх ажлыг явуулж, хүний эрхийг тууштай хамгаалах хэрэг бүртгэх албаны удирдах ажилтны удирдлагын арга барилыг өөрчлөн шинэчлэхэд бидний анхаарал төвлөрөх ёстой.

Тус алба байгуулагдсан цагаасаа эхлэн үйл ажиллагаандаа хуулийг дээдэлж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, албадын хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэрэг ялангуяа хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг ахиулах, ёс зүйг төлөвшүүлэх зэрэг тодорхой зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Энэ хүрээнд “Алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, хуулийг дээдлэн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын арга барилыг боловсронгуй болгох” эрхэм зорилгыг дэвшүүлэн тодорхойлж, бүхий л ажлаа чиглүүлж байгаа нь Хэрэг бүртгэх ажиллагаанд хүний эрхийг хамгаалахад зарчмын чухал ач холбогдолтой болсон юм.

“Хэрэг бүртгэх албаны дүрэм”, “Алба хаагчдын ёс зүйг төлөвшүүлэх ажлын стандарт”-ыг батлан мөрдүүлж, албаны сургалтын агуулгыг шинэчлэн өөрчлөх асуудлыг боловсруулж байна.

Манай удирдлагын менежмент нь Хэрэг бүртгэх албаны болон алба хаагчдын гүйцэтгэх үүргийг оновчтой тогтоох, ажлын байрны тодорхойлолтыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх, хүний цогц хөгжлийг хангах, тэдний ажлыг бодитой шударга үнэлэх, хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хэрэг бүртгэх ажлыг мэргэжлийн болон зохион байгуулалтын удирдлагаар хангах, арга хэлбэрийг боловсронгуй болгох зэрэг асуудлуудад чиглэгдэх ёстой.

“Хүний эрх-хэрэг бүртгэх ажиллагаа” сэдвээр болж байгаа өнөөдрийн зөвлөлгөөний анхаарал ч үүнд чиглэх ёстой гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулинд хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулах тухай онцлон заасан нь хүний эрхийг тууштай хангах улс төр, эрх зүй, эдийн засгийн шинэ нөхцөл, баталгааг бий болгосон юм.

* “Хүний эрх-Хэрэг бүртгэх ажиллагаа” сэдэвт Хэрэг бүртгэх албаны удирдах ажилтны нэгдсэн зөвлөлгөөн дээр тавьсан илтгэл

Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр 1990 оноос Монголын төр засаг, хууль хянал, олон нийтийн байгууллагуудаас өргөн хүрээтэй ажил зохиож тодорхой үр дүнд хүрч байгааг бид сайн мэднэ. Эдгээрийн нэг гол чиглэл нь төр засагт хуулийн байгууллагуудын тогтолцоог хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг бодитой хангах, үйлчилгээг нь иргэдэд ойртуулахад анхаарч байгаа явдал юм.

Үүний нэг тодорхой жишээ нь 2002 онд Хэрэг бүртгэх албыг биеийг нь даалган зохион байгуулснаар уг албыг нэгдмэл бодлого, цогц байдлаар хөгжүүлэх, хүний эрхийг тууштай хамгаалах, мэргэжил ур чадвар, хууль ёсонд түшиглэсэн цоо шинэ тогтолцоог бүрдүүлсэн явдал юм.

Ингэснээр цагдаа, тагнуул, цэрэг, татвар, гааль зэрэг олон газарт өөр өөрсдийн салбарын явцуу эрх ашигт үйлчилж, харьяалах эзэнгүй урсгалаар явагдаж байсан хэрэг бүртгэх ажлыг Хэрэг бүртгэх албанд нэгтгэн төвлөрүүлэв.

Хэрэг бүртгэх газар нь монгол Улсын Эрүүгийн хуулийн олон бүлэг, зүйлд заасан хамгийн түгээмэл гардаг цэрэг, гааль, татварын зэрэг олон өнгийн адармаа түвэгтэй хэргүүдэд эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар хэрэг бүртгэх ажиллагаа явуулдаг эцсийн дүндээ Эрүү, эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэрэгжилтийн хувь заяаг Монгол төр, иргэдийн өмнө хариуцдаг өвөрмөц үүрэг хариуцлага бүхий мэргэжлийн төв байгууллага болон хөгжиж байна.

Хэрэг бүртгэх алба байгуулагдаад 3 жил болж байгаа хэдий ч монголын цагдаагийн байгууллагын тогтолцоонд томоохон байр эзэлж, мэргэжлийн алба болон өргөжиж байна.

2002 оны 9 дүгээр сарын 01-нээс хойш энэ оны 9 дүгээр сар хүртэлх 3 жилийн хугацаанд улсын хэмжээгээр 120126 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаж шийдвэрлэсэн нь жилд дунджаар 38.0-40.0 мянган гомдол оногдож байна.

Энэ нь улсын хэмжээний цагдаагийн байгууллагын хүлээн авсан бүх гомдлын 68.0-75.0 хувийг эзэлж байна.

Хүлээн авсан гомдол мэдээллийг хэргийн өнгөөр нь ангилан үзвэл бүх гомдлын 21.9 хувь буюу 26347 нь танхайрах, 21.1 хувь буюу 25388 нь иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг, 9.8 хувь буюу 11733 нь хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг шинжтэй гомдол мэдээлэл тус тус эзэлж байна.

Жилд хүлээн авсан бүх гомдол мэдээллийн 99.3-99.5 хувийг шалган шийдвэрлэж байгаагийн зэрэгцээ 99.6-99.8 хувийг хуулийн анхны хугацаанд барагдуулжээ.

Төв, орон нутгийн хэрэг бүртгэх албад 2002 оны 9 дүгээр сараас өнөөдрийг хүртэл 3 жилийн хугацаанд нийтдээ 44930 холбогдогчтой 49723 эрүүгийн хэрэг шалгасан нь жилд дунджаар 16.0 мянган хэрэг оногдож байна.

Энэ нь улсын хэмжээнд бүртгэгдсэн эрүүгийн хэргийн 70 гаруй хувьд хэрэг бүртгэх ажиллагаа явуулж байна гэсэн үг юм.

Шалгасан бүх хэргийн 32.0 хувь буюу 15937 хэрэгт ялын дүгнэлт үйлдэж, 42.7 хувь буюу 21214 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай тус тус прокурорт шилжүүлж, 14.4 хувь буюу 7159 хэргийг харьяалхын дагуу шилжүүлж шийдвэрлэн жилд дунджаар шийдсэн бүх хэргийн 94.7-98.5 хувийг хуулийн анхны хугацаанд шийдвэрлэжээ.

Энэ хугацаанд шинээр эрүү үүсгэсэн хэргийн 60.3-71.2 хувийг хулгай, булаалт, залилан зэрэг бусдын өмчийн эсрэг хэрэг, 18.9-19.5 хувийг хүний эрүүл мэндийн

эсрэг, 12.1-16.0 хувийг танхайн, 7.3-8.5 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Шинээр эрүү үүсгэн шалгаж байгаа хэрэг нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд зөвхөн 2004 онд 13162 хэрэгт шинээр эрүү үүсгэсэн нь урьд оныхоос 11.3 хувиар ахисан байна.

Энэ нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шинээр нэмэлт өөрчлөлт орж, хулгай, мал хулгайлах гэмт хэргийг үндсэндээ манай албанд бүрэн харьяалуулах болсонтой холбоотой юм.

Хөнгөн, хүндэвтэр хэргийн илрүүлэлт жил тутам ахиж 89.4 хувьд хүрсэн нь улсын дунджаас 13.1 хувь дээгүүр байна.

Гэмт хэргийн улмаас 3 жилийн хугацаанд иргэд байгууллагад нийтдээ 12 тэрбум 791.0 сая төгрөгийн хохирол учирснаас 60.8 хувь буюу 8 тэрбум 452.4 сая төгрөгийн хохирлыг барагдуулж, 244.7 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжлэн хамгаалав. 8 тэрбум төгрөгийн хохирол барагдуулсан нь тус газрын 10 жилийн төсвийн мөнгөтэй тэнцэж байна.

Татварын болон байгаль орчны байгууллагуудтай хамтран ажиллаж улсын төсөвт 7.8 тэрбум төгрөгийн орлого оруулж улсын төсвийн бүрдэлтэнд тодорхой хувь нэмэр оруулаа.

Гэмт хэргийг халуун мөрөөр нь шуурхай илрүүлэх, нөхөн илрүүлэх асуудал манай албаны гол үүргийн нэг юм. Өнгөрсөн хугацаанд улсын хэмжээгээр нийтдээ урьд онуудын 1714, тухайн оны 843 хэргийг нөхөн илрүүлж, 9626 хэргийг халуун мөрөөр нь илрүүллээ.

Эдгээрийн дүнд урьд онуудын 11063 хэргийг сэргээн шалгаж шийдвэрлэлээ.

Энэ нь жилд дунджаар 3.0-4.0 мянга орчим түдгэлзүүлсэн хэргийг сэргээн шалгаж шийдвэрлэлээ гэсэн үг юм.

Албаны хэмжээгээр жилд дунджаар 1200-1800 эрүүгийн хэрэг түдгэлзүүлж байгаагийн 800-1000 нь эзэнгүй, 300 нь оргосон үндэслэлээр түдгэлзүүлсэн судалгаа байна.

Оргодол эрэн сурвалжлах ажлыг байнга тасралтгүй зохион байгуулж Хэрэг бүртгэх газарт эрэн сурвалжлах ажил хариуцсан ахлах байцаагчийн орон тоог бий болгох зээг тодорхой бодлого боловсруулан ажилласнаар 3 жилийн хугацаанд урьд онуудын 2120, тухайн оны 1741 оргодлыг олж баривчлан холбогдох хэргүүдийг шийдвэрлэлээ.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгуулахад анхаарч хэрэг бүртгэгчийн мэдэгдэл 7162-ыг бичсэн байна.

3 жилийн дүнгээр авч үзэхэд иргэдийн гомдлыг шуурхай барагдуулах, эрүүгийн хэргийг хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэх талаар Хэнтий, Орхон, Дорнод, Сүхбаатар, Өмнөговь аймаг, Нийслэлийн Чингэлтэй, сонгинохайрхан, Багануур дүүргийн Хэрэг бүртгэх тасгийн хамт олон ихээхэн санаачлагатай бусдаасаа илүү үр дүнтэй ажиллаж байна.

Үүнийг тухайн хамт олныг удирдан зохион байгуулж байгаа дарга нарын удирдлагын менежментийг зөв оновчтой хэрэгжүүлсний үр дүн гэж зүй ёсоор үнэлж байна.

Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх цагдаагийн газрын Хэрэг бүртгэх тасгийн дарга, цагдаагийн хошууч Я.Мөнхдэлгэр иргэдийн гомдол мэдээлэл,

эрүүгийн хэргийн хугацаанд графикаар хяналт тавьж, хэргийн нотлох баримтын бүрдэлтэнд тогтмол анхаарч, мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байгаагийн дүнд тус тасгийн ажлын чанар үр дүн сайн байна.

Дээрхи байдлуудаас үзэхэд хэрэг бүртгэх ажлын хэмжээ далайц байнга өсөн нэмэгдсэн ч ажлын чанар, үр дүн жил тутам ахижээ. Нөгөө талаас нь авч үзвэл хэрэг бүртгэх ажлын явцад хүний эрхийг хамгаалах ажилд бодитой хувь нэмэр оруулах үүргээ биелүүлэх хариуцлага улам дээшилж байгааг харуулж байна.

Энэ бүгд нь хэрэг бүртгэгч нарын мэргэжлийн ур чадварын өсөлт, манай хамт олны бүтээлч хандлагын илрэл юм. Бид энэ бүхнээрээ бахархах ёстой.

Гэвч манай аижлд даруй засаж арилгуштай дутагдал ч байсаар байгааг хэлэхгүй өнгөрч болохгүй. Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймаг, Нийслэлийн Баянгол, Хан-Уул, Сүхбаатар дүүргүүдэд илрээгүй болон түдгэлзүүлсэн хэрэг харьцангуй олон байгаад дүгнэлт хийж ажиллах шаардлагатай байна.

Мөн иргэдийн гомдол мэдээллийг шуурхай шалгадаггүй удаадаг, дутуу дулимаг шалгадаг, дахин явуулж чирэгдүүлдэг, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг иргэнд нь мэдэгдэхгүй орхидог зөрчил дутагдал нийтлэг, давтагдах өнгө аястай байна.

Хэрэг бүртгэлтийн ажиллагааны явцад процессийн зөрчил гаргах явдал ч үзэгдсээр байна. Хэргийг ялих, ялихгүй шалтгаанаар түдгэлзүүлж, хохирогчийн эрх ашгийг ноцтой зөрчиж, чирэгдүүлж байгаа байдал ч ажиглагдаж байна. Түүнчлэн прокуророос гологдол болж хэрэг буцах тохиолдол ч таслан зогсоогдохгүй байна.

Хэрэг бүртгэгчдийн дотроос үүрэгт ажилдаа хайнга хариуцлагагүй хандах, цагдаагийн болон хэрэг бүртгэгчийн ёс зүйг гажуудуулах явдал нэг бус удаа гарсаар байна.

Өнөөдрийн зөвлөгөөний зорилго нь хэрэг бүртгэх ажилд оршиж байгаа ололт амжилтыг бататгах, доголдол дутагдлыг арилгах замаар хүний эрхийг зөрчихгүй байх бодит боломжийг бүрдүүлэхэд чиглэх учиртай. Энэ үүднээс дор дурьдсан цөөн хэдэн асуудалд Хэрэг бүртгэх албаны удирдах ажилтнууд Та бүхний анхаарлыг төвлөрүүлэн ажиллах шаардлагатай байна.

1. Хариуцсан хэлтэс, тасгийнхаа 3 жилийн ажлын явц байдалд иж бүрэн шинжилгээ хийж өсөж, буурч буй үзүүлэлтийн шалтгаанд ажилтнуудынхаа хариуцлага сахилгын байдалтай холбон бодитой дүгнэлт хийж ажиллавал зохино.

Судалгаа, дүн шинжилгээ хийж удирдлагын хийдэл гаргахгүй ажиллах нь чухал ач холбогдолтой болохыг зориуд тэмдэглэж байна. Сар улирлынхаа ажлыг дүгнэхдээ ч ийм байдлаар хандаж хэвших хэрэгтэй.

2. Манай албаны тухайд шинэ байгууллагыг өсгөн бэхжүүлэхтэй холбогдсон олон тооны асуудлыг шуурхай шийдвэрлэх явдал тулгамдсан зорилт болж байгаагаараа цагдаагийн бусад албадаас онцлог юм.

Эдгээрээс хамгийн хүнд, хамгийн чухал нь шинэ хандлага, шинэ арга барил эзэмшсэн, мэргэжлийн өндөр ур чадвартай, ёс зүйн төлөвшил сайтай мэргэшсэн хэрэг бүртгэгчийг бий болгох, тэдний эгнээг өргөжүүлэх асуудал мөн.

Манайд одоо 400 шахам алба хаагч ажиллаж байгаагаас 258 хүртэл насны залуучууд 16.6 хувь, 1-3 жил ажиллаж буй шинэ хүмүүс 43.0 хувийг эзэлж байна.

Иймд шинэ залуу ажилтнуудыг төлөвшүүлэх, хэрэг бүртгэгчийн ажилд сурган дадлагажуулахад дарга, ахлахын анхаарал, хайр халамж “ус-агаар” шиг үгүйлэгдэж байгаа хамгийн “том” хэрэгцээ гэж томъёолж болох байна.

Хөгжилтэй орнуудын туршлагаас үзэхэд шинэ залуу ажилтнуудыг мэргэжшүүлэхэд наад зах нь 3-5 жил, хувийн амьдралдаа зохих байр суурь боломжоо хангахад 10-15 жил хэрэгтэй байдаг байна. Үүнээс үзэхэд бидэндхэрэг бүртгэгчдийг мэргэшүүлэх, хөгжүүлэх, төлөвшүүлэх чиглэлээр нөр их ажил хийх шаардлага байна.

3. Цагдаагийн нийт ажлын 70 гаруй хувийг эзэлж байгаа хэрэг бүртгэх ажлын хувь заяа удирдах ажилтан Та бидний ажилд хандах хандлага, удирдлагын арга барилаас шууд хамаарч байгааг ухаарч ажиллах хэрэгтэй байна.

Хаана удирдлагын арга нь хоцрогдсон, зарчимч шаардлага дутагдсан, хүнээ хөгжүүлэх ажлыг орхигдуулж байна тэнд тэр ажлын эцсийн үр дүн буурч, хуулийн зөрчил бусдаас илүүтэй гарч, хүний эрх зөрчигдөж байдгийг амьдрал нотолж байна.

4. Хулгайн хэрэгтэй тэмцэх ажлын хандлага арга барилыг өрчлөн шинэчлэхэд гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллахыг төр, иргэд биднээс байнга шаардсаар байна.

Бид нарын нэрлэж хэвшсэнээр “жигжиг гэмт хэрэг” гэж нэрлэгддэг улсын хэмжээнд үйлдэгдэж буй хэргийн 40 гаруй хувийг эзэлж байгаа хулгайн гэмт хэрэг, энгийн иргэдийг их зовоож төвөг учруулж илрүүлэлт нь хамгийн доогуур түвшинд байгаа нь цагдаагийн бүх шатны удирдлагын арга барилыг өөрчлөхийг шаардсан хамгийн тулгамдсан асуудал гэдгийг зөвлөлгөөний энэ хүндэт индрээс онцлон тэмдэглэж байна.

Энэ үүднээс хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын зохион байгуулалтыг ойрын үед боловсронгуй болгох арга хэмжээ авах шаардлага ч байна.

Түүнчлэн улс орныг хамарсан малын хулгайн хэргийн бүхэл бүтэн сүлжээ бий болсныг анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хууль гарсан нь бидэнд төр, засаг ард иргэдийн хүч туслалцааг авах шинэ боломжийг бүрдүүлэв. Үүнийг соргогоор тусгаж санаачлагтай ажиллан малын хулгайн хэргийг бууруулах бололцоо ч бидэнд бий. Энэ боломж тэр бүр бүрэн дайчлагдахгүй байна. Малын хулгайн хэргээр дагнан мэргэшсэн хэрэг бүртгэгчдийг сургаж бэлтгэх явдал ч чухал байна.

5. Түдгэлзүүлсэн хэргүүдийг шийдвэрлэх чиглэлээр эрс зоримог өөрчлөлт хийх асуудал манай дарга нарын ур ухааныг шалгасан шийдэл хүлээсэн ажлын нэг юм.

Энэ талаар зарим ажил хийгдэж байгаа ч нийгмийн өнөөгийн өндөр шаардлагыг тэр бүр хангахгүй байна. Сүүлийн үед иргэдээс ирж буй гомдлын дийлэнхийг түдгэлзүүлсэн хэргийг шийдвэрлэхтэй холбогдсон асуудал эзэлж байна.

Шинээр хэрэг түдгэлзүүлэх асуудлыг онцгой учралд тооцож дарга нар өөрсдийнхөө хяналтандаа авах нь зүйтэй.

6. Өнөөдөр улс орны хэмжээнд эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал ээдрээ төвгтэй хүнд байгаагийн гадна, зарим шинэ төрлийн гэмт хэргүүд гарах

болж, гэмт этгээдүүдийн арга барил улам бүр нарийсч, зохион байгуулалттай байдалд шилжиж байгаа нь хэрэг бүртгэгчдээс байнгын мэргэжлийн өндөр үр чадвар шаардаж өчигдрийн мэдлэг боловсрол дадлагаар өнөөдөр ажиллах боломжгүй болжээ.

Үүнийг хэрэг бүртгэх албаны удирдах ажилтанд тавигдаж байгаа нийгмийн шинэ захиалга, шаардлага гэж ойлговол зохино.

7. Хуулийн өмнө иргэн бүхэн тэгш байх зарчим, хохирогч, сэжигтэн, яллагдагч зэрэг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын хууль ёсны эрхийг хамгаалах асуудлыг хэрэг бүртгэгч хэрхэн яаж хангаж байгааг албадын дарга, ахлахууд байнгын хяналтандаа авч ажиллах явдал чухал байна. Үүнтэй холбоотойгоор хэргийн гологдлыг даргын ажлын гологдол гэж үзэж үнэлэлт өгдөг журам тогтоож мөрдүүлэх шаардлага ч байна.

Эцэст нь тэмдэглэхэд өнөөдрийн зөвлөлгөөнөөс Хэрэг бүртгэх албаны ажилтан, цагдаагийн алба хаагч нарт хандаж хууль хэрэгжүүлэх ажиллагаанд хүний эрхийг тууштай хангах ажлыг бодитой хэрэгжүүлэх зорилгоор уриалга гаргахаар шийдвэрлэлээ.

Уриалгыг Та бүхэн хүлээн авч дэмжин, хэрэгжүүлж ажиллана гэдэгт итгэж байна.

Та бүхэнд хууль хэрэгжүүлэх, хүний эрхийг хангах хариуцлагатай ажилдаа урьд урьдынхаас өндөр амжилт гаргахыг хүсэн ерөөе.

“ЦААТАН-21” ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ОРШИЛ

МУ-ын Хүний эрхийн Үндэсний Комиссоос Канад сангийн санхүүгийн дэмжлэгтэй “Цаатан-21” төслийг 2004-2005 оны хооронд хэрэгжүүлж дууслаа. ХЭҮК-ын хувьд уг төслийг хэрэгжүүлэх болсон дараах үндэслэл, шаардлага байсан юм. Үүнд:

- Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд зааснаар тус Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих байгууллага мөн. ХЭҮК-ын Стратеги төлөвлөгөөний Зорилт 1.3-т “Нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн эрхийн талаар судалгаа, хяналт шалгалтын ажлыг тогтмол хийж, тэднийг эрхийнхээ төлөө тэмцэх чадварыг сайжруулахад нөлөөлөх” гэж заасан бөгөөд тус зорилтын хүрээнд “цаатан иргэдийн эрхийн хэрэгжилтийг дээшлүүлэхэд чиглэсэн жижиг хэмжээний төсөл боловсруулж, хэрэгжүүлэх” үйл ажиллагааг төлөвлөсөн байна. Эдгээр заалтууд нь уг төслийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болж байгаа юм.
- Хөвсгөл аймгийн Цагааннуур суманд оршин суух цаатан иргэд нь манай улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөн бөгөөд хэл яриа, соёл, зан заншил, шашин шүтлэгийн хувьд ялгаатай үндэстний цөөнх мөн билээ. Гэвч сүүлийн жилүүдэд амьжиргааны эх үүсвэрийн хомсдол, ажилгүйдэл, ядуурал зэрэг бэрхшээлээс гадна соёл, зан заншлыг нь хадгалах, өвлүүлэх, нийгмийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүргэх талаар төрийн бодлого, зохицуулалт дутагдсаны улмаас цаатан иргэдийн зан заншил, соёл уламжлалд мөхөх аюул нүүрлээд байгаа юм. Иймээс тэдгээр иргэдийн эрхийг хангуулах талаар төрийн бодлогод нөлөөлөх, эрхээ эдлэх явдлыг нь хөхиүлэн дэмжих нь хүний эрхийн үндэсний байгууллагын хийвэл зохих ажлын нэг мөн юм.

Уг төсөл нь үндэсний цөөнхийг ойлгох, хүндэтгэх, эвсэн найрамдах хандлагыг олон нийтэд төлөвшүүлэхэд нөлөөлөх зорилготой бөгөөд энэхүү зорилгынхоо хүрээнд дараах тусгай зорилтуудыг дэвшүүлэн тавьсан юм. Үүнд:

- Цаатан хүүхдүүдэд төрөлх хэлээ дунд сургуульд сургах боломжийг судлах, цаатан иргэдэд амьдралын уламжлалт хэв маягаа хадгалан үлдэхэд нь туслах
- Цаатан иргэдийг үндэсний цөөнхийнх нь хувьд хөгжүүлэх, тэдгээр иргэдийн нийгмийн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах
- Цаатан иргэдийн иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн болон соёлын эрхээ эдлэх таатай нөхцлийг бүрдүүлэхэд туслах зэрэг болно.

Төслийн багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсан болно.

- С.Цэрэндорж, ХЭҮК-ын дарга, доктор (Ph.D), Төслийн удирдагч
- Б.Хишигсайхан, ХЭҮК-ын ажлын албаны дарга, Төслийн зохицуулагч
- П.Оюунчимэг, ХЭҮК-ын ахлах референт, Багийн гишүүн
- Г.Золжаргал, ХЭҮК-ын референт, Багийн гишүүн
- А.Саруул, ХЭҮК-ын мэргэжилтэн, Багийн гишүүн

Төслийн хүрээнд явуулсан үйл ажиллагааг үндэстний цөөнхийн эрхийн асуудлаар зохион байгуулсан сургалт, сурталчилгааны ажил, цаатан иргэдийн эрхийн төлөв байдлыг дээшүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ, цаатан иргэдийн эрхийн асуудалд холбогдох байгууллагуудын анхаарлыг хандуулах чиглэлээр авсан арга хэмжээ гэж ангилж болох бөгөөд эдгээр үйл ажиллагаа бүрийг тус бүрд нь дэлгэрэнгүй танилцуулья.

НЭГ. ҮНДЭСТНИЙ ЦӨӨНХИЙН ЭРХИЙН АСУУДЛААР ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ

Үндэстний цөөнхийн эрхийн асуудлаарх сургалт сурталчилгааны ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг явууллаа. Үүнд:

- Иргэд зориулсан гарын авлага, эвхмэл хуудас бэлтгэх, түгээх
- Үндэстний цөөнхийн эрхийн асуудлаар насанд хүрэгчид болон хүүхдүүдийн дунд эссе, зохион бичлэгийн уралдаан зарлах
- Цаатан иргэдийн талаар ТВ-ийн богино хэмжээний баримтат кино хийж, нийтийн хүртээл болгох
- Нутгийн төр, захиргааны байгууллагуудын ажилтнуудад сургалт зохион байгуулах
- Цаатан иргэдэд хүний эрхийн боловсрол олгоход чиглэгдсэн арга хэмжээ зохион байгуулах
- Нутгийн ТББ, олон нийтэд зориулсан сургалт зохион байгуулах

1.1 Иргэдэд зориулсан гарын авлага, эвхмэл хуудас

ХЭҮК-ын хийсэн ажиглалт, судалгаануудаас төл суурингаас алслагдах тусам иргэдийн эрх зүйн мэдлэг хомс, эрх зүйн туслалцаа авах нөхцөл боломж хязгаарлагдмал болж улмаар эрх ашиг нь хохироход хүрч байгаа нь ажиглагддаг юм. Иймээс цаатан иргэдэд тулгамдаад байгаа асуудлуудад хууль эрх зүйн үүднээс тайлбар өгөх гарын авлага, эвхмэл хуудсыг боловсруулж түгээх нь чухал ач холбогдолтой юм. Төслийн хүрээнд 5 төрлийн эвхмэл хуудас боловсруулахаар төлөвлөсөн боловч мэдээллийн багтаамж, иргэдийн хэрэгцээ шаардлагыг харгалзан 3 төрлийн гарын авлага, 1 төрлийн эвхмэл хуудас боловсруулсан болно. Гарын авлага, эвхмэл хуудсыг тус бүр 500 хувийг хэвлүүлэн ХЭҮК-ын Хөвсгөл аймаг дахь итгэмжлэгдсэн төлөөлөгч, Цагааннуур сумын төрийн захиргааны холбогдох албан тушаалтнууд, тус сумын тайгын багийн засаг даргаар дамжуулан иргэдэд түгээлээ.

Иргэний баримт бичгийн бүрдэл дутуу, энэ талаарх эрх зүйн мэдлэг хомс зэргээс шалтгаалан тэтгэвэр, тэтгэмж авах эрхээ эдлэж чаддаггүй хүмүүс цаатан

иргэдийн дотор нэлээд өндөр хувьтай байгаа нь ХЭҮК-ын 2004 онд хийсэн судалгааны дүнд харагдсан юм. Иймээс “Тэтгэмжийн сангаас олгох тэтгэмж”, “Тэтгэвэрийн сангаас олгох тэтгэвэр” сэдвээр 2 гарын авлагыг боловсруулсан болно.

ХЭҮК-ын хөдөө, орон нутагт зохион байгуулдаг олон нийтийн уулзалтуудын үеэр үндэстний цөөнхийг ойлгох, хүндэтгэх олонхийн хандлага төдийлөн сайнгүй байгаа нь харагддаг. Иймээс үндэстний цөөнхийн онцлогийг олон нийтэд ойлгуулах, тэднийг хүндэтгэх, соёл, уламжлалын ялгаатай байдлыг нь хүлээн зөвшөөрүүлэх хандлагыг нэмэгдүүлэх үүднээс “Үндэстний цөөнхийн эрх” сэдвээр гарын авлагыг боловсруулсан болно.

Цаатан иргэдийн амьдралын өвөрмөц байдал нь гадаад, дотоодын хүмүүсийн сонирхлыг татсаар ирсэн билээ. Цагааннуур сумын тайга нь аянчин, жуулчдын үзэхийг хүсдэг газрын нэг мөн төдийгүй цаатан иргэдийн аж амьдралын талаар кино зураг авах гэсэн хүсэлтэй хүмүүс ч цөөнгүй байдаг юм. Гэтэл цаатан иргэдэд гурил, будаа, бага хэмжээний мөнгө өгнө гэж тохиролцон хөхөө өвлийн хүйтэнд нүүлгэх, суулгах зэргээр зураг авдаг, зургаа авч дууссан боловч тохиролцсон зүйлээ өгөхгүй байх тохиолдол гардаг тухай нутгийн иргэд бидэнд ярьж байсан юм. Түүгээр ч зогсохгүй орон нутгийн төрийн албан хаагчийн зүгээс ийнхүү нүүж суухыг шахаж шаардах, тулгах зэрэг дутагдал гарч байсан юм. Иймээс иргэдэд эрхээ хамгаалах арга замаа мэдэхэд тусламж үзүүлэх зорилгоор “Кино зураг авахуулсныхаа төлөө хөлс авах ёстой юу?” эвхмэл хуудсыг боловсруулан түгээлээ.

1.2 Үндэсний цөөнхийн асуудлаар зарласан эссе, зохион бичлэгийн уралдаан

ХЭҮК-оос Монгол Улсын үндэстний цөөнхийн өмнө тулгамдаж буй хүний эрхийн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах, үндэстний цөөнхийн эрхэд хүндэтгэлтэй хандах нийгмийн ухамсарыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор 2005 оны 4 дүгээр сарын 1-ээс 5 дугаар сарын 15-ны хооронд эссе, зохион бичлэгийн уралдааныг зарлалаа. Уралдааныг нь насанд хүрэгчдийн болон сургуулийн насны гэсэн ангилалтайгаар дараах сэдэв, төрлөөр зохион байгуулсан болно. Үүнд:

- Насанд хүрэгчдийн дунд “Үндэстний цөөнхийн эрхийн асуудал Монголд” сэдэвт эссе бичих уралдаан
- Дунд сургуулийн 8-10 дугаар ангийн сурагчдын дунд “Миний мэдэх Үндэстний цөөнх” сэдэвт зохион бичлэг бичих уралдаан

Уралдааны зарыг Өдрийн сонин, Зууны мэдээ, Ардын эрх, Өнөөдөр, Үнэн зэрэг өдөр тутмын сонингуудад нийт 7 удаа нийтлүүлээ.

Уралдааны насанд хүрэгчдийн ангилалд нийт 21 зохиогчийн 22 бүтээл, сургуулийн насны хүүхдүүдийн ангилалд нийт 10 оролцогчийн 11 бүтээлийг хүлээн авч, дүнг дүнг 5 дугаар сарын 15-31-ний хооронд гарган, шагналыг 6 дугаар сарын 1-нд гардуулсан. Уралдааныг шүүх шүүгчдийг дараах бүрэлдэхүүнтэй байгууллаа.

- Ж.Дашдорж, ХЭҮК-ын гишүүн, Шүүгчийн ахлагч
- Б.Хишигсайхан, ХЭҮК-ын Ажлын албаны дарга
- К.Айнагуль, Улаанбаатар хотын Засаг даргын тамгын газрын хуулийн зөвлөх
- Б.Бадам-Оюу, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн ажилтан, угсаатны зүйч
- С.Энхжин, Түүхийн ухааны доктор, Боловсролын Их сургуулийн багш

Уралдаанд шалгарсан бүтээлүүдийг үзүүлбэл:

Насанд хүрэгчдийн ангилалд:

- 1-р байранд ШУТИС-ийн оюутан А.Амундрагийн “Үндэсний цөөнхийн цөөнх” эссе
- 2-р байранд Өвөрхангай аймгийн Ноён-Уул FM радиогийн захирал С.Мөнхдалайн “Казахийн тухай бодол” эссе
- 3-р байранд Хэл судлаач дээд сургуулийн дэд захирал С.Энхтайваны “Хүн хийгээд хүйн холбоо” эссе

Сургуулийн насны хүүхдүүдийн ангилалд:

- 1-р байранд УБ хотын 14-р дунд сургуулийн 8а ангийн сурагч Б.Итгэлчимэгийн “Миний мэдэх үндэсний цөөнх” зохион бичлэг
- 2-р байранд ЭМШУИС-ийн лицейн 21-р дунд сургуулийн 10а ангийн сурагч Б.Оюун-Эрдэнийн “Найз нөхдөө хүндэтгэх ёстой” зохион бичлэг
- 3-р байранд Дархан-Уул аймгийн Дархан сумын 15-р дунд сургуулийн 9в ангийн сурагч Д. Тунгалагийн “Миний мэдэх үндэстний цөөнх-Цаатан” зохион бичлэг шалгарсан.

1.3 “Үндэстний цөөнх-Цаатан” телевизийн нэвтрүүлэг

Төслийн төсөвт тусгагдсан эссе, зохион бичлэгийн уралдаан зохион байгуулах зардлаас тодорхой хэмжээний мөнгө хэмнэгдэж үлдсэн тул төслийг хэрэгжүүлэгчийн зүгээс цаатан иргэдийн тухай телевизийн нэвтрүүлэг бэлтгэж, нийтийн хүртээл болгохоор шийдвэрлэлээ. Энэхүү телевизийн нэвтрүүлэг нь цөөнхийн эрхийн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах, цөөнхийн эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилготойгоор бэлтгэгдсэн болно. “Үндэсний цөөнх-Цаатан” сэдэвтэй 15 минутын телевизийн нэвтрүүлэгийг Монголын Үндэсний Телевизтэй хамтран бэлтгэж, нийтийн хүртээл болголоо.

1.4 Нутгийн төр, захиргааны ажилтнуудад зориулсан сургалт

2005 оны 2-р сард Хөвсгөл аймгийн Мөрөн хот болон Цагааннуур суманд нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан “Үндэстний цөөнх ба Хүний эрх” сэдэвт тус бүр 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд аймгийн төвд 27 хүн, суманд 26 хүн хамрагдсан. Ялангуяа сумын төвийн хурал, захиргааны ажилтнууд сургалтыг цаг үеэ олсон сургалт боллоо хэмээн үнэлж байсан юм.

- “Өөрсдийн ажилд хүний эрхийн мэдрэмжтэй хандахад тустай сайн сургалт боллоо”.
- “Орон нутагт ирж, сургалтыг явуулж байгаа нь мэдээллээс алслагдсан нутагт маш их мэдээлэл боллоо”.
- “Хүний төлөө ажил зохиодог юм байна. Өөрсдийн сэтгэлээр зах хязгаар нутагт ирж хүний эрх, мэдлэгт оюуны маш их хөрөнгө оруулалт хийлээ”.
- “Энэ сургалтанд сууснаар эрх зүйн бага боловч мэдлэгтэй боллоо. Хойшид төсөв, төлөвлөгөө болон орон нутагтаа хийгдэх ажлууддаа төр нь иргэнээ дээдэлж, аюулгүй орчин бүрдүүлж ажиллахад анхаарах ёстойг ойлголоо”.

Сургалтын үнэлгээний хуудаснаас ...

Сургалтаар хүний эрх, эрх чөлөөний талаарх үндсэн ойлголт, зарчмууд, хүний эрхийг хамгаалах механизм болон үндэстний цөөнхийн эрх, түүнийг хангах, хамгаалах талаар төр, орон нутгийн байгууллагуудын хүлээх үүрэг, хүний эрхийн мэдрэмжтэй төсөл, төлөвлөгөө боловсруулах зэрэг сэдэвтэй 32 цагийн хичээлийг ХЭҮК-ын Ажлын албаны ажилтнууд заалаа.

Сургалтанд зориулж тусгай гарын авлага боловсруулан тараасан нь мэдээллээс алслагдсан сумын удирдлагуудад нэн хэрэгцээтэй болохыг сургалтанд оролцогчид хэлж байсан. Сургалтын гарын авлагыг дараах сэдвийн хүрээнд боловсруулсан болно. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөө, зарчим, хязгаарлалт
- Хүний эрхийг хангах, хамгаалах механизм
- Иргэний ба улс төрийн эрх
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрх
- Бүлгийн ба хамтын эрх
- Хөгжлийн бодлого боловсруулахад хүний эрхийн үүднээс хандах нь
- Үндэстний цөөнхийн эрх зэрэг болно.

Энэхүү сургалт нь оролцооны арга зүйд тулгуурлан явагдсанаараа оролцогчдод зөвхөн хүний эрхийн мэдлэг олгоод зогсохгүй, чадвар олгох, хандлага төлөвшүүлэхэд чухал хувь нэмэр болсон юм.

1.4 Цаатан иргэдэд хүний эрхийн боловсрол олгоход чиглэгдсэн сургалт, сурталчилгааны ажил

Цаатан иргэдэд хүний эрхийн боловсрол олгох зорилгоор дараах төрлийн арга хэмжээг зохион байгуулаа. Үүнд:

- Цагааннуур сумын 9 жилийн сургуульд ном хандивлах
- Цагааннуур сумын баруун, зүүн тайгад ном хандивлах
- Цаатан иргэдтэй уулзалт зохион байгуулах
- Радиогийн нэвтрүүлэг бэлтгэж, цацах

1.4.1 Цагааннуур сумын 8 жилийн сургуульд ном хандивласан тухай

Төслийн хүрээнд хийгдсэн нэг бодитой ажил бол Улаанбаатар хотоос 1000 орчим км-ийн алсад байдаг сумын сургуулийн номын санд ном хандивлах ажил байсан. Учир нь тус сургуулийн барилга 2001 онд шатаад, 2002 онд шинээр барилга барьсан ч сургуулийн номын санг сэргээн босгож чадаагүй байдалтай байсан юм. Номын санд Монголын уран зохиолын дээжис цувралын сүүлчийн 49 боть, Л.Түдэвийн 25 боть болон компьютер, англи хэл, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх бодлого дасгал зэрэг 10 орчим төрлийн 85 ширхэг ном, Комиссын 2004 оны 1, 3-р улирлын 88 ширхэг мэдээллийн хуудсыг хандивлалаа. Тус сургуулийн захирал Ц.Дариймаа номын сангаа шинээр сэргээж байгаа үед эдгээр номнуудыг хүлээн авч байгаа нь цаг үеэ олсон арга хэмжээ боллоо хэмээн өндөр сэтгэгдэлтэй байгаагаа илэрхийлж байсан юм.

ХЭҮК-оос номнуудыг сургуулийн захиргаанд хүлээлгэн өгөх арга хэмжээнд сумын ИТХ-ын дарга М.Эрдэнэбат, Тамгын газрын дарга С.Дөшгөө, сургуулийн захирал Ц.Дариймаа нар болон сумын иргэд, хурал, захиргааны хариуцлагатай албан тушаалтнууд болон сургуулийн сурагчдыг байлцуулаа. Ийнхүү номын

цуглуулгыг бэлэглэснээр зөвхөн сургуулийн сурагчид төдийгүй, тэдний эцэг эхүүд ч мөн авч унших боломжтой болж байгаа билээ.

1.4.2 Цагааннуур сумын баруун, зүүн тайгад ном хандивласан тухай

Төслийн багийн гишүүд Цагааннуур сумын баруун, зүүн тайгад ажиллах явцдаа тайгын иргэдийг мэдээллээр хангах зорилгоор нүүдлийн номын сан ажиллуулж байсан юм. Нүүдлийн номын сан нь сүүлийн үед хэвлэгдсэн хууль, эрх зүй болон уран зохиолын 20 гаруй төрлийн 25 ширхэг номноос гадна ХЭҮК-оос гаргасан 7 төрлийн гарын авлага бүхий номын фондтой байв. Тайгын иргэдэд тогтвортой, хүртээмжтэй үйлчлэх үүднээс энэхүү номнуудыг тайгын иргэдэд хандивласан болно. Хандивын номнуудыг тайгын багийн Засаг дарга Г. Буянтогтоход хүлээн өгөхөд нутгийн иргэдийн төлөөллийг байцуулаа.

1.4.3 Олон нийтийн уулзалт

Төслийн багийн гишүүд Цагааннуур сумын баруун, зүүн тайгад ажиллах явцдаа олон нийтэд зориулсан 3 удаагийн уулзалт ярилцлагыг зохион байгуулсан болно. Уулзалт ярилцлагыг цаатны урсанд зохион байгуулсан бөгөөд тайгад амьдардаг 44 өрхийн төлөөлөл 100% оролцлоо. Уулзалтын үеэр багийн гишүүд ХЭҮК-ын үйл ажиллагаа, үндэстний цөөнхийн эрхийн талаар танилцуулж, иргэдийн асуусан асуултанд хариулан харилцан ярилцаж байсан юм. Мөн шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх ажлыг ч мөн зохион байгуулсан болно. Уулзалтын үеэр иргэдэд зориулан боловсруулсан гарын авлагыг түгээж байсан бөгөөд амьдралд хэрэгцээтэй, практик асуудлуудыг багтаасан эрх зүйн лавлагаатай болсондоо иргэд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж байсан юм. Гарын авлага нь дараах агуулгатайгаар боловсруулагдсан болно. Үүнд:

- Гэр бүлийн харилцааны зарим асуудлууд
- Гэр бүлийн хүчирхийллийн талаарх зарим асуудлууд
- Эд мөнгөний тусламж авах эрх
- Иргэний нэхэмжлэлийн төрлүүд ямар байдаг вэ?
- Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах шийдвэрлүүлэх тухай
- Захиргааны хэргийн шүүхийн тухай
- Хүний эрх зөрчсөн талаарх гомдлыг хянан шийдвэрлэх нь
- Бууны албан татварын тухай зэрэг сэдвүүдийг багтаалаа.

1.4.4 Радио нэвтрүүлэг бэлтгэсэн тухай

3 төрлийн радиогийн нэвтрүүлэгийг бэлтгэж, цацлаа.

1.5 Төрийн бус байгууллага, иргэдэд зориулсан сургалт

Төслийн хүрээнд зохион байгуулагдах ТББ-ын ажилтнууд болон олон нийтэд зориулсан сургалтанд нийт 20 иргэдийг оролцуулахаар төлөвлөсөн байсан хэдий ч иргэдийн эрэлт хэрэгцээ их байсан тул 39 хүнийг сургалтанд хамруулаа. Иргэд тус сургалтанд идэвхтэй оролцож байсан бөгөөд сум, орон нутгаа өөрчлөхөд иргэний нийгэм, иргэн хүний гүйцэтгэх үүрэг чухал болохыг оролцогчид тэмдэглэн хэлж байсан. Түүнчлэн ийм төрлийн сургалтыг илүү олон хүн хамруулж, дахин дахин явуулахыг хүсч байлаа. Ялангуяа төрийн бус байгууллага байгуулах талаар

ажиллаж байгаа зарим иргэд сургалт өндөр үр дүнтэй болсон тухай сэтгэгдлээ сургалтын төгсгөлд хэлсэн.

- “Алс бөглүү нутагт амьдардаг, мэдээлэл хомс байдаг биднийг хүний эрх болон бусад мэдээлээр хангаж, мэдэж ойлгож амжаагүй өмнө ямар нэгэн үйл ажиллагаа явуулахад алдаж байсан зүйлс бүр харьцааны соёл дээр ч гэсэн тусгаж авах их зүйл байлаа. Мөн ийм сургалтыг цаашид боломж байвал улам өргөжүүлж явуулбал чухал байна. Зөвхөн Цагааннуур сумын төвд амьдардаг хүмүүс бус хөдөө орон нутагт амьдардаг хүмүүс оролцсон нь чухал байв”.
- “Сургалтанд хамрагдсан иргэдэд хүний эрх гэж юу болохыг мэдүүлсэн, хүний эрхийн талаар ямар хууль тогтоомж, журамд заагдсан, хэн болохоо, цаашид хэрхэн амьдрах гэх мэт амьдралын итгэлийг өрнүүлж өгсөн сургалт болсон”.
- “Бид нар энэ сургалтанд сууснаар амьдралдаа маш том хөрөнгө оруулалт хийлээ”.

Сургалтын үнэлгээний хуудаснаас...

Сургалтын хөтөлбөрт хүний эрх, эрх чөлөөний тухай ойлголт, зарчим, хүний эрхийг хамгаалах механизм, үндэстний цөөнхийн эрх болон нөлөөллийн арга хэмжээг (advocacy) хэрхэн зохион байгуулах, ТББ-ын стратеги төлөвлөлт, төсөл бичих аргачлал гэх мэт хичээлүүдийг багтаасан юм. Сургалтанд зориулан боловсруулсан гарын авлага нь дараах агуулгатай байлаа.

- Хүний эрхийн нөлөөлөл
- Стратеги төлөвлөлт
- Төсөл боловсруулах нь зэрэг болно.

ХОЁР. ЦААТАН ИРГЭДИЙН ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫГ ДЭЭШҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Цаатан иргэдийн эрхийн төлөв байдлыг дээшлүүлэх чиглэлээр дараах ажлыг зохион байгууллаа. Үүнд:

- Цаатан иргэдийг иргэний бичиг баримтжуулах ажил
- Цаатан иргэдэд эмнэлэгийн тусламж үзүүлэх ажил
- Тува хэлний хөтөлбөрийг ЕБС-ийн сургалтын стандартад тусгуулах ажил

2.1 Цаатан иргэдийг иргэний бичиг баримтжуулах ажил

Хөвсгөл аймгийн Иргэний бүртгэлийн ахлах байцаагч н.Саранчимэгтэй урьдчилан тохиролцсоны дагуу цаатан иргэдийг бичиг баримтжуулах ажлыг тус аймгийн иргэний бүртгэлийн байцаагч Ц.Дашравдан, зурагчин П.Жамба нартай хамтран Цагааннуур суманд зохион байгууллаа. Иргэний үнэмлэх олгох ажлыг цаатан иргэдэд чирэгдэлгүй зохион байгуулах зорилгоор Цагааннуур сумын зүүн, баруун тайгад очиж ажилласан болно. Сумын Засаг даргын тамгын газрын дарга С.Дөшгөө, тайгын багийн Засаг дарга Г.Буянтогтох, төвийн багийн Засаг дарга Х.Баярхүү нар иргэдэд мэдээлэл хүргэх, өргөнөөр хамруулах ажлыг зохион байгуулж, туслалцаа үзүүлсэн юм.

Төслийн багийн гишүүд Цагааннуур суманд 4 хоног ажиллах явцдаа иргэний үнэмлэх шинээр авах 27, нөөцөд авах 7, дахин олгох 10 хүний бичиг баримтыг бүрдүүлсэн бөгөөд энэ ажлын дүнд нийт 44 иргэний үнэмлэхний зураг, иргэний

үнэмлэхний төлбөр тооцоо, 22 иргэний үнэмлэхний зургийг тус төслөөс санхүүжүүлж, иргэдэд олголоо.

2.2 Цаатан иргэдэд эмнэлэгийн тусламж үзүүлсэн тухай

ХЭҮК-ын 2003 онд цаатан иргэдийн эрхийн төлөв байдалд хийсэн судалгааны дүнгээс анхаарал татаж байсан асуудал бол тайгад амьдарч байгаа цаатан иргэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах байдал хангалтгүй байгаа явдал байлаа. Тиймээс төслийн хүрээнд аймгийн төвөөс нарийн мэргэжлийн эмч нарыг, аппарат хэрэгслийн хамт авч явж Цагааннуур сумын төв, зүүн баруун тайгад нийт 4 хоног ажиллуулсан юм. Энэ ажлыг нутгийн иргэд тэдний хэрэгцээнд нийцсэн, бодитой ажил боллоо гэж дүгнэж байлаа. Ялангуяа тайгад, цаатан иргэдийн амьдардаг урцанд аппарат хэрэгслээ ажиллуулан, эмнэлэгийн үзлэг, үйлчилгээ явуулсан нь цаатан иргэдийн хувьд анх удаа тохиолдож байгаа, талархлыг нь хүлээсэн ажил болж чадсан юм.

Сумын төвд эмнэлгийн үзлэгт орох хүсэлтэй хүмүүсийг харгалзан хоёр өдөр уртасгасан цагаар ажиллаж, үзлэг хийсэн.

Эрүүл мэндийн үзлэгийн явцад цусны даралт тогтоох, зүрхний бичлэг хийх, дотор эрхтнийг эхогийн аппаратаар оношлох, эмэгтэйчүүдийн дотуур үзлэг хийх, бамбай булчирхай, нойр булчирхайн өвчлөлт тогтоох зэрэг нарийн оношлогоог хийж, эмчилгээг бичиж өгч байсан. Эмчилгээг тайгад ургадаг эмийн ургамал, хоол хүнсэнд тулгуурлан хэлж өгч байсан нь цаатан иргэдэд илүү тохиромжтой болох нь харагдаж байлаа. Түүнчлэн төслөөс тайгад амьдарч байгаа 40 өрхөд 10 гаруй төрлийн ойр зуурын эмийн цуглуулгыг өгсөнд ихэд талархаж байсан.

Нийт 4 хоногийн эрүүл мэндийн үзлэгт 216 хүн эхо аппаратаар үзүүлж, 89 хүн зүрхний бичлэг хийлгэж, 112 хүн эмэгтэйчүүдийн үзлэгт хамрагдсан. Давхардсан тоогоор нийт 417 хүн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан юм.

2.3 Тува хэлний хөтөлбөрийг ЕБС-ийн сургалтын стандартад тусгуулах талаар авсан арга хэмжээ

Төслийн хүрээнд хийгдэх ёстой чухал арга хэмжээнүүдийн нэг бол тува хэлний хөтөлбөрийг ЕБС-ийн сургалтын стандартад тусгуулах явдал байлаа. Энэ ажлын хүрээнд уг ажлын ач холбогдлыг тайлбарлан таниулах, цаашид тува хэлний хөтөлбөрийг ЕБС-ийн сургалтын стандартад тусгуулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхүйц лобби группыг байгуулах зорилгоор 2005 оны 3, 4-р саруудад ХЭҮК-оос БСШУЯ-ны холбогдох албан тушаалтнуудтай 2 удаагийн уулзалтыг зохион байгууллаа. Түүнчлэн 2005 оны 8-р сард БСШУСайдын нэр дээр Ажлын хэсгийг байгуулах талаар арга хэмжээ авах тухай албан бичгийг явуулсан юм. Эдгээр ажлын үр дүнд 2005 оны 9-р сард тува хэлний хөтөлбөрийг ЕБС-ийн сургалтын стандартад тусгуулах ажлыг судлах Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

**ГУРАВ. ЦААТАН ИРГЭДИЙН ЭРХИЙН АСУУДАЛД ХОЛБОГДОХ
БАЙГУУЛЛАГУУДЫН АНХААРЛЫГ ХАНДУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ**

3.1 ХЭҮК-ийн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар

Төслийн багийн гишүүд Хөвсгөл аймагт ажиллахдаа тус аймгийн Засаг дарга Б.Батхүү, Цагааннуур сумын ИТХ-ын дарга М.Эрдэнэбат нартай 2004 онд ХЭҮК-ын хийсэн судалгааны мөрөөр илгээсэн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх, цаашид улам сайжруулах зорилгоор уулзалт, ярилцлага зохион байгууллаа.

Зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэж үзэхэд цаатан иргэдийн төлөөллийг орон нутгийн хуралд гаргах талаар Цагааннуур сум нилээд анхаарч ажилласан нь харагдаж байсан. Тухайлбал 2004 оны 10-р сард болсон орон нутгийн сонгуулийн баруун, зүүн тайгын тойрогт нэр дэвшигчид нь бүгд цаатан иргэд байсан бөгөөд үүний дүнд хуралд 3 цаатан иргэн сонгогдсон байлаа.

Түүнчлэн цаа бугын өсөлт сүүлийн жил гаруйн хугацаанд сайжирсан, өвчлөлт буурсан зэрэг үр дүн гарчээ. Өнгөрсөн оны 12 дугаар сард хийсэн мал тоологоор 704 цаа буга тоолуулсан байсан нь 2002 онд 563 цаа буга тоологдсон гэсэн дүнтэй харьцуулахад нийт 20 орчим хувиар өсчээ. Энэ нь ТОТЕМ төслийн хүрээнд цаа бугын эмч Нансалмаа тайгын 2 багт н.Борхүү, С.Ганбат гэсэн орон тооны бус малын эмч нартай хамтран ажиллаж, цаа бугын эмчилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй хийх болсонтой холбоотой юм.

Гэсэн хэдий ч цаатан иргэдийн ядуурлыг бууруулах, цаатан хүүхдүүдэд тува хэл заах, аялал жуулчлалыг хөгжүүлэх зэрэг зөвлөмжид тусгагдсан чиглэлүүдээр дорвитой хийгдэж байгаа ажил ховор байна.

3.2 “Үндэсний цөөнх ба Хүний эрх” Бага Хурал

ХЭҮК-оос 2003 онд хийсэн цаатан иргэдийн эрхийн хэрэгжилтийн талаарх судалгааны ажил, түүний мөрөөр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар танилцуулах, цаатан иргэдийн эрхийн хэрэгжилтийг сайжруулах асуудалд төр, ТББ, бизнесийн болон ОУ-ын байгууллагын анхаарлыг хандуулах, үндэсний цөөнхийн эрхийг хангах, хамгаалах тухай зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хандаж гаргах зорилгоор 2005 оны 9-р сарын 16-ны өдөр “Үндэсний цөөнх ба Хүний эрх” Бага Хурлыг зохион байгууллаа.

Бага Хуралд ХЭҮК, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам, Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн яам, Зам тээвэр, Аялал жуулчлалын яам, Хүнс, Хөдөө аж ахуйн яам, Байгаль орчны яам, Хөвсгөл аймаг, Цагааннуур сумын засаг даргын тамгын газар зэрэг төрийн захиргааны байгууллагууд, Шинжлэх Ухааны Академийн Түүхийн Хүрээлэн, Малын удмын сан, Улсын Мал Эмнэлэг зэрэг судалгаа шинжилгээний байгууллагууд болон ТББ-ууд, хэвлэл, мэдээллийн байгууллагууд, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдийг төлөөлсөн 53 хүн оролцсон юм.

Бага Хурлын үеэр цаатан иргэдийн эрхийн олон чухал асуудлыг бүх талаас нь хөндсөн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулагдсан бөгөөд төрийн захиргааны төв байгууллагуудад хандсан зөвлөмжийг боловсруулан баталсан юм. Бага Хуралд оролцогчдын анхаарлыг цаатан иргэдийн эрхийн асуудалд хандуулан, энэ талаар цаашид улам үр ашигтай хамтран ажиллах ажлын эхлэлийг тавьж, цаатан иргэдийн талаар төрөөс баримтлах бодлого, авах арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэхэд

анхаарахуйц, тэдгээр иргэдийн нийтлэг ашиг сонирхолыг тусгасан баримт бичгийг боловсруулан гаргасанд тус Бага Хурлын ач холбогдол оршиж байлаа.

ДҮГНЭЛТ

“Цаатан-21” төслийг ХЭҮК нь Канад сантай байгуулсан гэрээний хугацаанд хэрэгжүүлж дууссан бөгөөд төслийн хүрээнд төлөвлөж байсан ажлууд бүрэн хийгдсэн болно. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарлаа. Үүнд:

- Иргэдийн нийтлэг хэрэгцээнд тулгуурлан 3 төрлийн гарын авлага, 1 эвхмэл хуудсыг боловсруулж нийтийн хүртээл болголоо. Ингэснээр Хөвсгөл аймгийн Цагаан нуур сумын зүүн, баруун тайгын цаатан иргэд болон олон нийтийн хүний эрх, ялангуяа үндэстний цөөнхийн эрхийн талаарх мэдлэг ойлголт дээшлэхэд хувь нэмрээ оруулсан болно.
- Хөвсгөл аймгийн Мөрөн хот, Цагааннуур сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, төрийн захиргааны байгууллагын ажилтнууд болох нийт 53 хүнийг оролцуулсан “Үндэстний цөөнх ба Хүний эрх” сэдэвт 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд оролцсон нутгийн захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын албан хаагчдын үндэстний цөөнхийн эрхийн талаарх мэдлэг, ойлголт дээшилж, шийдвэр гаргахдаа цөөнхийн эрхийн асуудалд мэдрэмжтэй хандах чадвартай боллоо.
- ТББ үүсгэн байгуулсан 39 хүнийг тусгай сургалтанд хамруулаа. Сургалтанд хамрагдсанаар тухайн иргэд нь үндэстний цөөнхийн эрхийн талаар зохих мэдлэгтэй, өөрсдийн болон бусдын зөрчигдсөн эрхийг хамгаалах талаар нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах чадварыг эзэмшлээ. Сургалтанд зориулан 2 төрлийн гарын авлага боловсруулж түгээсэн болно.
- Олон нийтийн цөөнхийн эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, тэдний эрхийг хүндэтгэх хандлага төлөвшүүлэх зорилгоор эссе болон зохион бичлэгийн уралдааныг зохион байгуулж, дүнг гаргалаа.
- “Үндэстний цөөнх-Цаатан” сэдэвт 15 минутын телевизийн нэвтрүүлэг, 4 төрлийн радио нэвтрүүлэг бэлтгэгдэж, нийтийн хүртээл боллоо.
- Цагааннуур сумын 8 жилийн дунд сургуулийн номын санд “Монголын уран зохиолын дээжис” цувралын сүүлчийн 49 боть, зохиолч Л.Түдэвийн 25 боть зохиол болон компьютер, англи хэл, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх бодлого дасгал зэрэг 10 орчим төрлийн 85 ширхэг ном, ХЭҮК-ын 2004 оны 1, 3-р улирлын Мэдээллийн хуудаснаас 88 ширхэгийг хандивлалаа.
- Цагааннуур сумын баруу, зүүн тайгын иргэдэд 20 гаруй төрлийн 25 ширхэг ном, 7 төрлийн гарын авлагыг хандивлав.
- Төслийн хүрээнд иргэний үнэмлэх шинээр авах 27, нөөцөд авах 7, дахин олгох 10 хүний бичиг баримтыг бүрдүүллээ. Мөн 22 иргэний үнэмлэхний зургийг авахуулах, 44 иргэний үнэмлэхийг олгуулах төлбөр тооцоог санхүүжүүлсэн болно.
- Цаатан иргэдэд эмнэлэгийн тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулаа. Нийт 4 хоногийн эрүүл мэндийн үзлэгт 216 хүн эхо аппаратаар үзүүлж, 89

хүн зүрхний бичлэг хийлгэж, 112 хүн эмэгтэйчүүдийн үзлэгт хамрагдсан. Давхардсан тоогоор нийт 417 хүн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдлаа. Түүнчлэн тайгад амьдарч байгаа 40 өрхөд 10 гаруй төрлийн өргөн хэрэгцээний эмийн цуглуулгыг хүлээлгэн өглөө.

- Цагааннуур сумын 9 жилийн дунд сургуульд тува хэлийг заадаг болгох, тува хэлийг ЕБС-ийн сургалтын стандартанд оруулах ажлыг судлах ажлын хэсэг БСШУЯаманд байгуулагдан ажиллаж байна.
- Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, ТББ-ууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, олон улсын байгууллага, сан, төсөл хөтөлбөрүүдийг төлөөлсөн нийт 53 хүнийг оролцуулсан үндэсний хэмжээний Бага Хурлыг зохион байгууллаа. Бага Хурлыг зохион байгуулсан нь оролцогч байгууллагуудын анхаарлыг үндэстний цөөнхийн эрхийн асуудалд хандуулахад чухал ач холбогдолтой болсон юм.
- Үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилтийг дээшлүүлэхэд төрөөс баримлах бодлого, авах арга хэмжээний талаар цаатан иргэдээс дэвшүүлсэн санал, санаачлагад тулгуурлан боловсуулсан зөвлөмжийг төрийн захиргааны төв байгууллагад илгээлээ.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАР,
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИТХ, ЗАСАГ ДАРГА,
ЦАГААННУУР СУМЫН ИТХ, ЗАСАГ ДАРГА НАРТ



ЗӨВЛӨМЖ

2005 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос Канад сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “ЦААТАН XXI” төслийн хүрээнд “**ҮНДЭСТНИЙ ЦӨӨНХ БА ХҮНИЙ ЭРХ**” сэдэвт Бага хурлыг 2005 оны 9-р сарын 16-ны өдөр зохион байгуулав.

Тус бага хурал нь Хөвсгөл аймгийн Цагааннуур суманд оршин суудаг цөөнх болох цаатан иргэдийн эрхийн хэрэгжилтийн талаарх судалгааны ажил, түүний мөрөөр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулах, мөн цаатан иргэдийн эрхийн хэрэгжилтийг сайжруулах асуудалд төр засаг, орон нутгийн удирдлага, ТББ, бизнесийн болон ОУ-ын байгууллагын анхаарлыг хандуулахад чиглэсэн болно.

Бага хуралд оролцогчдоос цөөнхийн эрхийг хангах, хамгаалахтай холбоотой Зөвлөмжийг холбогдох байгууллагад хандаж гаргалаа.

Тайгад амьдарч буй цаатан өрхийн 70 орчим хувь нь ядуу, нэн ядуу нөхцөлд амьдарч байна. Цаатангуудын хувьд уламжлалт зан заншил нь баларч үгүй болох, хүүхэд залуучууд нь өөрийн төрөлх хэлээ муу мэддэг, эсхүл мэдэхгүй болж, ахуй амьдралын хувьд ядууралд автаж буй нь тэдний цөөнхийн хувьд оршин тогтнох эсэхийг эргэлзээтэй болгож байна. Тайгын цаатангуудын амьдралын салшгүй нэг хэсэг болох цаа бугын тоо толгой эрс цөөрч, өвчлөлд нэрвэгдэж, бие нь давжаарсан зэрэг нь цаатангуудын аж амьдралыг доройтуулах, улмаар уламжлалт амьдралын хэв шинжээ алдахад хүргэж байна.

Нэг. Цаатан иргэдийн цөөнхийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр

1.1 Цаатангуудын түүх, соёлыг судлах, хэвлэх, түгээн дэлгэрүүлэх ажлыг дэмжих, тэдний түүх, зан заншил, шашин, угсаатны зүйн уг гарвалыг сонирхолтойгоор өгүүлсэн ном бичвэр, баримтат кино бүтээх ажлыг хөхүүлэн дэмжих;

1.2. Цаатан иргэдийн зан заншил, шашин шүтлэг, эд өлгийн соёлыг олон нийтэд хүрэх түгээх зорилгоор орон нутгийн шинжтэй музей, соёлын төв байгуулах ажилд мөргөжлийн болон техникийн туслалцаа үзүүлэх;

1.3. Цаатан иргэдийн эх хэл болох тува хэлийг нь Цагааннуур сумын 9 жилийн сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулах;

1.4 Саатан хүүхдүүдийг сургуульд бэлтгэх зорилготой сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг албан бус боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах, үр өгөөжийг нэмэгдүүлэх;

1.5 Сагааннуур сумын сургуулийн багшилж байгаа боловсон хүчнийг чадавхийг дээшлүүлэх, давтан бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх ажлыг хүртээмжтэй, тэдний хэрэгцээ онцлогт тохирсон хөтөлбөрөөр зохион байгуулах, сургалтын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах;

1.6 Саатан иргэдийн дээд боловсрол эзэмших хүсэл эрмэлзлийг дэмжих тусгай хөтөлбөр гарган, цогцоор нь авч үзэх /сургалтын төлбөр, дотуур байрны зардал, хоол, бичиг хэргийн зүйлсээ авах доод жишгээр тогтоосон зардал, орон нутагтаа буцах зардлыг 1-2 жилд нэг удаа гэх мэт/;

1.7 Цаа бугын удмын санг хамгаалах, эрүүлжүүлэх, тоо толгойг өсгөх ажлыг мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор зохион байгуулах, энэ чиглэлээр гарч байгаа үүсгэл санаачилгыг дэмжиж ажиллах.

Хоёр. Саатан иргэдийн аж амьдралыг дээшлүүлэх чиглэлээр:

2.1 Саатан иргэдийн аж амьдралыг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах чиглэлээр төв болон орон нутгийн удирдлагаас тодорхой үндэслэлтэй, тусгай бодлого боловсруулж, хэрэгжүүлэх. Үүнд: хүнсний, малжуулах, жимс, жимсгэнийг боловсруулах жижиг цехийг байгуулах, ясан эврээр гар урлалын бүтээгдэхүүн хийх гэх мэт чиглэлээр хэрэгжих төсөл, үйл ажиллагааг дэмжих;

2.2 Саатан иргэдэд зориулсан ажлын байр бий болгох талаар онцгойлон анхаарах; “Цаачин” хоршоог дэмжих;

2.3 Тайгад олон жил цаа малласан цаачдын тэтгэвэр, тэтгэмж авах насыг бууруулах чиглэлээр хууль тогтоомжид өөрчлөлт оруулах;

2.4 Саатан иргэдэд үзүүлж байгаа тусламжийн үр нөлөөг дээшлүүлэх үүднээс үнэлгээ хийх, хяналт тавих ажлыг олон талын төлөөлөлтэйгээр зохион байгуулж байх;

2.5 Жуулчны сүлжээг бий болгох;

2.6 Тайгын байгалийг хамгаалах төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллах;

2.7 Саатан иргэдэд тусламж дэмжлэг үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллага, гадаадын төсөл, хувь хүмүүстэй үр бүтээлтэй хамтран ажиллах.

Гурав. Саатан иргэдийн талаар авах бусал арга хэмжээ

3.1 Сагааннуур сумыг цахилгаан эрчим хүчний эх үүсвэрээр хангах ажлыг дэмжих;

3.2 Орон нутгийн өөрийн орлогыг нэмэгдүүлэх эх үүсвэрийг бий болгоход анхаарах. Тухайлбал спорт агнуурын хураамжийн тодорхой хувийг сумын төсөвт шууд оруулах, загасыг орон нутагтаа эцсийн бүтээгдэхүүн болгон боловсруулах талаар гарч байгаа санаачилгыг дэмжих гэх мэт;

3.3 Саатан иргэдийн дунд нөхөн үржихүйн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.4 Цаатан иргэдийг нийгмийн амьдралд оролцох оролцоог хангах, үүний тулд албан бус боловсролын төрөл бүрийн хөтөлбөрийг тайгад хэрэгжүүлэх;

3.5 Цаатан иргэдэд мэдээлэл хүлээн авах боломжийг олгох чиглэлээр тайгын холбоог сайжруулах, нар, салхины эрчим хүчийг ашиглан телевиз, радиогийн мэдээллийг хүлээн авах боломжоор хангах;

3.6 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад цаатны төлөөллийг бодлоготойгоор оруулах;

3.7 ЗЗНДН-ийн төсөл хэлэлцэж байгаатай холбогдуулан Цагааннуур сумын хилийн цэсийг тогтоохдоо цаа бугын нутаг бэлчээрийг харгалзан үзэх;

3.8 Тайга хүрэх замыг засварлах, байгаль, цаг уурын хүнд нөхцөлд тайгад түргэн тусламжийг цаг алдахгүй хүрэхэд шаардлагатай унааны асуудлыг шийдвэрлэх;

3.9 Үндэсний Статистикийн газар, Хөвсгөл аймгийн статистикийн мэдээнд цаатан иргэд, цаа бугатай холбоотой статистик мэдээллийг оруулах, орон нутгийн төрийн байгууллагууд үндэстний цөөнх болох цаатантай холбоотой мэдээллийг жил бүр цуглуулж байх.

БАГА ХУРАЛД ОРОЛЦОГЧИД

УРИАЛГА

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Цагдаагийн ерөнхий газрын Хэрэг бүртгэх газартай хамтран Хэрэг бүртгэх албаны удирдах ажилтны нэгдсэн зөвлөлгөөнийг “Хүний эрх-Хэрэг бүртгэх ажиллагаа” сэдвээр 2005 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгууллаа.

Зөвлөлгөөний зорилго нь хэрэг бүртгэх ажиллагаанд Монгол Улсын Үндсэн, тус улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээ, эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хууль тогтоомжид заасан хүний эрхийн талаархи заалт шаардлагыг нэг мөр ойлгон хэрэгжүүлж, Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх эрх чөлөөг зөрчихгүй байх, хэрэг бүртгэх албаны ажилтнуудын ажлын сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн болно.

Зөвлөлгөөнөөс хууль хэрэгжүүлэх ажиллагаанд хүний эрхийг хүндэтгэн сахих, аливаа хүний эрхийн ноцтой зөрчлөөс ангид байх зорилгоор Хэрэг бүртгэгчид, цагдаагийн байгууллагын алба хаагч нарт хандаж доорхи уриалгыг гаргаж байна. Үүнд:

1. Хэрэг бүртгэх ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, тус улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенц, эрүү, эрүүгийн байцаан шийтгэх хууль, Хүний эрхийг Хангах Үндэсний хөтөлбөр, холбогдох бусад баримт бичигт тусгасан хүний эрхийн талаархи хэм хэмжээ, шаардлагыг чанд сахин биелүүлж хүний эрхийг хүндэтгэж ажиллах,
2. Байцаан шийтгэх ажиллагаа явуулахдаа сэжигтэн, яллагдагч, гэрч хохирогч нарыг эрүүдэн шүүх, тэдэнд хүнлэг бус хэрцгий хандах, хүний нэр төрийг доромжлон харьцах зэрэг аливаа зөрчлөөс ямагт зайлсхийж ажиллах,
3. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч хууль бусаар баривчлах, цагдан хорих, мөрдөн мөшгөхгүй, эрх чөлөөнд нь халдахгүй, эрх ашгийг нь хохироохгүй байх, хэрэгт холбогдогчийн өмгөөлөгчөө сонгох, эрх зүйн туслалцаа авах эрхийг нь хангаж ажиллах,
4. Цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээг тэдэнд улам бүр ойртуулж, шуурхай соёлтой, шударга, хүлээцтэй, ухаалаг, зөв боловсон харилцааг хэвшүүлж, хүний нэр төрийг хүндэтгэж, хүн бүрт адил тэгш, шударга хандаж сурах,
5. Хууль хэрэгжүүлэх ажиллагаанд хүний эрхийг хэрхэн хангаж байгаа байдлаа алба, нэгж бүр шинжлэн судалж, дүгнэлт хийж, хүний эрхийг зөрчихгүй байх бүхий л боломж нөхцлийг бүрдүүлж ажиллах,
6. Сэжигтэн, яллагдагчтай зүй бусаар харьцсан, эрүүдэн шүүсэн албан тушаалтантай хариуцлага тооцох тогтолцоог боловсронгуй болгон, эрүүдэн шүүсэн гэх тохиолдол бүрийг нягтлан шалгаж, ийм зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх,
7. Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх, тэдэнд цол хэргэм шагнах, албан тушаал дэвшүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хэрхэн сахин биелүүлж байгааг гол үзүүлэлт болгон авч үзэж байх,

8. Хуулийг хүндэтгэх, сахин биелүүлэх талаар өөрсдөө үлгэр жишээ үзүүлж, олон нийтийн итгэл хүндэтгэлийг хүлээж, тэдний дэмжлэг туслалцааг авч ажиллах,
9. Ажил мэргэжил хүндэтгэлтэй хандаж, албан үүргээ гүйцэтгэхдээ танил тал, албан тушаалтны нөлөөнд орох, шан харамж авах зэрэг хууль бус үйлдлээс ангид байж, өргөсөн тангарагтаа үнэнч, шударга ажиллах.

Энэхүү уриалгыг цагдаагийн нийт алба хаагчид сахин биелүүлж, хэрэгжүүлж ажиллахыг энэхүү зөвлөлгөөнд оролцогчид уриалж байна. Гүнээ итгэж байна.

**МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС,
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХЭРЭГ БҮРТГЭХ АЛБАНЫ УДИРДАХ
АЖИЛТНЫ НЭГДСЭН ЗӨВЛӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧ**

Улаанбаатар хот

2005 оны 9-р сарын 20-ны өдөр

АЗИ НОМХОН ДАЛАЙН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧУУЛГАН

Ази Номхон Далайн Хүний Эрхийн Үндэсний Байгууллагуудын Чуулган (АНДХЭҮБЧ) нь бүс нутгийн улс түмнүүдийн хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилгоор үндэсний байгууллага үүсгэн байгуулах, хөгжүүлэхийг бүсийн хамтын ажиллагааны хэлбэрээр дэмжин ажилладаг хараат бус, ашгийн төлөө бус байгууллага бөгөөд 1995 онд үүсгэн байгуулагдсан.

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) нь тус Чуулганы 9 дэх гишүүнээр 2001 оны 9 дүгээр сард элсэн орсон.

Чуулганы гишүүд нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг бүхий үндэсний байгууллагуудын эрх зүйн зарчим болох НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Үндэсний байгууллагуудын үйл ажиллагааны Зарчим/Парисын Зарчмууд/ дээр үндэслэн байгуулагдсан бие даасан ХЭҮБайгууллагуудаас бүрэлдэн тогтдог. Чуулганы бүхий л гишүүд нь Парисын Зарчимд тусгагдсан наад захын стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох ёстой. Парисын Зарчмуудын үндсэн шалгууруудыг нэгтгэвэл:

- Үндсэн хууль эсвэл хуулиар байгуулагдсан байна
- Хараат бус, бие даасан байдлаар үйл ажиллагаагаа явуулна
- Хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн эрх хэмжээ нь аль болох өргөн хүрээтэй байна
- Иргэний нийгэмтэй хамтран ажиллана

Чуулганы жил бүрийн хуралдаан нь Ази Номхон Далайн бүсэд тогтмол зохион байгуулагддаг хамгийн өргөн хүрээний оролцогчид оролцдог хүний эрхийн том арга хэмжээ юм. Хуралдааныг жил бүр Чуулганы аль нэг гишүүн оронд зохион байгуулдаг уламжлалтай. Эдгээр уулзалтууд нь хүний эрхийг бодитойгоор хэрэгжүүлэх, хүрсэн түвшинг ахиулах чухал механизм юм. Учир нь эдгээр хуралдаанд улс орнуудын хүний эрхийн үндэсний болон Засгийн газрын байгууллагууд, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, олон улсын төрийн бус байгууллагууд оролцдог.

АНДХЭҮБЧ-ны ээлжит 10 дугаар хуралдаан 2005 оны 8 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулагдаж өнгөрлөө.

Уг хуралдааныг АНДХЭҮБЧ-ны Нарийн Бичгийн Дарга нарын газар болон Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос зохион байгуулсан бөгөөд энэхүү 10 дахь хуралдаанаар эрүү шүүлт болон бусад хүнлэг бус, хэргийг догшин харьцаж хандахаас урьдчилан сэргийлэх явдал болон энэ чиглэлээрх үндэсний хүний эрхийн байгууллагуудын гүйцэтгэх үүргийн талаарх асуудалд гол анхаарлаа хандуулсан юм. Мөн цагаач ажилчид, алан хядах, дотоодын дүрвэгсдийн эрхийн тухай асуудлууд, хүнийг хил дамжуулан наймаалах, хүүхдийг садар самуунд ашиглах явдал, цаазаар авах ял, хүний эрхийн боловсролын талаар хэлэлцэв. Монгол улсын ХЭҮК-оос эрүүдэн шүүхийн эсрэг зохион байгуулж буй нээлттэй

хяналт шалгалтын ажил болон хүний эрхийн боловсролын чиглэлээр явуулж буй үйл ажиллагаа, ололт амжилтынхаа талаар илтгэл тавьсан.

Энэ удаагийн хуралдаанд Чуулганы жинхэнэ гишүүн болох Австрали, Балба, БНСУ, Фижи, Филиппин, Энэтхэг, Индонез, Малайз, Монгол, Тайланд, Шинэ Зеланд, Шри Ланка зэрэг 12 орны хүний эрхийн үндэсний байгууллагууд мөн Чуулганы бүрэн бус гишүүд болох Афганистан, Йордан, Палестины хүний эрхийн байгууллагууд, нийтдээ 30 шахам улс орны засгийн газрын болон төрийн бус байгууллагын 150 гаруй зочид төлөөлөгчид оролцов.

Хуралдааны үеэр Афганистаны бие даасан Хүний Эрхийн Комисс жинхэнэ гишүүнээр, Зүүн -Тиморийн Хүний Эрх Шударга Ёсны Провидор болон Катарын Хүний Эрхийн Үндэсний Байгууллага Чуулганы бүрэн бус гишүүнээр элсэж Чуулган нийт 17 гишүүн байгууллагатай боллоо.

Улаанбаатар хотноо болсон энэхүү хуралдаан нь Ази, Номхон Далайн Бүс Нутгийн Хүний Эрхийн Үндэсний Байгууллагуудын Чуулганы 10 жилийн ойтой давхцаж байснаараа онцлог болсон юм. Хуралдааныг нээж Монгол улсын Ерөнхийлөгч Н. Энхбаяр үг хэлсэн.

Энэхүү хуралдааны гол баримт бичгүүд болон Монгол улсын ХЭҮК-оос тавьж хэлэлцүүлсэн хоёр илтгэлийг сэтгүүлд хэвлэж байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ НАМБАРЫН ЭНХБАЯРЫН АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧУУЛГАНЫ Х ХУРАЛДААНЫ НЭЭЛТ ДЭЭР ХЭЛСЭН ҮГ

**Монгол Улс дахь НҮБ-ын суурин төлөөлөгч, хатагтай Пратиба Мехта,
Хатагтай, ноёд оо!**

Өнөөдөр Ази Номхон далайн бүс нутгийн олон улс орны Хүний эрхийн үндэсний байгууллага, засгийн газар, төрийн бус байгууллагуудын төлөөлөгчид манай эх оронд хуран цуглаж, жил тутмын ээлжит хуралдаанаа зохион байгуулж байна.

Хэдийгээр манай бүс нутагт хамрагддаг улс орнууд ёс заншил, шашин шүтлэг, соёл, ахуй амьдрал, эдийн засгийн хөгжлийн түвшин нь ихээхэн өөр өөр боловч та биднийг нэгтгэж байгаа, адилхан болгож ижилсүүлэн буй зүйл нь хавьгүй их бөгөөд олон байгаа гэдэгт би итгэлтэй байна. Үүний нэг том хэсэг нь хүний эрхийн тухай асуудал юм.

Хүн төрөлхтөн өөрийн амьдрал, тэмцэл, хөгжлийн явцад олон үнэт зүйлийг цогцлуулан бий болгосны хамгийн сор, хамгийн нандин зүйлийн нэг нь яах аргагүй арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэгээр үл ялган хүн бүрийн эрх, эрх чөлөөг хүндэтгэн хөгжүүлэхийг Дэлхийн хамтын нийгэмлэгийн гол зорилго, зарчим болохыг тунхаглаж, хүний эдлэх ёстой эрхийг олон улсын баримт бичгүүдэд томъёлон тодорхойлж, ихэнх улс орнуудаар хүлээн зөвшөөрүүлж чадсан явдал юм гэдэгтэй та бүхэн санал нэгдэх буй заа.

Өнөөдөр 1948 оноос хойш батлагдсан 90 гаруй улс орны Үндсэн хуульд Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын гол гол заалтыг шууд оруулсан байх буюу эсхүл түүний үзэл санаа, нөлөөн доор хүний эрхийн асуудлыг тусгасан гэж судлаачид гаргажээ.

Монгол Улс өөрийн дөрөвдэх Үндсэн хуулийг 1992 онд баталсан ба энэхүү хуулийн Хоёрдугаар бүлэгт хүний эрх, эрх чөлөөний асуудлыг тусгайлан авч үзсэн болно. Үндсэн хуулийн бусад бүлэг хэсэгийн дотор Хүний эрх, эрх чөлөөний тухай бүлэг нь хэмжээ, багтаамжийн хувьд хамгийн том бүлэгийн нэг болж орсон нь тохиолдлын хэрэг биш юм. Анх удаа Монгол Улсад хүний эрхийг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн түвшинд томъёолж, түүний хэрэгжилтийг хангах нь төрийн үүрэг гэдгийг тод томруунаар зааж өгсөн юм.

Шинэ Үндсэн хуулиас хойших арав гаруй жилийн хугацаанд уг хуулийн үзэл санаа, зарчимд нийцүүлэн хууль тогтоомжоо үндсэнд нь бүрэн хэмжээгээр шинэчилж чадсан гэж хэлэх бүрэн үндэстэй юм.

Түүнчлэн Монгол Улс хүний эрхийн олон улсын үндсэн гол чухал баримт бичгүүдийг хүлээн зөвшөөрч, өнөөдрийн байдлаар 50 шахам гэрээ, конвенцийг соёрхон баталсан.

Хүний эрхийг дээдлэх үзэл санааг хүндэтгэх, дотоодын хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцид тусгагдсан хүний олон арван эрх, эрх чөлөөний бодит хэрэгжилтийг хянах, судлах, шаардлагатай үед эрх баричид, албан тушаалтнуудтай хариуцлага тооцох нь зайлшгүй бодит хэрэгцээ болсоныг Монгол Улсын Парламент, Засгийн газар харгалзан үзээд 2000 онд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг баталж, уг Комиссыг байгуулсан.

2003 онд Парламент Монгол Улсад хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийг баталж, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг авахыг Засгийн газарт даалгасан юм. Энэхүү хөтөлбөр нь төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа – механизмыг бүрдүүлэх, хүний эрхийг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг тууштай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх үйлсэд засаг төрийн байгууллага, албан тушаалтны санаачилга, хариуцлагыг дээшлүүлэн, иргэний нийгэм, төрийн бус байгууллага, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хувийн хэвшлийн оролцоог өргөтгөн, үр нөлөөг нь сайжруулах, иргэдийн идэвхи санаачлагыг өрнүүлэх чиглэл, арга замыг тодорхойлсон төрийн бодлогын томоохон хэмжээний баримт бичиг болсон юм.

Уг хөтөлбөрийг хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд хөшүүрэг болгож, хүний эрхийн байдалд тодорхой ахиц өөрчлөлт гаргахыг Монгол Улсын Засгийн газар, төрийн бүх шатны байгууллага, иргэний нийгмийн чухал зорилт байх ёстой гэж үзэж байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааг идэвхижүүлэх, Хүний эрхийг хангах Үндэсний Хөтөлбөрийг боловсруулж бэлтгэхэд НҮБ, Хүний эрхийн Дээд Комиссариатын Газрын дэмжлэг, тусалцаа, хамтын ажиллагаа жинтэй хувь нэмэр оруулсан ба цаашид ч чухал үүрэг гүйцэтгэнэ гэж бодож байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээ, конвенцид заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих үүргээ зохих ёсоор биелүүлэн, хүний эрхийн төлөө тэмцэл, үйл ажиллагааны тэргүүн эгнээнд байгаа гэдгийг цохон хэлэхийг хүсч байна. Үүний нэг тод илрэл энэхүү бүс нутгийн Чуулганы ээлжит хуралдаан юм.

Цаашид тус Комиссын бүтэц бүрэлдэхүүнийг өргөтгөх, бүрэн эрхийг нь нэмэгдүүлэх, төсөв зардлыг нь хараат бусаар, үр нөлөөтэй ажиллах боломжийг нь хангахад хүрэлцэхүйц байхаар баталж байхад анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Чуулганы Х хуралдааны зочид төлөөлөгчид өө, хатагтай, ноёд оо!

Энэ хуралдаанаар хүний эрхийн боловсрол, хүний эрхийн сургалт сурталчилгаа, дотоодын шилжин суурьшигчдын асуудал, терроризм, хүн наймаалах, цаазаар авах ял, хүүхдийн порнографи, эрүү шүүлт гэсэн хүний эрхийн олон хурц асуудлыг хөндөж ярилцахаар төлөвлөжээ.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрсгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхээс урьдчилан сэргийлэх асуудлаар тусгай илтгэл хэлэлцэж, тогтон ярилцах гэж буй нь их цаг үеэ олсон чухал сэдэв гэж үзэж байна.

Эрүүдэн шүүлт бол хүн гэдэг эрхэм нэр төрийг нухчин дарангуйлж, хүний дотоод итгэл үнэмшил, үзэл бодлыг уландаа гишгэдэг хүний эрхийн ноцтой зөрчил төдийгүй, онц аюултай гэмт хэрэг юм. Манай улс НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг Конвенцид 2000 онд нэгдэн орж, дотоодын хууль тогтоомждоо зарим өөрчлөлт оруулсан.

Энэ чиглэлээр манай улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос нилээд судалгаа, хяналт шалгалтын ажил хийж, олны анхаарлыг энэ асуудалд хандуулж буйг зөв зүйтэй эхлэл гэж үзэж байна. Саяхан Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах үйл ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөж байгаа талаар судалгаа хийх, дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний тухай санал боловсруулах, эрүүдэн шүүж, хүнлэг бус харьцаа, уг үйлдлийг өдөөн хатгадаг, зөвшөөрдөг, боломж олгодог албан тушаалтнуудтай хариуцлага тооцох тогтолцоог бий болгоход чиглэгдсэн хяналт шалгалт, сургалт сурталчилгааг зохион байгуулах томоохон хэмжээний ажлын хэсгийг байгуулсан байна.

Хүний эрхийг хүлээн зөвшөөрөх, хуульчлах, олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох нь асуудлын зөвхөн нэг тал бөгөөд хамгийн гол, хамгийн төвөгтэй, хүнд ажил нь тэдгээр эрхийг хүн нэг бүр баталгаатай эдлэх эдийн засаг, нийгэм, хууль зүйн орчныг бүрдүүлэх, зөрчигдсэн эрхийг сэргээж, хохирлыг барагдуулах явдал билээ. Түүнчлэн хүний эрхийн нөхцөл байдлыг дээшлүүлэхэд улс орнуудын төр, засгийн байгууллагуудаас ихээхэн хүчин чармайлт, уйгагүй ажиллагаа шаардагдах нь мэдээж гэдгийг цохон тэмдэглэмээр байна.

Ази Номхон далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганы ээлжит хуралдаан үйл ажиллагаанд амжилт хүсье.

Энэ хуралдаантай давхацаж Чуулганы үүсгэн байгуулагдсаны 10 жилийн ой болж буйг тэмдэглэж, та бүхэнд халуун баяр хүргэе.

**МОНГОЛ УЛСЫН ХЭҮК-ЫН ДАРГА С.ЦЭРЭНДОРЖИЙН АЗИ
НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧУУЛГАНЫ Х ХУРАЛДААН
ДЭЭР ХЭЛСЭН ҮГ**

2005-8-24

Улаанбаатар хот

**Монгол Улсын Ерөнхийлөгч өө!
НҮБ-ын суурин төлөөлөгч, хатагтай Пратиба Мета!
Х хуралдааны зочид төлөөлөгчид өө!
Ажил үйлс нэгт хамтран зүтгэгчид ээ!
Хатагтай, ноёд оо!**

Бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын ээлжит хуралдаан манай эх оронд амжилттай эхэлж байгаад Монгол улсын ХЭҮК-ын хамт олон болон хамтран ажиллагч түнш байгууллагуудынхаа өмнөөс та бүхэнд чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж байна. Чуулганы ээлжит хуралдаанд 30 шахам улс орны Хүний эрхийн үндэсний байгууллага, Засгийн газар, төрийн бус байгууллагуудын зочид төлөөлөгчид оролцож байна.

Хүний эрхийг баталгаатай хамгаалах хүний эрхийн чиглэлээр мэдэгдэхүйц ахиц өөрчлөлт дэвшил гаргах хүний эрхийг бүх нийтээр хүндэтгэх үзэл санааг төлөвшүүлэх нь төр засаг хүний эрхийн үндэсний байгууллагууд, иргэний нийгмийн хамтын ажиллагааны хүчээр л хэрэгжих том үйл хэрэг гэж бид үздэг.

Засгийн Газар, түүний харьяа байгууллагуудыг шүүмжилж, шаардахын зэрэгцээгээр харилцан ойлголцож, бие биенээ хүндэтгэсэн нягт хамтын ажиллагаа хүний эрхийн байдлыг сайжруулахад чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь ТББ, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй нягт хамтран ажиллах нь язгуур эрх ашгийн асуудал билээ.

Монгол улсын ХЭҮК 2001 оноос Ази Номхон Далайн Бүс Нутгийн Хүний Эрхийн Үндэсний Байгууллагуудын гишүүнээр элсэж хамтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ирсэн юм. Шинэ тутам байгуулагдсан манай комиссын ажилтнуудын чадавхийг сургаж, дадлагажуулах, бүс нутгийн хүний эрхийн арга хэмжээ, хурал семинарт идэвхтэй оролцоход дэмжлэг үзүүлэх, мэдээлэл харилцан солилцоход Чуулганы нарийн бичгийн дарга нарын газраас болон бусад ХЭҮК-уудаас анхаарч тусалж байдгийг онцлон хэлэхийг хүсч байна.

Түүнчлэн тус комиссын үйл ажиллагааг эхнээс нь тууштай дэмжиж ирсэн Хүний эрхийн дээд Комиссиартын газар, Монгол улс дахь НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр болон бусад хамтран ажиллагч дотоод гадаадын түншүүддээ энэхүү чуулганы хуралдааныг тохиолдуулан чин сэтгэлийн талархлаа илэрхийлж байна.

Чуулганы энэ удаагийн хуралдаан Манай улс орнуудад хүний эрхийн тулгамдаж буй асуудлуудад анхаарлаа хандуулж, өмнөө тавьсан зорилго амжилттай шийдвэрлэнэ гэдэгт Монгол Улсын ХЭҮК бат итгэлтэй байна.

Ази Номхон далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганы ээлжит X хуралдааны нээлтийг зарлаж, Монгол Улсын Ерөнхийлөгч, ноён Намбарын Энхбаярыг үг хэлэхийг урьж байна.

АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧУУЛГАНЫ Х ХУРАЛДААН

2005 оны 8 дугаарсарын 24-26,

Улаанбаатар хот

ТӨГСГӨЛИЙН БАРИМТ БИЧИГ

Оршил

1. Ази Номхон Далайн Бүс Нутгийн Хүний Эрхийн Үндэсний Байгууллагуудын чуулганы ээлжит аравдугаар хуралдаан Монгол, Афганистан, Австрали, Фижи, Энэтхэг, Индонези, Йордан, Малайз, Непал, Шинэ Зеланд, Палестин, Филиппин, Катар, БНСУ, Шри Ланка, Тайланд болон Зүүн - Тиморийн төлөөлөгчдийн хамтаар 2005 оны 8 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо зохион байгуулагдлаа.
2. чуулганы Зөвлөлийн Гишүүд нь Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисст хурлыг хүлээн авч зохион байгуулсанд, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар /ХЭДКГ/ болон бусад хандивлагч байгууллагуудыг хурлын үйл ажиллагааг санхүүжүүлсэнд чин сэтгэлийн талархалаа илэрхийлж байна. Түүнчлэн чуулганы Зөвлөлийн гишүүд Монгол Улсын Хүний Эрхийн үндэсний Комиссын гишүүд болон Ажлын Алба, чуулганы Нарийн Бичгийн Дарга Нарын Газарт хурлыг амжилттай зохион байгуулсан явдалд талархаж буйгаа илэрхийлж байна.
3. Чуулганы Зөвлөлийн Гишүүдийн зүгээс Чуулганы Хуульчдын Зөвлөлийн оролцоо болон үйл ажиллагаанд онцгойлон талархаж буйгаа илэрхийлж байна. Түүнчлэн хуралдаанд ажиглагчаар оролцсон Мальдив, Иран, үзбекистан, Саудын Арабын хүний эрхийн байгууллагын төлөөлөгчид, олон улсын, бүс нутгийн, үндэсний болон төрийн бус байгууллагын гучин таван төлөөлөгчид, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, ЮНИСЕФ, ЮНЕСКО, ХЭДКГ, Тайвань, Шинэ Зеланд, Монгол, Франц, Канад болон Австрали Улсын Засгийн Газрын төлөөлөгчдийг халуун дотноор хуралдаанд хүлээн авлаа.
4. Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаяр, Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссийн Дарга бөгөөд АНДХЭҮБЧ-ны дарга С.Цэрэндорж, НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газрын дарга Луиз Эрбоурын нэрийн өмнөөс чуулганыг Даргалагч, Нэгдсэн үндэсний Байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгч хатагтай Пратиба Мета нар энэ удаагийн уулзалтыг нээж үг хэллээ. Чуулганы хуралдааныг нээж үг хэлсэн эдгээр хүндэт зочид Ази-Номхон Далайн Хүний Эрхийн Үндэсний

Байгууллагуудын чуулган байгуулагдсаны арван жилийг тохиолдуулан хүрэлцэн ирэгсэдэд баяр хүргэлээ.

Дүгнэлт

Чуулганы хаалттай хуралдаанаар:

5. Ажиглагчдын тухай асуудлыг Чуулганы хаалттай хуралдаанаар хэлэлцсэн ба энэ талаар бодлого боловсруулж, Чуулганы Зөвлөлийн гишүүдэд танилцуулан шийдвэрлүүлэхийг НБДНГ-аас хүсч байна.
6. Өнгөрсөн жилийн ээлжит хуралдаанаас хойш Чуулганы хийсэн үйл ажиллагааны тайланг сонсож, НБДНГ-ын ажилд талархаж буйгаа илэрхийлж байна. Чуулганы захиргаа, санхүүгийн талаарх НБДНГ-ын тайланг сонсож, 2005 оны 3-р сарын 31-ээр дуусгавар болсон удирдамж, санхүү, аудитын тайланг Чуулганы Зөвлөлийн гишүүд баталлаа. (1) Чуулганы гишүүн байгууллагууд (2) Австрали, Энэтхэг, Шинэ Зеланд, БНСУ, Тайланд, Их Британи болон АНУ-ын Засгийн Газрууд (3) Их Британий Зөвлөл, Бруукингсийн Институт, Мак Артурын сан, Ардчиллыг дэмжих Үндэсний сан болон бусад санхүүжүүлэгч байгууллагууд (3) Засгийн Газрын хоорондын агентлагууд, Их Британийн Хамтын нөхөрлөлийн орнуудын НБДНГ, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд (НҮБХЭДКГ, НҮБХХ, ЮНЕСКО, ЮНИСЕФ) зэрэг Засгийн Газрын хоорондын байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлсэнд нь чин сэтгэлээсээ талархаж буйгаа илэрхийллээ.
7. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлагдсан 49/134 тоот шийдвэр буюу Хүний Эрхийн Үндэсний Байгууллагуудын статустай холбоотой зарчмууд болох Парисын Зарчмуудын хэрэгжилтийг сайжруулах ажлын хүрээнд хүний эрхийн үндэсний байгууллагуудын гишүүдийг сонгох, тэдний үйл ажиллагааны хараат бус байдлыг хамгаалахад чиглэгдсэн арга зүйн удирдамжийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулахаар тохиролцож, Чуулганы 11 дүгээр ээлжит хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэхээр болов.
8. Чуулганы 2006 оны төлөвлөгөөг баталж, 2007-2009 онд хэрэгжих 3 жилийн шинэ стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг байгуулах, үүнийг Чуулганы 11-р хуралдааны үеэр бүтэн өдөр хаалттайгаар хэлэлцэхээр тохиролцлоо.
9. ХЭҮБ-уудын сургалтын хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн ажлын үр дүнг хүлээн авлаа. Эдгээр үр дүн дээр тулгуурласан сургалтын төлөвлөгөөг боловсруулж, Чуулганы зөвлөлийн гишүүдэд танилцуулж, зөвшөөрөл авсны үндсэн дээр хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт хайхыг НБДНГ-аас хүсч байна.
10. Хүний эрхийн үндэсний байгууллагуудын бүтэц, чиг үүрэг нь Парисын зарчмуудад нийцсэн байх ёстой гэдгийг дахин батлан илэрхийллээ. Үүний үндсэн дээр Афганистаны хараат бус ХЭК-ыг Чуулганы жинхэнэ гишүүнээр, Зүүн Тиморын Хүний эрх ба Шударга ёсны Провидорыг бүрэн бус гишүүнээр, Катарын ХЭХороог сурвалжлагч гишүүнээр хүлээн авахаар шийдвэрлэснээр Чуулган нийт 17 гишүүн байгууллагатай болж өргөжлөө.
11. Чуулганы Зөвлөлийн Гишүүд нь Парисын Зарчмуудтай бүрэн нийцсэн Хүний эрхийн үндэсний байгууллага байгуулах, бэхжүүлэхийг Ази Номхон Далайн бүс нутгийн ЗГ-уудад уриалж байна.

12. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтийн талаар төрийн хүлээх үүргийн тухай асуудлыг Хуульчдын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр тогтож, энэ талаар удирдамжийн төслийг боловсруулж, Чуулганы гишүүдэд танилцуулж батлуулахыг Чуулганы НБДНГ-аас хүслээ.
13. Хүний эрхийн үндэсний байгууллагуудын ОУ-н зохицуулах хорооны магадлан итгэмжлэл хариуцсан дэд хороонд Чуулганыг төлөөлсөн Фижигийн ХЭК-ын тайланг хүлээн авч, төлөөлөгчдийн гаргасан хүчин чармайлтад талархаж байгаагаа илэрхийлээ. Чуулганы Зөвлөлийн гишүүд ОУ-ын зохицуулах хороонд Чуулганаас одоогоор нэр дэвшээд байгаа хүмүүсийг дахин нэр дэвшүүлж байна.
14. Чуулган болон Хүний эрхийн дээд комиссарын газрын хооронд тогтвортой түншлэл бий болгох арга замыг эрэлхийлэх талаар 2005 оны 8-р сарын 30-наас 9-р сарын 2-ны өдрүүдэд Бээжин хотноо болох Ази Номхон далайн бүс нутагт Хүний эрхийг хамгаалах, бус нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай НҮБ-н ээлжит 13-р зөвлөлгөөний үеэр нэгдсэн байр суурийг баримтлахаар тохиролцов.
15. НҮБ-ын ХЭК-ын үйл ажиллагаанд ХЭҮБ-уудын оролцоог нэмэгдүүлэх талаар НҮБ-ын ХЭК-ын 61-р ээлжит хурлаас гарсан 2005/74 тоот шийдвэрийг талархан хүлээн авч байна. Чуулганы зөвлөлийн гишүүд Парисын зарчмуудыг дагаж мөрдөж буй талаар тогтмол шалгалт хийх шаардлагатай гэж үзэв. Чуулганы Зөвлөлийн гишүүд НҮБ болон НҮБ-ын ХЭК-ын хүрээнд явагдаж буй шинэчлэлтэй холбоотой яриа хэлэлцээрийг цохон тэмдэглэж, үүнд байнга анхаарал хандуулж, явцынх нь талаар хэлэлцэж байхаар тогтлоо. Энэхүү яриа хэлэлцээрт ХЭҮБ-ыг идэвхитэй оролцуулах талаар Засгийн газрууд болон ХЭДКГ-тай хамтран ажиллаж байхаар болов. Чуулганы зөвлөлийн гишүүд НҮБ-ын ХЭК-ыг залгамжлагч нь ямар ч тохиолдолд хүний эрхийн үндэсний байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг аль болох нэмэгдүүлэх зорилготой байх хэрэгтэй гэдгийг онцлов.
16. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар НҮБ-н шинэ конвенцийг боловсруулах ажилд Ази Номхон Далайн Хүний Эрхийн Үндэсний Байгууллагуудын Чуулганы гишүүн байгууллагуудын гүйцэтгэж буй үүргийг талархан хүлээн авч байгаагаас гадна тус конвенцийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянахад Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь албан ёсны үүрэг оролцоотой байх шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрлөө. Энэ талаар Үндэсний байгууллагуудын гүйцэтгэж болох үүргийн талаар Чуулганы зөвлөлийн гишүүд өөрийн орны Засгийн газруудтай ярилцаж, энэ талаар гарсан саналуудыг 2006 оны 1-р сард болох НҮБ-н Ерөнхий Ассамблейн түр хорооны 7-р чуулганы үеэр дэмжин ажиллахыг Засгийн газрууддаа санал болгохоор тохиролцов. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн талаарх асуудлуудыг Хүний эрхийн Үндэсний байгууллагуудын зүгээс цуглуулж, ангилах арга замыг тодорхойлон турших ажлыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хөхүүлэн дэмжих ОУ-ын байгууллагтай хамтран ажиллахаар чуулганы зөвлөлийн гишүүд тохиролцов.
17. Ажлын албаны дарга нарын тайланг хүлээн авч ХЭҮндэсний байгууллагуудын үйл ажиллагааг үр дүнтэй, үр ашигтай явуулахад тэдний оруулж буй хувь нэмрийг магтан сайшаав. Ажлын албаны дарга нар хамтын

ажиллагаагаа нэмэгдүүлж өөрсдийн үйл ажиллагаа болон хамтын ажиллагааныхаа талаар чуулганы 11-р ээлжит хуралдаан дээр тайлагнахыг хүсч байна.

18. Монгол Улсын ХЭҮК-г (энэ удаагийн ээлжит хуралдааныг зохион байгуулж буй байгууллага) Чуулганыг даргалагчаар санал нэгтгэйгээр сонголоо. БНСУ-ын Хүний эрхийн үндэсний комисс (өнгөрсөн хуралдааныг зохион байгуулагч) болон Фижигийн Хүний эрхийн комиссийг (ирэх жилийн хуралдааныг зохион байгуулагч) Чуулганы орлогч дарга нараар санал нэгтэй сонголоо.

Чуулганы нэгдсэн хуралдааны үеэр:

19. Чуулгантай тогтвортойгоор хамтран ажиллах талаар Хүний Эрхийн Дээд Комиссарын газраас гаргаж буй хүчин чармайлтыг талархан сайшааж, Чуулганы стратеги төлөвлөгөө болон Ази Номхон Далайн бүс нутагт хүний эрхийн тогтолцоог бий болгох талаарх НҮБ-ын ажлын хүрээнд энэхүү асуудлыг хэрхэн тусгаж болох арга замыг хамтдаа эрэлхийлэх, энэ тухай чуулганы 11-р ээлжит хуралдаан дээр тайлагнахыг ХЭДКГ болон чуулганы НБДНГ-аас хүсч байна. Түүнчлэн ХЭДКГ-ын ажил ялангуяа Хүний эрхийн үндэсний байгууллагатай холбоотой ажлыг дэмжихэд санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлэхийг гишүүн улс орнууддаа уриалж байна.
20. Төрийн бус байгууллагуудын чуулганы үйл ажиллагаанд оруулж буй хувь нэмрийг талархан хүлээн авч байна. Энэ удаагийн хуралдаанд бичгээр мэдээлэл өгч хамтран оролцож нөлөөллийн үйл ажиллагаа явуулсан төрийн бус байгууллагуудад талархаж байна. Төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн саналуудыг Чуулганы 3 жилийн шинэ стратеги төлөвлөгөөг боловсруулахад анхааралтай авч үзэх болно. Чуулганы үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд цаашид идэвхитэйгээр хамтран ажиллахыг Чуулганы зөвлөлийн гишүүд төрийн бус байгууллагуудаас хүсч байна.
21. Хүний эрхийг хамгаалах, хөхүүлэн дэмжих тухай Чуулганы гишүүд, холбогдох байгууллагууд болон бүс нутгийн ЗГ-дын илтгэлүүдийг хүлээн авч, хуралдаанд идэвхитэй оролцож үнэтэй хувь нэмэр оруулсан ЗГ-дад талархаж байна. Цаашид Чуулганы гишүүдийн тавих илтгэл нь сэдэвчилсэн, тэргүүн туршлага эсвэл томоохон асуудлуудыг хөндсөн байх нь зүйтэй гэж үзэв.
22. Хүний эрхийн боловсролын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхдээ Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь өөрийн улсын боловсролын байгууллагуудтай идэвхтэйгээр хамтран ажиллах нь зүйтэй гэдэгт санал нэгдлээ. Хүний сурч боловсрох эрхийг бүрэн хэрэгжүүлэх үүднээс хүний эрхийн боловсролыг бүх нийтэд ялангуяа алслагдсан болон хөдөө орон нутгийн иргэдэд хүргэх хэрэгтэй юм.
23. Парисын зарчмуудын дагуу хүний эрхийн үндэсний байгууллагууд нь хүний эрхийг хөхүүлэн дэмжих, ялгаварлан гадуурхахтай тэмцэх үүрэгтэй гэдгийг батлан илэрхийлэв. Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь маш үр нөлөөтэй арга болохынх нь хувьд хэвлэл мэдээллийн хэрэгслийг хүний эрхийн боловсролыг олгоход ашиглаж байх нь зүйтэй. Үүнтэй холбоотой сургалтын хөтөлбөрийг бэлтгэн, хэрэгжүүлсэн Нарийн Бичгийн Дарга

- Нарын Газарт талархалаа илэрхийлэв. Түүнчлэн Ажлын Албаны дарга нарын дотоод сүлжээг бий болгон ашиглах замаар хүний эрхийн боловсролын шилдэг арга зүйн зөвлөмжүүдийг солилцох боломж бий болгохыг Нарийн Бичгийн Дарга Нарын Газарт даалгав.
24. Бус нутаг дахь дотоодын дүрвэгсдийн асуудлаар сэтгэл ихэд зовниж буйгаа илэрхийлж, энэ талаарх НҮБ-ын удирдамжийн дагуу дотооддоо дүрвэсэн хүмүүсийн эрхийг хамгаалах, хөхүүлэн дэмжих талаар үр дүнтэй арга хэмжээ авахыг Чуулганы гишүүдэд уриалав. Брукингийн Институттэй хамтран ажиллаж буйг сайшааж цаашид уг ажлаа үргэлжлүүлэхийг Чуулганаас хүсч байна. Ялангуяа байгалийн гамшигт үзэгдлээс шалтгаалан дотооддоо дүрвэсэн хүмүүсийн эрхийг хамгаалах талаар удирдамжийн төсөл боловсруулах явдлыг талархан хүлээн авч байна.
 25. Цаазаар авах ял, хүнийг хил дамнуулан наймаалах болон алан хядах үйл ажиллагааны талаар Хуульчдын зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар тайлагналаа. Хуульчдын зөвлөлийн зөвлөмжүүд амжилттай хэрэгжиж буй тухай Чуулганы олон гишүүд онцлон тэмдэглэсэн.
 26. Цаашид ч мөн эрх хэмжээгээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах хараат бус байдал, мэдээллээр бүрэн хангагдах, байгууллагын чадавхийг дээшлүүлэх, нөхцөл бололцоог ханган баталгаажуулахыг Чуулганы гишүүн байгууллагуудын ЗГ-уудад уриалж байна.
 27. Олон улсын экспертүүд, төрийн бус байгууллагуудын санал бодол, хуульчдийн зөвлөлийн илтгэлд тусгагдсан эрүү шүүлтийн тухай асуудлыг авч үзсэн. Чуулганы зүгээс Хуульчдийн зөвлөлийн гишүүдэд мэдлэг туршлагаа хуваалцаж, өргөн цар хүрээтэй тайлан бэлтгэж танилцуулсанд талархаж байна. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколын хүрээнд Хүний Эрхийн Үндэсний Байгууллагууд ямар үүрэг гүйцэтгэж болох талаар Чуулганы зөвлөлийн гишүүд нарийвчлан авч хэлэлцэх болно. Мөн Конвенци болон түүний нэмэлт Протоколд нэгдэн орохыг Засгийн газрууддаа зөвлөж байна.
 28. Иран, Мальдивийн үндэсний байгууллагуудад тулгамдсан асуудлууд дээр анхаарч цаашид тэдгээрийн хүний эрхийг хамгаалах, хөхүүлэн дэмжих үйл ажиллагааг дэмжиж байхыгаа илэрхийлж байна.
 29. 2006 онд болох 11-р ээлжит хуралдааныг зохион байгуулах талаархи Фижигийн Хүний Эрхийн Комиссын саналыг талархан хүлээн авч байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА БА ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ*

**Ж.Дашдорж,
МУ-ын ХЭҮК-ын гишүүн**

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлд “Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг хэрэглэхийг хориглоно” гэж заасан.

Үндсэн хуулийн энэхүү заалтын дагуу Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд ч эрүү шүүлтийг гэмт хэрэг гэж үзэж, эрүүдэн шүүхийг хориглосон заалт тусгагдсан.

Гэсэн хэдий ч эрүүдэн шүүх болон хүнлэг бус хэрцгий харьцах, мэдүүлэг гаргуулхаар албадах хүч хэрэглэх зэрэг зөрчил гарсаар байгаа нь манай Комиссын анхаарлыг татсаар байна. Эрүү шүүлттэй тэмцэх, эрүү шүүлтийг илрүүлэн гаргах, гэм буруутанд хариуцлага тооцох сонирхол бүхий төрийн бие даасан байгууллага өнөөдөр байхгүй гэхэд хилсдэхгүй.

Монгол Улсын хууль тогтоомжид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажилд хяналт тавих үүргийг прокурорын байгууллага хүлээдэг тул эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар харьцаж, шийтгэж байгаа зөрчлийг илрүүлэх, арга хэмжээ авах нь прокурорын байгууллагын үүрэг мөн. ХЭҮК-ын үзэж байгаагаар прокурорын байгууллага энэ үүргээ тэр бүр сайн биелүүлж чадахгүй байна.

Шүүх, прокурор, цагдаагийн албан хаагчидтай холбоотой хэргийг мөрдөн байцаах үүрэг бүхий мөрдөн байцаах албыг УЕП-ын дэргэд байгуулж 2002 оны 9-р сараас эхлэн үйл ажиллагаагаа явуулсан. Гэвч өнөөгийн байдлаар эрүүдэн шүүсэн буюу хэрцгий, хүнлэг бус харьцсан хэргээр нэг ч албан тушаалтан ял шийтгэл хүлээгээгүй байна. Ийм утга агуулгатай өргөдөл гомдол жил дутам олон арваараа гардаг боловч мөрдөн байцаалтын явцад хохирогчтой эвлэрсэн эсвэл тогтоогдоогүй гэдэг үндэслэлээр хэрэгсэхгүй болгодог. Иймээс хүний эрхийн үндэсний бхйгууллага нт эрүү шүүлттэй тэмцэх, түүнийг ил гаргаж тавих, төр, олон нийтийн анхаарлыг хандуулахад үйл ажиллагаагаа чиглүүлэх нь чухал юм.

ХЭҮК байгуулагдсан цагаасаа эхлэн дээр дурьдсан зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байна. Тус Комиссоос энэ чиглэлээр дор дурьдсан үйл ажиллагааг явуулж байна.

1. Монгол Улсын хууль тогтоомж эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг НҮБ-ын конвенцтой хэрхэн нийцэж байгаа болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй механизм болж чадаж байгаа эсэхэд судалгаа дүгнэлт хийж байна.

* АНДБНХЭБ-ын Чуулганы Х хуралдаан дээр тавьсан илтгэл

Энэ жил шинээр батлагдах гэж байгаа хууль тогтоомжийн төсөлтэй танилцаж санал өгөх, хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг судалж санал, зөвлөмж гаргах гэсэн 2 чиглэлээр явагддаг.

- Монгол Улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид 2000 оны 11-р сарын 2-нд нэгдэн орсон. Монгол Улсын Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль, хуулийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой багц хуулиуд 2002 оны эхээр шинэчлэгдэн батлагдсан. Тухайлбал шинэ эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн төслүүд дээр Хүний Эрхийн Үндэсний Комиссоос 20 орчим санал өгсний 80 орчим хувь нь биелэгдэж байсан. Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас шинээр боловсруулагдаж буй хуулийн төслүүдэд ХЭҮК-ын саналыг авдаг практик хэвшил болж байгаа нь сайшаалтай.
- Шинээр мөрдөгдөж буй Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн заалттай уялдуулан дүгнэлт хийж, ХЭҮК-ын 2003, 2004, 2005 оны Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэлд оруулж уг илтгэлийг Монгол Улсын Их Хурал, Засгийн газарт өргөн барьсан нь ач холбогдолтой болсон.
- 2003 оны илтгэлд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийн талаархи илтгэлийг Засгийн газар бэлтгээгүйг анхааруулж конвенцийн 2, 4, 10, 11, 15-р заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газар хангалтгүй ажиллаж байгааг тэмдэглэсэн шаардлага илгээсэн. Үүний үр дүнд Засгийн газрын илтгэлийн бэлтгэл ажил хийгдэж байна.
- ХЭҮК-ын 2002 оны илтгэлд шинээр батлагдсан ЭБШ хуулийн зарим заалтуудыг эрүү шүүлт болон хүнлэг бус хэрцгий харьцаатай холбон дүгнэлт хийсэн. Тухайлбал хорьж мөрдөх нийт хугацаа 30 сар, насанд хүрээгүй хүүхдийг хорьж мөрдөх хугацааг сараар тогтоосон, цагдан хорих үндэслэл хэт өргөн байгаа учир хэнийг ч хэзээ ч цагдан хорьж болохоор байгаа нь хүнлэг бус залхаан цээрлүүдэлт мөн гэж тэмдэглэсэн. Энэ хуульд өөрчлөлт оруулах ажлын хэсэг ажиллаж, хорьж мөрдөх хугацааг ихээхэн багасгахаар яригдаж байна.

2. Баривчлах, цагдан хорих байрны ахуй нөхцлийг олон улсын болон үндэсний хууль тогтоомжийн заалтад нийцүүлэх, цагдан хорих байранд үзлэг шалгалт хийх ажил эрүү шүүлттэй тэмцэх чиглэлийг нэг гол чиглэл болж байна.

Тус Комисс байгуулагдсан цагаасаа эхлэн цагдан хорих байр, хорих ангийн ахуй нөхцлийг сайжруулахад ихээхэн анхаарал тавьж байна.

- 2002 онд Ганц хугагийн цагдан хорих төвд, 2004 онд улсын хэмжээний бүх цагдан хорих байруудад үзлэг, шалгалт хийж, дүгнэлт гаргасан. Монгол Улс 1999 онд Сэжигтэн яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх журмын тухай хууль баталж, цагдан хорих байрны стандартыг тогтоосон боловч энэхүү стандарт одоо хүртэл хэрэгжээгүй байна.
- Энэ хуульд зааснаар цагдан хорих байр нь цонхтой, цонх нь салхивчтай, агааржуулах төхөөрөмжтэй байх ёстой. Улсын хэмжээнд 22 цагдан хорих байр 431 хорих камертай ба түүний дөнгөж 41 /10 хувь/ нь гадна орчин руу харсан цонхтой байна. Хорих камерын 90 хувь нь ямарч цонхгүй, газар доогуур байрлалтай, нар салхи үзэх ямар ч боломжгүй. Иймээс байнга

агаар, гэрлийн дутагдалтай, чийгшилт ихтэй, цэвэр усны хангамжгүй байдаг нь хоригдогсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг. Ийм нөхцөлд удаан хугацаагаар хорих нь эрүү шүүлтийг нөхцөлдүүлж байна.

Хорих байрны ахуй нөхцөл хэт хүнд байгаагаас хоригдогсод жингээ алдах, сүрьеэ болон амьсгалын замын өвчнөөр өвдөх, хараа нь муудах зэрэг өвчлөл бага бус гарч зарим тохиолдолд амь насаараа хохирч байна.

ХЭҮК-оос хөдөө аймгуудад нээлттэй өдөрлөг зохион байгуулахдаа цагдан хорих байруудад үзлэг хийж, эрүү шүүлтийн илрэл байгаа эсэхэд анхаарч, илэрсэн зөрчлийг арилгуулж, шаардлага, зөвлөмж өгч хэвшээд байна. Иймээс ХЭҮК нь эрүү шүүлт, хүнлэг бус хэрцгий харьцаатай тэмцэх нэг чиглэлийг хорих байрны ахуй нөхцлийг сайжруулах ажил гэж үздэг.

3. ХЭҮК нь эрүү шүүлтийн нөхцөл байдалтай уялдуулан эрүү шүүлттэй тэмцэхэд төрийн байгууллага, албан тушаалтны анхаарлыг хандуулах, эрүү шүүлтийн нөхцөл байдлыг тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг сайжруулах зорилгоор “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хориглох нь” сэдвээр олон нийтийн нээлттэй хяналт, шалгалтын ажлыг 1 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлж байна.

Энэ ажил нь нийслэл Улаанбаатар хот болон бусад 8 аймгийг хамарч хийгдэж байна. Нээлттэй хяналт, шалгалтын хүрээнд доорхи ажлыг хийж байна.

- Монгол Улсын хууль тогтоомж, захиргааны шийдвэр, хуулийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй дүрэм, журам нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зөв механизм болж чадаж байгаа эсэхэд дүгнэлт хийх
- Шүүх, прокурор, өмгөөлөх, цагдаагийн байгууллагын ажилтнуудтай эрүү шүүлтийн тухай ярилцлага зохион байгуулж, мэдээлэл цуглуулах
- Иргэд байгууллагаас өргөдөл гомдол, мэдээлэл хүлээн авч дүгнэлт хийх, шалгаж тодруулах, холбогдох арга хэмжээг авах
- Прокурор болон мөрдөн байцаах албанд шалгагдаж байгаа өргөдөл гомдол, мэдээлэл, хэргийг уншиж, судалж, дүгнэлт хийх
- Цагдан хорих байруудад үзлэг хийж ахуй нөхцлийг тодруулах, хоригдож буй хүмүүсийн биед үзлэг хийж, гомдол мэдээллийг сонсож, холбогдох арга хэмжээ авах
- Эрүү шүүлтийн асуудлаар хохирогч болон иргэд хуулийн байгууллагын ажилтнуудыг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах

Одоогийн байдлаар Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Улаанбаатар хотод энэ ажлыг зохион байгуулж байна.

Нээлттэй хяналт, шалгалтын ажилтай уялдуулан мэдээлэл, ухуулга, сурталчилгааны ажил зохион байгуулж байна. Үүнд:

- Эрүүдэн шүүхийг хориглох тухай конвенци болон үндэсний хууль тогтоомжийн заалтыг иргэдэд таниулах зорилгоор 4 төрлийн богино хэмжээний реклама сурталчилгаа хийж Монголын Үндэсний телевизээр нэвтрүүлсэн
- Улс даяар захиалгаар түгээдэг өдөр тутмын сонин “Өдрийн сонин”-д “Эрүү шүүлт ба хүний эрх” булан ажилуулж мэдээлэл нийтлүүлж байна
- “Эрүү шүүлт ба хүний эрх” сэдвээр НҮБ-ын тусгай илтгэгч төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, эрүү шүүлтийн хохирогчийг оролцуулсан телевизийн 30 минутын нэвтрүүлэг хийж телевизээр цацсан

- ХЭҮК-ын дарга, гишүүд өдөр тутмын сонин, радио, телевизэд уг сэдвээр 20 орчим удаа ярилцлага өгөөд байна.

ХЭҮК-ын зохион байгуулж буй энэ ажлыг зарим байгууллага, хувь хүмүүс талархан дэмжиж байгаагаа илэрхийлж, гомдол мэдээлэл ирсээр байна. Тухайлбал; Эмнести Интернэйшнл байгууллагын Монгол дахь салбар, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Хүний эрх хөгжил төв зэрэг байгууллагууд дэмжиж илгээж ирүүлсэн.

Нээлттэй хяналт шалгалтын ажлын эцсийн зорилгыг дараах асуудлуудаар төлөвлөж байна.

- Монгол дахь эрүү шүүлтийн нөхцөл байдлыг тодорхойлно.
- Эрүү шүүлт гарч буй шалтгаан нөхцлийг тодорхойлно.
- Эрүү шүүлттэй хэрхэн тэмцэж байгааг тодорхойлж дүгнэлт хийнэ.
- Хууль тогтоомжид дүгнэлт хийнэ.

Хяналт шалгалтын ажлын үнэлэлт дүгнэлтэнд үндэслэн дараах арга хэмжээг авна.

- Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөө төлөв байдлын тухай ХЭҮК-ын 2006 оны ээлжит илтгэлийг зөвхөн энэ сэдвээр бичих Монгол Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж байхаар Их Хурал шийдвэрлэсэн нь Комиссын илтгэлд хууль тогтоогч ихээхэн ач холбогдол өгч байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Иймд Монгол дахь эрүү шүүлт, хэрцгий хүнлэг бус харьцааны нөхцөл байдлыг хууль тогтоогчийн сонорт хүргэх нь онцгой ач холбогдолтой ажил болно. МУ-ын Их Хурлаас тодорхой шийдвэр гарах болно.

- Засгийн газар, холбогдох яам, газруудад тус тусын үйл ажиллагаатай нь холбогдсон шаардлага, зөвлөмж, санал боловсруулан хүргүүлнэ.
- Хяналт шалгалтын ажлын тайланг хэвлүүлж, олон нийтэд түгээх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, тайлбарлан таниулах ажил зохион байгуулна.

Энэ ажил нь Монголын ХЭҮК хүний тодорхой нэг эрхэд чиглэсэн өргөн хүрээтэй ажил зохион байгуулж байгаагийн нэг хэлбэр мөн. Энэхүү ажлыг зохион байгуулахад зарим олон улсын байгууллага, зөвлөхүүд гүн тусалцаа үзүүлснийг зориуд тэмдэглэж байна.

4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлын нэг чиглэл нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенци болон үндэсний хууль тогтоомжийг хуулийн байгууллагын ажилтнуудад тайлбарлан таниулах, олон улсын гэрээ конвенцийг үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэдэг болгоход чиглэгдэж байна.

- Монгол Улсын ОУ-н гэрээ конвенцид ихээхэн ач холбогдол өгч Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээ конвенци, үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжтой харьшилбал олон улсын гэрээ конвенцийн заалтыг баримтална хэмээн Үндсэн хуульд заасан. Гэвч Олон улсын гэрээ конвенцийн заалтыг Монгол Улсын шүүх огт хэрэглэдэггүй хэмээн НҮБ-ын Хүний Эрхийн хорооны зөвлөмжид нэг бус удаа тэмдэглэгдсэн байдгийг ХЭҮК анхааралдаа авч шалтгаан нөхцлийг тодруулсан. Гол шалтгаан нь Монгол Улсын нэгдэн орсон гэрээ конвенци төрийн мэдээлэл сэтгүүлд

нийтлэгдээгүй байсан тулд хуульд зааснаар шүүх албан ёсоор хэрэглэх боломжгүй байсантай холбоотой байсан.

ХЭҮК Монгол Улсын Их Хурлын тамгын газартай хамтран хүний эрхтэй холбоотой (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийг баталсан) Монгол Улсын нэгдэн орсон 57 гэрээ конвенцийн албан ёсны орчуулгыг хийлгэж төрийн мэдээллийн тусгай дугаарын 2 боть болгон хэвлүүлж түгээсэн. Энэ шүүх дээр дурьдсан гэрээ конвенцийг үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэх боломжийг бүрдүүлж байна. ХЭҮК-иос шүүх, прокурор, цагдаа, өмгөөлөх байгууллагын ажилтнуудад явуулж буй сургалт нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэж байна.

ЦЕГ-тай харилцан тохиролцож, Нийслэлийн бүх дүүргийн Цагдаагийн газрын ажилтнуудад “ЭБШ ажиллагаа ба хүний эрх” сэдэвт 1 өдрийн сургалт зохион байгуулж байна. Энэ сургалтанд Эрүүдэн шүүхийн конвенци, ЭБШ ажиллагаанд гарч буй хүний эрхийн зөрчил зэргийг онцгойлон авч үзэж байна.

- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон Олон улсын Эмнести Интернэйшнл байгууллагаас гаргасан Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь сэдэвт үйл ажиллагааны гарын авлага номыг Монгол хэлэнд орчуулан хэвлүүлж хуулийн байгууллагын ажилтнуудад түгээсэн нь эрүү шүүлттэй тэмцэх олон улсын туршлага, арга барилыг түгээн дэлгэрүүлэх чухал арга хэмжээ болсон.
- 2002 оны 9-р сараас эхлэн мөрдөгдсөн ЭБШХ-иар аливаа гэмт хэрэгт холбогдсон этгээдийг баривчлах цагдан хорих шийдвэрийг шүүгч гаргадаг болсон нь Олон улсын гэрээ конвенцийн заалтыг үндэсний хууль тогтоомжид тусгасан хүний эрхийн томоохон дэвшил мөн. Энэ заалтийг амьдралд зөв хэрэгжүүлэх хүний эрхийг хангах зорилгоор улсын хэмжээнд ийм шийдвэр гаргах эрхтэй шүүгчдийг хамруулсан 1 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Баривчлах Цагдан хорих зөвшөөрөл олгоход хүний эрхийн үүднээс хандах, энэ арга хэмжээг өргөн хэрэглэхээс, удаан хугацаагаар хорихоос аль болох зайлсхийх, энэ шийдвэрийг гаргахдаа хэрэгт холбогдогч түүний өмгөөлөгчийг заавал оролцуулах, Монголын Цагдан хорих байрны нөхцөл олон улсын стандарт зэрэг асуудлыг голлон анхаарсан.

Түүнчлэн шүүгчдийн дунд явуулж буй сургалт нь олон улсын гэрээ конвенцийг хэрэглэх, тайлбарлан таниулахад чиглэгдэж байна.

- 2005 онд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажилд хяналт тавих үүргийг гүйцэтгэх аймаг, нийслэлийн прокурорын газрын орлогч прокуроруудад зориулсан 2 өдрийн сургалт зохион байгуулж, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, эрүүдэн шүүхтэй холбоотой зөрчлийг шалган шийдвэрлэх хариуцлага хүлээлгэх, эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийг хэрэглэх зэрэг сэдвүүдээр ярилцсан.

ХЭҮК-оос Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж буй гол ажлуудыг та бүхэнд товч танилцууллаа. Энэхүү ажил цаашид ч үргэлжлэн тогтмол хийгдэх анхаарал татсан асуудал гэж үзэж байна.

ХЭҮК –оос удаа дараалан тавьсан санал, зөвлөмж, шаардлага, илтгэлд хийсэн дүгнэлтийг Засгийн газар анхааралдаа авч, 2005 оны 8-р сарын 8-нд Ерөнхий сайд Захирамж гаргаж, хэрэг бүртгэлд мөрдөн байцаах үйл ажиллагааны явцад болох цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүний эрх

зөрчигдөж байгаа талаар судалгаа хийж, дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний тухай санал боловсруулах ажлын хэсэг байгуулав.

Ажлын хэсэгт:

- ЭБШ ажилгааны явцад цагдан хорих байруудад хоригдогсдын эрх зөрчигдөж байгаа эсэх,
- Хорих байрны нөхцөл хуулийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүгнэлт өгөх,
- Зөрчлийг арилгахад шаардагдах хөрөнгийн тооцоо гаргах,
- ЭБШ болон Эрүүгийн хуулийн заалтыг хүний эрхийн үндсэн зарчимд, Монгол улсын олон улсын гэрээнд нийцүүлэх санал боловсруулах,
- Эрүүдэн шүүж, хүнлэг бус харьцдаг, уг үйлдлийг өдөөн хатгадаг, зөвшөөрдөг, боломж олгодог албан тушаалтнуудад хариуцлага тооцох тогтолцоог бий болгоход чиглэсэн хяналт шалгалт, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулахыг даалгасан байна.

Энэ нь Комиссын энэ чиглэлээр хийсэн ажлын үр дүн гэж үзэж байна.

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ АЛБАН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРТ*

**Б.Хишигсайхан,
ХЭҮК-ын Ажлын албаны дарга**

“... Боловсрол нь бие хүнийг өв тэгш хүмүүжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болгоход чиглэх ёстой. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арстан хийгээд шашны бүлгүүд бие биенээ ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн НҮБ-аас энх тайвныг сахин хамгаалах талаар явуулж буй үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстой. . . ”

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, 26-р зүйл...

“Хүний эрхийн боловсрол”-ын тухай 57 жилийн өмнө өгсөн сонгодог тодорхойлолтоор илтгэлээ эхлүүлэхийг хүссэн тул Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалаас иш татан авсан билээ. Энэхүү түүхэн чухал баримт бичгээс хойш гарсан хүний эрхийн олон улсын олон баримт бичгүүдэд хүний эрхийн боловсрол, боловсролын хэрэгцээ, ач холбогдлыг тусгаж ирсэн. Тухайлбал Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын Пакт (13-р зүйл), Арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай Конвенци (7-р зүйл), Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенци (10-р зүйл), Хүүхдийн эрхийн тухай Конвенц (29-р зүйл), Вены Тунхаглал ба Үйл ажиллагааны хөтөлбөр (1-р хэсэг, 33-34, 2-р хэсэг 78-82), Арьс үндсээр ялгаварлан гадуурхах ... дэлхийн хурлын Тунхаглал ба Үйл ажиллагааны хөтөлбөр (1-р хэсэг, 33-34, 2-р хэсэг 78-82) зэргийг дурьдаж болно.

Хүний эрхийн боловсролын агуулга нь хүмүүсийн суурь үнэт зүйлсийг төлөвшүүлэх, эрхийг нь хамгаалах стратегийг боловсруулахад чиглэгдэх ёстой. Түүнчлэн хүний эрхийн боловсролын агуулгад тэгш боломж, ялгаварлан гадуурхалтын асуудлууд зайлшгүй багтах ёстой юм. Үүний дүнд хүмүүс соёл, зан заншил, хэл, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, хүйс гэх мэт ялгаатай байдлаа хүлээн зөвшөөрч, хүлцэн тэвчиж, өөр өөр бүлгүүд, олонх, цөөнх бие биетэйгээ зохицон амьдрах, эрх, эрх чөлөөгөө эдлэх тэгш боломжоор хангагдах угтвар нөхцөл болох юм. Нөгөө талаасаа хувь хүн эрхээ мэддэг, хэрэгжүүлж чаддаг болж, улмаар энэ нь дэлхий нийтийн энх тайван, хувь хүмүүсийн дээд зэргийн хөгжлийг хангах чухал арга зам болно. Ингэснээр нийгэмдээ эрхээ хэрэгжүүлж чаддаг болж бусдын эрхийг хүндлэнэ, тэгвэл эрх тэгш иргэдийн нийгэм дэх эрхийг хамгаалах үйл явцыг мэдэхийг хүснэ, ингэхийн тулд шийдвэр гаргах үйл явцад хүний идэвхтэй оролцоо шаардагдана. Энэ бүгд мэдлэгийн чанарыг шаардах ба бүрэн хэрэгжилт нь ур чадвараас хамаарна. Эцсийн бүлэгт энэ бүгдийг боловсрол хангана.

* АНДБНХЭБ-ын Чуулганы Х-р хуралдаан дээр тавьсан илтгэл

1993 онд Австри улсын нийслэл Вена хотноо хуралдсан НҮБ-ын “Хүний эрх” бага хурлаар хүний эрхийг хангах, хамгаалах явдалд ахиц гаргахад хүний эрхийн боловсролыг бүх нийтэд олгох нь зайлшгүй болохыг хүлээн зөвшөөрсөн билээ. Бүх нийтэд хүний эрхийн боловсролыг олгохын тулд сургуулийн өмнөх боловсролоос эхлэн дээд боловсрол хүртэл буюу боловсролын бүх түвшинд хүний эрхийн агуулгыг суралцагчдын хэрэгцээ, шаардлага, нас, сэтгэхүйн онцлогт нийцүүлж тусгах, багш нарыг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, энэ чиглэлийн албан бус сургалтыг эрчимжүүлэх ажлыг улс орнуудын Засгийн газрууд хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих явдалд чухал түлхэц өгсөн арга хэмжээ бол Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1995-2004 оныг Хүний эрхийн боловсролын 10 жил болгон зарласан явдал юм. Энэхүү 10 жилийн үр дүнг хэлэлцээд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас “Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр”-ийг батлаад байгаа билээ. Хөтөлбөрийн эхний ээлжинд 2005-2007 онд ерөнхий боловсролын систем дэх хүний эрхийн боловсролд анхаарал хандуулах зорилтыг дэвшүүлэн тавьсан билээ. Хөтөлбөр нь хүний эрхийн боловсролыг албан боловсролын системд оруулах явцад түлхэц өгсөн чухал арга хэмжээ болох нь дамжиггүй.

Хүний эрхийн боловсролыг албан боловсролын хөтөлбөрт оруулах чиглэлээр Монгол улс ямар арга хэмжээ авч буй, үр дүн ямар байгаа тухай авч үзье. Монгол Улсын боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд боловсролоос бүрдэнэ.

Манай улсын хувьд 1990 онд өрнөсөн ардчилсан хувьсгал, 1992 онд баталсан ардчилсан Үндсэн Хуулиас улбаалан хүний эрх, эрх чөлөө цоо шинэ утга агуулгаар баяжигдаж, олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн томъёологдож, хангагдаж, хамгаалагдах эхлэл тавигдсан. Үүнээс үүдэн хүний эрхийн боловсролыг бүх нийтэд, тодорхой зорилтот бүлэгт хүргэх явдал манай улсын тулгамдсан зорилтын нэг болоод байна. Хэдийгээр Монгол улс хүний эрхийн салбарт Хүний эрхийн Үндэсний Комисс (2001)-ыг байгуулсан, Монгол улсад Хүний эрхийг хангах Үндэсний Хөтөлбөр (2003)-өө баталсан зэрэг ололт амжилт багагүй байгаа хэдий ч хүний эрхийн боловсролыг албан боловсролын хөтөлбөрт тусгах талаар хийсэн амжилтаа бататгах, үнэлэх, цаашид сайжруулах талаар багагүй зүйлийг хийх шаардлага тулгарч байна. Засгийн газар хүний эрхийн боловсролыг албан болон албан бус боловсролоор дамжуулан иргэддээ хүргэх үүрэгтэй билээ. Албан боловсролын системийн тухайд МННХ-ээс БСШУЯ-тай хамтран хэрэгжүүлсэн “Хууль бидний амьдралд” хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн эрх зүйн хөтөлбөрийг шинэчлэх ажил хийгдэж, “Хүний эрх” хичээлийг өмнө үзэж байсан агуулгаас ялгаатай буюу илүү олон улсын хүний эрхийн боловсролын стандартад нийцүүлэн боловсруулсныг дурьдаж болох боловч сургалтын чанар хүссэн хэмжээнд хүрэхгүй хэвээр байна. Түүнчлэн хүний эрхийн боловсролын хөтөлбөр их дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд зэрэгт байхгүй байсаар өнөөг хүрлээ. Энэ хүрээнд зарим нэг хууль зүйн их дээд сургуулийн хувьд л заавал үзэх, сонгож үзэх байдлаар цөөн цагаар орж байна. Албан бус боловсролын хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудаас хүний эрхийн боловсролын чиглэлээр явуулж буй үйл ажиллагааг сайшаахгүй байх аргагүй юм. Харин Засгийн газрын зүгээс энэ чиглэлээр мөн л дорвитой хийсэн ажил ховор байна.

Монгол улсын хувьд хүний эрхийн боловсролын талаар баримтлах нэгдсэн бодлого байхгүй өнөөг хүрч ирсэн. Саяхан батлагдсан Хүний эрхийг хангах үндэсний Хөтөлбөрт хүний эрхийн боловсролын тухай асуудал орхигдсон нь энэ чиглэлээр цаашид анхаарах шаардлагатай болохыг харуулж байна. Илтгэлийг хүний эрхийн боловсролын чиглэлээр хийгдсэн зарим судалгааны ажлын дүнд тулгуурлан бэлтгэсэн. Монгол улсын хувьд хүний эрхийн боловсрол албан боловсролын түвшинд ямар байгааг ерөнхий боловсрол, их дээд сургуулийн хүрээнд танилцуулж байна.

Ерөнхий боловсролын сургуульд

Монгол улсын хувьд НҮБ-аас зарласан Боловсролын 10 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн нэг томоохон ажил бол ерөнхий боловсролын сургуулийн эрх зүйн хичээлийн хөтөлбөрийг цогцоор нь шинэчилсэн явдал билээ. Дунд сургуулийн эрх зүйн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх ажлыг МННХ (Соросын сан)-ийн “Хууль бидний амьдрал” хөтөлбөрийн хүрээнд 1998-2003 онуудад хийж гүйцэтгэжээ. Эрх зүйн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэхдээ хүүхэд, залуучуудын хүний эрхийн боловсролд ихээхэн анхаарал тавьсан бөгөөд анги тус бүрийн хичээлийн агуулгад хүний эрхийн асуудлыг тусгахыг хичээснээс гадна, 6-р ангид “Хүний эрх” хичээлийг бие даалган оруулахаар бодолцож боловсруулсан. Шинэчилсэн хөтөлбөрийн дагуу 2003 оноос орж эхэлсэн хүний эрхийн хичээлийн зорилго бол сурагчдыг хүний эрх, эрх чөлөөний талаар мэддэг, хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх арга замыг ашиглаж чаддаг, бусдын эрхэд хүндэтгэлтэй ханддаг болгон төлөвшүүлэх явдал юм. Мэдээж энэхүү цогц чадамжыг сурагчдад олгоход сургалтыг уламжлалт аргаар явуулах хангалттай биш бөгөөд багш нар сургалтын олон арга техникийг хэрхэн хэрэглэж байгаа болон сургуулийн удирдлага, хамт олны зүгээс сургуулийн байр, анги танхимд хүний эрхийн орчинг хэрхэн бүрдүүлсэн бэ? зэрэг олон хүчин зүйлээс хамаарах болоод байна.

Ерөнхий боловсролын сургуулиудын хүний эрхийн хичээлд үнэлгээ хийж үзэхэд өнөөгийн байдлаар дараах давуу болон сул талыг ажиглагдаж байна.

Давуу тал

- Хүний эрхийн боловсролын стандарт нь цогц чадамжийг хөгжүүлэхэд чиглэгдсэн;
- Хүний эрх хичээлийн хөтөлбөрийг шинэчилсэн;

Сул тал

- Тогтоосон цагаар оруулахгүй байх, тухайн цагт нь өөр хичээлийг оруулах, энгийн болон сонгон суралцах ангиудад ялгавартай оруулах;
- Багшлах боловсон хүчний нөөц хомсдолтой, хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин хомс, багш нарт удирлагын зүгээс агуулга, арга зүйн туслалцаа үзүүлэх нь хомс;
- Хүний эрхийн хичээлийг олон багшаар дамжуулан заалгах;
- Сургалтыг ихэвчлэн уламжлалт аргад тулгуурлан явуулдаг;
- Сургалтын менежер боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөөнд тогтмол хяналт тавихгүй байх

Ерөнхий боловсролын сургууль 2005-2006 оны хичээлийн жилээс эхлэн 11 жилийн сургалтанд (10 жил байсан) шилжиж байгаатай холбогдуулан боловсролын стандарт шинэчлэгдэж байгаа бөгөөд хүний эрхийн боловсролыг I – XI ангиудад нас, сэтгэхүйн онцлогт нь тохируулан оруулахаар шинэчлэлт хийгдэж байгаа явдал бол энэ салбарт гарч байгаа нэг том ахиц дэвшил мөн билээ.

Ерөнхий боловсролын сургууль нь хүний эрхийн хичээлийг заагаад зогсохгүй ерөнхий боловсролыг олгож байгаа бусад судлагдахуунуудаа ч мөн ялгаагүй хүний эрхэд суурилсан байгаа эсэхийг эргэж харах ёстой.

Ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд хүний эрхийн боловсролыг олгох явцад хүний эрхийн хичээл зааж буй багшаас гадна, бусад багш нар, сургуулийн удирдлагуудын хувьд ч өндөр үүрэг хариуцлага оногдох ёстой. Хүний эрхийн боловсролыг олгоход зөвхөн хичээлийн анги, танхим биш, танхимын гаднах орчин ч эерэг болон сөргөөр нөлөөлдөг. Хүний эрхийн боловсролын нэг чухал зорилт бол хамт олон, нийгэмд хүний эрхийн орчныг бүрдүүлэх явдал байдаг. Нөгөө талаасаа хүний эрхийн орчин бүрдээгүй газар хүний эрхийн боловсролыг төгс эзэмших боломжгүй билээ. Сургуулийн хүний эрхийн орчин бол сурагчдын хүний эрхийн боловсролыг эзэмших нэг чухал угтвар нөхцөл юм. Тиймээс сургуулийн дотоод дүрэм журмаас эхлээд хүний эрхийн зарчимд тулгуурласан байх явдал нэн чухал. Түүнчлэн багш нарын ажлыг дүгнэхдээ баримтлах гол шалгуур үзүүлэлт хүний эрхэд тулгуурласан байх, сурагчдад суралцах тэгш боломж олгох, буруутай сурагчдад хүлээлгэх хариуцлага нь хүний нэр төр, эрхэм зэрэгт хүндэтгэлтэй хандахад чиглэсэн байхад сургуулийн удирдлага анхаарлаа хандуулж байх ёстой. Сургуулийн ардчилсан орчин бол хүний эрхийн боловсрол цэцэглэн хөгжих хамгийн таатай хөрс суурь гэдгийг хэзээ ч мартаж ёсгүй.

Гэвч өнөөдрийн байдлаар хүний эрхэд суурилсан боловсролын тухай, сургуулийн хүний эрхийн орчны талаар нарийвчлан хийсэн судалгаа, шинжилгээний тоймтой ажил байхгүй байгаа бөгөөд Комиссоос хийсэн судалгааны дүнгээс харахад сургуулийн орчинд хүний эрх, хүүхдийн эрх зөрчигдөх явдал түгээмэл байна. Сургуулийн материаллаг орчны хувьд ч мөн ялгаагүй хүүхдийн эрүүл аюулгүй орчинд суралцах, ном, сурах бичиг, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байх гэх мэт эрхүүд нөөцийн хомсдолтой холбоотойгоор ноцтойгоор зөрчигдөж байна. Энэ байдал төвөөс алслагдах тусам, хөдөөгийн сүмдэд илүү хүндэрч ажиглагдаж байна.

Их дээд сургуулийн хөтөлбөрт

Их, дээд сургуулийн хөтөлбөрт хүний эрхийн боловсролыг хэрхэн тусгасан талаар цөөн тооны судалгааны ажлууд байдаг. Одоогийн байдлаар эрх зүйн боловсрол олгож байгаа болон бусад их дээд сургуулиуд хэмээн ялгаатайгаар судалгааны ажлыг хийж байна. Их дээд сургуулийн хичээлийн хөтөлбөрт хүний эрхийн хичээлийг оруулах зайлшгүй шаардлага өнөөдөр байгаа билээ. Учир нь төрийн болон хувийн хэвшилд ажиллаж байгаа албан хаагчдын зүгээс хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдал түгээмэл байгаа болох нь төрөл бүрийн хүний эрхийн судалгааны үр дүн харуулж байна.

Хууль зүйн их дээд сургуулиудын хувьд Гэгээрлийн сайд, Хууль зүйн сайдын (хуучин нэрээр) хамтарсан 230/200 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрт хүний

эрхийн хичээлийг 36 цаг үзэхээр зааж, энэ нь 1997 оноос хэрэгжиж эхэлсэн. Хэдийгээр хүний эрхийн хичээлийг оруулахаар заасан ч бодит байдал дээр маш цөөн тооны сургууль хүний эрхийн хичээлийг заавал үзэх, ихэнх сургуулиуд сонгон байдлаар үзэхээр заасан байгаа нь хуульч мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудын хувьд хангалттай үзүүлэлт биш билээ. Сургуулийн удирдлагууд хүний эрхийн хичээлийг бусад салбар эрхзүйн хүрээнд яригдах боломжтой, тусгайлан үзэх шаардлагагүй хэмээн цааргалах байдал одоо ч байсаар байна. Одоогоор эрх зүйн боловсрол олгож байгаа их дээд сургуулийн боловсролын стандартыг шинэчилж байгаа бөгөөд энэ ажлын хүрээнд хүний эрхийн хичээлийг заавал үзэх судлагдахуун болгох талаар мэргэжилтнүүд идэвхийлэн ажиллаж байгаа юм.

Бусад их дээд сургуулиудын хувьд эрх зүйн хичээлийн цагт хүний эрхийн хичээлийг судалдаг гэж байгаа ч энэ нь Үндсэн хуулийн эрх зүйн хичээлийн хүрээнд орж байгаагаас тухайн мэргэжилтэй холбоотой хүний эрхийн тухай асуудлыг дэлгэрүүлэн үздэг сургууль байхгүй байна. Түүнээс гадна хүний эрхийн тухай асуудал бол зөвхөн хуульч мэргэжилтэн мэдвэл зохих зүйл хэмээн хэт өрөөсгөл үздэг байдал манай улсын их дээд сургуулийн удирдлага, багш, оюутнуудын дунд байсаар байгаа юм. Саяхнаас багш бэлтгэдэг зарим сургуулиуд эрх зүй, нийгмийн ухааны ангид судлах хүний эрхийн хичээлийн хөтөлбөрийг боловсруулж туршиж байгаа явдал бол энэ салбарт гарч байгаа нэг томоохон ахиц дэвшил.

ХЭҮК-ЫН ГҮЙЦЭТГЭЖ БҮЙ ҮҮРЭГ

Илтгэлийн дараагийн хэсэгт Хүний эрхийн Үндэсний Комисс хүний эрхийн боловсролыг албан боловсролын хөтөлбөрт оруулах чиглэлээр юу хийж байгаа тухай оруулсан болно.

Хуулинд заагдсаны дагуу ХЭҮК-ын нэг гол чиг үүрэг бол хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих явдал юм. Тиймээс ч 2000, 2004 онд баталсан Хүний эрхийн үндэсний Комиссын стратеги төлөвлөгөөнд Хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих чиг үүрэг нь Комиссын үйл ажиллагааны чухал хэсэг юм хэмээн үзсэн. Тиймээс ч Хүний эрхийн боловсролын хөтөлбөрөө боловсруулж, батлан, хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн эрхэм зорилго нь хүний эрхийн үзэл баримтлалыг нийгмийн хэм хэмжээ, үйл байдал бүрт шингээхэд чиглэгдсэн бөгөөд хөтөлбөр нь:

- Бүх шатны сургуульд
- Нийгмийн тодорхой зорилтот бүлэгт
- Олон түмэнд гэсэн гурван категорид ангилан хэрэгжихээр төлөвлөгдсөн.

Үүнээс бүх шатны сургуульд юу хийж байгаа тухай дэлгэрүүлье.

Стратеги төлөвлөгөөнд Комисс нь холбогдох яам, газруудтай хамтарч ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулиудад хүний эрхийн боловсрол олгох, хүний эрхийн сургалт явуулах нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх талаар ажиллахаар тусгасан.

Ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн боловсролын хөтөлбөрийг боловсруулах үе шатанд Комисс байгуулагдсан цагаасаа эхлэн идэвхтэйгээр хамтран ажиллаж ирсэн. Тухайлбал ЕБС-ийн 6-р ангид оруулах хүний эрх

хичээлийн сурах бичгийг боловсруулах, хянах ажилд Комиссын дарга, ажилтнууд идэвхтэй оролцож байсан.

Комиссоос энэ чиглэлээр хийж байгаа нэг томоохон ажил бол 2005 оноос “Хүний эрхийн боловсрол ерөнхий боловсролын сургуульд” сэдвийн хүрээнд ЮНЕСКО-ын дэмжлэгтэйгээр жижиг хэмжээний төсөл хэрэгжүүлж байна. Энэ төслийн зорилго бол хүний эрхийн боловсрол олгох ажил Ерөнхий боловсролын сургуульд хэрхэн явагдаж байгаад үнэлгээ өгөх, цаашид сайжруулах талаар санал, зөвлөмжийг холбогдох байгууллагад тавих болон энэ хичээлийг заах багшид тавигдах наад захын шаардлагыг боловсруулах явдал юм. Энэхүү судалгааны ажлын тайлан боловсруулагдаж дуусч байгаа бөгөөд дараагийн шатны ажилдаа ороод байна.

Мөн түүнчлэн Комиссын Ажлын албаны дарга HURISTMON төслөөс санхүүжүүлсэн ерөнхий боловсролын сургуульд хүний эрхийн хичээл заах багшид зориулсан гарын авлага боловсруулах ажилд хамтран зохиогчоор оролцсон. Энэ нь хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай байгаа өнөө үед ялангуяа хөдөө орон нутгийн багш нарт чухал хэрэгцээтэй гарын авлага болж, хүний эрхийн боловсрол олгох ажилд ахиц гаргах нь дамжиггүй.

Комиссоос албан боловсролын хөтөлбөрт хүний эрхийн боловсролыг тусгуулахаар хийсэн өөр нэг чухал ажил бол Канад сангийн дэмжлэгтэйгээр 2003 онд хэрэгжүүлсэн “Хүний эрхийн боловсрол” төсөл билээ. Энэ төслийн хүрээнд эрх зүйн боловсрол олгож буй их дээд сургуулийн хүний эрхийн хичээлийн загвар хөтөлбөрийг боловсруулсан юм. Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхээр Үндсэн хуульдаа тунхаглаж, хүний эрх, эрх чөлөөг цоо шинэ утга агуулгаар баталгаажуулсан өнөөгийн нийгэмд хүний эрхийн боловсролтой, асуудалд хүний эрхийн мэдрэмжтэй ханддаг эрх зүйч мэргэжилтэнг бэлтгэн гаргах нь нэн тулгамдсан асуудал болоод байна. Учир нь хууль, шүүхийн байгууллага нь хүнийг мөрдөх, шийтгэх зэвсэг, төрийн илд хэмээн үзэх нийгмийн гаж хандлага өнөөг хүртэл давамгайлсаар байгаа бөгөөд энэ салбарт хүний эрхийн ноцтой зөрчлүүд гарсаар байгаа нь Комисс болон өөр байгууллагуудын явуулсан судалгаанаас харагдаж байгаа билээ.

Хуульч мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудад судлах хүний эрхийн хичээлийн хөтөлбөрийн зорилгыг бид хүний эрхийн талаар өндөр мэдлэг, хүний эрхийг хангах, хамгаалах арга, механизмыг ашиглах чадвар, хүний эрхийг эрхэмлэн хүндэтгэх хандлага бүхий цогц чадамжийг оюутанд төлөвшүүлэх явдал хэмээн тодорхойлсон.

Хөтөлбөрийн зорилт

- Хүний эрх, эрх чөлөө, түүнийг хангах, хамгаалах үндэсний болон олон улсын механизмын талаар мэдлэгтэй болох
- Хүний эрхийн хөгжлийн өнөөгийн чиг хандлагыг танин мэдэх
- Хүний эрхийн зөрчлийг тогтоож, түүнийг шийдвэрлэх, таслан зогсооход олон улсын болон үндэсний механизмыг бүрэн дүүрэн ашиглаж сурах
- Хүний эрхийг баталгаажуулсан олон улсын гэрээ конвенц болон үндэсний хууль тогтоомжийг харьцуулан судлах, тэдгээрт дүн шинжилгээ хийх

- Асуудалд тал бүрээс нь шүүмжлэлтэй ханддаг, бусдыг сонсож, бусадтай хамтран ажилладаг, энэ үндсэн дээр шийдвэр гаргадаг үйл явцад суралцах
- Асуудалд хүний эрхийн өндөр мэдрэмжтэй хандаж сурах

Тус төслийн хүрээнд боловсруулсан загвар хөтөлбөр нь нилээд иж бүрэн болсон бөгөөд хөтөлбөрт заагдсан хичээлүүдийг заахад тодорхой оролцооны аргуудыг санал болгосон. Түүнчлэн багшийн онолын мэдлэгт хувь нэмэр болох мэдээллийн болон түгээмэл хэрэглэгддэг арга зүйг хэрэглэх аргачлалуудыг багтаасан хоёр хавсралтаас хөтөлбөр бүрдсэн. Энэхүү хөтөлбөрийг сайжруулах үүднээс 3 их дээд сургуульд туршилт хийж, 20 оюутныг оролцуулсан “Зуны сургалт” зохион байгуулсан юм. Төслийн хүрээнд 20 орчим их дээд сургуулийн 60 гаруй багш нарт (давхардсан тоогоор) хөтөлбөрөөр хэрхэн хичээл заах тухай арга зүйн сургалтыг 3 удаа зохион байгуулсан. Төгсгөлд нь хүний эрхийн хичээлийг заавал судлах ач холбогдлыг холбогдогч талуудад ойлгуулах үүднээс оролцогч бүх талуудыг урьж бага хурал зохион байгуулсан.

Мөн түүнчлэн нийгмийн ухааны багш бэлтгэдэг сургуулийн хүний эрх хичээлийн хөтөлбөр боловсруулах багт зориулсан сургалтанд ХЭҮК-ын ажилтнууд очиж, өөрсдийн туршлагаасаа хуваалцсан.

Дээрх бүхий л ажлууд нь Комиссын зүгээс хүний эрхийн боловсролыг албан боловсролын хөтөлбөрт оруулахад хувь нэмэр болоход чиглэж байсан бөгөөд цаашид ч энэ чиглэлийн үйл ажиллагаагаа улам бүр эрчимжүүлэхээр чармайн ажиллаж байгаа болно.

Комиссын албан боловсролын системд хүний эрхийн боловсролыг тусгах санаачилгыг дэмжиж санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Канад сан, ЮНЕСКО зэрэг санхүүжүүлэгч байгууллагууд, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн их, дээд сургуулийн эрдэмтэн багш нар, заах арга зүйн мэргэжилтнүүдэд талархлаа дэвшүүлье.

Хүний эрхийн боловсролыг албан боловсролын хөтөлбөрт оруулж, боловсролын бүхий л салбар чиглэлээр дамжуулан хүний эрхийн боловсролыг иргэдэд олгох нь дэлхий дээр энх тайван тогтоох, аливаа төрлийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох хамгийн үр дүнтэй арга мөн тул энэ чиглэлээр үндэсний, бүс нутгийн, олон улсын байгууллагуудыг идэвхтэй хамтран ажиллахыг уриалж байна.

ХУУЛЬЧДЫН ЗӨВЛӨЛИЙН ЭРҮҮ ШҮҮЛТИЙН ТАЛААРХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Хураангуйлал

ЭШУСХолбоо	Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх холбоо
Хүч хэрэглэх тухай зарчим	(НҮБ)-ийн Нийгмийн хэв журам сахиулах зарчим
Бээжингийн Дүрэм	Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг Дүрэм
Зарчмуудын цогц	(НҮБ)-ийн Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах Зарчмууд
ЭШЭК	Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенц
ЭАБХУК	Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц
ЭЗНСЭХ	(НҮБ)-ийн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо
ХЭК	Хүүхдийн эрхийн тухай конвенц
ЭШЭТ	(НҮБ)-ийн Бүх этгээдийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай Тунхаглал
ХЭЕШ	Хүний эрхийн Европын шүүх
ЕХ	Европын Холбоо
ЕК	Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах Европын Конвенц
Женевийн Конвенц 1	Дайтаж байгаа армийн шархадсан ба өвчтэй цэргийг асран хамгаалах тухай Женевийн Конвенц
Женевийн Конвенц 4	Дайны үед энгийн хүн амыг хамгаалах тухай Женевийн Конвенц
ХЭХ	(НҮБ)-ийн Хүний эрхийн хороо
ХЭАДК	Хүний эрхийн Америк дундын Комисс
ОУЭШ	Олон улсын эрүүгийн шүүх
ИУТЭОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт

ЭЗНСЭОУП	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт
ЮЦШ	Хуучин Югаславын олон улсын эрүүгийн шүүх
Инстанбулын зарчим	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг гутаан доромжлох, шийтгэх хэргийг баримтжуулах болон тийм хэрэгт үр дүнтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулах Зарчим
ТББ	Төрийн бус байгууллага
ХЭҮБ	Хүний эрхийн үндэсний байгууллага
ХЭДКГ	Хүний эрхийн дээд комиссариатын газар
Эмнэлгийн ёс зүйн зарчмууд	(НҮБ)-ийн Хоригдсон болон саатуулагдсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлох,
ДК	Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай Конвенц
Ромын дүрэм	Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм
Насанд хүрээгүйчүүдийг хамгаалах дүрэм	(НҮБ)-ийн Эрх чөлөөгөө хасуулсан насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах Дүрэм
Женевийн Конвенц 2	Тэнгисийн зэвсэгт хүчний шархдагсад, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд нэрвэгдэгсдийг хамгаалах тухай Женевийн 2-р Конвенц
НЗЖД	(НҮБ)-ийн Хоригдлуудтай харьцах наадзахын жишиг дүрэм
Женевийн Конвенц 3	Дайнд олзлогсодтой харьцах тухай Женевийн 3-р Конвенц
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ХЭТТ	(НҮБ)-ийн Хүний эрхийн түгээмэл тунхаглал
Венийн Конвенц	Олон улсын гэрээний жрх зүйн тухай Венийн Конвенц

**Ази Номхон далайн бүс нутгийн Хүний эрийн Үндэсний байгууллагуудын
Чуулганы Хуульчдын зөвлөл**

Хуульчдын зөвлөл нь хүний эрхийн олон улсын хэм хэмжээ (хууль тогтоомж, стандарт)-г тайлбарлах, хэрэглэх асуудлаар Ази, Номхон далайн Хүний эрхийн Үндэсний байгууллагуудын Чуулганд зөвлөр эрх бүхий байгууллага юм. Хуульчдын зөвлөл нь шүүхийн өндөр албан тушаалтан эсвэл эрдэмтэд болон хүний эрхийн байгууллагын албан тушаалтан зэрэг нэр нөлөө бүхий хуульчдаас бүрддэг.

Хуульчдын зөвлөлийг байгуулсан явдал нь олон улсын хүний эрхийн асуудлаар хараат бус, албан ёсны зөвлөгөө авах түүнчлэн олон улсын хүний эрхийн хэм хэмжээг тайлбарлах, хэрэглэхтэй холбоотой бүс нутгийн эрх зүйн тогтолцоог хөгжүүлэх зайлшгүй шаардлага байгааг Чуулган хүлээн зөвшөөрснийг илтгэн харуулж байна. Хуульчдын зөвлөлөөс дараахь лавлагааны материалуудыг тус тус гаргасан байна. Үүнд: 1) Терроризмийн эсрэг хууль тогтоомж; 2) Хуулийг дээдлэх зарчим (2004); Хүүхэд, эмэгтэйчүүдийг хил дамнуулан худалдах; 3) Шаазаар явах ял (2000); болон 4) Интернет дэх хүүхдийн садар самууныг хориглосон журам (2000) зэрэг болно.

Хуульчдын зөвлөлийн үйл ажиллагааны талаар www.asiapacificforum.net/jurists/ сайтаар орж дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.

Чуулганы Хуульчдын зөвлөлийн гишүүд:

- Жүгнээгийн Амарсанаа (Монгол)
- Профессор Гиллиан Триггс (Австрали)
- Шүүгч Энтони Гейтс (Фижи)
- Фали С Нариман (Энэтхэг)
- Профессор Якоб И Сахетапи (Индонез)
- Дато' Махадев Шанкар (Малайз)
- Даман Нат Дунгана (Балба)
- Шүүгч Сьюзан Глейзбрүүк (Шинэ Зеланд)
- Седфри А Ордонез (Филиппин)
- Профессор Къёон-Вам Анн (Солонгос)
- Ражендра КВ Гүнесекере (Шри Ланк)
- Профессор Витит Мунтарбхорн (Тайланд)

АЖЛЫН УДИРДАМЖ

Балбын Вант улсад 2004 оны 2-р сард хуралдсан Ази, Номхон далайн бүс нутгийн Хүний эрхийн Үндэсний байгууллагуудын Чуулганы 8-р хуралдаанаас гаргасан шийдвэрээр цагдан хоригдох хугацаанд эрүү шүүлтээс хамгаалах асуудлаар шинэ лавлагаа, тайланг Хуульчдын зөвлөлөөр боловсруулж төслийг Чуулганаар хэлэлцүүлж, батлуулахыг Чуулганы нарийн бичгийн дарга нарын газраас Ази, номхон далайн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулган Хуульчдын зөвлөлд хандаж эрүү шүүлт тулгах буюу хэргийг эсхүл хүний ёсноос гадуур нэр төрийг нь гутаан доромжлон харьцаж шийтгэхтэй холбоотой олон улсын хууль тогтоомж, баримт бичгүүд болон хэм хэмжээний асуудлаар санал зөвлөмж боловсруулахыг хүссэн байна.

Ялангуяа Хуульчдын зөвлөл дараах асуудлуудыг авч үзэхийг хүссэн байна.
Үүнд:

- (i) Урьдчилан хорих, мөрдөн байцаалт явуулах, эмнэлгийн туршилт хийх, биеэр шийтгэл үзүүлэх, жендерийн тусгайлсан хэлбэртэй болон бэлгийн хүчирхийллийн тухайд “эрүү шүүлт” болон бусад хэлбэрийн хүнлэг бус харьцааг олон улсын хүний эрхийн баримт бичгүүд, хэм хэмжээнд юу гэж тодорхойлж байна вэ? Дээрх дүгнэлтийн хүрээнд мөрдөн байцаалтын наад захын жишиг стандартыг боловсруулж танилцуулахыг Хуульчдын зөвлөлөөс хүссэн юм.
- (ii) Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хүнлэг бус харьцааг олон улсын заншлын хуулиар хориглосон нь олон улсын, бүс нутгийн болон үндэсний шүүхийн шийдвэр, зарим эрдэмтдийн дүгнэлт болон Хүний эрхийн хороо, Эрүү шүүлтийн эсрэг хороо зэрэг олон улсын байгууллагуудын бичиг баримтанд тусгагдсан байна.
- (iii) Эрүү шүүлт тулгах буюу хэргийг, эсхүл нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хориглосон нь зарим нөхцөлд зөрчигддөг эсэх
- (iv) Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хүнлэг бус харьцаанаас хамгаалахад чиглэгдсэн хүний эрхийн олон улсын эрх зүйгээр тогтоосон процедурын баталгаа болон бусад төрлийн хамгаалалтын мөн чанар, хүрээ
- (v) Олон улсын хүний эрхийн хууль тогтоомж болон хэм хэмжээгээр тогтоосон хамгаалалтын арга хэрэгсэл нь эрүү шүүлт болон зүй бус харьцааны үр дүнд тогтоогдсон аливаа мэдүүлгийг шүүн таслах ажиллагаанд нотлох баримт болгон ашиглахгүй байх явдлыг хангах нь
- (vi) Засан сайжруулах арга хэмжээ (исправительные меры) нь өргөдөл гомдол барагдуулах, нөхөн олговрын механизм болон эрүүл мэндийг нөхөн сэргээх замаар эрүү шүүлт болон бусад хэлбэрийн зүй бус харьцааны золиос бологсдод хүртээмжтэй байх
- (vii) Тухайн хүмүүсийг эрүү шүүлт болон хүнлэг бус харьцааны золиос болж болох орон руу нь хүчээр буцаахаас хамгаалах нь
- (viii) Дотоодын болон олон улсын мөргөлдөөний үе дэх эрүү шүүлт болон бусад төрлийн зүй бус харьцааны талаарх олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомж
- (ix) Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн зүй бус харьцааг авч үзэж буй үндэсний болон олон улсын цэргийн шүүхийн эрх мэдэл

- (х) Олон улсын энхийг сахиулах хүчний үйлдсэн эрүү шүүлт болон бусад хэлбэрээр зүй бус харьцсан хэргийг үндэсний болон олон улсын цэргийн шүүхээр шүүн таслах нь
- (хи) Бусад байгууллага (төрийн бус эсвэл олон нийтийн байгууллагууд)-ын үйлдсэн зөрчлөөс хамгаалах үүргийн мөн чанар, хүрээ зэрэг болно.

ЭРҮҮ ШҮҮЛТИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ

Анх Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 5-р зүйлд:

“Хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, хүний ёсноос гадуур эсхүл, нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхийг хориглоно” гэж заасан нь эрүү шүүлтийг хориглосон олон улсын баримт бичгийн эхлэл нь болсон юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын энэхүү үг хэллэг (нэр томьёо) нь дараа дараагийн олон улсын болон бүс нутгийн шинж чанартай хүний эрхийн баримт бичгүүд болох “Хүний эрх, суурь эрх чөлөөг хамгаалах Конвенц”, “Хүний эрхийг хамгаалах Америкийн Конвенц”-д тусгагдсан билээ. “Эрүү шүүлт” гэсэн нэр томьёоны утгыг дараах олон улсын эрх зүйн баримт бичиг, гэрээ, конвенцийн зүйл заалтаар ерөнхийд нь болон тусгайлан тайлбарласан (нарийвчлан тодорхойлсон) байна.

(i) Эрүү шүлтийн талаарх олон улсын хүний эрхийн баримт бичгүүд

Хүний эрхийн болон хүмүүнлэгийн эрх зүйн баримт бичгүүд

Эрүү шүүлттэй холбоотой хүний эрхийн олон улсын хэд хэдэн гэрээ хэлэлцээр байдаг. Тухайлбал:

- Эрүүдэн шүүх болон хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц
- Эрүүдэн шүүх болон хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт протокол
- Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт
- Хүүхдийн эрхийн конвенц
- Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц
- Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц (Дүрвэгсдийн конвенц)

зэрэг болно.

Женевийн конвенц болон уг конвенцийн 2 нэмэлт Протоколууд нь нийлээд олон улсын хүмүүнлэгийн гэрээ болох бөгөөд эдгээр нь мөн л эрүү шүүлттэй холбоотой. Тухайлбал:

- Дайтаж байгаа армийн шархадсан ба өвчтэй цэргийг асран хамгаалах тухай конвенц
- Тэнгисийн зэвсэгт хүчний шархдагсад, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд нэрвэгсдийг хамгаалах тухай
- Дайнд олзлогсодтой харьцах тухай
- Дайны үед энгийн хүн амыг хамгаалах тухай

- Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдсдийг хамгаалах тухай 1949 оны 8-р сарын 12-ны Женевийн конвенцийн нэмэлт Протокол
- Олон улсын бус зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай 1949 оны 8-р сарын 12-ны Женевийн конвенцийн нэмэлт Протокол

Эцэст нь Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм нь энхийн болон дайны (зэвсэгт мөргөлдөөний үед) үед эрүү шүүлтийг хориглохтой холбогдсон чухал ач холбогдол бүхий олон улсын гэрээ юм.

Дээрх Конвенцэд нэгдэн орсон Ази, Номхон далайн Чуулганы гишүүн 15 орны хүний эрхийн үндэсний байгууллагуудын статусын талаар Хүснэгт –1-д (Эрүү шүүлттэй холбоотой хүний эрхийн баримт бичиг), эрүү шүүлттэй холбоотой хүмүүнлэгийн баримт бичгийн талаар Хүснэгт-2-оос тус тус үзнэ үү.

Нэмэлт баримт бичгүүд

НҮБ-ийн Ерөнхий Ассемблей, Эдийн засаг, нийгэм болон соёлын эрхийн зөвлөлөөс саатуулагдсан этгээдтэй харьцах (ерөнхий) мөн эрүү шүүлт (тусгайлсан заалт бүхий)-тэй холбоотой хэд хэдэн нэмэлт баримт бичгүүдийг тус тус баталсан байна. Үүнд:

- Бүх этгээдийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай Тунхаглал
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлох, шийтгэх хэргийг баримтжуулах болон тийм хэрэгт үр дүнтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулах Зарчим
- Хоригдсон буюу саатуулагдсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон харгис хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах ба шийтгэхээс хамгаалахад эрүүлийг хамгаалах ажилтнууд, тухайлбал, эмч нарын гүйцэтгэх үүргийн ёс зүйн зарчмууд
- Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах Зарчмууд цогц
- Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд
- Эрх чөлөөгөө хасуулсан насанд хүрээгүй хүмүүсийн эрхийг хамгаалах Дүрэм
- Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль
- Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан, галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн Зарчим зэрэг болно.

Ерөнхий санамж

Эрүү шүүлттэй холбоотой ИУТЭОУП, ЭШЭК болон Хүүхдийн Конвенц тус бүрээр тусгайлсан заалтуудыг “Ерөнхий санамж” гэсэн хэсэгт оруулж өгсөн. Эрүү шүүлтийн эсрэг Хороо нэг санал боловсруулж танилцуулсан байна. Ерөнхий санамж-1 нь 22-р зүйл (хувь этгээдийн гомдол барагдуулах механизм)-ийн хүрээнд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 3-р зүйл (буцаах)-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой юм. Энэхүү ерөнхий санамж нь буцаахгүй байх зарчмын асуудлаарх Хороонд хандах гэсэн хүмүүсийг практик шинжтэй удирдамж, зөвлөгөөгөөр хангасан.

Эрүү шүүлттэй холбогдолтой асуудлаарх бусад ерөнхий санамжийг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо, Хүний эрхийн хороо болон Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах асуудлаарх хорооноос тус тус гаргажээ. Үүнд:

- ЭЗНСЭХ-ны Ерөнхий санамж - 14: эрүүл мэндийн хувьд биеийн болон сэтгэл санааны аливаа шаналал зовлонд өртөхгүй байх эрх,
- ХЭХ-ны Ерөнхий санамж - 20: эрүү шүүлт болон бусад хэлбэрээр хэрцгий, нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхийг хориглох,
- ХЭХ-ны Ерөнхий санамж - 24: Пакт болон Нэмэлт протоколд нэгдэн орсон эсвэл Пактын 41-р зүйлийн хүрээндэх тунхаглалтай холбоотой хийгдсэн тайлбар,
- ХЭХ-ны Ерөнхий санамж - 29: Онцгой байдлын үеэр зүй бус харьцахгүй байх (4-р зүйл),
- ХЭХ-ны Ерөнхий санамж - 31: Пактад оролцогч улсуудын хүлээх эрх зүйн үүргийн мөн чанар,
- Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах асуудлаарх хорооны Ерөнхий санамж - 19: Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл,

А ХЭСЭГ

Ерөнхий зөвлөмж, санал

Хүний эрхийн үндэсний байгууллагууд болон эрүү шүүлтээс хамгаалах асуудлаар Хуульчдын зөвлөл хэд хэдэн зөвлөмж, санал боловсруулж танилцуулсан болно. Эдгээрээс хамгийн чухал нь Наад захын жишиг стандарт (санал болгож буй) бөгөөд эрүү шүүлт тулгах буюу хүнлэг бус, хэрцгий, хүний ёсноос гадуур эсхүл, нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхийг хориглох ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

Холбогдох олон улсын баримт бичгүүдийг батлах

- Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь ИУТЭОУП, үүний 1-р нэмэлт Протокол, ЭШЭК болон нэмэлт Протокол зэрэг эрүү шүүлттэй холбоотой бүх холбогдох гэрээ конвенцэд нэгдэн орох (гарын үсэг зурах)-ын ач холбогдлыг өөрсдийн засгийн газар (төр засаг)-таа ойлгуулах ёстой.
- Ялангуяа хувь этгээд олон улсын холбогдох байгууллагад хандах (гомдол гаргах) эрхтэй байхын чухлыг ойлгуулах ингэснээрээ улс орнууд ИУТЭОУП-ын 1-р нэмэлт Протоколын оролцогч тал болох мөн ЭШЭК-ийн 22-р зүйлийн хүрээнд мэдэгдэл гаргах эрхтэй болох юм.

Тухайн улсын эрх зүйд олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх нь.

Хүний эрхийн үндэсний байгууллагууд дараах арга хэмжээ авахыг өөрсдийн Засгийн газруудад уриалах хэрэгтэй. Үүнд:

- “Эрүү шүүлт” гэсэн ойлголтыг дотоодын хууль тогтоомжид өргөн хүрээтэй тодорхойлох,

- ❑ Эрүү шүүлт бол онц хүнд гэмт хэрэг болохыг дотоодын хууль тогтоомжид баталгаажуулах,
- ❑ Хүмүүсийг эрүү шүүлтэд өртөх, эсвэл хэрцгий, хүнлэг бус эсвэл нэр төрийг нь доромжлон харьцаж, шийтгэж болох магадлал бүхий орон руу нь буцаахыг хориглох зэргээр “үл буцаах зарчим”-д хууль эрх зүйн ач холбогдол өгөх,
- ❑ Тухайн улсын болон бусад хүмүүсээс үйлдсэн эрүү шүүлтийг хориглосон эрх зүйн үндсийг (extraterritorial) тодорхойлсон хуулийг батлах,

Хэрэгжүүлэлтийн бусад арга хэмжээ

- ❑ Эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, хүний ёсноос гадуур эсхүл нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхийг хориглохтой холбоотой олон улсын үүргийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх нь сонор сэрэмж, дотоодын хууль тогтоомжийг шинэчлэн батлах (шинээр хууль батлах эсвэл нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг нэмэлт арга хэмжээ) түүнчлэн холбогдох олон улсын хэм хэмжээнд даруй нэгдэн орох (батлах)-ыг шаардаж байна.
- ❑ Хүний эрхийн үндэсний байгууллагууд өөрсдийн төр засгаас албан хаагчдын үйлдсэн эрүү шүүлт болон хүний ёсноос гадуур нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэсэн бүх хэргийг бие даасан, хараат бус, шударга шүүхээр шүүлгэх, эрүү шүүлт үйлдсэн эдтээдийг сайтар шийтгэх нөхцлийг хангуулах талаар шаардлага тавих хэрэгтэй. Заавал тайлагнах тогтолцоо болон эрүү шүүлт эсвэл хүнлэг бус харьцсан, нэр төрийг нь доромжилж харьцсан гэсэн сэрдлэг байгаа нөхцөлд “энэ талаар холбогдох газар мэдээлэх” талаар хуульчилж өгөхөд анхаарах хэрэгтэй.
- ❑ НҮБ-ийн Эрүү шүүлтийн асуудлаархи болон бусад холбогдох Тусгай илтгэгч нарыг урьж тайлан, илтгэл тавиулах талаар Хүний эрхийн үндэсний байгууллагууд өөрсдийн Засгийн газартаа уламжлах шаардлагатай байна. Түүнчлэн холбогдох олон улсын гэрээ, конвенцийн шаардлагын дагуу гаргах тайланг тогтмолжуулах явдлыг хангах талаар төр засагтаа анхааруулах хэрэгтэй. Мөн дараа тайлангийн төслийг авч үзэж болно.
- ❑ Мөн холбогдох мониторингийн хороо, Тусгай илтгэгчдийн тайланд тусгагдсан бүх зөвлөмж, дүгнэлтийг хэрэгжүүлэх талаар дорвитой арга хэмжээ авахыг төр засгаас хүсэх шаардлагатай бөгөөд үүнд Хүний эрхийн үндэсний байгууллагууд тэргүүлэх үүрэг рольтой байна.
- ❑ Хүний эрхийн үндэсний байгууллагууд эрүү шүүлт тулгах, хэрцгий эсхүл нэр төрийг нь доромжилж харьцах, шийтгэхийн эсрэг үйл ажиллагаа явуулж буй НҮБ-ийн албан тушаалтнууд болон тусгай төлөөлөгчдийн халдашгүй байдлын асуудлаар бодлогын шинэчлэл хийх ёстой.

Боловсрол, сургалтын талаар

- ❑ Хүний эрхийн үндэсний байгууллагууд нийгмийн бүхий л давхарга (сектор) тухайлбал, хуульчид, сэтгүүлчид, эмч, эмнэлгийн ажилтнууд, багш, цагдаа, цэргийнхэн, ахлах шатны төрийн албан хаагчид, шүүгчид, хууль тогтоогчлод эрүү шүүлт тулгах, буюу хүнлэг бус харьцаж, нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг олон улсын хуулийн учир холбогдол болон

тэдгээрийг хэрэглэх чиглэлээр боловсрол олгоход идэвхи, санаачилгатай оролцох ёстой.

- Хүний эрхийн үндэсний байгууллагууд Ази, номхон далайн бүс нутагт эрүү шүүлт тулгах буюу хүнлэг бүс харьцаж, нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхийг хориглох талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр Хүний эрхийн дээд комиссариатын газартай нягт хамтран ажиллах шаардлагатай. Ялангуяа, Хуульчдын зөвлөлийн гаргасан дүгнэлт (олж тогтоосон нотолгоо)-ийг ХЭДКГ-аас боловсруулсан сургалт семинарын хөтөлбөрт нэгтгэх (нэгдсэн хөтөлбөр) хэрэгтэй байна.

Мөрдөн байцаалтын стандарт

- Хүний эрхийн үндэсний байгууллагууд Хуульчдын зөвлөлийн боловсруулсан Мөрдөн байцаалтын наад захын жишиг стандартыг танилцуулах (сурталчлах) хэрэгтэй бөгөөд мөрдөн байцаалтын явцад хамрагдаж буй бүх албан тушаалтнууд энэхүү стандартын талаар бүрэн дүүрэн мэдээлэлтэй, мөн тэдгээрийг ашиглах талаар заавар зөвлөгөө (сургалтад хамрагдсан) авсан байх нөхцлийг хангах ёстой.
- Мөрдөн байцаалтын наад захын жишиг стандартыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд нэмэлт нөөц шаардагдаж болох юм. Ийм нөхцөлд Хүний эрхийн үндэсний байгууллагууд шаардлагатай санхүүжилтийг хайж олох хэрэгтэй.
- Мөрдөн байцаалтын наад захын жишиг стандартыг тухайн үндэсний эсвэл бусад хэл рүү орчуулж холбогдох бүх албан тушаалтнуудад тараах хэрэгтэй. Түүнчлэн Мөрдөн байцаалтын наад захын жишиг стандартыг хуулийн системийн, ялангуяа, шүүгч болон хуулийн мэргэжилтнүүдэд бүгдэд нь хүртээмжтэй тараах ёстой.

Тайлагнах

- Хүний эрхийн үндэсний байгууллагууд эрүү шүүлт тулгах буюу хэрцгий эсхүл нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхийг хориглох асуудлаар алдаа зөрчил гаргасан (хуулийг хэрэгжүүлээгүй) эрх бүхий албан байгууллагууд, тухайлбал цагдаа, цэрэг, хорих, эмнэлгийн ажилтнууд болон хүмүүжүүлэгчдийн талаар ХЭДКГ-т тогтмол мэдээлж байх хэрэгтэй.
- Хүний эрхийн үндэсний байгууллагууд эрүү шүүлт тулгах буюу хэрцгий эсхүл нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхтэй холбоотой асуудлаар тусгайлан хүлээж авсан өргөдөл гомдлын системчилсэн бүртгэл хийх нөхцлийг хангах хэрэгтэй. Хүний эрхийн үндэсний байгууллагууд парламентэд тайлагнах илтгэлдээ иймэрхүү өргөдөл гомдлын талаарх лавлагааг оруулах шаардлагатай.

Эрүү шүүлтэй тэмцэх бусад (альтернатив) арга хэмжээ

- Холбогдох олон улсын гэрээ, конвенцийн оролцогч бус мөн үүний зэрэгцээ эрүү шүүлт тулгах буюу хэрцгий эсхүл нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхтэй холбоотой тусгайлан хууль тогтоомж байхгүй орнуудад ч гэсэн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, тухайлбал эрүүгийн хуулийг гэмт этгээдүүдийг яллахад хэрэглэх ёстой.

- Эрх бүхий байгууллага нь хангалттай нөөцтэй байх ёстой ингэснээрээ туршилт шинжилгээний арга техник (биеийн болон сэтгэл зүйн хувьд албадлага орохгүй)-ийг ДНА-ийн сорилт зэрэг шинжлэх ухааны туршилт хийхэд ашиглах талаар Хүний эрхийн үндэсний байгууллагууд сурталчлах шаардлагатай.
- Хүний эрхийн үндэсний байгууллагууд хүний нэр төрийг хүндэтгэх явдлыг хангах үүднээс урьдчилан хорих байруудын одоогийн нөхцөл байдал (дэд бүтэц)-ыг сайжруулах чиглэлээр Засгийн газартай хамтарч ажиллах ёстой.
- Түүнчлэн урьдчилан хорих төвүүдийн нөхцөл байдалд мониторинг хийхэд идэвхитэй үүрэг гүйцэтгэх хэрэгтэй.

Сайжруулах

- Хүний эрхийн үндэсний байгууллагууд эрүү шүүлт тулгах буюу хэрсгийг эсхүл нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгүүлсэн хүмүүс (эрүү шүүлтийн золиос бологсад, нэрвэгсэд)-т нөхөн олговор олгох асуудлыг тавих хэрэгтэй.
- Хэргийн талаар шүүхээр шийдвэр гаргуулах эрх зүйн хүчин чадал нь дээр дурьдсан үүргийг гүйцэтгэхэд дэмжлэг болно.
- Хүний эрхийн үндэсний байгууллагууд өөрийн орны бүх зэвсэгт хүчний хэргийн асуудлаар харьяалалтай байх ёстой.

Анхан шатны лавлагаа

- Терроризмтой тэмцэхэд хуулийг дээдлэх хүрээнд Хуульчдын зөвлөлийн боловсруулсан санал, зөвлөмжүүд нь Эрүү шүүлтийн удирдамжид ялангуяа урьдчилан хорих болон мөрдөн байцаалттай холбоотой олон улсын хууль тогтоомж, хэм хэмжээг зөрчиж байгаа терроризмийн эсрэг хуульд мөн адил хамаарна.
- Цаазаар авах ялтай холбоотойгоор Хуульчдын зөвлөлийн гаргасан санал, зөвлөмжүүд нь Эрүү шүүлтийн удирдамжид ялангуяа цаазаар авах ялыг гүйцэтгэх аргатай холбоотой олон улсын хүний эрхийн хязгаарлалтууд, алах ял заагдсан хүмүүсийн хоригдох хугацаа, нөхцлийн хязгаарлалтуудад мөн хамаарах юм.

Мөрдөн байцаалтын наад захын жишиг стандарт

Байцаалт нь аливаа гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдийг эрх бүхий албан тушаалтан асуун шалгаж байгаа процесс юм. Байцаалт нь баривчлагдсан, урьдчилан хорих төвд байгаа этгээд, мөн сайн дураараа ярилцлага өгөхөөр ирэгсэд, эсвэл гэрчийн хувьд эсвэл холбогдох мэдээлэл бүхий этгээд гэхдээ байцаалтын явцад хэрэгт холбоо бүхий этгээд болж сэжиглэгдэхэд мөн адил хамаарна.

1. Улс орнууд байцаалтын өмнө, байцаалтын үеэр эсвэл дараа нь эрүү шүүлт тулгах буюу хэрсгий, хүний ёсноос гадуур эсхүл нэр төрийг нь доромжлон харьцаж, шийтгэх явдал гарахгүй байх нөхцлийг хангах ёстой. Түүнчлэн нэг нь нөгөөгийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг албадаж болохгүй.

2. Байцаалт нь нууц газар явагдах ёсгүй. Хэрвээ байцаахаар хүнийг саатуулсан

(баривчилсан) бол түүний хамаатан садан, мөн түүний сонголтоор гуравдагч хүн боломжтой бол консулын газарт урьдчилан хоригдсон тухай болон байршлын талаар шуурхай мэдээлэх ёстой.

3. Хувь этгээдийг тэдний хувийн шинж чанарыг харгалзан тодорхой (бага) хугацаанд байцаана. Хэрэв хугацааг сунгавал тогтмол завсарлага авах шаардлагатай.

4. Байцаагдаж буй этгээд нь хангалттай хоол хүнс, нойр, солих хувцас, угааж цэвэрлэх боломжоор хангагдах, шаардлагатай бол тэдний нас, хүйс, шашин шүтлэг, эмнэлгийн үйлчилгээ авах хэрэгцээ шаардлага, тахир дутуу болон бусад эмзэг асуудал (байдал)-г харгалзан эмнэлгийн үйлчилгээ авах ёстой.

5. Мэдээлэл өгсөн эсвэл байцаалт өгөхөөс татгалзсантай холбогдуулан хувийн ариун цэвэр, хоол, амралт, нойр зэрэг наад захын хэрэгцээг хангахгүй гэх зэргээр заналхийлж болохгүй.

6. Шийдвэр гаргах, дүн шинжилгээ хийх чадварыг үгүй хийх (бууруулах, муутгах)-үйц тийм арга (мөрдөн байцаалтын) хэрэглэж болохгүй.

7. Байцаалт эхлэхээс өмнө байцаагдагч этгээдэд байцаах болсон шалтгаан болон түүний эсрэг тулгасан хэргийн талаар мэдээлсэн байх ёстой.

8. Баривчлагдах эсвэл урьдчилан саатуулагдах үедээ (аливаа байцаалтын өмнө) тухайн этгээд байцаалт эхлэхээс өмнө нөхцөл байдлын талаар ойлголттой (магадлалтай) байх үүднээс эрх бүхий, шударга эмчийн үзлэгт орох эрхтэй байх ёстой. Эмнэлгийн үзлэг хийсэн цаг хугацаа, дүгнэлтийн талаар протокол хөтлөнө.

9. Байцаалт эх хэл дээр нь явагдаагүй нөхцөлд байцаагдагч этгээд эрх бүхий, шударга орчуулагч авах эрхийг нь түүнд байнга сануулна. Хэрэв байцаалтын явц, асуултын талаар тухайн хүнийн ойлгоцтой холбоотой асуудал гарвал орчуулагчийг тухайн этгээдийн сонгосноор хангаж өгнө.

10. Байцаалт эхлэхээс өмнө байцаагдагч этгээд өөрийн сонгосон хуульчтай хувийн асуудлаар цаг алдалгүй зөвлөлдөх боломжоор хангагдах ёстой. Албан тушаалтнууд байцаагдагч этгээдийн сонгосон хуульчтай холбоо тогтоох үүрэгтэй. Байцаагдагч этгээд хуулийн үйлчилгээг төлөх бололцоогүй тохиолдолд хуулийн зөвлөгөө үнэгүй авна.

11. Байцаагдагч этгээдийн хуульч биечлэн ирэх бөгөөд хуулийн дагуу явж байгаа эсэхийг магадлан нягтлах үүднээс байцаалтын явцад оролцох эрхтэй байна. Байцаагдагч этгээд шаардлагатай бол байцаалтын явцад өөрийн хуульчтай хувийн асуудлаар зөвлөлдөх эрхтэй байна.

12. Хуульч авах боломжгүй эсвэл байцаагдагч этгээд өмгөөлөгч авахыг хүсээгүй тохиолдолд тухайн этгээд төрийн бус байгууллагын төлөөлөгч оролцуулах эсвэл өөрийн сонголтоор хамаатан садан эсвэл найз нөхдөө байлцуулах боломжтой байна.

13. Баривчилсан эсвэл урьдчилан хорьсон цаг хугацаа, байцаалт явуулсан газарт ирсэн хугацааг протоколд тэмдэглэх ёстой.

14. Байцаалт нь оролцож буй бүх хүмүүсийн биеийн байцаалт (үнэмлэх, паспорт г.м.)-ыг үзэж, тэдгээрийн нэр, албан тушаал мөн байцаалт явуулж буй газрын нэрийг бичиж протокол хөтөлснөөр эхлэнэ. Байцаалт эхэлсэн, дууссан цаг мөн завсарлага авсан шалтгаан, үргэлжилсэн хугацааг тэмдэглэнэ.

15. Байцаалтын бүх процесс байцаагдагч этгээдийн нас, хүйст тохирсон түүний зарим онцлог шинж чанар тухайлбал шашин, үндэс угсаа болон эмзэг (онцлог) байдлыг харгалзан явагдах ёстой.

16. Гэмт хэрэгт сэжиглэгдсэн 18 нас хүрээгүй этгээдийг байцаахдаа түүний сонгосон насанд хүрэгсдийг заавал байлцуулна.

17. Ялангуяа оюуны хомсдолтой, сэтгэхүйн өвчтэй, эмгэгтэй болон бусад шинж тэмдэг бүхий этгээдийг байцаахдаа онцгой анхаарал тавих ёстой.

18. Байцаалтын бүх процессын талаар протокол хөтлөх ёстой. Процессын талаар аудио, видео бичлэг хийж болох боловч байцаагдагч этгээд зөвшөөрөөгүй (хүсээгүй), эсвэл боломжгүй тохиолдолд протоколыг дэлгэрэнгүй хөтөлнө.

19. Байцаалтын протоколыг найдвартай байлгах үүднээс хадгалахдаа анхаарах хэрэгтэй. Мөрдөн байцаалтын протокол байхгүй баримт нотолгоог шүүх ажиллагаанд авч үзэхгүй.

20. Байцаалтын протоколыг байцаагдагч этгээд болон түүний сонгосон өмгөөлөгчид танилцуулна. Протоколыг бичгээр үйлдсэн тохиолдолд байцаагдагч этгээд болон түүний өмгөөлөгч түүнийг засах боломжтой байх ёстой.

21. Байцаалтын дараа байцаагдагч этгээд (мэдлэг чадвартай, шударга эмч) эмнэлгийн үзлэг хийлгэх эрхтэй байна.

22. Эдгээр хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд тохирох шийтгэл оногдуулах ёстой.

Б ХЭСЭГ

Лавлагааны явцад тавьсан асуултын хураангуй

(i) Урьдчилан хорих, мөрдөн байцаалт явуулах, эмнэлгийн туршилт хийх, биеэр шийтгэл үзүүлэх, хүйсээр ялгаварлах болон бэлгийн хүчирхийллийн тухайд “эрүү шүүлт” болон бусад хэлбэрийн хүнлэг бус харьцааг олон улсын хүний эрхийн баримт бичгүүд, хэм хэмжээнд хэрхэн тодорхойлж байна вэ? Дээрх дүгнэлтийн хүрээнд мөрдөн байцаалтын наад захын жишиг стандаартыг боловсруулж танилцуулахыг Хуульчдын зөвлөлөөс хүссэн юм.

- Эрүү шүүлтийг олон улсын эрх зүйгээр бүрмөсөн хориглосон. Энэхүү хориглолт нь тухайн улс холбогдох олон улсын гэрээ, конвенцийн оролцогч тал мөн эсэхээс үл хамаарч бүх улсад хүчин төгөлдөр үйлчилнэ.
- Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5-р зүйл, ИУТЭОУП-ын 7-р зүйлд: “Хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хүний ёсноос гадуур эсхүл, нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхийг хориглоно” гэж заасан. Гэхдээ эдгээрийн нөхцлийг сайтар тодорхойлоогүй.
- 1949 оны Женевийн 4 Конвенц болон 1977 оны 2 Нэмэлт протоколоор эрүү шүүлт болон холбогдох бусад практикийг хориглосон. (Женевийн Конвенцийн 3-р зүйлийг үзнэ үү). Эрүү шүүлтийг тодорхойлоогүй байна.

Эрүү шүүлтийг тодорхойлох нь

- Дараах тодорхойлолтуудад эрүү шүүлт тулгах буюу хүний ёсноос гадуур эсхүл, нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэх гэдэгт юуг ойлгох вэ гэдгийг концепцийн хувьд бүрэн дүүрэн гаргаагүй ч цаг хугацааны явцад

өргөн хүрээтэй үйлдлүүдийг агуулсан ойлголт болж өөрчлөгдөх (тодорхойлолт улам нарийн, бүрэн дүүрэн илэрхийлэгдсэн болох) боломжтой юм.

- Эрүү шүүлтийн эсрэг Конвенцийн 1-р зүйлд эрүү шүүлтийг дараах суурь ойлголтуудыг хамруулсан байна. Үүнд:
 - ◆ Бусдын биед санаатайгаар хүнд гэмтэл учруулах эсвэл тарчлаах (зовоох),
 - ◆ Бие, сэтгэлийн хувьд дарамт учруулах, зовоох,
 - ◆ Уг хэрэг төрийн албан хаагч (төрийн өмнөөс эрх мэдэл хэрэгжүүлдэг)-аар үйлдэгдсэн байх,
 - ◆ Мэдээлэл олж авах, хэрэг хүлээлгэх эсвэл шийтгэл оногдуулах эсвэл ялгаварлан үзэх зэрэг зорилго агуулсан байх,
 - ◆ Иймэрхүү бусдад учруулсан гэмтэл, зовиур нь хууль ёсны зөвшөөрөлгүй (төрөлхийн бус, тохиолдлын бус)-гээс үүдэлтэй байх,
 - ◆ Энэ тодорхойлолтод олон улсын заншлын эрх зүйн хүрээн дэх эрүү шүүлтийн тодорхойлолтыг тусгасан байна. (Олон улсын заншлын эрх зүйд төрийн албан хаагчийг оролцуулах шаардлагагүй байна).

Хэргий, хүний ёсноос гадуур эсхүл, нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэх нь

- Прецедентийн хууль (шүүхийн практикаас үзэхэд)-ийн дагуу “хэргий, хүнлэг бус харьцаа” нь наад зах нь хахир хатуу (хүнд ширүүн харьцааны доод түвшин) байх нөхцөлтэй бөгөөд энэ нь хэргийн бүх нөхцөл байдал тухайлбал, хир удаан хугацаанд ингэж харьцсан (үйлдлийн давтамж), үүгээрээ бие, сэтгэлд нь үзүүлсэн нөлөө, зарим тохиолдолд, нас, хүйс, шашин шүтлэг болон хохирогчийн биеийн байдал зэргээс хамаарна. Гэхдээ энэ харьцаа нь зовиур шаналал учруулах зорилго агуулах шаардлагагүй.
- Прецедентийн хуулийн дагуу “доромжилж харьцах” нь хангалттай хатуу ширүүн харьцаа бөгөөд ингэхдээ дээд зэргээр нэр төрийг нь гутаан, доромжлох, ингэснээр хүний өөрийнх нь нэр төр, үнэ цэнийг унагадаг. Харин энэ харьцаа нь зорилго агуулах шаардлагагүй.
- Хэргий, хүнлэг бус харьцаа болон доромжилж харьцах болон эрүү шүүлт хоорондын ялгаа нь зовиур шаналалаас илүү үйлдэгчийн зорилготой холбоотой.

Цагдан хорих

- Тухайн улс холбогдох олон улсын гэрээний оролцогч тал мөн эсэхээс үл хамааран эрүү шүүлт тулгах буюу хүний ёсноос гадуур эсхүл, нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхийг хориглосон олон улсын хууль тогтоомжийн хориглолт нь цагдан хоригдсон бүх хүмүүст хамаатай.
- ИУТЭОУП-ын 7-р зүйлийн заалт нь цагдан хорих нь хууль ёсны эсэхээс үл хамааран цагдан хоригдсон бүх хүмүүст ижил хүчинтэй.
- Түүнчлэн ИУТЭОУП-ын 10 (1)-р заалтад эрх чөлөөгөө хасуулсан бүх хүмүүст нэр төрийг нь хүндэтгэн, хүнлэг харьцах ёстой гэж заасан.
- Цагдан хорихтой холбоотой тусгайлсан шаардлагуудыг НҮБ-ийн “Эмнэлгийн ёс зүй ба эрүү шүүлт”, “Цагдан хоригдож буй хүмүүст баримтлах

зарчим”, “Наад захын жишиг дүрэм” болон Насанд хүрээгүйчүүдийг хамгаалах дүрэм зэрэг баримт бичгүүдэд тусгасан байна. Эдгээр хэм хэмжээг зөрчиж байгаа нь олон улсын эрх зүйн хүрээнд эрүү шүүлтэй холбоотой ерөнхий хориглолтууд болон ИУТЭОУП-ын 7, 10-р зүйл заалтуудыг зөрчиж байна гэсэн үг юм.

- Цагдан хорих тухай үндсэн шаардлагуудыг биелүүлэхгүй байгаа байгууллага нь эрүү шүүлт буюу хэрцгий, хүнлэг бус нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхэд хүргэж болох юм. Түүнчлэн хоригдлын хувийн нөхцөл байдал нь ганцаарчилсан эсвэл тусгайлсан харьцаа шаардаж болно. (Энэ нь хорих байгууллагад хоригдолтой тусгайлан харьцах үүрэг ногдуулж байгаа хэрэг юм)
- Ял шийтгэл хүлээлгэлгүй эсвэл шүүхээр шийтгэлгүй удаан хугацаагаар хорих мөн ИУТЭОУП-ын 14(3)-р зүйл заалтыг зөрчиж байгаа нь эрүү шүүлт буюу хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхэд хүргэж байна. Энэ нь хорих болон хоригдогч этгээдийн нөхцөл байдлаас хамаарна.
- Цагдан хорих хугацаанд дөнгө хэрэглэх (үүнийг хориглосон) нь эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хориглосон олон улсын эрх зүйн заалтууд болон ИУТЭОУП-ын 7, 10(1)-р зүйл заалтуудыг зөрчиж байгаа хэрэг юм.

Хүч хэрэглэх ба аюулгүй байдлын арга хэмжээ

- Хүч хэрэглэх болон аюулгүй байдлын арга хэмжээ нь эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, эсхүл хүний ёсноос гадуур нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхэд хүргэж болох юм.
- Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрэм (НҮБ) болон Хүч хэрэглэх үндсэн зарчмуудад хүч хэрэглэх болон аюулгүйн арга хэмжээ авах талаар тусгайлсан заалтууд бий.
- Хууль сахиулах байгууллагын болон хорихын ажилтнууд зөвхөн онцгой шаардлагатай үед болон ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тэр л хэмжээнд хүч хэрэглэж болно.
- Цагдан хорих төвд үйлдэгдсэн гэмт хэрэг эсвэл хууль ёсны баривчилгааг гүйцэтгэх зэрэг гэмт хэргээс хамгаалах зайлшгүй шаардлагатай нөхцөлд хүч хэрэглэнэ. Үүнээс бусад тохиолдолд тухайлбал зорилгодоо хүрэх үүднээс тэнцвэртэй хэмжээнд хүч хэрэглэж болно.

Эмнэлгийн эмчилгээ, тусгай хэрэгсэл

- ЭЗНСЭОУП-ын 12-р зүйлд эмнэлгийн эмчилгээ, нэмэлт үйлчилгээ хийхээс татгалзвал энэ нь эрүүдэн шүүлт тулгах буюу хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхэд хүргэж болно гэж заасан.
- Үг Пактын 12-р зүйлд зааснаар хүн бүхэн бие, сэтгэлийн хувьд эрүүл байх эрхтэй байна.
- Цагдан хоригдож буй бүх хүмүүс өөрсдийн хүсэлтээрээ эмнэлгийн болон шүдний зохих эмчилгээ үнэ төлбөргүй хийлгэх ёстой бөгөөд эдгээр эмчилгээ нь тэдэнд тохирсон байх ёстой.

- Шаардлагатай бол, хоригдогсдыг эмнэлэг зэрэг эрүүл мэндийн мэргэжлийн байгууллага руу шилжүүлэх ёстой.
- Сэтгэхүйн өвчтэй хүмүүст зориулсан эмнэлгийн газрын үйл ажиллагаатай холбоотой практик стандартуудыг мөн боловсруулаад байна. (Жнь: Сэтгэцийн өвчтэй хүмүүсийн эрхийг хамгаалах ДЭМБ-ын журам)

Байцаалт

- Байцаалтын өмнө, байцаалтын үеэр мөн дараа нь хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэрцгий эсхүл хүний ёсноос гадуур нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэж үл болно.
- НҮБ-ийн Эмнэлгийн ёс зүй ба эрүү шүүлтийн зарчимд мөрдөн байцаалтын ажиллагаанд туслах өөрөөр хэлбэл байцаагдагч этгээдийн бие, сэтгэлийн эрүүл мэнд болон нөхцөл байдалд эсрэгээр нөлөөлөхүйц байдлаар эмнэлгийн ажилтнууд өөрсдийн мэдлэг чадвараа ашиглахыг хориглосон.
- Хуульчдын зөвлөлөөс мөрдөн байцаалтын наад захын жишиг стандартыг боловсруулсан. (Дээр дурьдсан хэм хэмжээг үзнэ үү)

Эмнэлгийн болон шинжлэх ухааны туршилт

- ИУТЭОУП-ын 7-р зүйлд тухайн хүнтэй өөртэй нь зөвшилцөлгүйгээр түүн дээр эмнэлгийн болон шинжлэх ухааны туршилт хийх нь эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг доромжлон харьцаж шийтгэж байгаа хэрэг гэж үзсэн байна.
- Олон улсын эрх зүйд нилээд өөрчлөлт (хөгжсөн) орсноор ямар ч зөвшилцлийн талаар бүрэн дүүрэн мэдээлэлсэн байх ёстой.

Хүйсийн үндсэн дээр хүчирхийлэх

- Хүйсийн үндсэн дээр хүчирхийлэх, хүйсийн ялгавартай хүчирхийллийн дор эрүүдэн шүүх буюу зүй бусаар харьцах, шийтгэх энэ хоёр ойлголт давхцаж байна.
- Хүйсийн үндсэн дээр үйлдэгдэж буй хүчирхийлэл (гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл болон мөлжлөг) нь эрүү шүүлт (зүй бусаар харьцах, шийтгэх)-ийг бий болгодог. Үүнтэй ижил эмэгтэй хүний нөхөн үржихүй (бэлэг эрхтэн) эрэмдэг болгох зэрэг нь мөн л эрүү шүүлтийг бий болгож байна.
- ЭАБХУК-ийн 2-р зүйлд эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхахыг зэмлэн буруушаасан (яллах). ЭЯГБХУстгах асуудлаарх хорооны Ерөнхий санамжийн 19-т: “Эмэгтэйчүүдийн хүний эрх, суурь эрх чөлөөг хаан боогдуулж буй хүйсийн хүчирхийлэл (эрүү шүүлт тулгуулах буюу хэрцгий, хүнлэг бус харьцаж, шийтгэхүүлэхгүй байх эрх) нь ЭАБХУК-ийн 1-р зүйлд заасан ялгаварлан гадуурхах тухай тодорхойлолт (нэр томьёо буюу Конвенцийн тодорхойлолт)-ын хүрээнд ялгаварлан гадуурхаж байгаа хэрэг мөн” гэж дурьдсан байна.
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүч хэрэглэхийг устгах тухай Тунхаглалдаа Ерөнхий Ассемблей нийгмийн ч, хувийн ч амьдралд ялгаагүй эмэгтэйчүүдэд бие махбодын, сэтгэл зүйн болон бэлгийн дарамт учруулах, зовоох эсвэл

иймэрхүү үйлдлээр айлган сүрдүүлэх, албадах эсвэл эрх чөлөөгийг нь боогдуулах (хасах) зэргээр илэрсэн эсвэл илэрч магадгүй хүйсийн аливаа хүчирхийллийг зэмлэн буруушаасан.

- Нийгмийн бусад хэсгийн эсрэг чиглэсэн тухайлбал, арьсны өнгө, нас, тахир дутуу байдал, бэлгийн чиг хандлага (ориентац), үндэс угсаа эсвэл шашин шүтлэгийн үндсэн дээр үйлдэгдсэн аливаа хүчирхийлэлд мөн ижил зарчим үйлчилнэ.

Гэсгээлт (Бие мах бодын шийтгэл)

- ХЭХ-ийн 19-р зүйлд хүүхдийг гэсгээн цээрлүүлэхийг бүх нийтээр хориглосон.
- Олон улсын эрх зүйгээр насанд хүрэгчдэд бие мах бодын шийтгэл үзүүлэх нь эрүү шүүлт үүсгэж байгаа учир мөн нийтээр хориглосон байна. (ХЭХ-ны Ерөнхий санамж – 20-д дурьдсан жишээг үзнэ үү)
- Дотоодын хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөгдсөн эсэхээс үл хамааран бие мах бодын шийтгэл үзүүлэх шүүхийн ял шийтгэл нь эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, эсхүл нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хориглосон заалтыг зөрчиж байгаа хэрэг болно.
- Эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, эсхүл нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх нь цаазаар авах ялын үе шатууд тухайлбал, ялыг гүйцэтгэх арга, цаазын өмнөх байранд байрлах хугацаа, нөхцөл болон процессын шаардлагыг хангаагүй зэрэгт илэрч болно.
- Түүнчлэн цаазаар авах ялыг гүйцэтгэх нь (per se) өөрөө эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, эсхүл нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хориглосон заалтыг зөрчиж байна гэсэн зарим нэг санал ч байна.

(ii) Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хүнлэг бус харьцааг олон улсын заншлын хуулиар хориглосон нь олон улсын, бүс нутгийн болон үндэсний шүүхийн шийдвэр, зарим эрдэмтдийн дүгнэлт болон Хүний эрхийн хороо, Эрүү шүүлтийн эсрэг хороо зэрэг олон улсын байгууллагуудын мэдэгдэлд мөн тусгагдсан байна.

- Эрүү шүүлт тулгах буюу хэрцгий эсхүл хүний ёсноос гадуур нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хориглосон нь олон улсын заншлын эрх зүйн журам юм.
- Эрүү шүүлтийг хориглосон нь эрүү шүүлтийг хориглох явдлыг дээдлэн мөрдөх норм (jus cogens) мөн. Жишээ нь: ХЭХ-ны Ерөнхий санамж – 24, Фурунджийн Прокурор г.м. үзнэ үү.
- Олон улсын заншлын эрх зүй нь улсуудын ерөнхий практикаас үүдэлтэй. Бүх улсууд тодорхой замаар үйл ажиллагаагаа нэгдэн явуулахдаа энэ нь хуульд заасан шаардлагын дагуу явж байна гэсэн ерөнхий ойлголт чиг хандлагыг удирдлага болгодог бөгөөд энэ нь олон улсын заншлын эрх зүйн суурь болдог.
- Олон улсын ерөнхий хуулийг дээдлэх хэм хэмжээг олон улсын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий бүхэл бүтэн цогц хэм хэмжээ хэмээн үзэж, түүнийг ямар нэг байдлаар дордуулж болохгүй бөгөөд энэ нь зөвхөн ижил

агуулгатай өөр олон улсын хуулийн хөгжингүй дэвшилтэт хэм хэмжээн дүндэслэж өөрчлөх боломжтой юм. (гэрээний тухай Венийн Конвенцийн 53-р зүйл)

- Олон улсын заншлын хэм хэмжээ болон дээдлэн мөрдөх нормыг тухайн улс олон улсын гэрээ (ИУТЭОУП, ЭШЭК г.м.)-нд нэгдэн орсон эсэхээс үл хамааран бүх улсууд хүндэтгэх ёстой.

(iii) Эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, эсхүл нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хориглосон нь зарим нөхцөлд зөрчигддөг эсэх

- Эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, эсхүл нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хориглосон нь ямар ч нөхцөлд зөрчигдөх ёсгүй.
- Энэ нь эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, эсхүл нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг дайны үед ч, терроризмтой тэмцэхэд болон ямар ч онцгой нөхцөл байдалд бүрмөсөн хориглосон гэсэн үг юм. Бүр дотоодын хууль тогтоомжоор эрх олгогдсон эсвэл төрийн тэргүүний зарлиг гарсан ч гэсэн эрүү шүүлтийг бүрмөсөн хориглосон байна.
- Олон улсын эрх зүйн зарчмын дагуу эрүү шүүлт тулгасан буюу хэрцгий, эсхүл нэр төрийг доромжлон харьцаж шийтгэсэн этгээдийг ял шийтгэлгүй үлдээж болохгүй. Энэ нь эрүү шүүлт үйлдэгсдэд эрүүгийн хариуцлага ногдуулах хэрэгтэй гэсэн үг юм.
- Шинэ дэглэмийг бий болсон нь эрүү шүүлтийн үйлдлийг ялах талаар улсын хариуцлагыг үгүйсгэнэ (ямар ч нөхцөл байдалд хариуцлага тооцох) гэсэн үг биш.

(iv) Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хүнлэг бус харьцаанаас хамгаалахад чиглэгдсэн хүний эрхийн олон улсын эрх зүйгээр тогтоосон процедурын баталгаа болон бусад төрлийн хамгаалалтын мөн чанар, хүрээ

- Процедурын баталгаа болон бусад төрлийн хамгаалалтыг тогтоодог гэрээнд үндэслэсэн төрөл бүрийн шаардлага болон бусад хэм хэмжээ байдаг бөгөөд эдгээр нь эрүү шүүлт болон бусад төрлийн хүнлэг бус харьцаанаас хамгаалах (цагдан хоригдсон, байцаагдаж буй этгээдийг хамгаалалт, мониторинг болон сургалтын шаардлага)-д туслах зорилготой байна.

Цагдан хорих

- Цагдан хорих тухайд ИУТЭОУП-ын 7,9,10-р зүйл мөн Наад захын жишиг дүрэм, Цогц зарчмууд зэрэг бусад хэм хэмжээ хамаарна. Эдгээр нь аливаа этгээдийг цагдан хорьсон тохиолдолд дараахь процедурын хамгаалалтын арга хэмжээ авахыг санал болгож байна. Үүнд:
 - ◆ Цагдан хоригдсон этгээдийн төрөл төрөгсөд эсвэл түүний сонгосон гуравдагч этгээд мөн цагдан хоригдсон гадаадын этгээдийн орны Консулын газарт баривчилгаа болон цагдан хоригдсон газрын талаар цаг тухайд нь мэдэгдэнэ.
 - ◆ Нууц цагдан хорих байрыг хуулийн дагуу татан буулгах ёстой.
 - ◆ Цагдан хоригдсон бүх этгээд тэдгээрийг хорьсон нь хууль ёсны эсэх талаар маргалдах боломжтой байх ёстой.

- ◆ Цагдан хоригдохын өмнө хүн бүр эмнэлгийн үзлэгээр орох эрхтэй байна.
- ◆ Цагдан хоригдсон даруйдаа өөрийн сонголтоор өмгөөлөгч шуурхай авах боломжтой байх ёстой.
- ◆ Цагдан хоригдсон этгээдэд дээр дурьдсан бүх асуудлуудын талаар өөрийн ойлгодог хэл дээр мэдээлэл авах эрхтэй болохыг мэдэгдэх ёстой.
- ◆ ЭШЭК-ийн 11-р зүйлд заасны дагуу оролцогч улсууд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор түүний харьяа нутаг дэвсгэрт аливаа хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон хүмүүсийг байцаахтай холбогдсон журам, заавар, арга хэрэгсэл, түүнчлэн тэднийг хянан харгалзах, тэдэнтэй харьцах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд шат дараалсан хяналт тавина.
- ◆ Хуульчдын зөвлөлийн боловсруулсан байцаалтын наад захын жишиг стандартуудыг асууж шалгах явцад чанд мөрдөх ёстой.

Мониторингийн шаардлагууд

- Хараат бус бие даасан мониторингийн байгууллагууд хорих төвүүдийг урьдчилж мэдэгдэлгүйгээр, тогтмол шалгаж байх нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг рольтой юм.
- Мониторинг хийх эрх бүхий байгууллага нь мэргэжлийн мониторингийн үйл ажиллагаа явуулах бүхий л эрх мэдэл тухайлбал, холбогдох бүх мэдээллийг авах, хувийн асуудлаар ярилцлага авах (ганцаарчилж уулзах эрх) болон хорих төвийн байр өрөөгөөр чөлөөтэй нэвтрэх эрхтэй байх ёстой.
- Мониторинг нь тухайн этгээд эрх чөлөөгөө хасуулсан бүхий л газрууд тухайлбал, цагдаагийн хэсэг, шорон, захиргааны саатуулах төв, цэргийн цагдан хорих төв, насанд хүрээгүйчүүдийг цагдан хорих байр болон сэтгэцийн эмнэлэг зэрэг нийгмийн халамжийн байгууллагуудыг хамруулах ёстой. Мониторингийн баг нь хуульч, эмнэлгийн ажилтнууд зэрэг янз бүрийн мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн байна.
- Мониторинг хийхдээ хоригдлуудтай харьцах болон хамгаалалтын арга хэмжээ, материалын нөхцөл, дэг журам ба үйл ажиллагаа, эмнэлгийн үйлчилгээ, хорихын бие бүрэлдэхүүн болон цагдаагийн хорих төвүүдэд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.
- ЭШЭК-ын Нэмэлт Протоколын дагуу олон улсын болон үндэсний бие даасан, хараат бус шинжээч байгууллагууд цагдан хорих төвүүдийг тогтмол шалгаж байх системийг бий болгох юм.
- Үндэсний түвшинд оролцогч улсууд өөрсдийн урьдчилан сэргийлэх байгууллагыг байгуулна. Үүнд хүний эрхийн үндэсний байгууллагууд мөн орох ёстой. Олон улсын түвшинд холбогдох байгууллага нь ЭШЭХ-ны дэд хороо бөгөөд эдгээр нь хүний эрхийн үндэсний байгууллагуудад зөвлөгөө өгөх эрхтэй байдаг.

Сургалт

- ЭШЭК-ийн 10(1) болон 16(1)-р зүйлд заасны дагуу оролцогч улс бүр хууль сахиулах байгууллагын ажилтнууд, иргэний болон цэргийн эмнэлгийн ажилтнууд, төрийн албан хаагчид болон саатуулах, байцаалт явуулах түүнчлэн цагдан хоригдогсодтой харьцаж буй бүх хүмүүст эрүү шүүлт тулгах буюу хэрцгийг эсхүл нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхийг хориглох талаар сургалт, мэдээллээр хангах үүрэгтэй.
- Төрөөс холбогдох байгууллагуудыг сургалтанд оролцуулж байгаа нь эрүү шүүлт тулгах буюу хэрцгийг, эсхүл нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх талаар олон улсын өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна гэсэн үг юм.
- Ялангуяа эмнэлгийн ажилтнууд эрүү шүүлт тулгах буюу хэрцгийг, эсхүл нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэх асуудлаар гомдол гаргасан этгээдэд үзлэг хийхдээ зохих түвшинд сургалтанд хамрагдсан байх ёстой. Иймэрхүү хүмүүст үзлэг хийхдээ ашиглаж болохуйц жишиг маягтыг Фижигийн Хүний эрхийн үндэсний байгууллага Эрүү шүүлтийн эсрэг эмч нартай хамтран боловсруулсан нь сургалтын ач холбогдолтой болсон байна. (Хавсралт 4-ийг үз).

(v) Олон улсын хүний эрхийн хууль тогтоомж болон хэм хэмжээгээр тогтоосон хамгаалалтын арга хэрэгсэл нь эрүү шүүлт болон зүй бус харьцааны үр дүнд авагдсан аливаа мэдүүлгийг шүүн таслах ажиллагаанд нотлох баримт болгон ашиглахгүй байх явдлыг хангах нь

- Эрүү шүүлтийг бүрмөсөн хориглосон нь эрүү шүүлтийн үр дүнд бий болсон аливаа мэдүүлгийг аль ч шүүн таслах ажиллагаанд нотлох баримт болгон ашиглахгүй гэдэг нь ойлгомжтой. Нөхцөл байдлаас шалтгаалан энэхүү зарчим нь нь эрүү шүүлт болон зүй буй харьцааны үр дүнд тогтоогдсон аливаа мэдүүлэгт мөн адил үйлчилж болно.
- ЭШЭК-ийн 15-р зүйлд: “Эрүүдэн шүүх замаар гаргуулсан болох нь тогтоодсон аливаа мэдүүлгийг шүүн таслах ажиллагаанд нотлох баримт бологон ашиглахгүй байх явдлыг хангана” гэж заасан.
- ИУТЭОУП-ын 14(3)(г)-д өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх эсвэл бурууг хүлээлгэхийг хориглоно гэж заасан.
- ХЭХ-ны (Жнь: Шри Ланкийн Сингарасагийн хэрэг) болон ЭШЭХ-ны (Францын П.И.-ийн хэрэг) эрх мэдэл нь эрүү шүүлт гарсан нөхцөлд дарамт шахалтгүйгээр хэргээ хүлээсэн гэдгийг батлах хариуцлага ногдуулж байна.

(vi) Засан хүмүүжүүлэх арга хэмжээ (исправительные меры) нь өргөдөл гомдол барагдуулах, нөхөн олговор олгох болон эрүүл мэндийг нь нөхөн сэргээх замаар эрүү шүүлт болон бусад хэлбэрийн зүй бус харьцааны золиос бологдсод хүртээмжтэй байх

- Олон улсын хуулиар олон улсын гэмт хэргийн хохирогдогсод нөхөн олговор авах эрхтэй байдаг. Нөхөн олговор нь хууль бус үйл ажиллагааны бүхий л үр дагаврыг аль болох бүрэн арилгах мөн иймэрхүү үйлдэл болоогүй тохиолдолд нөхцөл байдлыг дахин тогтооход чиглэгдэх ёстой. (Чорзоу Факторын хэрэг – Арбитрын шүүх, 1928).

- ИУТЭОУП-ын 2(3)-р зүйл нь оролцогч улсуудаас эрх нь зөрчигдсөн этгээдийн хувьд үр нөлөөтэй засан сайжруулах арга хэмжээ авах явдлыг хангахыг шаардаж байна.
- ЭШЭК-ийн 12-р зүйлд эрүү шүүлт үйлдэгдсэн гэж үзэх хангалттай үндэслэл байвал холбогдох эрх бүхий байгууллага өөрсдийн эрх мэдлийн хүрээнд шуурхай, шударга мөрдөн байцаалт явуулах бөгөөд үүнийг оролцогч улс бүр хангаж ажиллах ёстой. (Истанбулын зарчим - 11).
- ЭШЭК-ийн 13-р зүйлд зааснаар эрүү шүүлтийн золиос болсон этгээд нь энэ талаар холбогдох байгууллагад гомдол гаргаж, шуурхай, шударгаар шалгуулах эрхтэй байна. Гомдол гаргасан этгээд болон гэрчүүдийг гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй нь холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах талаар шат дараалсан арга хэмжээ авах хэрэгтэй.
- ЭШЭК-ийн 14-р зүйлд зааснаар эрүү шүүлтийн золиос бологсдод үр нөлөөтэй засан сайжруулах арга хэмжээ авах тухайлбал, хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах явдлыг улс орнууд хангах ёстой.
- НҮБ-ийн Хүний эрхийн комисс саяхан “Олон улсын хүний эрхийн болон хүмүүнлэгийн хууль зөрчсөнөөс хохирогсдод засан сайжруулах мөн нөхөн олговор авах эрхийн талаарх удирдамж, үндсэн зарчмууд”-ыг баталсан байна. 11-р Зарчмын дагуу олон улсын хүний эрхийн зөрчлийг сайжруулах арга хэмжээнд эрх тэгш, шударга шүүхээр шүүлгэх боломж, учруулсан хохирлыг хангалттай, үр нөлөөтэй, шуурхай барагдуулах, зөрчил болон нөхөн олговрын механизмын талаар холбогдох мэдээлэлтэй байх зэрэг орно.
- Үндсэн зарчмуудын 9-р хэсгийн хүрээнд нөхөн олговрын 4 ерөнхий хэлбэрийг тодорхойлсон байна. Үүнд: буцааж тавих (зөрчил гарахаас өмнө хохирогчийн эрхэлж байсан албан тушаалыг нөхөн сэргээх); нөхөн олговор (зөрчлөөс үүдэлтэй эдийн засгийн хохирлыг мөнгөөр нөхөн төлөх); нөхөн сэргээх (шаардлагатай эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж болон холбогдох нийгмийн үйлчилгээ); болон сэтгэл ханамж болон дахин давтагдахгүй байх баталгаа (зөрчил болон хариуцагчид хүлээлгэсэн эрүүгийн ба захиргааны сангийн талаар олон нийтэд мэдээлэх).
- Олон улсын хүрээн дэх засан сайжруулах арга хэмжээнээс чухал нь хувь этгээд олон улсын байгууллагад хандаж гомдол гаргах механизм юм. ЭШЭК-ийн 21-р зүйл болон ИУТЭОУП-ын 1-р Нэмэлт протоколоор зарим үр нөлөө бүхий арга хэмжээг хангадаг.
- Тухайн улс орон холбогдох гэрээнд нэгдэн орсон эсэхээс үл хамааран хувь этгээд (тухайн улс зөвшөөрсөн эсэх болон засан сайжруулах арга хэмжээ авагдсан эсэхээс үл хамааран) НҮБ-ийн Эрүү шүүлтийн талаарх Тусгай илтгэгчид хандаж тусалцаа авч болно

(vii) Тухайн хүмүүсийг эрүү шүүлт болон хүнлэг бус харьцааны золиос болж болох орон руу нь хүчээр буцаахаас хамгаалах нь

- Аливаа этгээдийг хавчлага мөрдлөгөөс айх хангалттай үндэслэл байгаа орон руу нь хүчээр буцаах (“үл буцаах зарчим”)-ыг олон улсын хуулиар хориглосон.
- Тухайн байгаа орныхоо аюулгүй байдалд хохирол учруулахуйц эсвэл хүнд ноцтой гэмт хэрэг үйлдсэн нь тухайн оронд аюул занал учруулж байгаа хүний хувьд жич зүйл байж болно. Энэ нь Дүрвэгсдийн статустай холбоотой 1951 оны Конвенц болон 1967 оны Протоколд тусгагдсан байна.
- Үл буцаах зарчим нь эрүү шүүлт тулгах буюу хэргий эсхүл нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэсэн тохиолдолд мөн адил үйлчилнэ.
- Олон улсын хуулиар тухайн улсаас хүнийг хөөж гаргах, буцаах, дүрвэн гарсан гэмт этгээдийг эгүүлэн шилжүүлэх зэргээр эрүү шүүлт тулгуулж болох аюул бодитой байгаа нөхцөлд эх орон руу нь буцаахыг хориглодог. Энэ бол бүрмөсөн хориглосон зүйл. Түүнчлэн заншлын эрх зүйгээр болон ЭШЭК-ийн 3-р зүйлд заасан шаардлагын дагуу хүлээсэн үүрэг байна.
- Дээр дурьдсан “хангалттай үндэслэл”-ийг гаргахын тулд эрүү шүүлт гарах эрсдэл болон цөллөгийн талаарх мэдэгдэхүйц үр дагаврын эрсдлийг тооцох шаардлагатай.
- Шийдвэр гаргагч тухайн этгээдийг хөөж гаргах, буцаах, дүрвэн гарсан гэмт этгээдийг эгүүлэн шилжүүлэх эсэхээ шийдэхдээ эрүү шүүлтийн аюулын түвшинд анхаарал хандуулах шаардлагатай.
- Үл буцаах зарчмыг төрийн албан хаагч бус хүнээс эрүү шүүлтийн аюул гарч буй үед мөн хэрэглэнэ. Энэ нь шүүхийн шийдвэрээр баталгаажсан байх ёстой.
- Дипломат амлалт нь тухайн хүн буцаж ирсэнээр эрүү шүүлтэд орохгүй гэж буцаасан орны Засгийн газрын албан ёсны баталгаа бөгөөд үл буцаах зарчмын дагуу үүнийг мөн хориглосон.
- Энэхүү хориглолтыг нэг улсаас нөгөө улсад хүн дамжуулах практикт мөн хэрэглэдэг.

(viii) Дотоодын болон олон улсын мөргөлдөөний үед дэх эрүү шүүлт болон бусад төрлийн зүй бус харьцааны талаарх олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомж

- Олон улсын хүмүүнлэгийн хуулийг цэргийн мөргөлдөөний үед хэрэглэдэг. Энд олон улсын болон олон улсын бус цэргийн мөргөлдөөний үеэр хүмүүсийг хамгаалах асуудал орно.
- Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйтэй холбоотой дараахь олон улсын суурь арга хэрэгслүүд байна. Үүнд:
 - ◆ 1899 оны Гаагийн Конвенц
 - ◆ 1907 оны Гаагийн Конвенц
 - ◆ 1949 оны Женевийн 4 Конвенц
 - ◆ 1977 оны Женевийн 4 Конвенцийн 2 Нэмэлт Протоколууд зэрэг болно.
- Эдгээр баримт бичгүүдэд олон улсын болон олон улсын бус цэргийн мөргөлдөөнд эрүү шүүлт, бусад хэлбэрийн зүй бус харьцааг хориглосон.

- Эдгээр хориглолт нь олон улсын заншлын хэм хэмжээний нэг хэсэг бөгөөд үл зөрчигдөх, энхийн болон дайны цагт мөн хүчинтэй байна.
- Аливаа зөрчил нь хувь этгээдийн эрүүгийн хариуцлагыг гаргаж тавьж байгаа бөгөөд энэ нь хуулийн дэлхий нийтийн түгээмэл зарчим юм. Үүний дагуу улс орон бүр гэмт этгээдүүдийг хаа ч байсан, хэнийг ч хариуцлагад татдаг.
 - Хувь этгээдийн хувьд эрүүгийн хариуцлага нь төрөл бүрийн олон улсын эрүүгийн шүүх байгуулсанаар цаашдаа улам тодорхой болох юм. Ялангуяа, 1998 онд Олон улсын эрүүгийн шүүхийг байгуулсан Ромын дүрмээр эрүү шүүлт нь геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон цэргийн гэмт хэрэг зэрэг олон улсын гэмт хэргийн нэг бүрэлдэхүүн хэсэг гэж үзжээ. Зарчмын хувьд Олон улсын эрүүгийн шүүх нь тухайн үндэсний эрх бүхий байгууллага үйл ажиллагаа явуулах боломжгүй эсвэл ингэх хүсэл эрмэлзэлгүй тохиолдолд ажиллагаа явуулах эрхтэй.
 - Олон улсын хүмүүлэгийн эрх зүйн хүрээнд эрүү шүүлтийн процесст тухайн улсын төрийн албан тушаалтныг оролцуулах шаардлагагүй.

(ix) Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн зүй бус харьцааг авч үзэж буй үндэсний болон олон улсын цэргийн шүүхийн эрх мэдэл

- ЭШЭК-ийн хүрээнд улс орон бүр эрүү шүүлт тулгах буюу хэргий эсхүл нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхийг дотоодын хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэж орон нутгийн (тухайн орны) цэргийн шүүхэд шилжүүлэх үүрэгтэй.
- Улс орны хувьд өөрсдийн хуулиа 2 үндэслэлээр хэрэглэнэ. Үүнд: хэрэгтний яс үндэс, эрүүгийн хэрэг тухайн улсын газар нутагт үйлдэгдсэн байх бөгөөд үүнийг газар нутгийн болон үндэстний зарчим гэж нэрлэсэн. Улс орнууд өөрсдийн эрх мэдлийн хүрээнд газар нутгаас халин хууль тогтоомжоо хэрэглэхээс зайлсхийдэг.
- Үүнээс гадна олон улсын хууль тогтоомжоор зарим гэмт хэрэг тухайлбал, дээрэм тонүүл, боолын худалдаа болон геноцидтой холбоотой хэргүүдийг шүүх эрх мэдлийг улс орнуудад олгосон. Эрүү шүүлтийг шүүн таслах ажиллагаа дэлхий нийтийн шинжтэй болж буй учир тухайн эрүүгийн гэмт хэрэг хаана үйлдэгдсэн, тухайн үндэстний бус хүн үйлдэгдсэн эсэхээс үл хамааран ямар ч улс өөрийн шүүхээр яллаж болно.
- Женевийн 4 Конвенц болон тэдгээрийн Нэмэлт Протоколуудад дурьдсан олон улсын хүмүүлэгийн хууль тогтоомжийн хүрээнд эрүү шүүлтээс өөр бусад хэлбэрээр зүй бус харьцаж шийтгэсэн тухайд олон улсын заншлын хэм хэмжээгээр дэлхий нийтийн шүүн таслах ажиллагаа явуулахгүй.
- Шүүн таслах үйл ажиллагаа заншлын хэм хэмжээнд байдаг учраас эрүү шүүлтийг шүүн таслах ажиллагаанд тухайн гэм хэрэгт сэжиглэгдэгч этгээдийн улс ЭШЭК-нд нэгдэн орсон эсэхээс үл хамаарна.
- ЭШЭК нь дээр дурьдсан үндэстний болон газар нутгийн зарчмаас гадна гэм хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийг өөр улсад шүүн таслах ажиллагаа явуулахаар гаргаагүй, тухайн улсад байгаа тохиолдолд харьяалал тогтоохыг улс орнуудаас шаардаж байна.

- Олон улсын шүүх нь Конгын бүгд найрамдах улс ба Бельгийн хэрэгт түгээмэл харьяалалыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ улс орнууд үндэстний болон газар нутгийн зарчмаар шүүн таслахыг илүүд үзэн практикт буй болсон түгээмэл хандлагыг баримжаалах нь ховор байна гэж тэмдэглэсэн. Мөн заншлын хэм хэмжээгээр шүүн таслах ажиллагаа явуулахыг улс орнуудаас шаарддаггүй гэж Шүүх үзсэн байна. Товчоор хэлэхэд хэргийн түгээмэл хаьяалалыг хүлээн зөвшөөрч болох боловч заавал хэрэгжүүлэх шаардлагагүй.
- Олон улсын шүүх Конгын бүгд найрамдах улс ба Бельгийн хэрэгт сайд нь албан үүргээ гүйцэтгэж байхдаа эрүү шүүлтийн гэмт хэрэгт сэжиглэгдсэн ч гэсэн шүүн шийдвэрлэх эрх мэдлээс чөлөөтэй байж, халдашгүй байх эрхийг хүлээн зөвшөөрсөн. Энэ шийдвэр маш их шүүмжлэлд өртсөн бөгөөд төрийн тэргүүний болон кабинетийн гишүүдийн халдашгүй байх эрхтэй холбоотой асуудал маргаантай хэвээр байна.
- Ирээдүйд эрүү шүүлтийг хэзээ ч албан ёсны үйлдэл гэж үзэхгүй байж болох юм. Тийм болохоор халдашгүй эрхээр хамгаалуулахгүй.
- ЭШЭК-оор эрүү шүүлт тулгах буюу хэрцгий эсхүл хүний ёсноос гадуур нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэх хэргийг шүүн таслах үүргийг оролцогч улсуудад гэрээгээр ногдуулсан.
- Олон улсын гэмт хэргийг шүүх үндэсний цэргийн шүүхийн харьяалалд хуучин Югослав болон Руандагийн цэргийн тусгай шүүх мөн Сьера Леоны олон улсын шүүх зэрэг олон улсын шүүх орно.
- 99 орон Ромын дүрмийг баталж хэргийн түгээмэл харьяаллыг Олон улсын эрүүгийн шүүхэд “шилжүүлсэн” бөгөөд тухайн улс орон эрүү шүүлт, хүн төрөлхтний эсрэг чиглэсэн гэмт хэрэг болон дайны гэмт хэргийг өөрийн шүүхээр шүүн таслахгүй гэж шийдсэн тохиолдолд Олон улсын эрүүгийн шүүх дээрх хэргийг шүүн таслах юм.
- Тухайн улс орон ИУТЭОУП болон ЭШЭК-ийн оролцогч тал байсан ч мониторинг хийх нэмэлт эрхийг ХЭХ болон Эрүү шүүлтийн эсрэг хороо мөн хэрэгжүүлж болно.
- Улс орнуудаас өргөдөл гомдол хүлээн авах эрх мэдлээс гадна эдгээр байгууллагууд тухайн өргөдөл гаргагчийн эх орон нь Нэмэлт Протокол болон ЭШЭК-ийн 21-р зүйлийн тунхаглалыг хүлээн зөвшөөрсөн бол хувь хүмүүсийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэнэ.
- ЭШЭК нь өөрийн санаачилгаар мөн байцаалт явуулж болно
- Эрүү шүүлтийн асуудлаарх НҮБ-ийн Тусгай илтгэгч нь ЭШЭК-ийн оролцогч тал бус орнуудад ч гэсэн гарсан зөрчлийн талаар мөн мониторинг хийх эрхтэй.

(х) Олон улсын энхийг сахиулах хүчний үйлдсэн эрүү шүүлт болон бусад хэлбэрийн зүй бус харьцсан хэргийг үндэсний болон олон улсын цэргийн шүүхээр шүүн таслах нь

- “Олон улсын энхийг сахиулах хүчин” гэсэн концепт (ойлголт)-ийн талаар олон улсын эрх зүйд ямар нэг албан ёсны хуулийн ойлголт байхгүй ч дараахь төрлийн цэргийн хүчний оролцоог ойлгож болно Үүнд:

- ◆ НҮБ-ийн Аюулгүйн зөвлөлийн шийдвэрээр оруулсан цэргийн хүчин
- ◆ Хоёр талын, бүс нутгийн болон олон талт хэлэлцээрийн дагуу оруулсан цэргийн хүчин
- ◆ Өөрийгөө хамгаалах эсвэл хууль бусаар цэргийн хүч ашиглах гэсэн албан бүс үйлдэл
- НҮБ-ийн Аюулгүйн зөвлөлөөс хүлээн зөвшөөрсөн хүч нь гол төлөв энхийг сахиулах хүчин бөгөөд цэргийн бүх албан хаагчид нь энэ талаарх НҮБ-ийн тусгай дүрэм, НҮБ-ийн Цэнхэр дуулгатны дүрэм, Үйл ажиллагааны процедурын стандарт болон хоёр талын Харилцан ойлголцох санамж бичигт нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна.
- Олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомж нь дээр дурьдсан цэргийн албан хаагчдад үйлчлэх бөгөөд НҮБ-ийн 1946 оны Халдашгүй байдал, эрхийн Конвенц нь нутаг дэвсгэрийн хүрээндэх хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилго агуулна.
- НҮБ хэргийн харьяалалын талаар тусгайлсан дүрэм журам тогтоогоогүй бөгөөд яллах ажиллагааг тухайн хүний харьяалах улс орны мэдэлд үлдэнэ. Тухайн улс орон яллах ажиллагааг өөрийн эрүүгийн хуулиар зохицуулдаг.
- Цэрэг оруулах асуудал холбогдох оролцогч улсуудын хоорондын гэрээгээр зөвшөөрөгдсөн тохиолдолд шүүн таслах болон холбогдох ажиллагаа Цэргийн хүчний статусын талаарх гэрээний дагуу явагдана. Сэжиглэгдэж буй этгээдийн орон нь гадаад орны газар нутагт үйлдэгдсэн аливаа гэмт хэргийн харьяалалыг тогтоох бөгөөд шүүн таслах ажиллагааг цэргийн комисс явуулна.
- Албан бус цэргийн хүч эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тухайн үед үйлдэгдсэн хэрэг болон зөрчилдөөний дараах ажиллагаа хоёрыг ялгаж зааглах хэрэгтэй. Олон улсын хүмүүнлэгийн хуулиар тогтоосон дүрэм журам нь олон улсын болон олон улсын бус зөрчилдөөнд мөн адил үйлчилнэ. Эрүү шүүлт нь 1949 оны Женевийн 4 Конвенц болон тэдгээрийн нэмэлт Протоколуудыг ноцтой зөрчиж байгаа хэрэг бөгөөд улс орон бүр зөрчлийг арилгаж хариуцлага тооцох (шүүн таслах ажиллагаа явуулах) үүрэгтэй.
- Зөрчилдөөн дуусмагц тухайн улсад байрласан хүчин нь түүний газар нутгийг “түрэмгийлэн эзэлсэн” гэсэн ойлголт (нэр томъёо)-той болдог тул эзэлсэн болон эзлэгдсэн улсуудын хоорондын харилцаа, хүлээх хариуцлагыг 1907 оны Гаагийн Дүрмээр зохицуулна.
- Хуульчдын зөвлөл Израйлын хэргээр 2004 онд дүгнэлт өгөхдөө олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг эзлэгдсэн газар нутагт мөн баримтлах (хэрэглэх) бөгөөд тухайн улсын газар нутгийг эзлэн авсан улс орон эрүү шүүлт зэрэг бүх гэмт хэрэг, зөрчлийн талаар олон улсын өмнө хариуцлага хүлээнэ гэж тэмдэглэсэн байна.
- Эрүү шүүлт нь хэргийн түгээмэл харьяалалтай учир улс орон бүр эзлэн түрэмгийлэх үеэр үйлдэгдсэн хэргийн харьяаллыг тогтоож болно. Олон улсын эрүүгийн шүүх Ромын дүрмийн хүрээнд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэргийг тухайн улс эсвэл сэжиглэгдэж буй этгээдийн улс гэрээнд нэгдэн орсон эсэхээс үл хамааран шүүн таслах ажиллагаа мөн явуулна.

- Эсрэгээрээ, Ромын дүрмээр хувь этгээд гэрээнд оролцогч улсын газар нутаг дэвсгэр дээр гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд оролцогч бус талын хэргийг шүүн таслах эрх мэдлийг Олон улсын эрүүгийн шүүхэд олгосон байна.
- Түүнчлэн Дарфуртай холбоотой хэргийн адил Аюулгүйн зөвлөл асуудлыг ОУЭШүүхээр шүүн таслуулахаар шилжүүлж болно.

(xi) Бусад байгууллага (төрийн бус эсвэл олон нийтийн байгууллагууд)-ын үйлдсэн зөрчлөөс хамгаалах үүргийн мөн чанар, хүрээ

- Улс орнууд аливаа этгээдэд төрийн бус байгууллагуудаас эрүү шүүлт тулгах буюу хэрцгий эсхүл хүний ёсноос гадуур нэр төрийг нь гутаан доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах үүрэг хүлээнэ. Төрөөс үр нөлөөтэй захиргааны хяналт тавихын зэрэгцээ эдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгдөг.
- Олон улсын эрх зүйн хүрээнд хувь хүмүүст төрийн бус байгууллагуудаас эрүү шүүлт тулгах буюу хэрцгий эсхүл хүний ёсноос гадуур нэр төрийг нь гутаан доромжлон харьцаж шийтгүүлэхгүй байх явдлыг хангахын тулд бүх улс орнууд шаардлагатай бүх арга хэмжээг авах ёстой.
- Аливаа этгээдэд төрийн бус байгууллагуудаас эрүү шүүлт тулгах буюу хэрцгий эсхүл хүний ёсноос гадуур нэр төрийг нь гутаан доромжлон харьцаж шийтгэсэн аливаа үйлдлийнхээ төлөө олон улсын болон үндэсний эрүүгийн хууль тогтоомжоор хариуцлага хүлээнэ.
- Түүнчлэн олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжийн ерөнхий зарчмын дагуу зэвсэгт мөргөлдөөний үеэр эрүү шүүлтийн гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө төрийн бус байгууллагууд мөн хариуцлага хүлээнэ.

Хавсралт 1

Хүснэгт 1

Эрүү шүүлтэй холбоотой Олон улсын хүний эрхийн үндсэн гэрээнд
Чуулганы гишүүн орнууд гарын үсэг зурсан байдал

(2005 оны 2-р сарын 15-ны байдлаар)

Улс	ИУТЭОУП	ИУТЭОУП-ын 1-р Нэмэлт Протокол	ЭЗНСЭОУП	ЭШЭК	ЭШЭК-ийн Нэмэлт Протокол	ХЭК	ХЭК-ийн Нэмэлт Протокол	Дүрвэгсэд
Афганистан	х	-	х	х	-	х	х	-
Австрали	х	х	х	х	-	х	х	х
Фижи	-	-	-	-	-	х	-	х
Энэтхэг	х	-	х	s	-	х	s	-
Индонез	-	-	-	х	-	х	s	-
Йордан	х	-	х	х	-	х	s	-
Малайз	-	-	-	-	-	х	-	-
Монгол	х	х	х	х	-	х	х	-
Балба	Х							
Шинэ Зеланд	х	х	х	х	s	х	s	х
Палестин								
Филиппин	х	х	х	х	-	х	х	х
Солонгос	х	х	х	х	-	х	х	х
Шри Ланк	х	х	х	х	-	х	s	-
Тайланд	х	-	х	-	-	х	-	-

Товчлол:

ИУТЭОУП: Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пакт

1-р Нэмэлт Протокол: Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактын 1-р Нэмэлт Протокол

ЭЗНСЭОУП: Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын Пакт

ЭШЭК: Эрүү шүүлт тулгах буюу хэргийг эсхүл хүний ёсноос гадуур нэр төрийг нь гутаан дормжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц

ЭШЭК-ийн Нэмэлт Протокол: Эрүү шүүлтийн эсрэг конвенцийн Нэмэлт Протокол

ХЭК: Хүүхдийн эрхийн Конвенц

ХЭК-ийн Нэмэлт Протокол: Хүүхдийг худалдах, биеэ үнэлэх болон хүүхдийн садар самууны талаарх Хүүхдийн эрхийн конвенцийн Нэмэлт Протокол

Дүрвэгсэд: Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай Конвенц

“х” – Олон улсын гэрээнд гарын үсэг зурсан буюу тусгай гэрээг хүлээн зөвшөөрсөн

“s” – Тусгай гэрээнд гарын үсэг зурсан

Эрүү шүүлтэй холбоотой Олон улсын хүмүүнлэгийн гэрээг
Чуулганы гишүүн орнууд гарын үсэг зурсан байдал

2004 оны 11-р сарын 10-ны байдлаар

Улс	Женевийн Конвенц	1-р Нэмэлт Протокол	2-р Нэмэлт Протокол	Ромын Дүрэм
Афганистан	х	-	-	Х
Австрали	х	Х	х	х
Фижи	х	-	-	х
Энэтхэг	х	-	-	
Индонез	х	-	-	-
Йордан	х	х	х	х
Малайз	х	-	-	-
Монгол	х	х	х	х
Балба	х	-	-	-
Шинэ Зеланд	х	х	х	х
Палестин				
Филиппин	х	-	х	s
Солонгос	х	х	х	х
Шри Ланк	х	-	-	-
Тайланд	х	-	-	s

Хавсралт 3

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХОЛБООНЫ ИЛТГЭЛ

**Эрүүдэн шүүх, хүнлэг бусаар нэр төрийг нь
доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэхэд
хүний эрхийн үндэсний байгууллагуудын үүрэг роль**

Сүүлийн 10 жилд олон улс орон хүний эрхийг хэмгээлэх, дээдлэх зорилгоор хүний эрхийн үндэсний байгууллагуудыг ардчиллыг бэхжүүлэх, хуулийг дээдлэх болон энхийн үйл явцыг бэхжүүлэх гол арга хэрэгсэл болгон байгуулсан зарим нь байгуулах асуудлыг анхааралдаа (чухал гэж үзэх) аваад байна. Эрүү шүүлт болон бусад зүй бус үйлдлээс урьдчилан сэргийлэхэд хүний эрхийн үндэсний байгууллагууд шийдвэрлэх үүрэгтэй. Энэхүү илтгэлд хүний эрхийн үндэсний байгууллагууд иймэрхүү зөрчлийг эрс бууруулахад ач холбогдол бүхий дараах 6 тодорхой алхам (арга хэмжээ)-ыг тус Холбооноос санал болгож байна. Эдгээрийг бүрэн дүүрэн (нэг бүрчлэн) хэрэгжүүлэх шаардлагагүй (үүнийг урьтал болгоогүй) харин хүний эрхийн үндэсний байгууллага тус бүрийн болон тухайн улс орны онцлог нөхцөл байдалд тохирсон байх ёстой юм.

А. ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГУУД

Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь үндэсний хэмжээнд хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дээдлэх хуулиар хүлээсэн үүрэг бүхий төрийн байгууллагууд юм. Бодит байдал (практикаас үзэхэд) дээр дээр дурьдсан өргөн хүрээтэй (хуулиар хүлээсэн) үүргээ гүйцэтгэж буй байдал хүний эрхийн үндэсний байгууллага бүрт харилцан адилгүй байна. Гэхдээ өөрсдийн зорилгодоо аль болох бие даасан хараат бус түүнчлэн үр дүнтэй хүрэхдээ нийтлэг онцлог шинж, эн тэргүүний хэрэгцээ шаардлагын асуудлаар санал солилцдог. Эдгээр онцлог шинжүүдээс Парисын зарчимд тусгагдсан бөгөөд уг зарчмаар хүний эрхийн үндэсний байгууллагуудын бүрэн эрх, үүрэг хариуцлага, бүтэц бүрэлдэхүүн, биедаасан хараат бус байх баталгаа, олон эштүзэл болон үйл ажиллагааны арга зүй (арга хэлбэр)-г тодорхойлсон. Эдгээр зарчмууд нь дэлхий даяар хүний эрхийн үндэсний байгууллага байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны суурь, лавлах (суурь зарчим) болсон юм.

Хүний эрхийн үндэсний байгууллагууд төрийн захиргааны үйл ажиллагаанд мониторинг хийх, төрийн байгууллгуудын зүй бус харьцаанаас урьдчилан сэргийлэх түүнчлэн (ер нь) хүний эрхийг хүндэтгэ дээдлэх явдлыг хөхиүлэн дэмжих үүрэгтэй. Зарим тохиолдолд хүний эрхийн үндэсний байгууллагууд хувь этгээдтэй холбоо бүхий өргөдөл, гомдлыг хүлээн авч сонсох, шийдвэрлэх зэрэг шүүх эрх мэдэл (quasi-judiciary)-ийг хэсэгчлэн хэрэгжүүлдэг. Тэдгээрийн үүрэг роль нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих бусад байгууллагууд тухайлбал, хууль

тогтоох болон шүүх эрх мэдлийн байгууллагууд, парламентын комисс, засгийн газрын болон төрийн бус байгууллагуудын бүрэлдэхүүн хэсэг мөн.

Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь Хүний эрхийн комисс, омбудсман зэрэг үндэсний хэмжээнд хуулиар хүлээсэн үүрэг бүхий албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн байгууллагын хэлбэртэй байж болно. Зарим байгууллагууд нь орон нутгийн омбудсман, эсвэл онцлог бүлгийн хүний эрхийг хамгаалах, хөхиүлэх дэмжих үүрэг бүхий үндэсний байгууллага зэрэг газар зүйн бүсийн болон үйл ажиллагааны онцлогийн хувьд тусгайлсан хэлбэртэй байдаг. Эдгээр байгууллагууд (онцлог, тусгайлсан хэлбэр бүхий хүний эрхийн байгууллагууд)-ыг Парисын зарчмын дагуу хүний эрхийн үндэсний байгууллага гэж авч үздэггүй бөгөөд дээрх байгууллагуудад Парисын зарчмыг мөн хэрэглэж болно гэдэгт тус Холбоо найдаж байна.

Б. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ 6 ТОДОРХОЙ АЛХАМ

Хүний эрхийн үндэсний байгууллагууд эрүү шүүлт болон зүй бус харьцаж, шийтгэхтэй илүү үр нөлөөтэй тэмцэхдээ доор дурьдсан арга хэмжээг хэрэгжүүлж болно. Үүнд:

1. Эрүү шүүлтийг хориглосон олон улсын болон бүс нутгийн хэм хэмжээг хэрэглэх талаар сурталчлах

- (а) Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь иргэний нийгэм болон хэвлэл мэдээллийнхэнтэй хамтарч холбогдох олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн баримт бичгүүдийг батлах, гэрээнд нэгдэн орох талаар сурталчилгаа явуулахад идэвхитэй үүрэг роль гүйцэтгэх ёстой. үүнийг зарим холбогдох байгууллагууд ялангуяа хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын институцүүдийг лоббидох, ухуулан сурталчлах замаар энэ зорилтыг хэрэгжүүлэх юм.

Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь хүний эрхийг хамгаалах олон улсын болон бүс нутгийн хэм хэмжээ, эрүү шүүлт, зүй бус харьцаж шийтгэхтэй тэмцэх тусгайлсан баримт бичгүүд түүнчлэн эмэгтэйчүүд, хүүхэд, дүрвэгсэд, баривчлан саатуулагдсан этгээдийн эрхийг хамгаалах олон улсын болон бүс нутгийн гэрээнд нэгдэн орох түүнчлэн соёрхон батлах талаар сурталчлахад бүрэн дүүрэн нийцсэн (аль ч талаараа үнэхээрийн тохирсон) байгууллага болно.

- (б) Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь соёрхон баталсан олон улсын болон бүс нутгийн хэм хэмжээг дотоодын хууль тогтоомжийн бүрдэл хэсэг болгох явдлыг хангана. Парисын зарчмын дагуу Хүний эрхийн үндэсний байгууллагууд хэвлэн нийтлэхээр шийдвэрлэсэн санал, дүгнэлт, зөвлөмжөө парламент, засгийн газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудад танилцуулах эрхтэй байх ёстой. Хүний эрхийн үндэсний байгууллагууд энэ эрх мэдлээ үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын хэм хэмжээнд бүрэн дүүрэн нийцүүлэх чиглэлээр сурталчилгаа явуулахдаа ашигладаг. Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь хүчин төгөлдөр үйлчиж буй хууль тогтоомж түүнчлэн хэлэцүүлэгдэж буй хуулийн төсөл, төсөлд өгсөн саналыг авч үзэж боломжит нэмэлт өөрчлөлтийн талаар санал

зөвлөмж өгөх эрхтэй. Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь мөн шинээр батлагдсан хууль эрхийн актыг сурталчлах боломжтой.

Дотоодын хууль тогтоомжийн адил тэнцүү байх ач холбогдлын асуудал нь эрүү шүүлтийн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэсэн үг юм. Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь эрүүшүүлт болон бусад зүй бус харьцааг дотоодын хууль тогтоомжид илэрхий эрүүгийн гэмт үйлдэл хэмээн тов тодорхой авч үзсэн эсэх (хуулийн тодорхойлолт)-ийг тогтоох ёстой. Хэрэв ийнхүү тов тодорхой авч үзээгүй бол эрүү шүүлт болон зүй бус харьцаж, шийтгэсэн үйлдэлд эрүүгийн хариуцлага тооцох асуудлыг яаралтай хуульчлах талаар холбогдо бүр арга хэмжээг авах ёстой.

- (b) Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх: Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөн авч үзэж, мониторинг хийх үүрэгтэй. Хангалттай мэдлэгтэй байх, шүүх олон улсын болон бүс нутгийн хэм хэмжээг ашиглах явдлыг хангах үүднээс Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь хүний эрхийн зөрчил ялангуяа эрүү шүүлт болон зүй бус харьцаж шийтгэхтэй холбоотой хэргүүдийн шүүх ажиллагаанд оролцох, ажиглалт явуулах ёстой. Асуудал гарсан (зөрчил илрүүлсэн) тохиолдолд шүүх системд өөрчлөлт шинчэлэлт хийх талаар санал дүгнэлт өгөх зэргээр засч сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай.

2. Хүний эрхийн олон улсын болон бүс нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах

- (a) Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь холбогдох олон улсын болон бүс нутгийн байгууллагуудад мэдээлэл, хэрэг, илтгэл тайлан танилцуулах ажиллагаанд оролцох ёстой.

Эрүү шүүлт болон зүй бус харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэхэд дараахь байгууллага, албан тушаалтнуудтай хамтран ажиллана. Үүнд:

- (i) Эрүү шүүлтийн асуудлаарх НҮБ-ийн Тусгай илтгэгч
- (ii) Эрүү шүүлтийн эсрэг НҮБ-ийн Хороо;
- (iii) НҮБ-ийн Хүний эрхийн хороо
- (iv) Арбитрийн баривчилгааны асуудлаарх НҮБ-ийн Ажлын хэсэг
- (v) Хүний эрхийн асуудлаарх Америк дундын Комисс
- (vi) Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хороо
- (vii) Хүний ба улс түмний эрхийн тухай Африкийн Комисс зэрэг болно.

Гэрээний бусад байгууллагууд болон бүс нутгийн тусгай процедураар эрүү шүүлт болон зүй бус харьцаатай холбоотой асуудлыг авч хэлэлцдэг гэдгийг анхаарах нь чухал. НҮБ-ийн хүрээнд: Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах хороо, Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах хороо, Хүүхдийн эрхийн хороо, Нүүдийн ажилчдын асуудлаарх хороо, Хүний эрхийг хамгаалагчдын асуудлаарх Тусгай илтгэгч, Арбитрийн баривчилгааны асуудлаарх Ажлын хэсэг, Хүчээр сураггүй алга бологсдын асуудлаарх Ажлын хэсэг, Албан бус (тухайн хэрэгт хамааралгүй) шүүхийн асуудлаарх Тусгай илтгэгч, Яаралтай эсвэл Арбитрийн шийдвэр гүйцэтгэл гэх мэт.

- (б) Хүний эрхийн үндэсний байгууллага нь тухайн засгийн газар олон улсын болон бүс нутгийн байгууллагуудад цаг тухайд нь тайлагнаж байгаа эсэх талаар мэдээлэлтэй байх мөн эдгээр байгууллагуудыг холбогдох мэдээллээр хангах замаар энэ процесст оролцох ёстой. Хүний эрхийн үндэсний байгууллага нь улсын албан ёсны тайлан бэлтгэх явцын талаарх зөвлөлдөх уулзалтад оролцох мөн төрийн бус байгууллагуудаас төслөөр оруулсан бие даасан тайланг бэлтгэхэд оролцох зэрэгт оролцдог.
- (в) Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь тусгай хүний эрхийн нөхцөл байдлыг шалгахад ирж буй олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн экспертүүдэд туслах ялангуяа сүүлийн үеийн мэдээллээр хангах, хэлхээ холбоо тогтоох, санал болгож буй асуудлаар санал өгөх зэргээр тэдний ажилд тусалцаа дэмжлэг үзүүлнэ.
- (г) Олон улсын болон бүс нутгийн байгууллагууд холбогдох тайлан ялангуяа тусгайлсан (тухайн орны тусгайлсан хүний эрхийн асуудлаарх) асуудлын илтгэл тайланг гаргахад Хүний эрхийн үндэсний байгууллагууд хэвлэл мэдээллээр дамжуулан тэдгээрийн санал, дүгнэлт, зөвлөмжийг тараахад юугаар ч орлуулшгүй хувь нэмэр оруулах ёстой. Дээр дурьдсан санал дүгнэлт, зөвлөмжүүд нь олон нийт түүнчлэн иргэний нийгмийн тодорхой байгууллагууд, парламент, олон нийтийн байгууллагууд, гүйцэтгэх болон шүүх засаглалын тусгай байгууллагуудад сонирхолтой байна. Түүгээр ч барахгүй, дээр дурьдсан олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын гаргасан тусгайлсан зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авч холбогдох байгууллагуудад тэдгээрийн хэрэгжилтийг хангахад шийдвэрлэх роль гүйцэтгэдэг.

3. Саатуулах байранд мониторинг хийх

- (а) Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь саатуулах байранд мониторинг хийх хөтөлбөртэй байх ёстой. Иймэрхүү хөтөлбөр нь эрүү шүүлт болон зүй бус харьцаанаас урьдчилан сэргийлэх хамгийн хүчирхэг хэрэгслэлүүдийн нэг нь юм. Саатуулах байранд байнгын урьдчилан сэргийлэх үзлэг хийснээр Хүний эрхийн үндэсний байгууллага ямар ч нөхцөлд эрүү шүүлтийг бүрмөсөн хориглосон болон саатуулах байрны шаардлага хангахуйц нөхцлийн талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийг төрд уриалах (шаардах) ёстой.
- (б) Үр нөлөөтэй мониторинг явуулахын тулд Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь эрх чөлөөгөө хасуулсан хүмүүс саатуулагдсан бүх газар тухайлбал, цагдаагийн хэсэг, шорон, захиргааны болон цэргийн саатуулах төв, хүүхдийн саатуулах (урьдчилан хорих) төв, сэтгэл мэдрэлийн эмнэлэг зэрэг нийгмийн эрүүл мэндийн газруудаар орох бүрэн эрх (хязгааргүй)-тэй байх ёстой. Түүнчлэн мэргэжлийн мониторингийн үйл ажиллагаа явуулах, тухайлбал, бүх хүмүүстэй уулзаж, ярилцах, тэдгэрийн сонгосон хүмүүстэй хувийн асуудлаар ярилцах, холбогдох мэдээлэл авах эрхтэй байх ёстой.
- (в) Ер нь урьдчилан хорих байруудаар явж үзэх баг нь олон ишт үзэл бүхий янз бүрийн мэргэжлийн боломжтой бол хуульч, эмч нарыг оролцуулах нь хамгийн үр нөлөөтэй байгааг тушрлага харуулж байна. Иймэрхүү

ажиллагааг аль болох тогтмол явуулах мөн мониторингийн баг нь зохих түвшинд сургалтанд хамрагдсан байх шаардлагатай.

- (г) Иймэрхүү ажиллагаа нь тухайн асуудлаар холобгдох бүх байгууллагуудтай хамтарч ажиллах талаар бүтээлч (үр нөлөөтэй, үр дүнтэй) харилцан яриа хэлцэл бий болгоход туслах ёстой. Иймээс Хүний эрхийн үндэсний байгууллага нь очиж үзсэн байгууллагын удирдлага түүнчлэн бусад яамд болон эрх чөлөөгөө хасуулсан хүний асуудлаар хариуцлага хүлээж буй засгийн газрын байгууллагад өөрийн дүгнэлт, зөвлөмжөө хүргэх шаардлагатай.

Хүний эрхийн үндэсний байгууллага нь олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн байгууллага өмнө нь орж танилцсан урьдчилан хорих төвд зочилж эрүү шүүлт, зүй бус харьцаатай холбоотой асуудлаар өгсөн тэдгээрийн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгаж баталгаажуулна.

- (д) Хүний эрхийн үндэсний байгууллага нь Эрүү шүүлтийн эсрэг НҮБ-ийн Конвенцийн Нэмэлт протоколоор тодорхойлсон үндэсний урьдчилан сэргийлэх механизмын нэг хэсэг болох бүрэн боломжтой. Энэ нь мониторингийн үүрэг ролийг ихээхэн өргөжүүлэх зорилго агуулсан болохоос хүний эрхийн үндэсний байгууллагын тусгайлсан үүрэг биш юм. Ихээхэн үр нөлөө бүхий механизм бий болгохын тулд олон нийтээр өргөн хүрээний мэтгэлцээн явуулсны үр дүнд улс орон бүр бүтцээ батлах (бий болгох) ёстой.

4. Ял шийтгэлгүй үлдэхтэй тэмцэх үүднээс эрүү шүүлт болон зүй бус харьцааны илэрхий болсон хэргүүдийг мөрдөн шалгах нь

- (а) Хүний эрхийн үндэсний байгууллага нь эрүү шүүлт, зүй бус харьцсан талаарх өргөдөл гомдлыг хүлээн авах, тэдгээрийн хөөн хэлэлцэх хугацаа, бүх нарийн ширийн асуудлыг мөрдөн шалгах, шаардлагатай бол, хэргийг дүрэм журмын дагуу шүүхээр үр дүнтэй шийдвэрлэх явдлыг хангах эрх мэдэл, чадвартай байх ёстой.
- (б) Хүний эрхийн үндэсний байгууллага нь эрүү шүүлтийн хохирогсод болон ойр дотныхонд зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, эрүүл мэндээ нөхөн сэргээх, нөхөн олговор авах эрхийг нь сурталчлах арга хэмжээ авах хэрэгтэй. Түүнчлэн эрүү шүүлтийн хохирогсод тусламж дэмжлэг үзүүлэх, хүчин төгөлдөр үйлчилж буй процедуртай холбоотойхууль, эрх зүйн чиглэл (зөвлөгөө) өгөх, мөн хэргийг нь шүүхээр шийдвэрлүүлэхэд туслах зорилгоор хуулийн тусалцаа, үйлчилгээг үзүүлэх шаардлагатай. Хүний эрхийн үндэсний байгууллага нь эрүү шүүлтийн золиосболосод шаардлагатай дэмжлэг тусалцаа үзүүлэх талаар засгийн газарт сануулах үүрэгтэй.
- (в) Ингэхдээ Хүний эрхийн үндэсний байгууллага нь нийгэм шүүхээр шийтгүүлэх ёстой хүчирхийлэл үйлдэгчдийг хүлцэхээс илүү хохирогсодтой эв нэгдэлтэй байна гэсэн тодорхой ойлголтыг бий болгох ёстой.

5. Олон нийтийн боловсрол, тэдний мэдлэг (ойлголт)-ийг дээшлүүлэх, сургалт

- (а) Хүний эрхийн үндэсний байгууллага нь хүний эрхийг хүндэтгэх соёлыг хөхиүлэн дэмжих үүднээс эрүү шүүлтийг хориглох, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн боловсрол, тэдний мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр

санаачлах, хэрэгжүүлэхэд тэргүүлэх байр суурьтай байна.

Олон нийтийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ бусад холбогдох байгууллагууд тухайлбал, олон улсын болон орон нутгийн хүний эрхийн төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийхэнтэй хамтарч ажиллана.

Тухайлбал, мөргөлдөөний дараахь нөхцөл байдал болон ардчилсан шилжилтийн явцад Хүний эрхийн үндэсний байгууллага нь холбогдох мэдээлэл, гэрчлэх баримтуудыг цуглуулах замаар хүний эрхийн зөрчлийн талаар хамдаа (нийгмээрээ) дахин дурсах, үүнийг одоо болон хойч үедээ ойлгуулахад туслах хэрэгтэй. Энд эвлэрэлийн асуудал, дахин хэзээ ч ийм үйлдэл гарахгүй гэсэн баталгаа гаргах шаардлагатаолбоотой асуудлаар үндэсний хэмжээний мэтгэлцээн явуулах ажлыг хөхиүлэн дэмжих боломжтой.

(б) Хүний эрхийн үндэсний байгууллага нь хүний эрхийн хэм хэмжээ дараахь байгууллагуудад зориулсан мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн чухал бүрдэл хэсэг болгох явдлыг хангах хэрэгтэй. Үүнд:

- Цагдаа
- Шоронгийн ажилтнууд
- Насанд хүрээгүйчүүдийн урьдчилан хорих төвийн ажилтнууд
- Цэргийн байгууллага
- Шүүгчид, прокурор болон өмгөөлөгчид
- Шүүх эмнэлгийн эмч нар
- Парламентын гишүүд

Мөн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд дээрх байгууллагуудын дорвитой хувь нэмрийг хангах үүднээс хүний эрхийн хэм хэмжээг практикт хэрэглэх талаар зөвлөгөө өгөх, тусгайлсан сургалтын арга хэмжээг хамтарч хэрэгжүүлэх боломжтой.

(в) Шаардлагатай бол Хүний эрхийн үндэсний байгууллага дээрх байгууллагуудын заримд нь олон улсын хэм хэмжээнд нийцсэн, ажлыг нь удирдан чиглүүлж байх ёс зүйн дүрмийг боловсруулахад нь тусалж болно. Иймэрхүү тогтолцоо байгаа нөхцөлд Хүний эрхийн үндэсний байгууллага тэдгээрийг (мэргэжлийн ёс зүйн дүрэм) хэрэгжүүлэхэд нь мэргэжлийн байгууллагуудад дэмжлэг тусалцаа үзүүлнэ.

6. Төрийн бодлого боловсруулахад оролцох нь

Хүний эрхийн үндэсний байгууллага нь эрх чөлөөгөө хсуулсан хүмүүстэй харьцах асуудлаар төрөөс баримтлах бодлого боловсруулах үйл ажиллагаанд идэвхитэй оролцох ёстой. Хүний эрхийн үндэсний байгууллага нь бусад холбогдох байгууллагуудтай хамтран хүний эрхийн төлөв байдлын талаарх тодорхой асуудлаар баримтлах ерөнхий стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад оролцох боломжтой. Түүнчлэн дээр дурьдсан бодлогыг хэрэгжүүлэх жишээлбэл цагдаа, засан хүмүүжүүлэх газар болон шүүх байгууллагад шаардлагатай нөөц гаргуулах, санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлэх талаар мөн сурталчилгаа, компанит ажил зохион байгуулж болно.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх холбоо

2005 оны 2-р сар

ДОРНОД АЙМГИЙН ИТХ-ЫН ДЭРГЭДЭХ ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛӨӨС ЗОХИОЖ БУЙ АЖЛЫН ТУХАЙ

**М. Цэрэндаваа,
Аймгийн Хүний эрхийн
ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ**

Дорнод аймгийн ИТХ-ын дэргэдэх Хүний Эрхийн зөвлөл нь 2003 онд 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан одоо хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүний эрхийн зөвлөл нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн баталсан “Дорнод аймагт Хүний эрхийн хангах талаар 2002-2006 онд хийх ажлын төлөвлөгөө, Монгол улсад Хүний эрхийн хангах Үндэсний Хөтөлбөр”-ийг ажлын удирдамж болгон орон нутагт хэрэгжүүлэх, зохион байгуулахад ажлаа чиглүүлж байна.

Нэг. Үр дүн

- Орон нутагт Хүний эрхийн хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын тогтолцоо бүрэлдэн бий болсон
- Төв орон нутгийн хүний эрхийн хангах талаар үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хамтын болон харилцан ажиллагааны арга хэлбэрүүд болж байна
- Хүний эрхийн үйл ажиллагааны талаар иргэд хөдөлмөрчид тодорхой мэдлэгтэй болж байна
- Төрийн болон ТББ-тай хүний эрхийн сургалт, сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулж, Хүний эрхийн талаархи бүхий л асуудлыг хөхүүлэн дэмжих, зөрчлийг арилгахад тус дөхөм болж байна

Хоёр. Зохион байгуулалтын ажлын талаар

- Хүний эрхийн зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжиж, хурлаа хагас жил тутам хийж, гишүүдийг холбогдох мэдээллээр хангагдах нь зөвлөлийн нэр хүндийг дээшлүүлэхэд ач холбогдлоо өгсөн
- Хүний эрхийн зөвлөлийн дарга, харийн бичгийн дарга, гишүүдийн ажил үүргийн хуваарийг баталж мөрдөн ажиллаж байна
- Жил улирлын төлөвлөгөөг баталж, биелэлтийг зөвлөлийн хурлаар хэлэлцэж хэвшсэн

Гурав. Энэ хугацаанд хийсэн ажлууд:

- ХЭҮК, НҮБХХ-ийн төслөөс өгсөн санхүүжилт, дэмжлэг тусалцааг түшиглэн хүний эрхийн сургалтын танхим байгуулсан
- Танхимд сургалтын төлөвлөгөөг баталж сургалт явуулахын зэрэгцээ гарын авлага ном товхимлоор хангагдсан
- “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль, “Эрүүдэн шүүхийн эсрэг” конвенцийг хэвлэн танхимд тавьсан
- Хүний эрхийн талаар мэдээллийн самбар хийж танхимд байрлуулсан
- Орон нутгийн мэдээллийн хэрэгслээр улирал тутам хоёр удаа хүний эрхийн сурталчилгааг тогтмол явуулж хэвшсэн

- Аймгийн өмгөөлөгчдийн зөвлөлтэй хамтран сургалт явуулж, иргэдэд үнэ төлбөргүй зөвлөгөө өгдөг өдөртэй болсон
- “Бүтээж туурвих эрх”, “Архидалт ба хүний эрх”, “Зах зээл-хүний эрх”, “Хөдөлмөрлөх эрх”, “Сурч боловсрох эрх”, “Хүний эрх” зэрэг олон сэдвээр сургалтуудыг зохион явууллаа
- Аймгийн ШШБГазрын харьяа урьдчилан хорих байр, түр саатуулах байранд “Эдлэх ёстой эрх” сургалт, сурталчилгаа, судалгааг цогц байдлаар хийлээ
- Архинд донтох өвчин ихэсч байгаагаас улбаалан хүний эрхийн зөрчил, ялангуяа хүүхдийн эрх ноцтой зөрчигдөх болсонд дүгнэлт хийж Аймгийн Хүүхдийн төлөө төв, Архидалт ассоциаци нийгэмлэг, зүүн бүсийн АХАЯ-г бууруулах зүүн бүсийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн холбоо, хороодтой хамтран сургалт зохиосон нь олныг хамарсан үр дүнтэй ажил болсон билээ.
- Олон улсын Хүний эрхийг хамгаалах өдрийг угтаж аймгийн 14 сумдын дунд сарын аян зохион байгуулж дүгнэж урамшууллаа
- Сургуулиудын нийгмийн ажилтнуудад “Сурах эрх ба ялгаварлан гадуурхалт” сэдвээр сургалт явуулсан нь Хүүхдийн эрхийн хамгаалах үйлсэд зохих хувь нэмэр оруулсан ажил боллоо

Сурталчилгааны талаар:

- “ТВ сургалт, сурталчилгаа” нэртэйгээр хүний эрх, өмгөөлүүлэх эрх зэрэг сэдвээр хууль зүйн асуулт хариулыг зохион байгуулж, Хүний эрхийн хангах Үндэсний Хөтөлбөр, Үндсэн хуулийн заалт, бусад гэрээ конвенцийн талаар сурталчилгаа явуулж олон нийтийг хамрууллаа
- Аймгийн Хүний эрхийн зөвлөлөөс улирал бүр “Хүний эрх” бичил сонин гаргаж хэвлүүлэн сумдын ХЭЗ болон нийтэд үнэгүй тараан өгсөн
- Хүний эрхийн талаар “Хууль тогтоомж” сурталчилсан эвхмэл хуудас гарган олон нийтэд тараан өгч байгаа нь иргэдийн эрхийн талаархи мэдлэгийг дээшлүүлэхэд тустай ажил болсон

Судалгааны талаар:

- ХЭҮК болон судалгааны төв багаас явуулсан ажилд байнга идвэхтэй оролцож, “Хүний эрхийн боловсрол: ЕБС-д”, “Эвлэлдэн нэгдэх эрхийн хэрэгжилтийн төлөв байдал”, “Сонгох, сонгогдох эрх”-ийн талаар судалж цаг хугацаанд нь тайлангаа тогтмол хүргүүлж байв.
- “Урьдчилан хорих байр”-нд “Хоригдогсдын эрхийн талаар болон эрүүдэн шүүхийн эсрэг” судалгаа хийж гарсан дүгнэлтийг аймгийн цагдаагийн газар болон ШШБГазарт хүргэсэн.

Бусад асуудлаар:

- Танхимийн зөвлөгөөг үнэ төлбөргүй өгч хэвшсэн ба танхимийн номын сан ажиллуулж иргэд хөдөлмөрчдийн Хүний эрхийн мэдлэгийг дээшлүүлэхэд тус нэмрээ оруулж байна.
- Хүний эрхийн зөрчлийн бүртгэл хийж, иргэдээс ирсэн санал гомдлыг хүлээн авч ХЭҮК-д болон зохих байгууллагад хандаж шийдвэрлүүлж, хариуг нь цаг тухайд нь өгч зөвлөгөө өгөх ажил тогтмолжсон

Аймгийн Хүний эрхийн зөвлөл нь хүний эрхийг хангах ажлын талаар гаргасан орон нутгийн санаачлага, Хүний Эрхийн Үндэсний Хөтөлбөрийг амьдралд хэрэгжүүлэх талаар сургалт, сургалчилгааны ажлаа улам боловсронгуй, үр дүнтэй болгох зорилт дэвшүүлэн, цаашид олон ажлыг төлөвлөн ажиллаж байна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Б. Эрдэнэчимэг
Аймгийн Хүний эрхийн
ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

Хүний эрхийн өнөөгийн төлөв байдал, хүний эрхийн чиглэлээр цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлох зорилгоор МУ-ын Засгийн газар НҮБХХ-тэй хамтран хэрэгжүүлсэн “Монгол Улсад Хүний Эрхийг Хангах Үндэсний хөтөлбөр боловсруулах төсөл”-ийн хүрээнд 2001 оны II, III улиралд нийт аймаг, нийслэлийг хамруулан хийсэн судалгааны ажлын хүрээнд тус аймагт хүний эрхийг хангахад тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор тодорхой 4 чиглэлээр “Хүний эрхийн төлөв байдлын” судалгааг хийж, хийсэн судалгаанд үндэслэн Дорноговь аймагт “Хүний эрхийг хангах дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөө”-г /2002-2006 он/ боловсруулан аймгийн ИТХурлын төлөөлөгчдийн 2001 оны 5 дугаар хуралдаанаар батлуулан ажилласан билээ.

Тус аймагт хүний эрхийг хангах хөтөлбөр, төлөвлөгөө батлагдсаны дагуу тухайн орон нутагт *Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, МУ-ын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон хүний эрхийн заалт болон хүний эрхийг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажилд хяналт тавьж, биелэлтийг зохион байгуулах, удирдлага зохицуулалтаар хангах, хүний эрхийн сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах, хүний эрхийг хангахад чиглэсэн нутгийн захиргааны болон ТББайгууллагуудын ажлыг уялдуулах зорилго бүхий Хүний эрхийн салбар зөвлөлийг байгуулж үйл ажиллагаа явуулсаар ирлээ. Тус салбар зөвлөл нь 9 гишүүнтэй бөгөөд ИТХ-ын төлөөлөгч, төрийн захиргааны болон ТББ, хувийн хэвшил, аж ахуйн нэгжийн төлөөлөөс бүрдсэн гишүүдтэйгээр ажиллаж байна.*

Улирал бүр хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг ХЭХСЗөвлөлийн даргаар батлуулан, хийсэн ажлын тайланг заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлэн ажилладаг бөгөөд ажлын цөм болох сургалт, сурталчилгаа, судалгааны ажлуудыг аймгийн захиргааны болон ТББ, хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран зохион байгуулж албан байгууллага, иргэд хөдөлмөрчдөд хүртээж, хүний эрхийн ойлголтыг орон нутагт түгээн дэлгэрүүлэх, мөн түүнчлэн тодорхой хууль тогтоомжоор сургалтад хамрагдагсдын хууль эрхийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх тал дээр анхааран ажиллаж тодорхой үр дүнд хүрч байна.

Сургалтаар голчлон хүний эрхийн тухай ойлголт, хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн харилцааны эрх зүйн зохицуулалт, нийгмийн халамжийн багц хууль, олон улсын гэрээ, конвенцууд болоод халдашгүй эрх, хүүхдийн эрх, сурч боловсрох эрхийн болоод бусад шаардлагатай гэрээ, конвенц, хуулиудын талаар зохих мэдлэг, мэдээлэл олгох тал дээр анхааран ажилладаг.

Улирал бүр 2-3 сургалтыг тодорхой бүлэгт тусгай сэдвээр зохион байгуулж ирсэн бөгөөд сургалтад хамрагдагсадын тоо даруй 800-д хүрсэн байна.

Сургалтанд оролцогсдын идэвхийг өрнүүлж, баг бүлэгт хуваан өөрсдөөр нь хэрэгцээг нь тодорхойлуулж ажилладаг нь сургалтыг хүртээмжтэй, үлдэцтэй, сонирхолтой болгох нэг хэлбэр болдог. Ингэснээр сургалт, сурталчилгааны ажлын үр өгөөж тодорхой хэмжээгээр нэмэгдэж ирлээ.

Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан хөтөлбөрийн зорилго, үндэслэлийг олон нийтэд сурталчлах, хүний эрхийг хангах орон нутгийн дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх ажлыг амжилттай зохион байгуулж байна.

Удирдамж, чиглэлийн дагуу холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран нийт 20 гаруй шалгалт, судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Судалгааны ажлыг хийхэд хэрхэн яаж, юунаас эхлэх, эрх нь зөрчигдсөн хүмүүстэй хэрхэн харьцах, хүний эрхийн зөрчлийн санг хэрхэн бүрдүүлэх, гарын авлага, сургалт, сурталчилгааны материалыг хэрхэн ойлгомжтой, цомхон хэлбэрээр бэлтгэх зэрэгт анхааран ажилласнаар байгууллага, иргэдтэй илүү ойр дөт ажиллахад дөхөм болж байдаг.

ХЭҮК, төслийн төв багаас ирүүлсэн сурталчилгааны бүхий л материал, ном товхимол, гарын авлагыг цаг хугацаанд нь шаардлагатай сум, баг, албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд хүргэн ажилладаг бөгөөд шаардлагатай гарын авлага, материалыг бэлтгэн тараах, сурталчилгааны самбараар дамжуулан олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж ирсний зэрэгцээ орон нутгийн телевиз, радиогоор хүний эрхийн болон аймгийн ХЭХСЗөвлөлөөс хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу болоод ажлын бусад шугамаар хийгдсэн сургалт, сурталчилгаа, судалгааны ажлын тайлан, мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж ирлээ.

Хүний эрхийн ойлголт, мэдлэгийг орон нутагт түгээн дэлгэрүүлж, тодорхой эрхүүдийн сургалт, сурталчилгаа, судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэснээр тус аймгийн хэмжээнд хүний эрх зөрчигдөж байгаа болоод, зөрчигдөх магадлал өндөртэй салбар, субъектуудыг тодорхойлж сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсанаар иргэд, төрийн болоод ТББ, хувийн хэвшлийн болоод аж ахуйн нэгж байгууллагын удирдлагууд, тэнд ажиллагсдын мэдлэг зохих түвшинд дээшилж, хүний эрхийн зөрчил гаргах явдал тодорхой хэмжээгээр буурсан байна. Тухайлбал: Ажил олгогч ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллах, цалин хөлс цаг хугацаандаа тавигдах, нийгмийн болоод эрүүл мэндийн даатгал цаг хугацаандаа төлөгдөх гэх мэт.

Мөн түүнчлэн хүний эрхийн зөрчлийн сан бүрдүүлэн ажилласнаар эрх нь зөрчигдсөн гэж үзэж байгаа хүмүүстэй уулзаж ярилцах, хууль зүйн зөвлөгөө өгөх, хаана, хэнд хандаж асуудлыг шийдвэрлүүлэх зэрэг асуудлаар ажиллаж байгаа нь тодорхой үр дүнгээ өгсөн ажил болж байна.

ЗАВХАН АЙМГИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ЗАРИМ АСУУДЛУУД:

Б. Ариунаа
*Аймгийн Хүний эрхийн
ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ*

Сурч боловсрох эрхийн хэрэгжилтийн талаар:

Боловсролын салбарт гарч буй нэг сөрөн тал нь сургууль завсардалт юм. Аймгийн хэмжээгээр 2004 оны байдлаар нийт 231 хүүхэд сургууль завсардсан байна. Сургууль завсардалтын шалтгааныг судлахад: малчид хүүхдээрээ мал маллуулж, өөрийн гарын үзүүрээр зарж байх сэтгэлтэй, хүүхэд өөрөө сургуульд сурах сонирхолгүй, амьдралын боломжгүй зэргээс шалтгаалдаг.

Их, дээд сургуульд элсэгчдийн консорциумын шалгалтын дэг тодорхой бус, тестээр шалгалт авах нь хүүхдийн мэдлэгийг үнэн зөв тогтоож чадахгүй байгаа талаар гомдол санал их гардаг байна.

Зөвхөн уралдаант шалгалтын хувьд ч биш аймаг, улсын олимпиад шударга биш явагддаг гэж эцэг эхчүүд дүгнэж байна.

Ер нь боловсролын тухай хуулийн мэдлэг багш сурагчид, ард түмний дунд хангалтгүй байгаагаас хуулийн заалт хэрэгждэггүй, зөрчигддөг байна.

Сургуулийн төсөв зардал хүрдэггүйгээс зарим үед засвар тохижилтыг хийхэд сурагчдаас мөнгө авдаг зөрчил их байлаа.

Орон нутагт зарим хичээлийн багш нарын хүрэлцээ хангалтгүй байна. Ялангуяа гадаад хэл, математик, хими, биологийн багш нар дутагдалтай байна. Энэ нь хөдөө орон нутагт багш нарын нийгмийн хамгааллын талаархи арга хэмжээ муу, цалинг хугацаанд нь олгодоггүй, цалин бага зэргээс болж багш нар мэргэжлээ орхин өөр ажил хөдөлмөр эрхлэх болсноос шалтгаалдаг байна.

Цэцэрлэгийн багш нарын ажлын цаг, нөхцөл байдал сургуулийн багш нарынхаас илүү хүнд байхад тэдний цалин хангамж хэт доогуур, нийгмийн асуудал орхигддог тухай ярьж байлаа. Сургуулийн өмнөх насанд /цэцэрлэгийн бэлтгэл ангид/ бүх үсэг, тоогоо үзээд сургуульд оруулдаг боловч энэ хөдөлмөрийн үр дүн төдийлөн үнэлэгддэггүй байна. Арал, төвийн цэцэрлэгт анги дүүргэлт хэтэрсэн цаана нь ч цэцэрлэгийн насны хүүхэд цэцэрлэгт явж чадахгүй байгаа нь цэцэрлэгийн байрлалыг зөв байршуулж, нэмэх шаардлагатайг харуулж байгаа юм.

Аж ахуй эрхлэх эрхийн хэрэгжилтийн талаар:

Аймаг, сумдын нийт 287 бизнес эрхлэгчдээс асуулгын хуудсаар судалгаа авлаа. Өнөөдөр аймаг, орон нутгийн ажил эрхлэгчдийн дийлэнх нь хувиараа бизнес

эрхэлж амьдралаа залгуулж байгаа юм. Алслагдмал нутгийн иргэд хол газраас бараагаа авч ирэхдээ хил гаалийн татвар, тээврийн зардал төлж ирээд орон нутагт дахин татвар төлөх, торгуулах, хураалгах зэрэг хүндрэлүүдтэй тулгардаг нь тэдний амьдралыг төдийлөн дээшлүүлж чаддаггүй, зөвхөн амьдралаа залгуулах төдий амжиргаа болдог байна.

Бизнес эрхлэгчдийн эрх ашгийн хамгаалсан ямар нэг байгууллага орон нутагт байдаггүй.

Эмзэг бүлгийн эрхийн талаар:

Аймгийн хэмжээгээр тахир дутуу насанд хүрсэн хүн 3900, хүүхэд 2270 орчим байгаагаас аймгийн төлд 1500 орчим, сумд 1700, хөдөөд 3000 гаруй нь амьдардаг байна.

Хөдөлмөрийн чадвартай тахир дутуу иргэдийн дөнгөж 1.5 хувь нь хөдөлмөр эрхэлдэг, 53 хувь нь ядуу өрхөд багтаж байгаа юм.

Тахир дутуу хүмүүсийн ихэнх нь гарын дүйтэй, эсвэл урлагийн юмуу ямар нэгэн авьяастай, хөдөлмөрлөх сонирхолтой байгаа нь тэдгээрийг сургалтанд хамруулах, ажлын байраар ханган дэмжин туслахад тус дөхөмтэй юм.

Оюуны хомсдолтой 680 гаруй хүн байгаагийн 380 нь насанд хүрсэн, 300 орчим нь хүүхэд байна. Эдгээр 680 орчим хүний 747 нь нэн ядуу, 146 нь ядуу амьдралтай байгаа нь тэдний талаар авах арга хэмжээ хангалтгүй байна гэж дүгнэж болохоор байгаа юм.

Хөдөлмөрийн хуулинд заасан 50 түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллага нь ажил албан тушаалынхаа 3 түүнээс дээш хувийн орон тоонд тахир дутуу болон одой хүнийг ажиллуулна гэсэн заалт хэрэгжихгүй байна. Үүний шалтгаан нь 60 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллага хуруу дарам цөөн, тавих хяналт сул, урамшуулах механизм муу байгаатай холбоотой.

Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэгдсэн 2600 орчим хүний 1600 орчим нь эмэгтэйчүүд байна. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийн устгах тухай конвенцид манай улс нэгдэн орсон боловч түүний хэрэгжилт хангалтгүй байна.

Жишээ нь, ажилд авахдаа хүйсээр гадуурхах явдал элбэг байдгаас гадна судалгаанд хамрагдсан 100 өрхийн 75 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд байдаг гэсэн дүгнэлт гарч байгаа юм. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд хууль хяналтын байгууллагад ханддаггүй нь нэр төрөө бодсон, дахин заналхийлэл доромжлолд өртөнө гэж айдгаас болдог ажээ.

Аймгийн хэмжээгээр сүүлийн 3 жилд дунджаар 16-21 өрх гэр бүл салж байгаа судалгаа гарч байгаа бөгөөд үүний уршгаар эмэгтэйчүүд, хүүхдүүд хохирч байгаа юм.

Гэр бүл салалтаас болж хүүхдүүд гэмт хэрэгт өртөх, хараа хяналтгүй болохн, сургууль завсардах зэрэг сөрөг үзэгдлүүд гарч байна.

2004 онд тус аймагт гэмт хэрэгт холбогдсон 47 хүүхэд байдаг байна. Хэдийгээр орон гэргүй тэнэмэл хүүхэд байдаггүй гэдэг боловч өөрийг нь асрамжлан хамгаалах хүнгүй, өөрийн орон байргүй, ах дүү, танил айлдаа зарцлагдан амьдардаг хүүхэд цөөнгүй байдаг.

Аймгийн хэмжээнд 2001 оны байдлаар тэтгэврийн насны 7300 орчим хүн байна. Үүний дотор хүүгийн болон ач зээгийн хамт амьдардаг өөрийн тусгай орон сууцгүй хөгшид дээрх тооны 20 хувийг эзэлдэг.

Үндсэн албан газар нь тарж үгүй болсноор анхааран халамжлах байгууллагагүй, албан газар нь байгаа боловч биеийн эрүүл мэнд болон ахуй амьдрал нь ядарч доройтсон үед нь туслан дэмжих, хоол хүнс, тэлээ нүүрс олгох, нэмэгдэл тэтгэвэр тогтоож өгөх үүргээ хэрэгжүүлэхгүй байна.

Нийгмийн халамжийн тухай хуулинд заасны дагуу нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний сангаас зарим хүмүүст орон сууцны халаалтын хөлс, утасны үнийг хөнгөлөх, тэлээ нүүрсний үнийг олгох, амралт сувиллын газар хөнгөлөлттэй үнээр үйлчлэх, тахир дутуу нэн ядуу хүний дотоодын протез, ортопедийн хэрэгслийн үнийг нэг удаа 100 хувь нөхөн олгоно, 1000 ба түүнээс дээш км-т алслагдсан газарт байгаа тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй нэн ядуу амьдралтай өрхийн тахир дутуу гишүүн өвчний улмаас нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгоно гэх мэт хуулиудын заалт бүрэн хэрэгжихэд төсөвлөсөн хөрөнгө мөнгө хүрэлцдэггүйгээс гадна эдгээр үйлчилгээ зохих эзэндээ хүрдэггүй, зөвхөн хөөцөлдөлгөө сайтай хүмүүст хүрч байгаа нь хүмүүсийн өөрсдийн эрхн зүйн мэдлэг дутмаг байгаагаас шалтгаалдгаас гадна багийн дарга нар ийм хүмүүсийнхээ талаархи судалгааг нарийвчлан гаргаж, тусламж үйлчилгээг эзнийг нь олж өгч байх хэрэгтэй байгааг харуулж байгаа юм.

Тахир дутуу иргэдэд тохиолдож байгаа бас нэг бэрхшээл нь группийн хугацааг 2 сар болоод сунгуулдаг явдал байдаг ба алс хол сумаас 2 сар болоод нэг хүн дагуулан ирж очих нь зардал төсвийн хувьд хүндрэлтэй бөгөөд 2 сард авсан группийн мөнгөнөөсөө ч илүү зардал гардаг байна.

Нийгмийн халамжийн сангаас тэтгэмж авах эрх нь үүссэн боловч ямар материал бүрдүүлж өгөх, хаана хандахаа мэддэггүй зэргээс уг эрхээ эдэлж чадахгүйд хүрдэг тохиолдол ч байдаг байна. Иймд нийгмийн халамж, нийгмийн даатгалын хуулийн сурталчилгааг иргэдэд байнга хийж сурталчлах хэрэгтэй байна.



НҮ ХХ нь илүү өндөр амьдрал, нөөцийн хангамж, улс орнуудын өмчийг олон нийтийн хувиар эзэмшээр замаар илүү сайн амьдралыг доголлон байгуулахад хамрагч туслах зорилго бүхий НҮ -ын дэлхий нийтийн хөгжлийн сэлжээ юм.

Эрхэм Уншигчид аа!

Та бүхэн манай сэтгүүлийн талаарх санал, үзэл бодлоо доор хаягаар ирүүлнэ үү.

Хүний Эрхийн Үндэсний Комисс

Хаяг: Улаанбаатар хот, Эрх чөлөөний талбай, Засгийн газрын XI байр, 5 дугаар давхар

Утас: 318082, 262971

Факс: 327136, 320284

Цахим шуудан: nco@mongol.net

Цахим хуудас: <http://www.nhrc-mn.org>